



Монгол Улсын Их Сургууль
ҮНДСЭН ХУУЛИЙН
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



БОЛОВСРОЛЫН БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛ, САНАЛ (ЭМХЭТГЭЛ)

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН



Монгол Улсын Их Сургууль
**ҮНДСЭН ХУУЛИЙН
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**



БОЛОВСРОЛЫН БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛ, САНАЛ (ЭМХЭТГЭЛ)

Улаанбаатар хот
2022

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн
& “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл

Боловсролын багц хуулийн төсөл, санал (эмхэтгэл)

Эмхэтгэсэн: Т.Эмүжин

© Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно.
Бүтээлийг бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм
хийх, электрон системд оруулах, бусад ямар нэгэн хэлбэрээр
олшруулахыг хориглоно.

АГУУЛГА

Р.Очирбал: Сурч боловсрох эрхийн тулгамдсан зарим асуудал	5
С.Сэлэнгэ: Боловсролд тэгш хамруулан сургах нь	32
Б.Ардак: Хос хэлний боловсрол	58
Д.Тунгалаг: Ашгийн төлөө бус боловсролын байгууллага	72
Г.Ганцэцэг: Боловсролын засаглал, хариуцлагын тогтолцоо	88
Б.Батжаргал: Эрх тэгш байдлын төлөөх санхүүжилт	100
“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн байр суурь: Боловсролын хуулийг боловсруулахад баримтлах, тусгах зарчим	108
“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс Боловсролын Ерөнхий хууль болон СӨБ, Ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн санал	113
Ц.Мандхайхатан, Н.Должин: Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүргүүлэх санал, зөвлөмж	119
Ц.Мандхайхатан, Н.Должин: Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөлд хүргүүлэх санал, зөвлөмж	131

ХАВСРАЛТ

Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал	142
Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга	156
Боловсролын ерөнхий хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/	164
Дээд боловсролын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/	210
Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл	233
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/	243
Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/	266

Р.ОЧИРБАЛ

СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Сурч боловсрох эрх нь Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор баталгаажсан хүний үндсэн эрх бөгөөд бусад эрх, эрх чөлөөг баталгаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх суурь юм. Ялангуяа, хүүхдүүд, эмэгтэйчүүд, орлого багатай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нутгийн уугуул иргэд, хэл болон соёлын цөөнх гэх зэрэг нийгмийн бүлгийн хувьд боловсрол нь нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжих, ядуурлаас ангижрах үндсэн хэрэгсэл юм. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүүхдийг хүнд хөдөлмөр, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах, хүний эрх, ардчиллыг дэмжих, байгаль орчныг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.¹

Хүний сурч боловсрох үндсэн эрхийг Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал,² Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт,³ Хүүхдийн эрхийн тухай конвенц,⁴ Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц зэрэг олон улсын болон бүс нутгийн олон тооны баримт бичгээр хамгаалсан. Дээрх олон улсын гэрээнд заасны дагуу төрөөс хүний сурч боловсрох эрхийг өөрийн дотоодын нөөц боломжийн хэмжээнд дэвшилттэйгээр хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээг авах бөгөөд боловсролын хүрэлцээтэй (availability),⁵ хүртээмжтэй (accessibility),⁶

¹ CESCR, General Comment No. 13: The Right to Education (Art. 13) (1)

² Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1946), 26 дугаар зүйл.

³ Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пакт (1966), 13, 14 дүгээр зүйл.

⁴ Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989), 28, 29 дүгээр зүйл.

⁵ Боловсролын байгууллага болон хөтөлбөр хангалттай хэмжээнд байх ёстой утгыг илэрхийлнэ. Тухайн боловсролын байгууллагаас үйл ажиллагаа явуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг нөөц, тухайлбал, шаардлагад нийцсэн байр, багшлах боловсон хүчин, номын сан, компьютер, мэдээллийн технологи хэрэгслүүдийг хангалттай хэмжээнд бүрдүүлсэн байх шаардлагатай

⁶ Боловсрол нь ямар нэгэн ялгаварлалгүйгээр хүн бүхэн бүхэнд, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүртээмжтэй байх шаардлагатай (non-discrimination). Боловсролыг хүртэх, хүлээн авах нь бие махбодийн хувьд аюулгүй байхын зэрэгцээ, хамрагдахад газар зүйн байрлалын хувьд тохиромжтой байх шаардлагатай (physical accessibility). Боловсролыг хүн бүр хүртэхүйц байх шаардлагатай. Хүн бүрд бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно (economic accessibility).

хүлээн зөвшөөрөгдсөн (acceptability),⁷ нийгмийн хэрэгцээ, шаардлагад уян хатан нийцсэн дасан байх (adaptability)⁸ баталгааг хангах үүрэгтэй.

Хүний сурч боловсрох эрхийн харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон тэдгээр хуульд нийцүүлэн гаргасан олон тооны дүрэм, журмаар зохицуулж байна. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), Алсын хараа-2050, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал зэрэг үндэсний хэмжээний бодлогын баримт бичигт иргэн бүрд хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэхээр заасан.

Хэдийгээр боловсролын салбарын бодлого, эрх зүйн зохицуулалтад тасралтгүй шинэчлэл хийгдсээр байгаа хэдий ч хэрэгжилтийн үр нөлөөг хангахад тогтвортой бодлого, оновчтой удирдлага, төсөв, санхүүгийн хангалттай нөөц, нөөцийн үр ашигтай хуваарилалт чухлаар хөндөгдөж байгааг олон тооны судалгаа, тайлангаас харж болно.

Сурч боловсрох эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхэд нэн тэргүүн ээлжид шийдвэрлэвэл зохих дараах асуудал байна.

Нийгмийн эмзэг бүлгийн боловсролын эрхийн асуудал

Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн үндсэн хэм хэмжээгээр баталгаажсан хүний сурч боловсрох үндсэн эрхийг хүн бүрд баталгаатай эдлүүлэхийн тулд нийгмийн эмзэг бүлгийн эрхийг онцгойлон авч үзэх нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын суурь зарчим болох хөгжлийн гадна хэнийг ч үл орхигдуулах зарчимд нийцнэ. Боловсролын тухай хуульд иргэний сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас,

⁷ Боловсролын хэлбэр, агуулга, тухайлбал сургалтын хөтөлбөр, багшлах арга зүй нь соёлын хувьд тохиромжтой, чанарын шаардлага хангасан бөгөөд суралцагч болон тэдгээрийн эцэг, эхчүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагатай.

⁸ Боловсрол нь уян хатан байх ёстой бөгөөд ингэснээр өөрчлөгдөж буй нийгэм, олон нийтийн хэрэгцээнд дасан зохицож, суралцагчдын нийгэм, соёлын янз бүрийн нөхцөлд тэдний хэрэгцээг хангах боломжтой болно.

хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш, боломж, нөхцөлөөр хангана⁹ хэмээн хуульчилсан нь дээрх бүлгийн иргэдийн сурч боловсрох эрхийг хамгаалах хууль, эрх зүйн үндсэн зохицуулалт юм.

2017 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Казах хүүхдүүд, бага орлоготой болон малчин өрхийн хүүхдүүд, алслагдсан хөдөө нутгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хөвгүүд, сүм хийдэд шавилан суугаа хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг баталгаажуулахыг¹⁰ Монгол Улсын Засгийн газарт зөвлөжээ. Мөн НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тухай Тусгай илтгэгч Вернор Муноз өөрийн тайлан илтгэлдээ хөдөө орон нутгийн боловсролын байгууллагын дэд бүтэц, эрүүл мэнд ариун цэвэр зэрэг боловсролын хүрэлцээг сайжруулахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон малчин иргэдийн боловсролын эрхийн асуудлыг¹¹ анхаарах талаар онцлон тэмдэглэжээ.

Нийгмийн зорилтод бүлгийн хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хангах үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэхэд бүрэн дүүрэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоо, холбогдох байгууллагууд мэдээллийг солилцох үйл явцыг сайжруулах шаардлагатай байна.¹²

А. Үндэсний цөөнхийн сурч, боловсрох эрх

Боловсролын хүртээмж, эрх тэгш байдал, санхүүгийн оновчтой хуваарилалт алдагдсанаас өөр хэл бүхий үндэсний цөөнх, тухайлбал Казак, тува гэх зэрэг иргэдийн сурч боловсрох эрх зөрчигдөж байгааг олон тооны судалгаанд онцолжээ.¹³ Төрөөс үндэсний цөөнхийн боловсролын талаар баримтлах бодлогын хүртээмжтэй, хүрэлцээтэй байдалд зарим

⁹ Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.

¹⁰ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тавдугаар тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмж (2017), §38.

¹¹ НҮБ-ын сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч Вернор Муноз Виллалобосын тайлан (2009), §79.

¹² Зорилтод бүлгийн хүүхдийн боловсролын хэрэгцээ, асуудлууд, 13.

¹³ Тухайлбал, БСШУСЯ, Global Partnership for Education, Дэлхийн банкнаас хамтран гаргасан Алсын Хараа 2050: Боловсролын салбарт тэгш байдал, үр ашиг үр дүнг нэмэгдүүлэх нь судалгаа,

эерэг өөрчлөлт байгаа хэдий ч боловсролын хүлээн зөвшөөрөгдсөн, цаг үетэйгээ зохицсон байдал хангалтгүй, бодлого шийдвэрийн хэрэгжилт сул байгааг зарим судалгаанд дүгнэжээ.¹⁴ Казах өрхийн хүүхдийн сурч боловсрох боломж хязгаарлагдмал,¹⁵ хамрагдалтын хувь хэмжээ¹⁶ болон сурлагын амжилт бусад бүлгийнхээс нийтлэг доогуур¹⁷ байна. Иймээс дараах асуудлыг дэвшилттэйгээр шийдвэрлэх шаардлагатай байна.

- **Үндэсний цөөнхийн боловсролыг дэмжих цогц бодлого үгүйлэгдэж байна.** Үндэсний цөөнхийн чиглэлээр гадны донор байгууллагын дэмжлэгт үндэслэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа хэдий ч эдгээрийг бодлогын хувьд нэгтгэсэн төрийн бодлого үгүйлэгдэж байна. Үндэсний цөөнхийн эрх хамгааллын чиглэлээр үндэсний цогц бодлого боловсруулж, салбар хоорондын уялдаа холбоог хангах, энэхүү бодлогын чухал бүрэлдэхүүн нь боловсролын бодлого байхаар тодорхойлох нь үр дүнтэй. Бодлогыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт дүн шинжилгээ хийх ажилд холбогдох байгууллагуудын идэвх, оролцоо, дэмжлэгийг уялдуулах шаардлагатай.
- **Хүн амын өөр хэл бүхий үндэсний цөөнхийн хос хэлний боловсролын талаарх харилцааг бодлого, эрх зүйн хувьд зохицуулах онцгой хэрэгцээ шаардлага тулгарч байна.** Хос хэлний талаарх үр нөлөөтэй бодлого дутагдалтай байгаагаас ерөнхий боловсролын сургуульд суралцагч үндэсний цөөнхийн хүүхдүүдийн сурч боловсрох эрх,¹⁸ сурлагын чанар, амжилтад¹⁹

¹⁴ ХЭҮК, НҮБ-ын Хүүхдийн сан, Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний зөвлөл, “Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт: Судалгааны тайлан”, (2017).

¹⁵ БСШУСЯ, Global Partnership for Education, Дэлхийн банкнаас хамтран гаргасан Алсын Хараа 2050: Боловсролын салбарт тэгш байдал, үр ашиг үр дүнг нэмэгдүүлэх нь судалгаа (2020), 6.

¹⁶ Мөн тэнд, 18, 36.

¹⁷ Мөн тэнд, 35.

¹⁸ 2010 онд хийсэн НҮБ-ын Хүүхдийн сангийн судалгаагаар Баян-Өлгий аймагт сургууль завсардалт (4.7%), сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт (65.4%), бичиг үсэг тайлагдалтын хувь (6.8%) байгаа нь улсын дунджаас бага байгаа бөгөөд түүнчлэн хүүхдүүд сургуульд зохих насандаа элсэхгүй байгаа нь сургууль завсардах болон сурлагын амжилт доогуур байхад сөргөөр нөлөөлж байна.

¹⁹ БСШУЯ, Азийн хөгжлийн банк, Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан (2019)

сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ цаашлаад хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээнд²⁰ нөлөөлж байна. Үндэсний цөөнхийн сурч боловсрох эрхийн талаар БСШУЯ-аас зарим хөтөлбөр²¹ баталж, мөрдүүлж байгаа хэдий ч хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй,²² сургууль, ялангуяа сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтад хос хэлээр сургалт явуулж буй сургуулийн сургалтын төлөвлөгөө, үндэсний онцлог бүхий хичээлүүдийн хөтөлбөр, сурах бичиг,²³ соёл хоорондын боловсрол, сургалтын арга зүйн талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа нь цөөнхийн хэлний боловсрол, боловсролын чанарт сөргөөр нөлөөлөд зогсохгүй нийгмийн тэгш бус байдлыг бий болгож байна.

Б. Малчин иргэдийн сурч боловсрох эрх

Хөдөө орон нутагт сургууль завсардалтын хувь хэмжээ өндөр, сурлагын амжилтын дундаж үзүүлэлт тааруу байгаа бөгөөд боловсролын түвшин ахих тутам хот, хөдөөгийн хүн амын боловсролын ялгаа нэмэгдэж байна.²⁴ Бодлого, эрх зүйн зохицуулалтад малчин иргэдийн сурч боловсрох эрхийг хангах талаар зохих хэмжээнд тусгагдсан хэдий ч малчин иргэдийн нүүдлийн соёл, ахуйн онцлог, хот суурин газраас алслагдмал амьдардаг зэрэг нь тэдгээр иргэдийн сурч боловсрох эрхийг үр нөлөөтэй хангах, хууль тогтоомж хэрэгжүүлэхэд томоохон сорилт болж байна. Хүүхдийн сурч боловсрох орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор малчин иргэд хот, суурин газарт суурьшин амьдрах болсон нь хотын хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд улам дарамт болж байна. Малчин иргэдэд хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн хэрэгцээ, шаардлагад уян хатан нийцсэн

²⁰ ХЭҮК, Казак, тува хүүхдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал судалгааны тайлан (2010), 37 https://nhrcm.gov.mn/media/documents/1359343952_kazah.pdf

²¹ БСШУ-ны сайдын 2007 оны 425 тушаалаар батлагдсан “Казак хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”; БСШУ-ны сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар батлагдсан “Тува хэлний хөтөлбөр”

²² ХЭҮК, Казак, тува хүүхдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал судалгааны тайлан (2010), 15.

²³ Нээлттэй нийгэм форум, Хос хэлний боловсрол: Казак хүүхдийн кейс судалгаа (2011).

²⁴ БСШУСЯ, Global Partnership for Education, Дэлхийн банкнаас хамтран гаргасан Алсын Хараа 2050: Боловсролын салбарт тэгш байдал, үр ашиг үр дүнг нэмэгдүүлэх нь судалгаа (2020), 35.

боловсрол олгохын тулд дараах асуудалд тэргүүн ээлжинд анхаарах шаардлагатай.

- **Малчин өрхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хүртээмж болон олон төрөлт арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх.** 2014-2024 оны Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод хүүхэд бүр СӨБ-д янз бүрийн хэлбэрээр (цэцэрлэг, улирлын чанартай нүүдлийн цэцэрлэг, гэр цэцэрлэг, нүүдлийн багш нар болон ээлжийн анги) хамрагдана хэмээн заасан хэдий ч тодорхой зорилт, бодит үйл ажиллагаа дутагдалтай, хоцрогдолтой байна.²⁵ Малчин өрхийн хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь хэмжээний талаарх нарийвчилсан тоо баримт олдсонгүй. Зарим ерөнхий мэдээ тайлан олон байна.²⁶ Гадны донор байгууллагын дэмжлэгт тулгуурласан²⁷ хувилбарт хөтөлбөр (гэр цэцэрлэг гэх мэт) нь нүүдэлчин ахуй бүхий малчин өрхийн хүүхдүүдэд СӨБ олгох үндсэн арга хэдий ч цаашид хөтөлбөрийг өөрийн дотоод чадавхад үндэслэн тогтвортой үргэлжлүүлэх санхүү, удирдлагын асуудал чухлаар хөндөгдөж байна. Хувилбарт хөтөлбөрийн агуулга, чанар, үр дүнг дээшлүүлэхийн тулд өөр өөр байгууллагаас хэрэгжүүлсэн тархаж сарнисан салангид судалгаа, мэдээлэл, тайлангуудыг өргөн хүрээнд нь системчлэн нэгтгэж, дүн шинжилгээ хийж хувилбарт хөтөлбөрийн үр нөлөө дээшлүүлэх, сорилт бэрхшээлийг²⁸ даван

²⁵ ЮНЕСКО-ийн Боловсролын газар, Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, (2019), 120. https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/PDF%20files/EPR%20final_web%20version1020.pdf

²⁶ 2019-2020 оны хичээлийн жилд нийт 31,891 хүүхэд хамрагдсанаас 11.8 хувь нь малчин иргэдийн хүүхэд байх бөгөөд 2 хүртэлх насны хүүхдийн хамрагдалт нэмэгдсэн бол 6 нас хүртэлх насны хүүхдийн тоо жил бүр огцом буурсан байна.

²⁷ ЮНЕСКО-ийн Боловсролын газар, Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, (2019), 121.

²⁸ ЮНЕСКО-ийн Боловсролын газрын эрхлэн гаргасан Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээнд (117) дурдсанаар нүүдэлчин малчдыг боловсролд хамруулахад 3 төрлийн үндсэн бэрхшээл тулгардаг. Нэгдүгээрт, сургууль нэг газраа байрлаад малчид нүүдэллэн амьдардаг учир ложистикийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй. Хоёрдугаарт, хүн ам цөөтэй орон нутагт сургууль, цэцэрлэгийн тоо цөөн тул боловсролын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх нь бэрхшээлтэй бөгөөд энэ нь боловсролын чанарт нөлөөлдөг. Гуравдугаарт, боловсролын хөтөлбөрийн агуулгад мал аж ахуйг амьжиргааны эх үүсвэр болгон амьдрахад хэрэглэх агуулга байдаггүй тул малчдын хэрэгцээнд уян хатан нийцдэггүй.

туулах арга замыг боловсруулах шаардлагатай. Үүний тулд СӨБ-ийн холбогдох стандартыг аль болох жигд хэрэгжүүлж, хэрэгжилт, хяналт,²⁹ удирдлагын тогтолцоог сайжруулах, шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг тогтвортой байдлыг хангах шаардлагатай.

- **Сургуулийн дотуур байрны хүрэлцээтэй, зохистой, аюул эрсдэлгүй, хүчирхийллээс ангид байдлыг хангаж хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх.** Дотуур байрны хүрэлцээ муу, орчин нөхцөлийн зохистой байх шаардлага хангаагүй, үе тэнгийн болон бусад дарамт, хүчирхийлэл³⁰ зэрэг нь шийдвэрлэвэл зохих үндсэн асуудал болжээ. Сургуульд элсэх насыг 6 нас болгосон нь зарим малчин эцэг, эхчүүд хүүхдээ бага насанд нь дотуур байранд амьдруулахаас зайлсхийн сургуульд 8-10 настайд нь оруулах, эсхүл том хүүхдээ сургуульд оруулалгүйгээр дараагийн дүүтэй нь хамт сургахыг илүүд үзэх тохиолдол цөөнгүй гарч байна. Эсхүл эцэг, эхийн аль нэг нь ялангуяа эх нь сургуулийн насны хүүхэдтэйгээ сургууль, цэцэрлэгээ бараадан гэрээсээ тусдаа амьдарч байгаа нь өрхийн бүтцэд муугаар нөлөөлж, зарим тохиолдолд гэр бүл цуцлах, түүнчлэн гэр бүлээ төв суурин газарт шилжин суурьшихад хүргэж байна.³¹ Иймд Дотуур байрны чанар, зохистой байдлын талаар нэгдмэл, цогц бодлого хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг (Боловсрол, хоол тэжээл, хүүхэд хамгаалал, ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж) дэмжих талаарх ЮНЕСКО-ийн Боловсролын газар³² гэх мэт байгууллагын гаргасан зөвлөмжийн хүлээн авч, тууштай хэрэгжүүлэх, холбогдох хөрөнгө, санхүүжилтийн тогтвортой, хүртээмжтэй байдлыг хангах шаардлагатай байна. Дотуур байрны үе тэнгийн дарамт болон бусад аливаа хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэх талаарх боловсролын байгууллагын эерэг үүргийг Боловсролын тухай хууль болон хүүхэд хамгааллын тухай хуульд хуульчлах боломжтой.

²⁹ Мөн тэнд, 123-124.

³⁰ Мөн тэнд, 124-125.

³¹ Мөн тэнд, 126.

³² Мөн тэнд, 127.

- Малчин иргэдэд албан бус болон насан туршийн боловсролын хүртээмжтэй, нийгмийн хэрэгцээ шаардлагад уян хатан нийцсэн байх шаардлагад нийцүүлэхийн тулд тогтвортой хөгжил-амьжиргаа, уур амьсгалын өөрчлөлт-дасан зохицох менежмент, байгаль хамгаалал, бэлчээр ашиглалт-хамгаалал-менежмент, малчдын эрх хамгаалал, өрхийн үйлдвэрлэлийн менежмент ба эдийн засаг, нүүдлийн уламжлалт соёлын шалгарсан мэдлэг, туршлага болон мал маллах уламжлалт болон орчин үеийн арга ухаан зэрэг агуулгыг түлхүү олгоход анхаарах шаардлагатай байна. Насан туршийн боловсрол олгох үндэсний механизмын ерөнхий чадамж (багшлах боловсон хүчний тоо, чанар, сургалтын хөтөлбөрийн агуулга, үр ашиг, санхүүжилт) нь дээрх асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл болж байна.

В. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд бүрэн, тэгш хамруулах, сурч боловсрох нөхцөлийг хангах талаарх төрийн үүргийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан.³³ Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдсан. Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын онцлог хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулах боловсролын тогтолцоог хөгжүүлэх, тэднийг жирийн хүүхдүүдтэй хамт нэг ангид суралцах нөхцөлийг хангах талаар цөөнгүй бодлого, хөтөлбөр хэрэгжиж байгаа хэдий ч хууль тогтоомж, хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлж боловсролын хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, нөхцөлд байдал, хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн

³³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)-ийн 5.1.3-т сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх нь тус хуулийн үндсэн зарчим байхаар заасан бөгөөд 6.3.3-т хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжлийг хязгаарлах, ялгавартай хандахыг хориглосон. Хуулийн 14-16 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, сурч боловсрох нөхцөл зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан.

байх шаардлагыг хангах асуудал чухлаар тавигдаж байна. Дараах асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай.

- **Бүх шатны боловсролын байгууллагад суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бүрэн, үнэн зөв мэдээллийн тогтолцоо бүрдээгүй нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.** 2019 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 3.3 хувь буюу 107,075 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн³⁴ байгаа ерөнхий статистик тоо мэдээ байгаа хэдий ч үндэсний хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн нийгэмшихүйсэтгэл хөдлөлийн хөгжлийн талаарх нас, хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй,³⁵ ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургууль, коллежид хамрагдалтын талаарх бүрэн, тогтмол шинэчлэгдсэн мэдээллийн тогтолцоо бүрдээгүй байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалал хүртэх, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлж, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд тогтмол дүн шинжилгээ хийхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх өргөн хүрээний бодит, үнэн зөв мэдээллийг бий болгож, салбар хоорондын уялдаа холбоог бий болгох шаардлагатай
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх чиглэлээр батлан гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, төслүүдийн бодит хэрэгжилтэд иж бүрэн, дүн шинжилгээ, судалгаа хийх онцгой шаардлагатай байна.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэр дундаа сурч боловсрох эрхийн чиглэлээр олон тооны судалгааны тайлан байгаа хэдий ч хууль тогтоомжийг хэрэгжилт, түүний үр өгөөжийн талаар цогц дүн шинжилгээ судалгааны явцад олдсонгүй.
- **Холбогдох хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах.** Одоогийн санхүүжилтийн тогтолцоо нь хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг

³⁴ Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө (2019), 21.

³⁵ Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан (2019), 20.

үр дүнтэй хэрэгжүүлэх, багшлах боловсон хүчин болон сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүнийг дээшлүүлэхэд хүрэлцдэггүй, хөгжлийн бэрхшээлтэй болон онцлог хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээг төдийлөн харгалзан үздэггүй³⁶ гэсэн шүүмжлэл олонтоо байна.

Г. Шилжин суурьшилтаас үүдэх боловсролын эрхийн асуудал:

Орон нутгаас хот, суурин газар руу чиглэсэн дотоодын шилжилт хөдөлгөөн нь нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон асуудлыг бий болгож байна. Хөдөлмөр эрхлэлт болон чанартай, хүртээмжтэй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ нь нийслэл болон томоохон хот, суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөний татах хүчин зүйл болж байна. Гэвч нийслэлд байнга оршин суух шилжилт хөдөлгөөнийг 2016 оноос эхлэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар хязгаарласан нь нийслэлд албан ёсны бүртгэлгүй шилжин суурьшсан орлого багатай иргэдийн эрүүл мэнд, боловсрол гэх мэт нийгмийн суурь үйлчилгээ, халамжид хамрагдах боломжийг хязгаарлаж Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна. Ийнхүү шилжих хөдөлгөөнийг хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамж нь хууль ёсны үндэслэл бүхий байх шаардлагад нийцэхгүй байхын зэрэгцээ хүний эрхийг зөвхөн хуулиар хязгаарлах, хязгаарлалт нь үндэслэл бүхий, зайлшгүй бөгөөд гарцаагүй байх, тухайн нөхцөл байдлыг хэр хэмжээнд тохирсон байх, хязгаарласан шийдвэр заавал тодорхой хугацаатай байх зэрэг хүний эрхийг хязгаарлахад баримтлах үндсэн шалгуурт нийцэхгүй байна.

Албан бус шилжин суурьшигч өрх нь тухай амьдран суугаа газрын хамаарах тойргийн сургуульд хүүхдээ суралцуулахад ихээхэн бэрхшээлтэй тулгардаг хэдий ч Монгол Улсын иргэн бүр суурь боловсролыг үнэ төлбөргүй заавал эзэмших эрхийг хэрэгжүүлэхийн тулд ЕБС-ууд хамруулан суралцуулдаг.³⁷ Харин сургуулийн өмнөх боловсролд

³⁶ БСШУСЯ, Global Partnership for Education, Дэлхийн банкнаас хамтран гаргасан Алсын Хараа 2050: Боловсролын салбарт тэгш байдал, үр ашиг үр дүнг нэмэгдүүлэх нь судалгаа (2020), 71.

³⁷ ЮНЕСКО-ийн Боловсролын газар, Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, (2019), 160.

хүүхдээ хамруулах нь албан бус шилжин суурьшигчдын хувьд хүнд сорилт хэвээр байна.

Шилжин суурьшигч өрхийн 40 орчим хувь нь орлого багатай нийгмийн эмзэг бүлэгт хамаарч байгаа нь тэдэнд төрийн онцгой дэмжлэг шаардлагатай болохыг харуулж байна. Шилжин суурьшигчдын боловсролын эрхийг хангахын тулд дараах асуудалд анхаарах шаардлагатай.

- **Дотоодын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, шилжин суурьшигчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх төрийн нэгдсэн, тогтвортой, үр дүнтэй бодлого шаардлагатай байна.** Шилжин суурьших хөдөлгөөний тогтвортой зохицуулах гол арга нь орон нутгийн боловсролын үйлчилгээг сайжруулах явдал юм. Төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын баримт бичигт³⁸ шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах талаар зарим чиглэл тусгагдсан хэдий ч шилжилт хөдөлгөөнийг нөхцөлдүүлэгч татах болон түлхэх хүчин зүйлийг бодитоор тооцоолж, тэдгээрт үндэслэн шилжилт хөдөлгөөнийг хүний эрхэд үндэслэсэн аргаар шийдвэрлэх бодлого, практик үгүйлэгдэж байна.
- **Нийслэл хотод шилжин суурьшигчид нь ихэвчлэн хотын алслагдсан бүсэд суурьшдаг нь цэцэрлэг болон дунд сургуульд хүүхдээ суралцуулахад ихээхэн хүндрэл үүсгэж байна.** Нийслэлд хотод шилжин суурьшигч зарим өрх сургууль, цэцэрлэгээс 6.8³⁹-7⁴⁰км хол, явган хүний зориулалтын зам, гэрэлтүүлэг, нийтийн тээврийн үйлчилгээ байхгүй газарт амьдарч байгаа нь боловсролын албан болон албан бус үйлчилгээг хүртэх боломжид сөргөөр нөлөөлж, боловсролын хүртээмжийг бууруулж байна. Ялангуяа өвлийн улиралд хол зам туулж сургууль, цэцэрлэгтээ очих нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд

³⁸ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025).”

³⁹ Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага, “Монгол Улс: Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа”, (2018), 23.

⁴⁰ БСШУСЯ, Global Partnership for Education, Дэлхийн банкнаас хамтран гаргасан Алсын Хараа 2050: Боловсролын салбарт тэгш байдал, үр ашиг үр дүнг нэмэгдүүлэх нь судалгаа (2020), 21.

ноцтой аюул учруулж байна. Иймд Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм гэх мэт баримт бичигт нийгмийн дэд бүтэц болох соёл, боловсрол, эрүүл мэндийн барилга байгууламж, үйлчилгээнд иргэд хэрхэн хүртээмжтэй холбогдох талаарх норм, стандартыг илүү тодорхой болгож, хэрэгжилтийг дэвшилттэйгээр хангах шаардлагатай. Ингэхдээ орон сууцны хороолол, гэр хороолол болон холимог хороолол тус бүрээр сургууль, цэцэрлэгийн барилгыг төлөвлөх талаарх тодорхой тусгах хэрэгтэй. 2019 онд 55 сургуульд 152 автобус үйлчилгээнд гарсан гарсан гэх судалгаа байх бөгөөд автобусны үйлчилгээний төлбөр төлөх⁴¹ нь орлого бага өрхийн хувьд багагүй дарамт болдог. Иймд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломжгүй алслагдсан, орлого багатай өрхийн хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, өрхийн санхүүгийн дарамтын бууруулах зорилгоор үнэ төлбөргүй, эсхүл хямд үнээр сурагчдын нэгдсэн тээврээр үйлчлэх боломжуудыг судлах, хөрөнгө оруулалтыг асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

- **Эрх бүхий албан тушаалтнаас баталсан хамран сургах тойрог тогтоосон шийдвэрийг боловсролын байгууллагууд хэрэгжүүлэхдээ албан ёсны бүртгэлгүй гэх шалтгаанаар шилжин суурьшигч өрхийн хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулахаас татгалздаг практикийг халж, хүүхдийн боловсрох эрхийн баталгааг хангах.** Хамран сургах тойрогт амьдардаг хэдий ч албан ёсны бүртгэлгүй гэсэн шалтгаанаар хүүхдийг хамран суралцуулахаас татгалзах эрхийг боловсролын байгууллагад олгосон хууль, шийдвэр, хэм хэмжээ олдсонгүй. Иймд зохих шийдвэргүйгээр хүний эрхийг хязгаарлаж буй дээрх хууль бус практикийг халах шаардлагатай.
- **Гадаадад төрсөн Монгол улсын харьяат, эсхүл Монгол улсын иргэнээс төрсөн гадаад улсын иргэний бүртгэлтэй хүүхдийн Монгол улсад түр болон удаан хугацаагаар оршин суух хугацаанд сурч боловсрох эрхийн асуудал шинэ тутам**

⁴¹ Мөн тэнд, 21.

үүсэж буй тулгамдсан асуудлыг нэг юм. Албан ёсны хаягийн бүртгэлгүй, түүнчлэн монгол хэл зохистой хэмжээнд эзэмшээгүй хүүхдүүдийн Монгол улсад түр болон удаан хугацаанд амьдрах хугацаанд хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, хэрэгцээ, шаардлагад уян хатан нийцсэн боловсрол олгох асуудал бодлого, удирдлага, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр гэх зэрэг боловсролын тогтолцоонд тодорхой зохицуулалтгүй хэвээр байна. Гадаадад чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр дээрх асуудлыг цар хүрээ өсөн нэмэгдэх магадлалтай байна. Гэвч энэ чиглэлээр судалгаа, мэдээлэл маш дулимаг байна.

Д. Орлого багатай нийгмийн эмзэг бүлгийн сурч боловсрох эрх

Суурь боловсролыг хүн бүр үнэ төлбөргүй эзэмших эрхтэй хэдий ч орлого багатай нийгмийн эмзэг бүлгийн боловсролын хүртээмжийн асуудал тулгамдсан асуудал хэвээр байна. Баянзүрх дүүргийн 28 хорооноос гэр хороолол бүхий 9, 21, 23, 24 дүгээр хорооны нийт өрхийн дунд сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгч, бичиг үсэг үл мэдэгч иргэдийг илрүүлэх судалгааг⁴² 11466 өрхөд хийж үзэхэд сургуульд хамрагдаагүй 96 хүүхэд байсны 25 хувь нь сургуульд огт сураагүй, 67 орчим хувь нь сургууль завсардсан, 27 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 64 орчим хувь нь эрэгтэй хүүхэд байжээ. Мөн 18-аас дээш насны 502 хүн зохих шатны сургуулиа дүүргээгүй байсны 46 хувь нь бичиг үсэг үл мэдэгдэгч, тэдгээрээс зонхилох хувь нь эрэгтэйчүүд байжээ. Сургууль завсардсан хүүхдүүдийн шалтгааныг судлахад 34 хувь нь хүүхэд төрүүлсэн, лам болсон, бичиг баримтгүй, сурах сонирхолгүй, ар гэрийн хайхрамжгүй байдлаас үүдсэн гэсэн бол үлдсэн хувь нь шилжилт хөдөлгөөн, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээл, багшийн эвгүй харьцаа нөлөөлсөн гэжээ.

Орлого багатай өрхийн сургууль завсардсан эрэгтэй хүүхдийн тоо харьцангуй өндөр байхын зэрэгцээ хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн

⁴² БСШУСЯ, Азийн хөгжлийн банк, Насан туршийн боловсролын дэд салбарын судалгааны тайлан, (2019), 33.

тоо мөн өндөр байгаа нь энэ бүлэгт боловсролын жендерийн харьцаа алдагдсаныг илтгэж байна. Орлого багатай иргэдийн боловсролын эрхийг хангахын тулд дараах асуудалд анхаарах шаардлагатай байна.

- **Ядуурлыг бууруулах чиглэлд хүчин чармайлтаа нэмэгдүүлэхгүйгээр орлого багатай иргэдийн сурч боловсрох эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх боломжгүй.** “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан ядуурлын бүх төрлийг эцэс болгох зорилтын хүрээнд 2016-2020 онд ядуурлын түвшинг 18 хувь хүртэл буулгахаар төлөвлөсөн ч ядуурлын бууралтад төдийлөн ахиц гараагүй байна.⁴³ Төрөөс Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021), Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2019-2024) зэрэг бодлогын баримт бичигт ядуу өрхийн гишүүдэд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхээр тусгасан хэдий ч хэрэгжилтийн явц, үр нөлөөний талаарх мэдээлэл олдсонгүй.
- **Орлого багатай өрхийн хүүхдүүдийн хувьд сургуулийн хүртээмж тулгамдсан асуудал байхын зэрэгцээ амьдралын чанар, орчин нөхцөлөөс үүдэн сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байна.** Зөвхөн нийслэлийн хэмжээнд эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй 10,000 орчим өрх амьдарч байгаа⁴⁴ нь үүний тод илрэл юм. Ядуу, орлого багатай өрхийн хүүхдүүд сургууль завсардалтад илүү өртдөг гэсэн ерөнхий тоо баримт байгаа хэдий ч шаардлагад нийцээгүй, аюулгүй байдал нь хангагдаагүй орчин, нөхцөлд амьдарч байгаа, зохистой орон гэргүй хүүхдийн талаарх нарийвчилсан мэдээлэл, судалгааны тайлан олдсонгүй. Амьдралын чанар алдагдсан, сурах орчин нөхцөл бүрдээгүйн улмаас боловсрол эзэмшиж чадахгүй байгаа хүүхдийн асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

⁴³ 2018 онд ядуурлын түвшин улсын хэмжээнд 28.4 хувь, ядуурлын гүнзгийрэлт 7.2 хувьтай байна. Хүүхдийг ивээх сан, Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ (2018).

⁴⁴ НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс, <http://www.time.mn/pn2.html>

Сүм, хийдэд шавилан сууж байгаа хүүхдийн сурч боловсрох эрх

2018 оны байдлаар улсын хэмжээгээр христийн 196, буддын 134, исламын 24, бусад төрлийн 10 сүм хийдэд нийт 1552 лам, санваартан шавилан сууж байна. Эдгээрээс хамгийн олон нь буддын сүмд 1321 лам санваартан байгаагийн дотор сургуулийн насны хүүхэд, тэр тусмаа бага, дунд, бүрэн дунд боловсрол эзэмшээгүй хүмүүс олон, ялангуяа хөдөөгийн жижиг сүм хийдэд байна.⁴⁵

Сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдийн боловсролын эрхийн асуудал бодлого, зохицуулалтын гадна үлдсэнийг хэд хэдэн судалгаанд тодорхой дурджээ. Шашин номын байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгож, ЕБС-ийн цөөн тооны хичээл зааж байгаагаас хүүхдэд суурь боловсрол заавал эзэмшүүлэх Үндсэн хуулийн заалт зөрчигдөж, сургууль завсардалт зэрэг сөрөг үр дагавар гарч байгаа нь энэ төрлийн харилцааг хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 2010 оноос эхлэн сүм хийдэд шавилан сууж буй лам хүүхдүүдийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулах төсөл хэрэгжүүлсэн хэдий ч дүйцсэн хөтөлбөрт хамруулах нь тэдгээр хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үр нөлөөтэй арга гэж үзэх боломжгүй. Түүнчлэн сүм, хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдийн суралцах орчны стандарт бүрдээгүй, ялангуяа дотуур байрны стандарт байхгүйгээс сүм, хийдийн зарим дотуур байранд 15м² хэмжээтэй өрөөнд 10 хүүхдийг нэг дор амьдруулж байсан⁴⁶ гэсэн дүгнэлт ажиглалтын судалгааны үед гарчээ. Хүүхэд хамгааллын хууль тогтоомжид заасан бүх орчинд хүүхэд бүрийг аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаарх зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа нь тодорхойгүй байна. Шавилан сууж байгаа хүүхдийг мөргүүлэх, сур, бүсээр шавхуурдах, зодох, эрхээр ороолгох зэрэг шийтгэлийн арга

⁴⁵ БСШУСЯ, Азийн хөгжлийн банк, Насан туршийн боловсролын дэд салбарын судалгааны тайлан, (2019), 58.

⁴⁶ ГБХЗГ, Судалгааны эмхэтгэл, (2019) 3 дугаар бүлэгт “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал”, 111.

хэмжээг хэрэглэсээр байгаа⁴⁷ нь Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг зөрчиж буй ноцтой зөрчил юм.

2. Төрийн бус өмчийн боловсролын байгууллага ба боловсролын тэгш бус байдал

Улс орны хөгжлийн түвшингээс үл хамааран бүх нийтийн суурь боловсрол олгох үйл ажиллагаа төрийн өмчийн боловсролын байгууллагууд дээр төвлөрдөг хэдий ч төрөөс тогтоосон доод шаардлагыг хангасан тохиолдолд төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг байгуулах нь ихэнх улс хүлээн зөвшөөрдөг. Гэвч боловсролын тогтолцоонд төдийгүй нийгмийн олон салбарт системийн ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг хянан зохицуулах зорилгоор төрийн бус өмчийн боловсролын байгууллагын талаарх бодлого, зохицуулалтад ихээхэн анхаарч байна. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн ихэнх улсад боловсролын үйлчилгээг төрөөс санхүүжилт авдаг хувийн өмчийн боловсролын байгууллагуудаар дамжуулан олгохыг хүлээн зөвшөөрөг хэдий ч нийт суралцагчийн эзлэх хувь харьцангуй бага байна.⁴⁸

Төрөөс хувийн хэвшлийн боловсролын байгууллагад татаас олгох энэхүү нийтлэг систем нь хувийн хэвшлийн боловсролын тогтолцооноос үүдэж нийгэмд тэгш бус байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэдэг.⁴⁹ Төрөөс татаас авч байгаа хувийн хэвшлийн боловсролын байгууллага нь ялгаа бүхий үндсэн дөрвөн загвараар үйл ажиллагаа явуулах боломжтой. Үүнд: Сургалтын эрх чөлөө (freedom of instruction),⁵⁰

⁴⁷ Мөн тэнд, 115.

⁴⁸ Финланд улсад 1-6 насны хүүхдийн 18 орчим хувь нь улсаас санхүүжилттэй СӨБ-д хамрагдсан бол суурь боловсролын байгууллагад суралцагчдын 3 хувь нь хувийн сургуульд суралцдаг. Төрөөс санхүүжилттэй хувийн өмчийн боловсролын байгууллага нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглодог.
https://eacea.ec.europa.eu/national-policies/eurydice/finland/organisation-private-education_en#:~:text=In%20Finland%20most%20private%20schools.Finnish%20National%20Agency%20for%20Education.

⁴⁹ Adrian Zancajo and Antoni Verger, *The instrumentation of public subsidies for private schools: Different regulatory models with concurrent equity implications* (2021) European Educational Research Journal, 2.

⁵⁰ Энэхүү загвар нь Австрали, Франц, Дани, Канад зэрэг улсад хэрэгждэг бөгөөд төрөөс хувийн хэвшлийн боловсролын байгууллагад олгох татаасыг санхүүгийн тогтвортой байдлыг хангах хэрэгсэл болгон ашигласан. Төрөөс олгох татаас нь хувийн хэвшлийн

Эквивалент (equivalence),⁵¹ зах зээлийн өрсөлдөөн (market competition),⁵² Боловсролын төрөлжүүлсэн бие даасан байдал (Autonomy for educational diversification).⁵³

Монгол улсын хувьд төрөөс хувийн өмчийн боловсролын байгууллагуудад татаас олгож байгаа хэдий ч ийнхүү татаас олгох бодлого нь боловсролын тэгш бус байдлыг хангахад ямар нөлөө үзүүлэх нь тодорхойгүй байна. Иймд боловсролын чанар, хүртээмж, хүлээн зөвшөөрөгдөх байдлаас үүдсэн нийгмийн тэгш бус байдлыг бууруулахын тулд төрөөс төрийн бус өмчийн боловсролын талаар баримтлах бодлого тодорхой байх шаардлагатай. Төрийн бус өмчийн сургуульд өндөр төлбөр, хангамжтайгаар чанартай мэдлэг, боловсрол эзэмших нь нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлаас үүдсэн давуу байдлыг бий болохгүй байх баталгааг төрөөс хангах шаардлагатай.

Төрийн өмчийн бус боловсролын байгууллага, тэр дундаа сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын салбарт дараах асуудалд анхаарах шаардлагатай.

- **Төрөөс төрийн бус өмчийн боловсрол болон боловсролын байгууллагын талаар баримтлах бодлого тодорхойгүй байна.** Үндсэн хуульд иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болохоор заасан. Гэвч дээрх заалтын агуулгыг хүний сурч боловсрох эрхийн үндсэн агуулгаас хөндийрүүлэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийн агуулгаар

боловсролын байгууллагын бие даасан байдлыг алдагдуулахгүйгээр төрөөс олгосон санхүүжилтийн хариуд чанартай үйлчилгээ үзүүлж, чанарын үндсэн стандартыг сайтар дагаж мөрдөхийг шаарддаг.

⁵¹ Төрөөс санхүүжилт авч байгаа хувийн хэвшлийн боловсролын байгууллагын үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх боломжийг олгох хэдий ч төр өмчийн болон хувийн хэвшлийн боловсролын эн тэнцүү байдлыг хангахыг эрмэлздэг. Солилцооны логикийн дагуу хувийн хэвшлийн боловсролын байгууллага төрөөс татаас авахын хирээр түүний үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх боломж нь хумигдана.

⁵² Зарим улс орнууд боловсролын тогтолцооны чөлөөт өрсөлдөөнийг дэмжих зорилгоор төрөөс хувийн өмчийн боловсролын байгууллагад татаас олгодог. Неолибераль онолын дагуу хувийн өмчийн боловсролын байгууллагад төрийн санхүүжилт олгох нь боловсролын салбарт хувийн хэвшлийн оролцоог идэвхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх юм. Өрсөлдөөнийг монополчлох нь сүйтгэх механизм хэмээн үздэг.

⁵³ Төрийн өмчийн сургуулийн хувийн менежмент, менежментийн өндөр түвшний бие даасан боловсролын байгууллагын хувийн нэгдлийг дэмжих загвар юм.

ойлгож, тайлбарлах төр, нийгмийн хандлага цөөнгүй ажиглагдаж байна. Энэ нь боловсролыг бизнес гэж харах, улмаар ашгийн үзэл давамгайлсан удирдлага, зохион байгуулалт төрийн өмчийн бус боловсролын байгууллагад хөгжих нөхцөлийг бүрдүүлж байна. Төрөөс хүний сурч боловсрох эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх үндсэн үүргээ биелүүлэхэд хойрго хандаж, уг орон зайг нөхөх зорилгоор хувийн өмчийн боловсролын байгууллагыг хөхиүлэн дэмжих нь хүний эрхийг хангах агуулгад харшилна. Иймд Үндсэн хуульд заасан хүний сурч боловсрох эрхийн агуулгад нийцүүлэн, боловсролын байгууллагын алдаатай тогтолцооноос үүдсэн нийгмийн тэгш бус байдлыг бууруулахын тулд төрөөс төрийн бус өмчийн боловсролын байгууллагын талаар баримтлах бодлогыг тодорхой болгох шаардлагатай.

- **Төрийн өмчийн бус боловсролын байгууллагад төрөөс санхүүжилт олгохдоо боловсролын эрх тэгш байдлыг хангах, нийгмийн эмзэг бүлгийнхэнд боловсролын хүртээмжийг дээшлүүлэх талаар ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээлгэдэггүй нь боловсролын хүрэлцээтэй, хүртээмжтэй байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байна.**⁵⁴ Төрийн бус өмчийн сургуульд төрөөс санхүүжилт олгож байгаа зорилгыг бодлогын хувьд тодорхой болгох шаардлагатай. Түүнчлэн боловсролын тэгш бус байдлыг хангах зорилгоор эцэг, эхийн эдийн засгийн боломж, нэр хүнд, чадвар, болон суралцагчийн авьяас чадварыг харж хүүхдийг элсүүлдэг, хэт ашгийн буюу арилжааны чиглэлтэй, ялгаварлан гадуурхалт гаргадаг, чанарын шаардлага хангадаггүй зэргээр эрх зүйн хүрээнд хуулиар хүлээсэн үүргээ зөрчиж байгаа ямар ч сургалтын байгууллагад төрөөс санхүүжилт, дэмжлэг олгохгүй байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.⁵⁵
- Төрийн бус өмчийн боловсролын байгууллага нь суралцагчийн тооноос хамааруулан нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдийг

⁵⁴ Сургуулийн өмнөх боловсролын салбарын дүн шинжилгээ, (2019), 93

⁵⁵ Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, “Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага: Нөлөөллийн баримт бичгийн тойм”, (2018), 10

үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр, эсхүл тэтгэлгээр суралцуулах үүргийг хуульчлах боломжийг судлах хэрэгтэй. Тухайлбал, Энэтхэг улсын 2009 онд батлагдсан Боловсролын эрхийн тухай хуулиар төрийн бус өмчийн боловсролын байгууллага нь нийт элсэн суралцагчдын 25 хувьд нь нийгмийн болон эдийн засгийн эмзэг бүлгийн хүүхдийг суралцуулахаар хуульчилжээ.⁵⁶ Дээрх зохицуулалтын үр ашиг, давуу болон сул тал, эрсдэл, хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх талаарх маргаан, мэтгэлцээн өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

- Боловсролын байгууллага суралцагчийн ололт, амжилтыг арилжааны буюу бизнесийн сурталчилгаанд ашиглах явдал цөөнгүй ажиглагдаж байна. Зөвхөн өндөр ур чадвар, гоц авьяас, потенциал бүхий суралцагчдыг элсүүлэн тусгай хөтөлбөрөөр сургах нь боловсролын тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлэх эрсдэлтэй.
- Төрөөс суурь боловсролын хүрэлцээтэй, хүртээмжтэй байдлыг хангах үүргээ өндөр төлбөртэй хувийн хэвшлийн байгууллагад даатгаж байгаа нь боловсролын салбарт нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийн эрх ноцтой зөрчигдөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг тухайн бүс нутагт сургуулийн насны хүүхдийн тооны өсөлт, төвлөрөлтэй уялдуулан нэмэгдүүлэх замаар Үндсэн хуульд заасан төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох заалтыг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай. Дээрх үйл ажиллагааг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулж, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар хувийн хэвшлийн сургуулийн хэт өсөлтийг сааруулах замаар боловсролын тэгш бус байдлыг бууруулах боломжтой.
- Сургалтын төлбөрийг гэрээ байгуулсан нөгөө тал буюу суралцагчийн эцэг, эхтэй бодитоор зөвлөлдөхгүйгээр хангалттай

⁵⁶ The Right to Education Act (India), section 12(1)(c). all schools (private, unaided, aided or special category) must reserve 25% of their seats at the entry-level for students from the Economically Weaker Section and disadvantaged groups.

үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх тохиолдол нийтлэг болж байна. Түүнчлэн, суралцагч болон тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчид урьдчилан мэдэгдэхгүйгээр, зөвшилцөхгүйгээр сургалтын бодлого, чиглэл гэх зэрэг тухайн сургуулийг сонгох гэрээ байгуулах болсон нөхцөлийг зөрчиж, алдагдуулах тохиолдол цөөнгүй гарч байна. Энэ нь шийдвэр гаргах түвшинд эцэг, эх суралцагчийн төлөөлөл огт байдаггүй, эсхүл хангалттай байдаггүйтэй холбоотой. Иймд төрийн бус өмчийн сургалтын байгууллагын суралцагчтай байгуулах гэрээний харилцаанд хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг холбогдох хуульд хуульчлах шаардлагатай. Түүнчлэн сургалтын төлбөрийн хэмжээнээс хамааран хувийн өмчийн боловсролын байгууллагад төрөөс санхүүжилт олгохгүй байхаар зохицуулах нь сургалтын төлбөрийн үндэслэлгүй хэт өсөлтийг хязгаарлах хөшүүрэг болно.

- Санхүүжилт, төсвийн зарцуулалтын илт тод байдал, түүнийг мэдээлэх үүргийг хуульчлан зохицуулаагүй нь боловсролыг хэт бизнес болох орчин нөхцөлийг бүрдүүлж байна. Боловсролын тухай хуульд хувийн өмчийн боловсролын байгууллага ашгийн болон ашгийн бус эсэхээс үл хамааран санхүүжилт, хандив туслалцаа, төсвийн зарцуулалтаа суралцагч болон тэдгээрийн эцэг, эхэд ил тод мэдээлэх үүргийг хуульчлах шаардлагатай. Харин улсаас авсан санхүүжилтийг хэрхэн зарцуулсан тухай холбогдох байгууллагад тайлагнадаг байх шаардлагатай

3. Онц байдал болон гамшгийн нөхцөлд байдлын үед хүүхэд бүрийн, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн баталгааг хангах

Ковид цар тахлын үеийн нөхцөл байдал нь Монгол улс онц байдал, нийтийг хамарсан тахал өвчний үед хүний сурч боловсрох, чанартай боловсрол эзэмших эрхийг баталгаатай, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхэд чиглэсэн ойлгомжтой, тодорхой бодлого, стратегитай байх шаардлагатай харуулж байна. Ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй, малчин болон алслагдмал газар амьдран суугаа болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн сурч боловсрох

эрхийг баталгаатай эдлүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт, бодлого, стратеги нэн шаардлагатай байна.

Бүх шатны боловсролын тухай хуульд онц байдал, гамшиг, цар тахлын үед хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрхийг тэгш, хүртээмжтэй, чанартай эдлүүлэхэд чиглэсэн тусгай зохицуулалт, тухайлбал, зайны сургалт, цахим сургалтад нийтээр шилжих, зайны сургалтад эдийн засгийн гачигдлаас үүдэн хамрагдах боломжгүй суралцагчид зайлшгүй үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон боловсролын санхүүжилтийг хамгаалах зэрэг асуудлыг зохицуулалтгүй байгаа нь сурч боловсрох эрх өргөн хүрээнд зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймээс онц байдал, нийтийн хамарсан гамшиг болон цар тахлын үед хүний, ялангуяа хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаарх төрийн захиргааны байгууллагууд (боловсрол, нийгмийн хамгаалал, мэдээлэл харилцаа холбоо, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага), боловсролын бүх шатны байгууллага, иргэний нийгмийн байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчдын эдлэх эрх, хүлээх үүрэг, бүх төрлийн нөөц, тэр дундаа санхүүгийн нөөцийг хэрхэн үр ашигтай, тогтвортой хуваарилах асуудлыг хуульчлан зохицуулах шаардлагатай.

2020 оны 8 дугаар сард НҮБ-аас гишүүн улс орнуудад хандан Ковид-19 цар тахлын үеийн боловсролын талаар дараах хариу үйлдлийг бодлогын хувьд авч хэрэгжүүлэхийг уриалсныг⁵⁷ үндэсний эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичгийг боловсруулахдаа чиглэмж болгох хэрэгтэй.

- **Вирусийн тархалтыг хумьж сургуулийн дахин нээх үйл ажиллагааг сайтар төлөвлөх.** Ингэхдээ бүх нийтийн аюулгүй байдлыг хангах, санал, дуу хоолойг сонсож, оролцоог хангах, холбогдох үндсэн оролцогчдын үйл ажиллагааг уялдуулах зэрэг хүчин зүйлийг жигд харгалзан үзэх шаардлагатай.
- **Боловсролын санхүүжилтийг хамгаалах.** Үндэсний болон

⁵⁷ UN, Policy Brief: Education during COVID-19 and beyond, August 2020. https://www.un.org/development/desa/dspd/wp-content/uploads/sites/22/2020/08/sg_policy_brief_covid-19_and_education_august_2020.pdf

олон улсын байгууллага нь боловсролын салбарт зарцуулах дотоодын нөөцийг нэмэгдүүлэх, боловсролын зардлын эзлэх хувийг тэргүүлэх чиглэл болгон хадгалах, зардлын үр ашиггүй байдлыг шийдвэрлэх, өрийн хямралыг шийдвэрлэх олон улсын санхүүжилтийг шийдвэрлэх, боловсролын хөгжлийн албан ёсны тусламжийг хамгаалах

- **Тэгш байдал, тогтвортой хөгжлийг хангахын тулд боловсролын уян хатан тогтолцоог бий болгох.** Боловсролын системийн уян хатан байдлыг бэхжүүлэх нь улс орнуудад сургуулиудын аюулгүйгээр нээхэд тулгарч буй тулгамдсан асуудлын талаар хариу арга хэмжээ яаралтай хэрэгжүүлэх, асуудлыг амжилттай шийдвэрлэх боломж олгоно. Боловсролын тэгш байдал, оролцоо, системийн бүх түвшинд эрсдэлийн менежментийн чадамжийг нэмэгдүүлэх, хүчирхэг манлайлал, зохицуулалт, зөвлөлдөх болон харилцаа холбооны механизмыг хөгжүүлэх чиглэлд Засгийн газар анхаарах ажиллах шаардлагатай.
- **Боловсролыг дахин зураглаж, багшлах болон суралцах үйл ажиллагааны өөрчлөлтийг эрчимжүүлэх.** Боловсролын тогтолцоонд үүссэн тогтолцооны хямрал, цочролыг аль болох хурдан хугацаанд шийдвэрлэх бодлого, стратегийн олон хувилбарыг боловсруулах шаардлагатай. Сургалтын хоцрогдлыг арилгах, нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн багшлах боловсон хүчний асуудал, суралцах үйл ажиллагаанд дүн шинжилгээ, мэдээлэл цуглуулах, сургалтын бүх түвшинд уян хатан байдлыг нэмэгдүүлэх.

Ийнхүү боловсролын тогтолцооны хямралыг шийдвэрлэх үндсэн арга нь зайны сургалт буюу цахим сургалт бөгөөд зайны сургалтын тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангахын тулд дараах үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай.

- Холбоо харилцааны тогтвортой, найдвартай дэд бүтцийг бий болгох

- Суралцагчдад ээлтэй, аюулгүй сургалтын орчинг дээд түвшинд бүрдүүлэх
- Сургалтын цахим хэрэглэгдэхүүн, мэдээллийг сурвалжийг бүрдүүлэх
- Суралцагчийг цахим орчны сөрөг нөлөө, хүчирхийлэл, аюул, заналхийллээс хамгаалах
- Зайны болон цахим сургалтад боломжгүй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг үр дүнтэй хангах хувилбарт бусад арга хэрэгслийг хүүхдийн онцлогт нийцүүлэн бий болгох.

4. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрх

Боловсролын хүрэлцээтэй, хүртээмжтэй байдлыг хангахад хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй, хүчирхийллээс ангид орчин, нөхцөлийг бүрдүүлэх асуудал чухлаар хөндөгддөг. Монгол улсад уг эрхийг боловсролын багц хууль, хүүхэд хамгааллын хууль тогтоомжоор тусгайлан хамгаалсан бөгөөд Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр,⁵⁸ Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт (MNS 6782:2019), Хүүхдийн тоглоомын талбайн стандарт (MNS 6751:2019), Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм гэх зэрэг актаар нарийвчлан зохицуулж байна. Гэвч хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх асуудал чухлаар яригдаж байгаа бөгөөд нэн ялангуяа дараах асуудалд анхаарч, шийдвэрлэх шаардлагатай.

❖ **Боловсролын байгууллагын барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, орны стандарт.** 2012 онд цэцэрлэгийн 51 барилга, 27 сургуулийн барилга ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь мэргэжлийн байгууллага дүгнэлтээр тогтоогджээ.⁵⁹ Зөвхөн нийслэлийн төрийн өмчийн 230 цэцэрлэгийн 42 цэцэрлэгийн барилга 50-аас дээш жилийн насжилттай буюу ашиглалтын хугацаа дууссан, 37 цэцэрлэгийн барилга 36-49 жил болж байгаа⁶⁰ тоо баримт байна. Гэвч дээрх барилгуудыг

⁵⁸ Засгийн Газрын 2017 оны 279 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр

⁵⁹ <https://aboutbarilga.mn/n.2146>

⁶⁰ Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Төлөвлөлт, судалгааны хэлтэс, Цэцэрлэгийн хүртээмж, төлөвлөлт, 2019 он www.ikon.mn

нурааж, ашиглалтын шаардлага хангасан барилга шинээр барих санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлээгүйгээс олон хүүхдийн амь насаа алдах өндөр эрсдэлтэй байна. Ялангуяа газар хөдлөлтийн бүс байнга эрчимжиж байгаа нь байдлыг улам бүр ноцтой болгож байна.⁶¹ Иймээс ашиглалтын шаардлага хангахгүй сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай. СӨБ болон ерөнхий боловсролын сургуулийн орчны газрын асуудалд онцгой ач холбогдол өгч газрын хэмжээг багасгахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй. Нийслэлийн төрийн өмчийн 230 цэцэрлэгээс хот төлөвлөлтийн шаардлага, дүрмийн дагуу газартай 32, норм дүрмээс бага газартай 196, эзэмшил газаргүй 2 цэцэрлэг газаргүй⁶² байгаа боловсролын хүрэлцээтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байдалд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийн хил залгаа барилга, байгууламж барих нь орчны дуу чимээ, тоосжилт, аюултай байдлын түвшинг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, цонх хааж барилга барьснаас нарны тусгалын хангамжийн таларх барилгын норм, дүрэм⁶³ зөрчигдөж хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

- ❖ **Боловсролын орчинд үйлдэгдэх хүүхдийн эсрэг хүчирхийлэл.** Боловсролын салбарт үйлдэгдэж байгаа хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь нийгмийн эрүүл мэнд, сайн сайхан байдал, эрүүгийн хэргийн гаралт, хүүхдийн ирээдүйн хөдөлмөр эрхлэлт, орлогын байдал, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход ноцтой үр дагавар учруулахын зэрэгцээ эдийн засгийн үргүй зардлыг нэмэгдүүлдэг болохыг бүс нутгийн судалгаанд⁶⁴ онцолжээ.

⁶¹ Зөвхөн нийслэлийн хэмжээнд 2005 онд газар хөдлөлт 308 байсан бол энэ тоо 2009 онд 508, 2012 онд 542 болж өсжээ. У.Ендон, Ашиглалтын хугацаа дууссан барилгуудаас сургууль цэцэрлэгүүдийг гаргахад өчнөөн зовлон бий. <http://www.barilga.mn/n/5882/>

⁶² Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Төлөвлөлт, судалгааны хэлтэс, Цэцэрлэгийн хүртээмж, төлөвлөлт, 2019 он www.ikon.mn

⁶³ Монгол Улсын барилгын норм ба дүрэм, Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж, Барилга, хот байгуулалтын сайдын 2007 оны 179 дүгээр тушаалаар батлагдсан.

⁶⁴ UNICEF Regional Office for South Asia, *Violence against children in Education Settings in South Asia: A Desk Review*, (2016) 41.

Хүүхдийн эрхийн тухай хуульд аливаа хүчирхийллээс ангид байх, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие мах бодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхийг өргөн хүрээнд хамгаалсан. Гэвч хүүхдийн эсрэг хүчирхийллийн дараах асуудалд бодлого, эрх зүйн зохицуулалтын хувьд анхаарах шаардлагатай.

- Үе тэнгийн хүчирхийлэл, дарамт: Сургуулийн орчин болон сургуулийн дотуур байранд үе тэнгийн сурагчдын хүчирхийлэл, дарамт, шахалт өндөр байгааг хэд хэдэн судалгаанд⁶⁵ дурджээ. Боловсролын тухай багц хуульд үе тэнгийн хүчирхийлэл, дарамт, шахалтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаарх боловсролын байгууллагын хүлээх үүргийг нарийвчлан зохицуулаагүй. Харин БСШУС-ын сайдын 2018 оны А/239 тоот тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”-ыг баталсан нь ихээхэн ач холбогдолтой болжээ. Уг журмын дагуу боловсролын байгууллага нь ялгаварлан гадуурхалт, ялгаатай байдлын талаарх хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан ажиллах, түүнчлэн аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтээс өөрийгөө болон бусдыг хамгаалах сэтгэл зүйн бэрхшээлийг даван туулах чадвар олгохоор заасан⁶⁶ хэдий ч журмын биелэлт, хэрэгжилтийн талаарх судалгаа, тайлан мэдээ олдсонгүй. Цаашид үе тэнгийн хүчирхийлэл, дарамт, шахалтыг сургуулийн орчинд бүрэн таслан зогсоож, урьдчилан сэргийлэх, хүүхдэд суралцах эрүүл, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаарх боловсролын

⁶⁵ Хүүхдийг ивээх сан, Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ (2018), 102.

⁶⁶ БСШУС-ын сайдын 2018 оны А/239 тоот тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”-ын 3.1.4, 3.1.5

байгууллагын үүргийг тодорхой болгож, нийтлэг удирдамжаар хангах зэрэг ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэрэв боловсролын байгууллага энэхүү үүргээ шударгаар, хангалттай хэмжээнд биелүүлээгүй тохиолдолд хохирогч хүүхдэд учирсан хохирлыг тухайн боловсролын байгууллага буюу төр хариуцах зохицуулалтыг хуульчлах нь хяналт, хариуцлагын тогтолцоог эрчимжүүлж, хуулийн хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

- Багшийн хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт: Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлд багш суралцагчийн бие махбодод халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглосон боловч ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд шуурхай таслан зогсоох, хүчирхийлэлд өсөн хүүхдэд сэтгэл санааны болон бусад шаардлагатай дэмжлэг, хүүхэд хамгааллын үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан хуулийг уг хуулиар тусгайлан зохицуулаагүй. Зөрчлийн тухай хуульд сургууль, сургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, асрамж халамжийн төв хүүхэд хамгааллын төв болон хүүхдэд үйлчилгээ явуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн эрх зөрчигдсөн бол иргэн, хуулийн этгээд торгох шийтгэл ногдуулахаар хуульчилсан. Хүүхдийн эрхийг удаа дараа ноцтой зөрчсөн багш, боловсролын байгууллагын ажилтныг боловсролын байгууллагад дахин ажиллах эрхийг хязгаарлах гэх мэт үр нөлөө бүхий хариуцлагыг шинэ төрлийг бий болгох талаар судалгаа хийх хэрэгцээ байна. Хэдийгээр эрх зүйн хамгаалалтын орчин зохих хэмжээд бүрдсэн хэдий ч хүүхдийг зодож шийтгэх, нэр төрийг нь гутаан доромжлох, цаашлаад бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн тохиолдол боловсролын байгууллагад гарсаар байна. Иймээс холбогдох хууль шийдвэрийн хэрэгжилтэд үндэсний хэмжээнд дүн шинжилгээ, мониторинг хийж, хяналт шалгалтыг тогтмолжуулах зайлшгүй хэрэгцээ ажиглагдаж байна.

Дүгнэлт

Иргэний сурч боловсрох эрхийн баталгааг хангах нь эдийн засаг, нийгмийн системт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх урт хугацааны үр дүнтэй арга хэрэгсэл, хүний бусад эрх баталгаагаар хангагдах суурь нөхцөл юм. Иргэний сурч боловсрох эрхийн баталгааг хангах эрх зүйн орчин нөхцөл боломжийн түвшинд бүрдсэн хэдий ч төсөв санхүүжилтийн тогтвортой бус байдал, тэгш бус-оновчтой бус хуваарилалт, зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах механизм, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй, боловсролын зарим асуудалд төрөөс баримтлах бодлого тодорхойгүй, ойлгомжгүй, хүний эрхэд үндэслэсэн төр болон хувийн хэвшлийн үр нөлөөтэй хамтын ажиллагаа бүрдүүлээгүй, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого нь нийгэм, эдийн засгийн эмзэг бүлэгт үр дүнтэй хүрч чаддаггүй, боловсролын удирдлага болон төрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай байнга шинэчлэгддэг мэдээллийн нэгдсэн сан хангалттай бүрдээгүй, боловсрол, нийгмийн хамгаалал, барилга, хот байгуулалт зэрэг салбар хоорондын мэдээлэл солилцоо, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаа нь хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

С.СЭЛЭНГЭ

БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ⁶⁷

НЭГ. БОЛОВСРОЛ ДАХЬ ТЭГШ ХАМРУУЛАЛТ НЬ ЗАЙЛШГҮЙ БӨГӨӨД БҮХ НИЙТИЙН ҮЙЛ ХЭРЭГ БОЛОХ НЬ

Технологийн эрс хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, зөрчил мөргөлдөөн, албадан нүүлгэн шилжүүлэлт, ковид 19 цар тахал зэрэг дэлхийн улс орнуудад шинэ сорилтыг бий болгосон нөхцөлд шинэ үеийнхэн үл тэвчихүй, үзэн ядалт, тэгш бус байдлаас зайлсхийж, эв нэгдэл, хүндэтгэл, хамтаараа баяр жаргалтай оршин тогтноход бага наснаасаа эхлэн боловсролд тэгш хамран сурсан байх нь хамгаас чухал болохыг олон улсын хөгжлийн чиг хандлага, боловсролын судалгаануудын үр дүн батлан харуулж байна.

Иймд хүүхэд бүрийг тэдний ялгаатай шинж байдал, нийгмийн гарал үүсэл эсвэл чадвараас нь үл хамааран боловсролд тэгш хамруулан сургах зарчмын үндсэн дээр боловсролын багц хуулиудаа боловсруулах хэрэгцээ шаардлага байна.

Боловсролын бодлогын баримт бичгүүдэд боловсролын ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрүүлэх, үл ялгаварлан гадуурхах гэх мэт олон зохицуулалтыг тусгах, санхүүжилтийг нь шийдвэрлэх хэрэгцээ шаардлага байна.

1. Тэгш хамралт нь БҮХ НИЙТЭД ХАМААТАЙ.

Боловсрол дахь тэгш хамруулалт гэдэг нь суралцагч бүр өөрийг нь үнэлж, хүндэтгэж байгааг мэдэрч сургуульд хамааралтай гэсэн тодорхой мэдрэмж авах явдлыг хангах үйл явц юм. Энэхүү зорилгод хүрэхдээ зөвхөн нийгмийн маргинал бүлгийн эрх ашигт төвлөрсөн зарчим мэтээр хязгаарлагдмал утгаар ойлгогдох хандлага түгээмэл байдаг. Гэвч энэ нь зөвхөн тодорхой нэг бүлгийн асуудлыг хөндсөн бус, бүх нийтэд боловсролыг

⁶⁷ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал С.Сэлэнгэ боловсруулав. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.apdc.mn хуудас руу хандана уу.


хүртээмжтэй болгоход чиглэсэн хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлсэн зарчим юм.

2. Тэгш хамралт бол ҮЙЛ ЯВЦ юм.

Хүүхэд бүрийн сурч боловсрох хэрэгцээг хангахад баримтлах суурь ойлголт нь боловсролд тэгш хамруулан сургах зарчим билээ. Бүх хүүхэд өөрийн тусгай хэрэгцээндээ нийцсэн дэмжлэг туслалцаатайгаар үе тэнгийнхэнтэйгээ хамт, адил тэгш суралцах боломжоор хангагдаж байх боловсролын үйл явц юм.⁶⁸

3. Боловсролын ялгаатай хэрэгцээг харгалзан үзэх нь ХҮНИЙ ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХҮНДЭТГЭН, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛГҮЙ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЖ БУЙ ХЭРЭГ.

Боловсролын тогтолцоо бүхэлдээ бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг, хүн бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, сурагч бүр өөрийн мэдлэг чадвараа ахиулан амжилттай суралцах боломжтой сургалтын орчныг бүрдүүлэх нь боловсролын гол зорилго байх ёстойг харуулж байна.



Боловсролын хувьд тэгш боломжийг тодорхойлохын тулд 'тэгш байдал-equality' ба 'тэгш боломж-equity' хоёрын ялгааг тодорхойлох шаардлагатай юм. Тэгш байдал гэдэг нь аливаа үйлийн нөхцөлт байдал юм (юу): орц буюу нөөц, гарц буюу анхдагч үр дүн эсвэл дам үр дүнд ажиглагдаж болох ямарваа нэгэн үр дүн юм. Тэгш боломж бол үйл явц юм (хэрхэн яаж): тэгш байдлыг баталгаажуулахад чиглэсэн үйл хэрэг юм.


Суралцагчдыг боловсролын тогтолцоонд тааруулахыг хичээхээс илүүтэйгээр хүн нэг бүрд таарсан хариу үйлдлийг боловсролын тогтолцоо үзүүлэх ёстой.

⁶⁸ Save the Children, Inclusive Education Handbook

4. Боловсролд Тэгш хамруулахад хэнийг ч ялгаварлан гадуурхаж үл болно.

Ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголт, хөндийрүүлэлт нь олон хүнийг үл хамрагдахад хүргэж байна. Үл хамруулах тэдгээр механизм нь жендер, байршил, эд баялаг, хөгжлийн бэрхшээл, угсаа, хэл, шилжилт, нүүлгэн шилжүүлэлт, бэлгийн чиг баримжаа, эдэлсэн ял, шашин шүтлэг болон бусад итгэл үнэмшил, хандлагаас үл хамааран мөн чанартаа ижил байдаг.

Боловсролд тэгш хамруулан сургах нь боловсролын салбарын урт хугацааны бодлого, түүний хэрэгжилт бөгөөд **боловсролын хүртээмж, оролцоо, сургалтын үр дүнгийн ялгаатай болон тэгш бус хандлага, ялгаварлан гадуурхалт, хязгаарлагдмал байдлын бүх хэлбэрийг шийдвэрлэхэд** бүх оролцогч талууд өөрөөр хэлбэл салбар дундаа тасралтгүй хамтран ажиллах үйл явц юм.



“**Гадуурхалт**” гэдэгт суралцагчид шууд болон шууд бусаар ямар нэгэн хэлбэрийн боловсрол эзэмшүүлэхээс татгалзах эсвэл элсүүлэхгүй байхыг ойлгоно.

“**Тусгаарлалт**” гэж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэдний тодорхой нэг согог эсвэл хэд хэдэн төрлийн нийлсэн согогт хариу үйлдэл үзүүлэх байдлаар зохион байгуулсан тусгай орчинд хөгжлийн бэрхшээлгүй суралцагчдаас тусад нь боловсрол олгохыг хэлнэ.


“Интеграци буюу Нэгтгэн сургах” гэдэгт нийтэд зориулсан боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг стандартчилсан шаардлагад нийцэн сурч чадна гэж ойлгон байршуулахыг ойлгоно.”⁶⁹

“Тэгш хамруулан сургах” гэдэгт тухайн насны бүх суралцагчдыг (1) эрх тэгшээр хамтдаа суралцах туршлагатай болгож, (2) тэдний давуу тал болон тавигдах шаардлагад хамгийн дээд зэргээр тохирсон орчныг бий болгож үйлчилнэ гэсэн алсын харааг хэрэгжүүлэхэд учрах саад тотгорыг даван туулахын тулд (а) боловсролын агуулга, (б) заах арга, (в) хандлага-арга зүй, (г) бүтэц, (д) стратегидаа тодруулга өөрчлөлт, цогц өөрчлөлт оруулах замаар тогтолцооны шинэчлэл хийх үйл явцыг багтаана.⁷⁰

ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сургуулийн өмнөх боловсролын 1435 байгууллагад 2018-2019 оны хичээлийн жилд нийт 261,354 хүүхэд хамрагдсаны 0,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ) байна. Цэцэрлэгийн тоо жил бүр тогтмол нэмэгдэж байгаа хэдий ч түүнд хамрагдаж байгаа ХБХ сүүлийн нэг жилийн хугацаанд огцом буурсан⁷¹. Монголд хүн амын 4 орчим хувь хөгжлийн бэрхшээлтэй байхад СӨБ суралцагчдын 0.4% хөгжлийн бэрхшээлтэй, 9/10 нь СӨБ-ын гадна.

Зураг 2 (Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй ХБХ-ийн тоо)




⁶⁹ НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн Хорооноос Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн тухай Конвенцийн 4-р Ерөнхий зөвлөмж, Тэгш хамруулах боловсрол, 2016 он

⁷⁰ Мөн тэнд

⁷¹ Сургуулийн өмнөх боловсролын салбарын статистик, БСШУЯ, 2012-2018

Зураг 3 (Сургуульд хамрагдаж буй ХБХ-ийн тоо, БСШУСЯ, 2012-2018)



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ЕБС-д хангалтгүй түвшинд хамрагдаж байгаагийн шалтгаан:

- o Монгол Улсад боловсролын тусгай хэрэгцээг тодорхойлох, тусгай хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээ авах тухай хангалттай зохицуулалт байхгүй.
- o Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах багш нарын бэлэн байдлыг үнэлэх судалгааны дүнгээс харахад ердийн сургуулиудын багш нарын 88% нь Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллахад хангалттай бэлтгэгдээгүй.⁷²

Сургуулиас завсардах эрсдэлд буй бүхий л суралцагчид ялгаварлан гадуурхалт, хуучны хэвшмэл үзэл, доромжлолын хувьд ижил төстэй нөхцөлд байна. Улс орнуудын 68% нь тэгш хамруулах боловсролын талаарх тодорхойлолттой бөгөөд эдгээрийн ердөө 57% нь хэд хэдэн эмзэг болон гадуурхагдсан бүлгийнхнийг хамруулсан байна.⁷³


Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллээр 2018-2019 оны хичээлийн жилд сургууль завсардсан 759 хүүхэд байна. Тэдгээр хүүхдүүдийн ойролцоогоор 70 орчим хувь нь өмнө нь огт сургуульд хамрагдаж байгаагүй, үлдсэн хувь нь сургуульд суралцаж байгаад завсардсан хүүхдүүд байна.⁷⁴

⁷² "Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь" төсөл, Судалгааны тайлан, АХБ, IRIM, 2019

⁷³ Боловсролын хяналт - шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй, Тэгш хамралт ба боловсрол, ЮНЕСКО, 2020

⁷⁴ Боловсролын салбарын танилцуулга 2018. Үндэсний статистикийн хороо

Зураг 4 (Сургууль завсардсан хүүхдүүдийн тоон мэдээлэл)



Насны хувьд сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь 6-10 насны хүүхдүүд байгаа нь бага боловсролын түвшинд завсардалт илүү их байгааг харуулж байна.⁷⁵

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2018 онд гүйцэтгэсэн баримт бичгийн судалгааны дүнгээр нийт сургууль завсардсан хүүхдүүдийн хувьд сургууль завсардахад хүргэсэн гол шалтгаанд (1) хөгжлийн бэрхшээл түүнээс үүдсэн эрүүл мэндийн нөхцөл байдал, 2) ар гэрийн гачигдал, ядуурал зэрэг шалтгаанууд дурдагджээ.

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулаад) сургууль завсардалтын гол шалтгаан нь 1) Ар гэрийн санхүүгийн боломжгүй байдал, эцэг эхийн анхаарал халамж сул, 2) Сургуулийн дэд бүтэц, анги танхим, сургалтын материалын хүрэлцээ, хүртээмжгүй байдал, 3) Хөгжлийн бэрхшээлээс үүдсэн эрүүл мэндийн нөхцөл байдал нөлөөлдөг хэмээн хариулжээ.⁷⁶

Боловсролд тэгш хамруулан сургахад тулгарч буй гол бэрхшээл нь тэгш хамруулахыг боломжтой, зайлшгүй шаардлагатай зүйл гэдэгт итгэх итгэл дутмаг байгаа явдал юм.

Ахиц дэвшил гарч байгаа ч боловсролын үйлчилгээний гадна үлдэж буй бүлгийнхний талаарх тоо баримт, мэдээллийг цуглуулах, тайлагнах эсвэл хэрэглэх явдал олон улс оронд хангалтгүй хэвээр байна. Нийт улс орны 41% буюу дэлхийн нийт хүн амын 13%-ийг төлөөлж буй эдгээр орнууд нь 2015 оноос хойш боловсролын үндсэн үзүүлэлтүүдээр нарийвчилж гаргасан тоо баримт, мэдээллийг олон

⁷⁵ "Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдийг илрүүлэх" Судалгааны тайлан, НТБҮТ, 2019

⁷⁶ "Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь" төсөл, Судалгааны тайлан, АХБ, IRIM, 2019

нийтэд нээлттэйгээр тайлагнах өрхийн түвшний судалгаагүй байна; Хөгжлийн бэрхшээлийн талаарх Вашингтон бүлгийн богино асуумжаар гаргасан 14 улсын саяхны тоо баримтаас харахад сургуулийн гадна буй хүүхдүүдийн 15%-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эзэлж байна.⁷⁷ Үр дүнтэй бодлого боловсруулах, тэгш хамруулсан, чанартай боловсролыг хөхиүлэн дэмжих арга хэмжээг авахад саад болдог нарийвчилсан задаргаатай тоон мэдээлэл, судалгаа хангалтгүй байна.

Санхүүжилтийг хамгийн их хэрэгцээ шаардлагатай нийгмийн бүлэгт онцгойлон зориулах хэрэгтэй. ЭЗХАХБ-ын гишүүн 32 орнуудын ихэнх нь нийгэм-эдийн засгийн хувьд эмзэг сургууль, ангиуд нь мэргэшлийн хувьд доогуур түвшний багш нартай байх нь илүү түгээмэл байна. Дөрвөн улс тутмын нэг нь эмзэг бүлгийнхнийг дээд боловсрол эзэмшихэд нь туслах үйл ажиллагааны зохистой хөтөлбөр хэрэгжүүлж байна. Бага, бага-дунд орлоготой улсуудын 40 орчим хувь нь КОВИД-19 хямралын үеэр сургууль завсардах эрсдэлтэй байгаа суралцагчдыг дэмжих арга хэмжээ аваагүй байна.⁷⁸

Багш нар, сургалтын материал, суралцах орчин нь олон талт ялгаатай шинж байдлыг хүлээн зөвшөөрч, дэмжихийн үр ашгийг ихэвчлэн үл ойшоодог.

Багш нарын 25 орчим хувь нь тусгай хэрэгцээт суралцагчидтай ажиллах чиглэлээр мэргэжил дээшлүүлэх шаардлага байна гэдгээ 48 улс илэрхийлжээ. Дэлхий нийтэд ердөө 41 улс дохионы хэлийг албан ёсны хэл хэмээн хүлээн зөвшөөрсөн байна. Европын 49 орны 23 нь бэлгийн чиг хандлага болон жендерийн өвөрмөц шинж чанарыг сургалтын хөтөлбөртөө тодорхойлон тусгаагүй байна.

ГУРАВ. БОЛОВСРОЛЫН БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХТАЙ ХОЛБООТОЙ ОРУУЛАХ САНАЛ

Монгол Улсад тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих бодлого, эрхзүйн орчин бүрдүүлэх ажлуудад багагүй ахиц гарч байна. Гэвч

⁷⁷ Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан, “Тэгш хамралт ба боловсрол”, ЮНЕСКО, 2020

⁷⁸ Мөн тэнд

эрхзүйн зохицуулалт, дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлэхэд санхүү болон хүний нөөцийн хүрэлцээ, бодлогод салбар дундын болоод сургалтын байгууллага доторх зохицуулалт дутагдалтай байсаар байна. Үүнээс гадна боловсролын гол оролцогч талуудын дундах хөгжлийн бэрхшээл, тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт зөрүүтэй хэвээр байгаа нь бодит байдал дээр тэгш хамруулан сургах практикийг үр дүнтэй нэвтрүүлэхэд хүндрэл учруулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхаж байгаа одоогийн хууль, зохицуулалт, уламжлал, өдөр тутамд хийж хэвшсэн үйл ажиллагааг өөрчлөх эсвэл арилгах нь БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ-ийн зорилго байх ёстой.

Иймд тэгш хамруулахын тулд дараах эрхзүйн зохицуулалтыг хуульд тусгаж, боловсролын бодлогыг боловсруулах хэрэгтэй байна.

БОЛОВСРОЛЫН БАГЦ ХУУЛЬД ОРУУЛАХ САНАЛ: ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХАД БҮХ НИЙТ РҮҮ ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ.

Хүүхэд өсөж том болохын хэрээр цаашид тасралтгүй суралцаж, хөгжих сууриа бий болгоход нь чухал үүрэгтэй СӨБ, бага боловсролын үйлчилгээний хүртээмж чухал болж ирнэ.⁷⁹

(А) Бүх хүүхдүүд бие биеийнхээ ялгаатай байдлыг үнэлж хүндэтгэсэн орчныг бий болгох бодлогын зохицуулалт хэрэгтэй: Суралцаж байгаа хамт олны гишүүн бүр хөгжлийн бэрхшээл арьс үндэс, өнгө, хүйс, хэл, угсаатны соёл, шашин, улс төрийн болон бусад байр суурь, үндэсний, угсаатны, уугуул эсвэл нийгмийн гарал, өмч, төрсөн байдал, нас, бусад нөхцөлөөс үүдэлтэй ялгаатай байдлыг ойлгон хүлээн авч, эн тэнцүү үзэж хүндэтгэх ёстой. Бүх суралцагч өөрсдийг нь үнэлж, хүндэтгэж, татан оролцуулж, сонсож байгааг мэдрэх ёстой. Тухайн газарт дарамт хүчирхийлэл, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг авсан байвал зохино. Тэгш

⁷⁹ EFA Global monitoring report UNESCO, 2006, Facts for life, NY, WHO, UNESCO, World bank, 2010

хамруулах нь суралцагч хувь хүн нэг бүрд чиглэсэн хандлага баримтлахыг хэлдэг;

(Б) Суралцахад таатай орчин хэрэгтэй: Тэгш хамруулсан суралцах орчин нь хүн бүр өөрийгөө аюулгүй, дэмжлэгтэй, урамшуулж байгааг мэдэрч, өөрийгөө илэрхийлж чаддаг хүртээмжтэй орчин байх бөгөөд сургуулийн эерэг хамт олныг бий болгоход суралцагчдаа онцгойлон анхаарч оролцуулдаг. Үе тэнгийнхэн хэсэг бүлгээрээ суралцах, эерэг харилцаа тогтоох, нөхөрлөх, нэг нэгнээ ойлгож хүлээж авах нь илүү байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй;

(В) Үр дүнтэйгээр шилжих хэрэгтэй: Боловсролын ялгаатай хэрэгцээтэй түүн дундаа Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид суралцаж байгаа сургуулиасаа мэргэжлийн, дээд боловсрол эзэмшихээр, эцэст нь ажиллахаар шилжихийг үр дүнтэй болгох үүднээс тодорхой дэмжлэг байх хэрэгтэй болдог. Суралцагчдын чадавх, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, тэднийг үнэлэх, шалгах дүрэм журамд адил тэгш хандаж, харилцаж, тэдний хүрсэн чадвар чадамж, амжилтыг бусадтай адил тэгш үзэж батламжлах ёстой;

(Г) Түншлэлийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй: Багш нарын холбоо, сурагчдын холбоо, нэгдсэн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, сургуулийн зөвлөл, эцэг эх-багшийн холбоо, бусад сургуулийг дэмждэг албан болон албан бус шинжтэй бүлгийн зүгээс хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжвэл зохино. Эцэг эх, асран хамгаалагч, нутгийн олныг татан оролцуулах нь нөөц, давуу талаа дайчлан хувь нэмрээ оруулах боломж гэж тооцогддог. Суралцах орчин болон орон нутгийн өргөн олны хоорондын харилцаа нь тэгш хамруулсан нийгмийг бий болгоход хүргэх зам гэж хүлээн зөвшөөрөх ёстой;

(Д) Хяналт мониторинг хийх хэрэгтэй: Тасралтгүй үргэлжлэх үйл явцын хувиар тэгш хамруулах боловсролыг тусгаарлаж эсвэл

нэгтгэн сургахад албан болон албан бус байдлаар хүргэхгүй байх үүднээс байнга мониторинг хийж, үнэлэх ёстой. Конвенцын 33 дугаар зүйлийн дагуу мониторинг хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг, тэр дундаа хүүхэд, маш ихээр дэмжлэг шаардлагатай хүмүүсийг тэдний төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцуулах ба шаардлагатай үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх эсвэл асран хамгаалагчийг оролцуулна. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хамруулсан талаарх шалгуур үзүүлэлтийг Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулж, ашиглах ёстой байна.

Үүний тулд доорх дөрвөн чиглэлээр бодлогын зохицуулалт хийгдсэн байх ёстой.

1. Тэгш хамруулан сургахад бүх нийт рүү чиглэсэн сургалтын байгууллагуудын бодлогын зохицуулалт хийх хэрэгтэй.
2. Тэгш хамруулан сургахад зорилтот бүлэг рүү чиглэсэн бодлогын зохицуулалт чухал.
3. Тэгш хамруулан сургахад ганцаарчилсан дэмжлэгийн арга хэмжээг авах бодлогын зохицуулалт шаардлагатай.
4. Сурч боловсрох эрхийн зөрчлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах зохицуулалт шаардлагатай

1. ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХАД БҮХ НИЙТ РҮҮ ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ХЭРЭГТЭЙ.

Боловсролын байгууллагууд боловсролд тэгш хамруулан сургахдаа дараах 3 хүрээнд анхаарлаа хандуулан ажиллах ёстой.

- Тэгш хамруулсан соёлыг сургалтын байгууллагад бий болгох
- Тэгш хамруулсан бодлогыг баримталж ажилладаг сургалтын байгууллага байх
- Тэгш хамруулсан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг сургалтын байгууллага байх

Тэгш хамруулах соёлын хүрээнд - Тухайн сургуульд бүх хүүхэд аюулгүй, хүлээн зөвшөөрөгдсөн, хамтач найрсаг орчин, соёл, үнэт зүйл төлөвшсөн эсэхийг авч үзсэн. Ингэхдээ тухайн сургуулийн орчинд хүүхэд бүр өөрийнхөө боломжит дээд хэмжээнд хүртэл суралцах, хөгжих боломжтой, хүүхэд бүр өөрийнхөө үнэ цэнийг мэдэрдэг орчин бүрдсэн байх нь чухал.

Зорилтот орон нутаг дахь цэцэрлэг, сургуулиудад тэгш хамруулсан соёлын орчин бүрдсэн эсэхийг үнэлэхэд СӨБ-ийн соёлын орчин 18.8 хувь, ЕБС-ийн соёлын орчин 1.4 хувьтай гарчээ. цэцэрлэг болон сургуулийн орчинд бүх хүүхдийг тэгш хамруулан сургах соёлын орчин бэлэн биш байгааг харуулж байна.⁸⁰

Тэгш хамруулах сургуулийн бодлогын хүрээнд - Сургуулийн дотоод бодлого, журам, төлөвлөгөө нь бүх ажилтан болон суралцагчийн оролцоог сургуульд элсэн орсон цагаас эхлэн дэмжих, хүүхэд бүрд хүрч ажиллах, ялгаварлан гадуурхалтыг хамгийн бага түвшинд байлгахад чиглэсэн эсэхийг тодорхойлсон.⁸¹

Тэгш хамруулах практик туршлагыг сургууль дээрээ бий болгох хүрээнд - Сургууль дээр дурдсан тэгш хамруулах зарчмыг дэмжсэн бодлого, соёлын хүчин зүйлээ үйл ажиллагааны хэрэгжилтдээ хэрхэн

Сургууль, цэцэрлэгт хамтын соёл бүрдсэн байдал:

- Хүн бүр бие биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг эсэх
- Багш нар хүүхэд бүрийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж найрсаг харилцдаг эсэх
- Хүүхдийн суралцах боломжийг хангасан аюулгүй орчинд суралцдаг эсэх
- Хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг эсэх
- Сургуулийн багш, ажилчид хүүхдийг бие биедээ туслахыг дэмждэг эсэх
- Багш нар бүх хүүхдэд адил тэгш, шударга ханддаг эсэх
- Сургууль мэргэжлийн өндөр ёс зүйтэй, хүүхдээ даатгаж болохуйц үлгэр жишээ багш нартай эсэх
- Сургууль нь хүүхдүүдэд маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг үлгэрлэдэг эсэх
- Багш нар хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажилладаг эсэх

⁸⁰ "Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь" төсөл, Судалгааны тайлан, АХБ, IRIM, 2019

⁸¹ "Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь" төсөл, Судалгааны тайлан, АХБ, IRIM, 2019

буулгаж, ханган ажиллаж байгааг тодорхойлсон. Тухайлбал, багш хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн ажиллаж чаддаг эсэх, сурагчдын ялгаатай байдал, хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулдаг эсэх, хүүхэд бүр сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог эсэх нь гол шалгуур болно.⁸²

БОДИТ БАЙДАЛ: Тэгш хамруулах соёлын орчны хүрээнд:

- Олон талын ялгаатай, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг хүлээж авах, нэг хамт олон болох тэгш хамруулах үнэт зүйлийн төлөвшил төслийн зорилтот цэцэрлэг, сургуулийн хэмжээнд маш сул байна.
- Цэцэрлэгт илүү бие махбодын бэрхшээлүүд болох хараа, сонсгол, хөдөлгөөн, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд соёлын орчны таагүй нөлөөллийг мэдэрдэг бол сургуулийн хувьд бусадтай нөхөрлөх, харилцаа холбоо тогтоох, суралцах, аливаа зүйлийг тогтоох, сэргээн санах зэрэг танин мэдэхүй, харилцааны чадвар султай хүүхдүүд соёлын орчны таагүй нөлөөллийг мэдэрдэг байна.
- Хүүхдүүдийн дунд хувь хүний нууц болон эд зүйлсэд хүндэтгэлтэй хандах байдал сургуулийн соёлын орчинд хамгийн хангалтгүй үр дүнтэй гарчээ.

Тэгш хамран сургах боловсролын бодлого нь нийгмийн бүх салбарын оролцоотойгоор хэрэгжүүлэх, хүлээх үүрэг, хариуцлагын нэгдэл юм. Тухайлбал, орон нутгийн засаг захиргаа, хууль эрх зүй, эрүүл мэнд, нийгмийн халамж хамгаалал, барилга, зам тээвэр, харилцаа холбоо гэх мэт олон салбаруудыг хамаарна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургахад гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог заавал хангуулахаар хуульд тодорхой заалтуудыг оруулж зохицуулалт хийдэг байна. Нэн ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй ч боловсролын гадна үлдэхгүй байх боломжийг хангадаг Дэмжих үйлчилгээг Монголд хэрэгжүүлэх санаачилгууд байгаа хэдий ч боловсролын тогтолцоонд бүхэлд нь оруулснаар **бүх хүүхэд хувь хүртэх боломж** бүрдэх юм.

⁸² "Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь" төсөл, Судалгааны тайлан, АХБ, IRIM, 2019

2. ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХАД ЗОРИЛТОТ БҮЛЭГ РҮҮ ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ ЧУХАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ерөнхий боловсролын сургуулийн ангид ямарваа нэгэн бүтцийн өөрчлөлт хийхгүйгээр оруулан суулгасан бол тэгш хамруулалт гэж үзэхгүй. Жишээлбэл хичээлийн, анги танхимын зохион байгуулалт, хичээлийн хөтөлбөр, заах ба суралцах арга зүй, стратегид өөрчлөлт оруулахгүйгээр оруулан суулгасан бол тэгш хамруулж байна гэж үзэхгүй.⁸³ 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу Боловсролын хуульдаа “тусгай хэрэгцээнд нийцсэн тохируулга хийх тухай” /reasonable accommodation/ ойлголтыг тусгах, энэхүү эрхийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай зааврыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.⁸⁴ Цэцэрлэг, бага болон дунд сургуулиудад суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ялангуяа хөдөө орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн “тусгай хэрэгцээнд нийцсэн дэмжлэг, тохируулгын” хүртээмжтэй боловсролын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсон хүчин, санхүүжилтийг гаргаж тодорхой бодлого, хөтөлбөрүүдийг Комиссын ерөнхий зөвлөмж 4 (2016)-тэй уялдуулан хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэх⁸⁵ үүргийг Монголын Засгийн Газар НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны өмнө хүлээсэн байдаг.

Санал

- 2.1. Боловсролын ялгаатай хэрэгцээтэй суралцагч гэдэг нэр томъёог Боловсролын ерөнхий хуульд оруулах хэрэгтэй.
- 2.2. Бага наснаас нь хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлэх бодлогын зохицуулалт зайлшгүй хэрэгтэй.

⁸³ НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн Хорооноос Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн тухай Конвенцийн 4-р Ерөнхий зөвлөмж, Тэгш хамруулах боловсрол, 2016 он

⁸⁴ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос 2019 онд Монголын Засгийн Газарт ирүүлсэн асуулгын жагсаалт

⁸⁵ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос 2019 онд Монголын Засгийн Газарт ирүүлсэн асуулгын жагсаалт

Хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх дэмжлэгийн хөтөлбөр, үйлчилгээнүүдийг нухацтай сайн боловсруулж, тэгш хүртээмжтэй бий болгож, хэрэгжүүлж ажиллах нь эцэг эхэд ажил хөдөлмөр эрхлэх цаг гаргаж өгөөд зогсохгүй хүүхдүүдийг цэцэрлэг сургуульд сурах боломжийг нэмэгдүүлдэг. Дэмжих үйлчилгээгээр дамжуулан хүргэх үйлчилгээг эцэг эхийн бие даан үзүүлэх үйлчилгээтэй хослуулан, гэрээр үзүүлэх мэргэжлийн үйлчилгээгээр дэмжсэн тогтолцоо нь хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлж, хүүхдийн хөгжлийн явцыг эрчимжүүлээд зогсохгүй хүчирхийлэл болон үл хайхралт гарахаас урьдчилан сэргийлж, сургуульд орох бэлтгэлийг хангаж өгдөг зэргээрээ хүүхдийн хөгжлийн суурийг тавьж өгөхөөс гадна эцэг эх, мэргэжилтнүүдийн ажилд хувь нэмэр болдог байна.

2.3. Тусгай хэрэгцээг тодорхойлох, үнэлэх, тусгай хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээний зохицуулалтыг хийх хэрэгтэй.

Боловсролд тэгш хамруулах нь хүн бүрийг харилцан хүндлэх, үнэ цэнтэй гэж үзэх явдлыг хөхүүлэн дэмжиж, мөн суралцахад хандах хандлага - арга зүй, боловсролын байгууллагын соёл, сургалтын хөтөлбөрт ялгаатай байдлын үнэт зүйлийг тусгасан сургалтын орчныг бий болгохоор зорих ёстой.

Боловсрол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний хувийн зан чанар, авьяас, бүтээлч байдлын хамт тэдний оюуны, бие махбодын, харилцааны ур чадварыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд чиглэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол нь ихэнх тохиолдолд тэдний чадварын алдагдалд хандсан, тэдний бодит эсвэл байж болох согогт төвлөрсөн, мөн тэдний чадамжийг урьдчилан тодорхойлсон сөрөг төсөөллөөрөө боломжийг нь хязгаарлахад чиглэсэн байдаг.

Боловсролын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөт нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломжийг хангахад чиглэх ёстой. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 23.3 дугаар зүйлийг дахин сануулж, Хорооны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмд дээд зэргээр нэгтгэх, хувь хүний хөгжлийн хамгийн дээд түвшинд хүрэхэд ээлтэй нөхцөлийг бүрдүүлсэн боловсрол хүртээмжтэй байхад дэмжлэг үзүүлэх ёстойг чухалчилсан билээ. Оролцогч улсууд хувь хүнд үзүүлэх

дэмжлэг, тохирох хэрэглэгдэхүүнийг эн тэргүүнд чухалчлах, боловсролыг заавал эзэмших бүх түвшинд үнэ төлбөргүй олгохыг хүлээн зөвшөөрөх ёстой.

2.4. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээг дэмжсэн Дэмжих үйлчилгээг Боловсролын байгууллага бусад оролцогч талуудын хамтаар хүргэдэг байх хэрэгтэй.

Нийтэд зориулсан боловсролын тогтолцооноос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гадуурхахыг, тэр дундаа тэдний бэрхшээлд нь тулгуурлан эсвэл бэрхшээлийн зэргээс нь хамаарч тэднийг тэгш хамруулахыг хязгаарлах, тодруулбал хувь хүний чадамжийн хэмжээнээс хамаарч тэгш хамруулах нөхцөлөө заах буюу тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүргээс зайлсхийх зорилгоор, үндэслэлгүй эсвэл зохицоогүй шалтаг гаргах зэргийг аливаа хууль тогтоомж эсвэл бусад зохицуулалтаар хориглох шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулахад шаардагдах тохирох хэрэглэгдэхүүнээр хангах болон хөшүүргийг багтаасан санхүүжилтийн механизм, яамд хоорондын зохицуулалт, дэмжлэг, тогтвортой байдал хангалтгүй ба оновчгүй байгаа нь хүүхэд сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байдалд хүргэж байна.

Хүүхдийн хөгжлийг хангахад сургуульд болон сургуулийн тогтолцооноос гадуур “Дэмжих үйлчилгээ” хэрэгтэй байдаг бөгөөд үүнийг бусад орнуудад боловсролын тухай хуульдаа оруулан зохицуулсан байдаг байна. АНУ-д 16 төрлийн дэмжих үйлчилгээг Эрүүл мэнд,

Дэмжих үйлчилгээ гэж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай боловсролыг дэмжих унаа тээвэр, хэл засал, сонсгол дэмжих үйлчилгээ, орчуулга, сэтгэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, засал руу чиглүүлсэн хөгжөөнт үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, үнэлгээ, сэргээн заслын гм зөвлөх үйлчилгээнүүд, шилжилт хөдөлгөөн дэмжсэн үйлчилгээ, оношилгоо, үнэлгээ хийх зорилготой эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хүүхдийн хөгжлийн, заслын, дэмжлэгийн үйлчилгээнүүд хамрагдана. Нэмэлт үйлчилгээнд сургууль дээр үзүүлдэг эрүүл мэнд, нийгмийн ажлын, эцэг эхэд зөвлөгөө өгөх үйлчилгээ багтана.

Нийгмийн халамж, хамгааллын тогтолцоонд нь оруулж, салбар дундын зохицуулалтаар хангаж хамтран ажилладаг нь боловсролын ялгаатай хэрэгцээтэй хүүхэд түүн дундаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох эрхээ эдлэхэд зайлшгүй хийгдэх арга хэмжээ болж байна. Боловсролын байгууллага хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулахын тулд эрүүл мэндийн, сэргээн засах,

зөөвөрлөн тээвэрлэх, харилцаа холбоог дэмжих гэх мэт олон үйлчилгээг хүргэх гэж боловсролын үндсэн зорилгоосоо хазайсан үйлчилгээг хүргэх гэж нөөцөө буруу хуваарилах, хөрөнгө санхүү хүрэлцэхгүй байх гэх мэт асуудлууд үүсдэг тул боловсролын сургалтын байгууллага боловсролын бус байгууллагуудаас Дэмжих үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэх байдлаар бодлогын зохицуулалтыг хийх нь хамгийн зөв гарц гаргалгаа болж байгаа юм. Боловсролын салбараас гадуур үзүүлж буй, хүүхдийн боловсролын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой үйлчилгээнүүд юм.

3. ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХАД ГАНЦААРЧИЛСАН ДЭМЖЛЭГИЙН АРГА ХЭМЖЭЭГ АВАХ БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ ШААРДЛАГАТАЙ.

3.1. Боловсролын ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад БСШУСЯ-ны Сайдын 2018 оны 155, 2019 оны 292, 2020 оны 184-р тушаалууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх цогц дэмжлэгийн арга хэмжээг (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаал) хэрэгжүүлэх бодлогын зохицуулалт нь Боловсролын багц хуулиуддаа тусгалаа олсон байх хэрэгтэй байна.

3.2. Салбар дундын зохицуулалттай Дэмжих үйлчилгээг боловсролын ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад хүргэх хэрэгцээ шаардлага маш их байна. Нэн ялангуяа боловсролын гадна байгаа хүнд болон хавсарсан бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулахад Дэмжих үйлчилгээнүүд зайлшгүй хэрэгтэй байдаг тул энэ зохицуулалтыг хуульд оруулж дэмжихийг хүсэж байна. Дэмжих үйлчилгээ тодорхойлолтыг харна уу.

4. СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ ИЛРҮҮЛЭХ, ЭЦЭГ ЭХ ГОМДОЛ ГАРГАХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ХАРИУЦЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ

Зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхийн зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, гомдлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох тал дээр онцгойлон анхаарч ажиллах хэрэгцээ байгааг энд дурдах хэрэгтэй.

СОНСГОЛГҮЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨГСӨН САНАЛ

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1 “Хос хэлний арга зүй” гэж Монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлийг хослуулан боловсрол олгох арга зүйг хэлнэ. (Сонсголгүй болон сул сонсголтой хүүхдүүдэд төрөлх хэл болох монгол дохионы хэлээр аливааг тайлбарлан ойлгуулж удаах хэл болох бичгийн монгол хэлийг холбон монгол дохионы хэлээр хослуулан заахыг хос хэлний арга зүй гэж хэлнэ.)

3.2 “Сонсголын бэрхшээлтэй суралцагч” гэж сонсголгүй болон сул сонсголтой хүнийг хэлнэ

6 дугаар зүйл.

6.2. Сонсголын бэрхшээлтэй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу дохионы хэл байна.

10 дугаар зүйл Суралцагчийн эрх үүрэг

10.1.12 Сонсголын бэрхшээлтэй суралцагч хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцохдоо дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээг авах

12 дугаар зүйл Багш, багшийг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоо

12.12. Бүх шатны боловсролын байгууллагад суралцаж буй сонсголын бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах багш сурган хүмүүжүүлэгч нь монгол дохионы хэлний ярианы ахисан түвшин хүртэл бэлтгэгдсэн байна.

12.13. Бүх шатны боловсролын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах багш сурган хүмүүжүүлэгч нь хос хэлний арга зүй ашиглан заах арга зүйн чиглэлээр бэлтгэгдсэн байна.

13 дугаар зүйл Багшийн эрх, үүрэг, багш ажилтны нийгмийн баталгаа

13.1.10. Сонсголгүй багш, ажилчид, суралцагчид бусадтай харилцахдаа монгол дохионы хэлээр харилцах эсвэл монгол дохионы хэлний мэргэжлийн хэлмэрч, орчуулагчаар дамжуулж харилцах

19 дүгээр зүйл Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага

19.1.11 Дохионы хэлний хэрэглээ, хөгжлийн судалгаа

20 дугаар зүйл Насан туршийн суралцахуй

20.4. Сонсголгүй хүүхдэд боловсрол олгож буй тухайн ерөнхий боловсролын сургуулийн нийт эцэг эхчүүдэд сонсголгүй хүний соёлын хэрэгцээ болон монгол дохионы хэлний сургалтыг тогтмол зохион байгуулах

29 дүгээр зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

29.1.10. Сонсголын бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцахад шаардлагатай дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

29.1.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хараа зүйч, сонсголтой болон сонсголгүй дохионы хэлний багш, сонсголтой болон сонсголгүй дохионы хэлний шинжээч, сонсголгүйн боловсролын мэргэжилтэн, дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, брайл бичгийн багш, сэтгэл зүйч, арга зүйч болон хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллахад шаардлагатай бусад мэргэжилтнийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургах асуудлыг зохион байгуулах;

43 дугаар зүйл. Боловсролын байгууллагын санхүүжилт

43.11. Сонсголын бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцахад дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ

6 дугаар зүйл. Тэгш хамран сургалт

6.6. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцах сонсголын бэрхшээлтэй 0-3 насны суралцагчийн эрт оролцооны хөтөлбөр, холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.10. Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад боловсрол олгож буй Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, захиргааны ажилчид нь сонсголгүй хүний соёлын хэрэгцээ болон монгол дохионы хэлний мэдлэг ойлголттой байна.

6.11. Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад дэмжлэгийн үйлчилгээ болох хэл заслын хичээлийг ганцаарчилсан хэлбэрээр орно.

6.12. Сонсголын бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах багш, сурган хүмүүжүүлэгч нь монгол дохионы хэлээр боловсролын үйлчилгээг үзүүлэх монгол дохионы хэлний ахисан түвшний байх бөгөөд тус багш, сурган хүмүүжүүлэгч нь сонсголын бэрхшээлтэй суралцагчид заах тусгай зөвшөөрөлтэй байна.

7 дугаар зүйл. Сургалтын хэл

7.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12.1-д зааснаар эх хэл нь дохионы хэл болох сонсголгүй хүүхэд эсхүл мэргэжилтний дүгнэлтээр дохионы хэлээр сургалт авах шаардлагатай суралцагч дохионы хэлээр цэцэрлэг болон ерөнхий боловсрол эзэмших эрхтэй байна.

7.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 7.5-т зааснаар сургалт явуулах цэцэрлэг, сургуулийг тусгайлан тогтоож болно.

7.7. Энэ хуулийн 8.3 дахь хэсэг нь бусад цэцэрлэг, сургуулийг сонсгол болон хараагүй хүүхдэд сургалтын үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахгүй.

11 дүгээр зүйл. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

11.10. Сонсголын бэрхшээлтэй суралцагчийн сургалтын онцлог хэрэгцээг хангах ном, сурах бичиг, гарын авлага, дохионы хэлний толь бичиг зохиох, дохионы хэлийг монгол ярианы хэл рүү хөрвүүлдэг технологи, дуу хураагуур, сургалтын боломжит тохируулга, тоног төхөөрөмжийг худалдан авах болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

12 дугаар зүйл. Суралцагчийн эрх

12.1.7. Бүх насны сонсголын бэрхшээлтэй суралцагчид нь үндэсний

хэмжээнд мөрдөгдөх Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу хос хэлний арга зүйгээр суралцах эрхтэй.

14 дугаар зүйл. Цэцэрлэг, сургуулийн ажилтан

14.6. Сонсголгүй хүүхдийн хос хэл, соёлын цэцэрлэг, Сонсголгүй хүүхдийн хос хэл, соёлын сургуульд Сонсголгүйн боловсролын мэргэжилтэн, багш, эрт оролцооны мэргэжилтэн, дохионы хэл шинжлэлийн мэргэжилтэн ажиллана.

15 дугаар зүйл. Багшийн ажил, үүрэг

15.3. 14.6-д заасан сургуульд хос хэлний арга зүй болон сонсголгүй хүүхдийн хараан дээр суурилсан соёлыг мөн хавсарган аливаа сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах. Мөн хараан дээр суурилсан соёлын хүртээмжтэй сургалтын орчин, толилуулалт, хэрэглэгдэхүүн аливаа хичээлийг харааны хүртэхүйн онцлогт тохируулан зураг, зурагт үзүүлэн, визуал материал болон дүрс, дүрслэл, бичлэг зэрэг харааны хүртэхүйн баялаг хэрэглэгдэхүүнүүдийг ашиглах

15.4. 14.6-д заасан сургуульд сонсголгүй болон сул сонсголтой хүүхдүүдтэй ажиллах багш, сурган хүмүүжүүлэгч нар нь монгол дохионы хэлний ахисан ба түүнээс дээш ярих чадвартай мөн монгол дохионы хэлээр мэргэшсэн хичээлээ заах бүрэн чадвартай байх

17 дугаар зүйл. Удирдах болон бусад ажилтан

17.6. 14.6-д заасан сургууль, цэцэрлэгийн бүх ажилчид буюу эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс нь сонсголгүй болон сул сонсголтой хүүхэдтэй харилцахдаа мэргэжлийн дохионы хэлний хэлмэрчээр дамжуулан орчуулуулж уулзаж ярилцах, аливаа сургалтыг зохион байгуулах

18 дугаар зүйл. СӨБ болон ЕБ-ын сургалтын байгууллага

18.6. Сонсголгүй хүүхдийн хос хэл, соёлын цэцэрлэг, Сонсголгүй хүүхдийн хос хэл, соёлын сургууль үйл ажиллагаагаа явуулна.

ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙГ ТЭГШ ХАМРУУЛЖ БУЙ САЙН ЖИШЭЭ

Бие бялдрын, мэдрэхүйн, сэтгэл санааны, зан авирын болон сурах үйлийн хувьд чадвар нь хязгаарлагдсан тохиолдолд бусад чадварыг нь ашиглах байдлаар хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг хөгжүүлэх хэрэгтэй байдаг. Гэхдээ боловсролын ялгаатай хэрэгцээ бол үүгээр хязгаарлагдахгүй. Эдийн засаг, хэл соёл, зан заншил, шашин, бэлгийн, бие эрхтний гэх мэт олон хүчин зүйлс нь боловсролын ялгаатай хэрэгцээг бий болгодог юм.

Хүн бүрийн үйлдэхүйн /харах, сонсох, хөдлөх, танин мэдэх, нийгэмдээ харилцах, бусадтай харилцах, сэтгэн бодох, хүртэх, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах үйл, өөрийгөө хянах үйл, анхаарлаа төвлөрүүлэх үйл, сурах үйл, унших үйл, тоо бодох үйл гэх мэт/ чадвар нь өөр өөр байдаг бөгөөд боловсролд энэ бүх ялгаатай чадварыг харгалзан үзэж, зарим тохиолдолд тусгайлан харгалзан үзэж, хариу арга хэмжээ авах шаардлага үүсдэг. Тэгш хамруулан хөгжүүлэхийн гол суурь нь энэ бөгөөд бүгд ялгаатай юм чинь хамтдаа л байх, тусгаарлахгүй байх явдал юм. Иймд өвчний оношоор шошгологгүй, үйлдэхүйн ялгааг нь харгалзан үзэж, олонх дунд нь сургахуйг ялгаатай байдлаар зохион байгуулахад дэлхийн нийтийн чиг хандлага явж байна.

1. Харааны ялгаатай чадвартай хүүхдийг тэгш хамруулахад үлдэц харааг ашиглаж болно. Огт харахгүй тохиолдолд хүрэлцэх, сонсох гэх мэт бусад байгаа чадварыг нь ашиглах байдлаар хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд хамруулдаг.

- Бага насны харааны бэрхшээлтэй хүүхдийн тэмтрэх мэдрэмжийг нь илүү хөгжүүлснээр танин мэдэхүйг нь тэлдэг. Хавтгай дээр будаагаар амьтны дүрсийг товойлгон хийх нь тухайн амьтан ямар хэлбэр, дүрстэйг төсөөлөн бодоход тусалдаг. Ямарваа хэлбэр, дүрсийг тайлбарлан хэлэхээс илүүтэйгээр тэмтэрч мэдрэхэд нь багш нар нь туслах нь зүйтэй.
- Хараа бүрэн алдсан тохиолдолд хүрэлцэх үйлийг бүрэн ашиглаж мэдээлэл авах, өөрийгөө илэрхийлэх, мэдсэнээ ойлгуулах, ном унших гэх мэтэд брайлаар уншиж, бичихэд сургах шаардлагатай.

Гараар тусгай зориулалтын цаасан дээр брайлаар шивж бичгэн харилцааг үүсгэдэг байсан бол одоо тусгай зориулалтын брайль бичгийн машинууд, брайл бичигч, хэвлэгч, уншигч хэрэглэгддэг болсон. Брайлыг насанд хүрсэн хойноо ч өдөр тутамдаа ашигладаг тул бага наснаас нь эрт гарын хуруугаар тэмтэрч сургах нь маш чухал.

- Сонсох үйлийг сурах үйл явцад их ашиглана. Номыг хэвлэмэл байдлаар хараагүй хүүхдэд хэрэглүүлэхээс зайлсхийж ном сурах бичгийг сонсох байдлаар буюу өөрөөр хэлбэл ярьдаг номуудыг сургалтад ашигладаг.
- Яриаг бичигт, бичгийг ярианд хөрвүүлдэг төхөөрөмжүүд, аппликшнүүд бий болсон нь харааны бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд ороход маш ихээр тус болж байна. Монгол хэлэнд Чимэгэ аппликшн гарсан нь яриаг бичигт хөрвүүлэх эхлэл тавигдсан. Орчин үеийн техникийн шийдлүүд нь компьютерийг ярьдаг програмтай болгосноор хараагүй хүн ч компьютерийг бүрэн ашиглах бололцоо бүрдсэн.
- Харааны үлдэгдэлтэй буюу сул хараатай бол томоор хэвлэсэн ном, сурах бичиг хэрэглэх боломжоор хангах хэрэгтэй. Мөн томруулагч, харааны шил зэрэг нь тухайн хүнд тохируулга болж өгдөг.

2. Сонсох үйлийг бүрэн алдсан тохиолдолд хүүхдийг хөгжүүлэхэд дохионы хэлийг харилцаанд ашигладаг бөгөөд энэ нь сонсголгүй хүний эх хэл нь болдог. Огт сонсохгүй хүн нь бусадтай харилцахдаа асуудалтай байгаа тул харилцаандаа хуруу, гараараа дохиж зангаж харилцаанд ордог. Үүнийг дохионы хэл гэдэг. Улс орон бүр дохионы хэлээ хөгжүүлдэг бөгөөд энэ нь биеэ даасан хэл хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Сонсголгүй хүнд дохиогоор харилцах чадварыг нь бий болгож, боломжоор нь хангах нь хөгжих эрхийг нь хангах суурь нь болдог юм. Иймд аль болох эрт бага наснаас нь дохионы хэлэнд сургах нь хамгийн зөв шийдэл байдаг. Сургуульд орох насыг хүлээх нь аль хэдий нь оройтсон байдаг. Өөрөөр хэлбэл хүүхдийн бусадтай харилцах харилцааг 6 нас хүртэл нь боомилж байгаа хэрэг болдог.

Иймд СӨБ-д нь дохионы хэлээр харилцах, хөгжих боломжийг олгох нь хамгийн зөв шийдэл болдог бөгөөд гэр бүлийн гишүүд мөн адил дохионы хэлэнд суралцсан байх нь хүүхэдтэйгээ бүрэн харилцах боломжийг олгодог. Тэгснээр хүүхдийн тархины хөгжилд ч сайнаар нөлөөлдөг. Цаашид амьдралынхаа туршид бусадтай харилцах харилцаа нь дохионы хэл байдаг тул сургууль, цэцэрлэгийн бүх харилцаанд дохиогоор харилцах боломжийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

3. **Сул сонсголтой буюу сонсгол муу** бол үлдэгдэл сонсголыг нь ашиглах сонсголын аппаратыг хэрэглэдэг. Сонсголын олон төрлийн аппаратууд бий болсон бөгөөд чихний имплантыг суулгадаг болсон. Ингэснээр сул сонсох чадвар нь сайжирч бусадтай харилцахдаа сонсголоо ашиглан, ярьж сурдаг.
4. **Хөдлөх үйлийн хязгаарлалттай хүмүүст** хөдөлгөөнд аль болох бага хүч ашиглаж оролцох боломжоор хангах нь тухайн хүнийг нийгмийн харилцаанд оруулахад хэрэгтэй. Энэ тохиолдолд орчны хүртээмж ихээр нөлөөлдөг.
 - Шилжилт хөдөлгөөн хийх хязгаарлалт 1. Тулах эрхтний өөрчлөлттэй үед хөдөлж чадахгүй, эсвэл хөдөлж явахад хүндрэлтэй тохиолдолд тэргэнцрээр шилжилт хөдөлгөөн хийдэг. Ингэснээр тухайн хүн орчиндоо саадгүй зорчих, хөдлөх боломж бүрддэг. Дугуй чөлөөтэй зорчих ямар ч орчин тухайн хүнд саадгүй бөгөөд шат, довжоо нь хөдөлгөөн хийхэд нь тэдгээр хүнийг бэрхшээлтэй болгодог. Иймээс орчныг нь бүгдэд хүртээмжтэй болгож налуу зам, лифт, урсдаг шатаар эдгээр саадыг арилгаж ямар ч хүн зорчих боломжоор хангадаг. Ингэснээр хэний ч туслалцаагүйгээр өөрсдөө орчиндоо зорчих, шилжилт хөдөлгөөн хийх боломжоор хангагдана.
 - Шилжилт хөдөлгөөн хийх хязгаарлалт 2. Таяг, алхуулагч гэх мэт туслах хэрэгслүүдийг хөдөлгөөн хийхдээ ашиглаж болдог.
 - Бичихэд гарыг ашиглаж чадахгүй байх хүндрэл. Энэ тохиолдолд аль нэг хуруугаар, эсвэл амандаа зуусан, толгойд тогтоосон зүйлээр компьютерын товчийг товшиж цохих чадварт сургах нь

чухал байдаг. Жишээ нь саажилттай хүүхдийг гараар бичүүлэх гэж “зовоох” нь түүнд биеийн илүү хүч гаргахад хүргэж тухайн хүүхэд бичих үйлдээ төвлөрөх биш хөдөлгөөнөө удирдахад хүчээ зарцуулахад хүргэдэг сул талтай.

5. **Хэт хөдөлгөөнтөх** эмгэг гэж байдаг бөгөөд хөл гар нь зүгээр хэрнээ тогтвортой нэг байрлалд зорилготойгоор үйлдэл хийхгүй, анхаарал сарнилт хавсарч тохиолдох нь элбэг байдаг. Энэ тохиолдолд анхаарлыг төвлөрүүлж, суулгаж сургахын тулд багш онцлогт нь тохируулан нэмэлт арга хэмжээ авах эсвэл туслах багштайгаар сургалтыг зохион байгуулдаг. Багшид нэмэлт дэмжлэг хэрэгцээтэй бөгөөд бусад хүүхдүүдийн ч, тухайн хүүхдийн ч анхаарлыг төвлөрүүлэн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахын тулд эмч, нийгмийн ажилтан, менежер, эцэг эхээс бүрдсэн дэмжлэгийн багаар зөвлөлдөн хэлэлцэж, хамтаараа шийдвэрлэх нь энэ тохиолдолд дөхөмтэй байдаг.
6. Сонсох чадвартай ч **хэл ярианы бэрхшээлтэй бол** хүүхдийн илэрхийлэх хэлийг насны онцлогоос хамааран өөр өөр байхаар зохион байгуулах хэрэгтэй байдаг:
 - Харилцахдаа хэл яриаг ашиглах чадвар нь муу байвал хөгжүүлж, өөрийгөө илэрхийлэхэд туслах нэмэлт хэл заслын дэмжих үйлчилгээнд эрт хамруулах хэрэгтэй. Хэл засалд хамрагдсанаар хүүхэд харилцахдаа ярьж сурах магадлал өндөр болдог.
 - Харилцахдаа буюу өөрийгөө илэрхийлэхдээ хэл яриаг ашиглаж чадахааргүй хүндрэлтэй байвал дохио зангаа, биеийн хэлэмж, зурган, бичгэн харилцаагаар харьцахад сургах хэрэгтэй. Магадгүй дохионы хэл сурч болох юм.
7. **Анхаарал төвлөрөл сул** тохиолдолд анхаарлыг сарниулах хүчин зүйлсийг сурах орчинд байлгахаас татгалзах хэрэгтэй:
 - Анхаарал сарних нөхцөлийг бага үүсгэхээр орчныг зохион байгуулдаг. Хананд болон тавиур, ширээн дээр хэт олон зүйлийг үзүүлэн байдлаар тавихгүй, хүүхэд төвлөрч хичээл хийх орчинд аль болох цөөхөн тавилгатай байлгадаг. Олон өнгийн зүйлээр эрээлж, мяраалахаас зайлсхийх хэрэгтэй. Багш, эцэг эхчүүдийн

эмх замбараатай байдал, ажлын болон орчны сайн зохион байгуулалт нь анхаарал төвлөрөх хугацааг илүү уртасгаж өгдөг сайн талтай.

8. Оюун ухаан танин мэдэхүйн хоцрогдолтой бол:

• Ойлгож ухаарахад хялбар дөхөм болгох аргуудыг хэрэглэнэ. Хүүхдийг хөгжүүлэхдээ багш олон мэдрэмжийг ашиглах байдлаар, хийсвэр бус, бодит үзүүлэн дээр тайлбарлах нь ойлгож ухаарахад хэрэгтэй. Үүнд харах, сонсох, тэмтрэх, амтлах, үнэрлэх гм мэдрэхүйнүүдийг таньж мэдэх, ойлгоход ашиглаж болдог.

- Давталттайгаар дадал хэвшлийг бий болгох замаар тухайн үйлдлийг хийж сургадаг.
- Дохио зангаа, биеийн хэлэмж, үгэн харилцааг дэмжиж харьцах нь зүйтэй бөгөөд ийм байдлаар өөрийгөө илэрхийлэхэд сургах хэрэгтэй.
- Хэрвээ оюуны чадавх нь дийлэнх олонхын хэмжээнд хүрч чадахгүй бол тухайн хүүхдэд заавал стандарт мэдлэгийг эзэмшүүлэх гэж зүтгэх нь буруу бөгөөд хүүхдийн өөрийнх нь чадавхад тохирсон байдлаар сургалтын зорилгыг хөнгөрүүлэн тавьж болдог бөгөөд ийм шийдлийг сонгох тохиолдолд эцэг эхтэй нь заавал хэлэлцэж, хүүхдийг дэмжих багийн хурлаар шийдвэрлэж, ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөг гаргаж ажилладаг. Гэхдээ энэ нь хүүхдийг дандаа ганцаарангаар нь сургах гэсэн ойлголт огт биш бөгөөд хөгжлийн түвшинг ангийн хамт олны дунд суралцангаа ямар хэмжээнд хүргэх хамтын төлөвлөгөө юм.

9. Зан авир, сэтгэл санааны өөрчлөлттэй тохиолдолд сурагч өөрийн зан байдлыг хянах, удирдах, хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцох, төвлөрөх чадвар алдагддаг. Мөн бусад үеийн найз нөхөдтэйгээ харилцахад хүндрэл үүсдэг. Энэ үед ангийн багш бусад хүүхдэд хичээл заах, зан авирын хувьд ааш гаргаж буй сурагчийг тайвшруулах гэх мэт ангид хичээл сургалтыг зохион байгуулахад хүндрэл бэрхшээл үүсдэг. Тэгш хамруулсан ангид энэ тохиолдолд тухайн хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн дараах хариу арга хэмжээг авснаар ийм нөхцөл байдлыг шийдвэрлэж болох юм. Үүнд:

- a) **Ангид баримтлах дүрмийг гаргаж, энгийн, ойлгомжтойгоор тайлбарлан, мөрдүүлнэ.** Ангид 3-5 дүрмийг мөрдүүлэхэд л хангалттай. Дүрэм мөрдүүлэхээс гадна сурагчдын дунд хичээлийн үеэрх үйл ажиллагаануудыг удирдан чиглүүлж болдог. Ангид ямар байхыг нь чиглүүлж өгснөөр сурагч хичээлээрээ юу хийхээ мэдэж, бусдын адил сурах үйл явцад оролцох эхлэл тавигддаг.
 - b) **Зерэг зан байдлыг магтан, урамшуулна.** Энэ тохиолдолд хүүхдийг шийтгэхийн оронд өөрийнх нь чармайн гаргаж буй зерэг үйлдэл бүрийг олж мэдэн сайшаан дэмжих хэрэгтэй байдаг.
 - c) **Завсарлага авах боломж бүрдүүлнэ.** Багш хичээл заах явцдаа завсарлага авч, сурагч бүрийн анхаарал сарнихгүй байхад чиглүүлэн сургалтын үйл явцыг удирдах хэрэгтэй.
 - d) **Бүгдэд адил хандах хэрэгтэй.** Зан төрхийн өөрчлөлттэй хүүхдүүд өөрт нь зохисгүй хандсан тохиолдолд дургүй, харин ч дүрсгүйтэх шалтгаан болдог.
 - e) **Сэдэлжүүлэх арга хэмжээ авна.** Сурагч хичээж, чармайж байгаа хүчин зүтгэл бүрт магтан сайшаа. Сурагч ангидаа цаашид ч өөрийгөө дайчлах сэдэл, тэмүүллийг төрүүлэх нь хүүхдийн хөгжилд маш үр дүнтэй.
- 10. Сурах үйлийн онцлог:** Энэ нь сурах бэрхшээлтэй хүүхдэд илүү тохиолддог бөгөөд уншихдаа, бодохдоо, хэлэхдээ, ярихдаа олонх хүүхэдтэй адил биш байдаг. Энэ онцлогт нь тохируулан хариу арга хэмжээ авах нь боловсролын ялгаатай хэрэгцээг харгалзаж буй хэрэг болдог. Бараг дийлэнх тохиолдолд оюун ухааны хоцрогдол биш байдаг.

Б.АРДАК

ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ⁸⁶

Монгол Улсад амьдарч буй үндэстний цөөнх иргэд, тэдний үр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг НҮБ, ОУ-ын байгууллагын эрх зүйн баримт бичгүүдэд баталгаажуулсан байдаг тул МУ-ын Үндсэн хууль, Боловсролын тухай хуулиудад эх хэлээрээ ярих, боловсрол эзэмших, соёлын үйл ажиллагаа явуулах эрхийг тодорхой зааж өгсөн байдаг. Тухайлбал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтад:

“... Хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө”; мөн хуулийн 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтад: “...Хүнийг үндэс угсаа хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж тус тус заасан.

Монгол хэлний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д “...суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах” 13.1.5-д «үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах»-ыг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулсан байдаг.

Хос хэлний боловсрол гэж юу вэ?

Хоёр хэлийг хичээл болгон заах, мөн түүнчлэн хоёр хэлээрээ бусад хичээлээ заах боловсролын хөтөлбөрийг хэлнэ.

Тухайлбал:

Казах, Тува, Монгол дохионы

Хос хэлтэй байна гэдэг нь:

Хоёр хэлийг хоёуланг нь төрөлх хэл шигээ чөлөөтэй мэдэж, адил тэнцүү хэрэглэх чадварыг хэлж буй.

Хос хэлийг хэрэглэгч нь:

Үндэстний цөөнх, /Казах, Тува/, сонсголын бэрхшээлтэй иргэд, бусад

⁸⁶ Энэ хэсгийг “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эсвэл, Налайх салбар зөвлөлийн зохицуулагч, философийн магистр Б.Ардак боловсруулав.

хэлний хичээл гэх мэт... Энэ нь нэг хэл дээр хичээл сургалтын үйл ажиллагаа явагдаж, өөр бусад хэлийг нэмж заалаа ч тэр хэлээр нь хичээл сургалтын үйл ажиллагаа явагддаггүй, боловсролын хөтөлбөрөөс ялгаатай гэсэн үг.

Монгол улсад өөрийн гэсэн өвөрмөц хэл, соёл, зан заншил, шашин шүтлэгээрээ нийгмийн олонхыг бүрдүүлэгч хэсгээс эрс ялгаатай Казах, Тува иргэдийг үндэстний цөөнх гэж үздэг.

Үндэстний цөөнх гэж хэн бэ?

Тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох, хэл, арьсны өнгө, соёлын хувьд ялгарах өөрсдийн өвөрмөц байдлыг (identity – амин чанар) хадгалах эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүс.

МУ-д өнөөдөр үндэстний цөөнх иргэд газар нутаг байршлын хувьд:

Баруун бүс: Баян-Өлгий аймгийн төв, Ховд аймгийн төв, Буянт, Булган, Ховд сум

Төвийн бүс: Улаанбаатар хот, Налайх, Багануур дүүргүүд, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн, Зүүн бүрэн, Шаамар сум, Төв аймгийн Батсүмбэр, Заамар сум, Дархан-Уул аймгийн Орхон сум, Орхон аймгийн Эрдэнэт хот, Хэнтий аймгийн төв Чандмань зэрэг сумуудад тархан суужээ.

2020 оны “Хүн амын тооллого”⁸⁷-оор Казах иргэдийн тоо нийт хүн амын 3,8%, нийт иргэдийн тоо 120999, Тува иргэдийн тоо 2354 буюу 0,1%-ийг эзэлж байна. Үүнээс: Баян-Өлгий аймгийн хүн амын тооллогоор нийт хүн амын 90,48% нь Казах, 0,76% Тува үндэстэн эзэлж байна.

Төвийн бүсийн Үндэстний цөөнх иргэдийн тархалтын тоон үзүүлэлтийг харуулбал:

Д/д	Газрын нэр	Нийт хүн амын тоо	Казах иргэдийн тоо	Нийт хүн амд эзлэх хувь
1	Улаанбаатар	1144954	9817	0,9%
2	Налайх дүүрэг	37715	3716	10%
3	Сэлэнгэ аймаг	107775	1015	0,9%
4	Дархан-Уул аймаг Дархан хот	102200	2612	2,6%
5	Дархан-Уул аймаг Шарын гол сум	8145	1330	16,3%
6	Орхон аймаг Эрдэнэт	104032	673	0,6%
	Нийт	1504801	19233	31,3%

⁸⁷ 1212.mn

Үндэстний цөөнхийн хүүхдүүд нь өөрсдийн хэл болох Казах, Тува хэл дээр боловсрол эзэмшихийн зэрэгцээ төрийн албан ёсны хэлийг эзэмших нь тэдэнд өргөн хүрээтэй нийгмийн харилцаанд оролцох, боловсролыг тасралтгүй эзэмших, хөдөлмөрийн зах зээл дээр бусад иргэдтэй тэгш өрсөлдөх зэрэг боломжийг бүрдүүлдэг. Иймд Казах, Тува хүүхдүүдийг хос хэл дээр боловсрол эзэмших боломжоор хангах эрх зүйн зохицуулалтуудыг хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

Санал 1: Боловсролын Ерөнхий болон бусад салбар хуульд бүх хүүхдэд боловсролыг тэгш, хүртээмжтэй ялгаварлан гадуурхахгүйгээр олгох “Боловсролын зарчим”-ыг тусгаж, салбар хуулиуд боловсруулахдаа баримтлах

Санал 2: Боловсрол эзэмших сургалтын хэлийг хуульчлах, хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн суралцагч суралцагчийн сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол эзэмших хэлийг холбогдох хуулиар зохицуулах,

Санал 3: Суралцагчийн эрх, үүрэгт уламжлалт соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд эх хэлээрээ харилцах, боловсрол эзэмших эрхийг хуульчлах

Санал 4: Багшийн эрхт, үүрэгт суралцагчийн ялгаатай байдал, тухайлбал хэл, соёлын ялгаатай байдал, хөгжлийн хэрэгцээ, онцлогт нийцсэн суралцахуйн арга барил, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хэлбэрээ сонгон хэрэглэхээр тусгах

Санал 5: Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг үндэстний цөөнхийн хэл судлал, хос хэлний сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүний гэх мэт чиглэлээр суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг эрхлэхээр хуульчлах

Санал 6: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхэд харьяа нутаг дэвсгэртээ амьдарч байгаа үндэстний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахаар тусгах

Санал 7: Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүнд хос хэлний боловсрол олгох цэцэрлэг, сургуульд

боловсрол эзэмшүүлэхэд хэрэглэх итгэлцүүрийг тооцох асуудлыг хуульчлах.

Санал 8: Хос хэлний сургалтын хөтөлбөр, удирдамж, сургалтын арга зүйг боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг БШУЯ-нд үүрэг болгон тусгах,

Санал 9: Хос хэлээр сургалт явуулах, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах асуудлыг хуульд тусгах

Санал 10: Хос хэлээр сургалт явуулах, сурах бичиг, гарын авлага, бусад сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, хэвлэх, толь бичиг зохиох, түүний хангамж, хүртээмж, чанарт онцгой анхаарч, санхүүжилтийг төсвөөс хангах чиглэлээр зохицуулалт оруулах

Санал 11: Төвийн бүсэд амьдарч буй үндэстний цөөнх иргэдийн эх хэлээ сурах, өв соёлоо суралцах, хадгалах, дамжуулах боломжийг хуульчлах

ҮНДЭСЛЭЛ

А. Монгол улсын боловсролын салбарт энэ чиглэлээр хийгдсэн ажлууд:

Тусгайлсан хөтөлбөрүүд:

Өнөөдөр МУ-д амьдарч буй үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр тусгайлан гаргасан бодлогын баримт бичиг нь БСШУЯ-наас дунд хугацаанд буюу 2006-2012 онд хэрэгжүүлэхээр баталсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр” байна. Тува ардын (тува, духа) үр хүүхдэд үндэстний тува хэлийг нь эзэмшүүлж, эх хэлээ нийгмийн харилцааны тодорхой орчинд бүтээлчээр хэрэглэж чаддаг цогц чадамж бүхий иргэн төлөвшүүлэх зорилго бүхий БСШУ-ны сайдын 2005 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 387 дугаар тушаалаар баталсан “Тува хэлний хөтөлбөр” хэрэгжиж байна

Тусгайлсан бүтэц:

Боловсролын Хүрээлэнгийн захирлын 2011 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 16 тоот тушаалаар Боловсролын Хүрээлэнгийн бүтцэд Казах хүүхдийн боловсролын судалгааны сектор байгуулагдсан. 2015 оноос тус секторын үйл ажиллагааны хүрээ өргөжиж, Үндэстний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор хэмээн нэрлэгдэх болсон.

Хос хэлний сургалттай сургуулиуд:

Баян-Өлгий аймагт төрийн өмчийн 38, төрийн бус өмчийн 6, нийт 44 ЕБС-ийн 2 нь сургалтаа дан монгол хэлээр, 14 бага сургууль казах хэлээр (2 дугаар ангиас монгол хэлний хичээл орно, бусад бүх хичээл казах хэл дээр), 6 сургууль монгол, казах зэрэгцсэн бүлэгтэйгээр, 19 сургууль казах-монгол хэлээр, 1 сургууль монгол-англи хэлээр, 1 бага сургууль тува-монгол хэлээр сургалтаа зохион байгуулж байна.

1998 оны 9 сарын 10-ны өдөр Цэнгэл сумын Тува бага сургууль байгуулагдсан ба Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А\816 тоот захирамжаар Тува бага сургууль нь 9 жилийн сургууль болж өргөжсөн байна.

Хос хэлний сургалтын сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн:

2013 онд бага ангийн эх хэлний (казах, тува) хөтөлбөр, суралцахуйн удирдамж хэвлэгдэж, өнөөг хүртэл сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байна.

2018 онд суурь боловсролын эх хэлний (казах, тува) хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулагдаж, тува хэлний хөтөлбөр хэвлэгдсэн. Казах хэлний суурь боловсролын хөтөлбөр боловсруулагдаж, сургалтад хэрэгжиж байна. Бүрэн дунд боловсролын *тува* хэлний хөтөлбөр, суралцахуйн удирдамж 2019 онд боловсруулагдаж, хэвлэгдсэн.

Бага ангийн Казах хэлний сурах бичиг (1-5 дугаар анги) 2019 онд шинээр хэвлэгдсэн бол Бага ангийн Тува хэлний сурах бичиг (1-5 дугаар анги) НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр 2013 оноос эхэлж, багшийн номын хамтаар хэвлэгдсэн.

Б. Тулгамдсан асуудлууд:

Хос хэлний боловсрол гэдэг нь боловсролын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэхдээ сургалтын үйл ажиллагаанд хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хоёр хэлийг ашиглах явдал юм. (Cohen, 1975)

Хос хэлний боловсролын тухай онолын эцэг гэгддэг Канадын эрдэмтэн Уаллас Ламберт нь "...**хос хэлний боловсролын гол зорилго нь** хүүхдэд эх хэлээр нь бичиг үсэг зааж уншиж бичиж сурсны дараа цаг алдалгүйгээр тухайн улсын дийлэнхийн хэл болох албан ёсны хэлийг эзэмшүүлэх, суурь боловсролын хичээлийн агуулгыг илүү сайн

ойлгуулахын тулд эх хэлийг нь тайлбар хийхэд ашиглахын зэрэгцээ аль болох богино хугацаанд дийлэнхийн хэл дээрх агуулгыг бүрэн ойлгох түвшинд хүргэх, үе тэнгийнхнээс хоцрогдолгүй болгоход орших ёстой (2009)” гэж тодорхойлсон.

Асуудал 1: Үндэстний цөөнхийн хос хэлний боловсролын талаарх хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн заалтууд нь Монгол улсын нэгдэн орсон конвенц, тунхаглалуудад туссан тунхгийн шинжтэй заалтууд байгаа нь хэрэгжилтийн байдалд сөргөөр нөлөөлж байна. Монгол улсад үндэстний цөөнхийн хүүхдийн хос хэлний боловсролын бодлого байхгүй тул хос хэлний боловсролын загвар, хос хэлний сургалтын арга зүй, хэл, соёлын агуулгыг нэгтгэсэн хөтөлбөр, агуулга, сурах бичигт хийгдэх агуулгын тохиргоо, эх хэлний мэргэшсэн багш бэлтгэх, СӨБ-ын түвшинд хос хэлтэй хүүхдийн хэл ярианы хөгжлийг хангах, үндэстний цөөнх иргэдийн оролцоог хангах арга замууд зэрэг асуудлууд бодлогын түвшинд шийдэгдээгүй байна.

Асуудал 2: Баян-Өлгий аймгийн ЕБС-иудын сургалтын жилийн төлөвлөгөөг Баян-Өлгий аймгийн БСУГ-ын дарга баталж мөрдүүлж байна. Энэ нь «Бага, дунд боловсролын тухай» хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасан “Ерөнхий боловсролын сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална ” гэсэнтэй зөрчилдөж байна. Баян-Өлгий аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын баталсан Хос хэлний сургалттай бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөөгөөр Ховд аймгийн Ховд сумын сургууль хичээллэх нөхцөл байдал үүссэн байна.

Асуудал 3: Монгол хэлний хичээл казах, тува хүүхдүүдэд 2 дугаар ангиас эхлэн орж байна. Гэвч өнөөг хүртэл үндэстний цөөнхийн хүүхдүүдэд зориулсан бага ангийн монгол хэлний хөтөлбөр боловсруулагдаж гараагүй ба монгол хэлийг казах, тува хүүхдүүдэд заах тусгайлсан арга зүй байхгүй.

Асуудал 4: Эх хэлний сургалтын хөтөлбөр хэрэгжиж удаагүй байгаа болохоор эх хэлний хичээлийг заах арга зүй мөн адил шинэчлэгдээгүй байна. Казах хэлний хичээлийн хувьд зөвхөн онол голлодог. Эх дээр

ажиллах, эхийн задлал хийх гэх мэт хэл бичгийн хичээлүүдийг заах орчин үеийн аргууд нэвтрээгүй байна.

Асуудал 5: Өнөөдөр Монгол улсад хос хэлээр хичээл заахаар бэлтгэгдсэн багш байхгүй. Тува, казах хэлний мэргэжлийн багш нарын хувьд Монгол Улсад мэргэжил дээшлүүлэх боломжгүй байна.

Асуудал 6: Сурах бичгийн хангамж, хүртээмж маш муу. Ялангуяа ахлах ангийн хувьд 30-35 хувийн хүрэлцээтэй байна. Зарим сурах бичиг маш их хуучирч, элэгдсэн. 4 дүгээр ангид Монгол хэлний гарын авлага ч байхгүй байна. 1 дүгээр ангийн 4 сурах бичиг тува хэлэнд, 1-5 дугаар ангийн 29 сурах бичиг казах хэлэнд орчуулагдсан байна. Сурах бичгийн орчуулгын чанар мөн анхаарал татаж байна.

Асуудал 7: Боловсруулагдаж, хэвлэгдсэн эх хэлний бүх сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийн санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сан хийсэн байна.

В. Судалгаа, нотолгоо

- **НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт зөвлөмжид** (2017 оны 6 сарын 2) “Бүх хүүхдийн нөхцөл байдал, нэн ялангуяа эмзэг байдлын нэн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн талаар дүгнэлт шинжилгээг сайжруулахын тулд Конвенцын бүх хүрээг хамруулан хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, яс үндэс, нийгэм-эдийн засгийн байдал зэрэг задаргаагаар мэдээллийг цуглуулах, мэдээлэл цуглуулах тогтолцоогоо аль болохоор яаралтайгаар үр дүнтэйгээр сайжруулахыг” зөвлөжээ. Мөн “Бүх түвшинд, бүх хүүхдэд боловсролын хүртээмж тэгш байхыг баталгаажуулах хүчин чармайлтаа бэхжүүлэх, ялангуяа Казах хүүхдүүд гэх мэт үндэстний болон хэлний цөөнх хүүхдүүд, бага орлоготой өрхийн хүүхдүүд, малчин өрхийн хүүхдүүд, алслагдсан хөдөө нутгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хөвгүүд, ялангуяа сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдэд илүү анхаарал хандуулах” арга хэмжээг заавал хэрэгжүүлэхийг Засгийн газраас шаардсан байна.

- **Хос хэлний боловсрол: Казах хүүхдүүдийн кейс судалгаа. Нээлттэй нийгэм форум, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. 2011.**


Монгол Улс үндэстний цөөнхийн эх хэлээрээ бага боловсрол эзэмших, хос хэлний хөтөлбөрөөр сургалт явагдах, соёл зан заншлаа өвлүүлэх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах, үндэс угсаа, хэл, соёлоороо ялгаварлагдахгүй байх, сурч боловсрох тэгш, боломжоор хангагдах эрхийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулж, холбогдох зарим хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд ерөнхийд нь шийдвэрлэж байгаа боловч боловсрол, түүний дотор сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд хос хэлээр сургалт явуулж буй сургуулийн сургалтын төлөвлөгөө, үндэсний онцлог бүхий хичээлүүдийн хөтөлбөр, соёл хоорондын боловсрол, сургалтын арга зүй, сурах бичгийн талаар нарийвчилсан зохицуулалт үгүй байна.

- Дээрх бодлого, хэрэгжилтийн хувьд тулгамдаж байгаа олон асуудал нийлээд Баян-Өлгий аймгийн сурагчдын эзэмшиж байгаа боловсролын чанар доогуур байхад нөлөөлсөн хэвээр байна. Тухайлбал:

БСШУЯ, Дэлхийн банк, “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс 2017 оны 4-5 сард Бага боловсролын математик, унших чадварын үнэлгээ, судалгаа хийж урьдчилсан үр дүнгээс тэгш байдлын үзүүлэлтийг авч харлаа. Нийгмийн цөөнхийн хувьд сурах, харилцах гол хэрэглүүр болсон хэлнээс боловсролын амжилт шалтгаалдаг тохиолдол бий. Судалгаанд оролцсон сурагчдыг үндсэн хэл болох монгол хэл ба үндэстний цөөнхийн казак хэлтэй сурагчдыг хооронд нь харьцуулж үзсэн. Казах үндэстний цөөнх нь нутгийн баруун хойд хэсэгт Баян-Өлгий аймагт оршдог ба хүн амын 3.7 хувийг эзэлдэг. Түүвэрт хамрагдсан сурагчдын 4 орчим хувь нь казак сурагч байсан ба бүх даалгаврууд дээр доогуур үнэлгээтэй байна.⁸⁸


⁸⁸ “Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан”, БСШУСЯ, Азийн хөгжлийн банк, 2019 он,

Зураг 5.1.23. Бага ангийн сурагчдын унших чадварын даалгаврын гүйцэтгэлийн хувь (Гэртээ монгол, казах хэлээр ярьдаг сурагчдын гүйцэтгэлээр)



Монгол хэлний даалгавар дээр хос хэлтэй буюу казах хэл дээр ярьдаг хүүхдийн гүйцэтгэл доогуур байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь голдуу математик чадварт бас нөлөөлдөг гэж үздэг тал бий. Харин математикийн суурь чадварын даалгавар дээр казах хэлээр гэртээ ярьдаг хүүхдийн гүйцэтгэл бусад хүүхдүүдээс энгийн даалгаврын гүйцэтгэлийн хувь 6-7 хувиар, ухагдахууны мэдлэг шалгах даалгаврын гүйцэтгэл 12-13 хувиар доогуур байна.

Зураг 5.1.24. Бага ангийн сурагчдын математикийн суурь чадварын даалгаврын гүйцэтгэлийн хувь (Гэртээ монгол, казах хэлээр ярьдаг сурагчдын гүйцэтгэлээр)



- Боловсролын хүрээлэнгийн** Үндэстний цөөнх болон гадаад дахь Монгол хүүхдийн боловсролын судалгааны сектороос 2013-2017 онд цуглуулсан мэдээллээс үзэхэд угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн боловсролын чанарт дорвитой өөрчлөлт гараагүй байна. Тухайлбал, 2016-2017 оны хичээлийн жилд тус секторын цуглуулсан мэдээллээс үзэхэд сурагчдын казах хэлний сорилын гүйцэтгэл 59 хувьтай, тува

хэлний сорилын гүйцэтгэл 58,2 хувьтай, монгол хэлний сорил 38,7 хувьтай байна.

Хүснэгт 5.1.3. Суралцагчдын унших, бичих чадварын сорилын ерөнхий дүн (2017)

Сорил	Авах ёстой оноо			Авсан оноо			Дундаж		
	казах	тува	монгол	казах	тува	монгол	казах	тува	монгол
Унших	1428	238		834	128	1307.5	53.4	53,7	50,7
Бичих	1224	204		794.8	128	1126.8	64.9	62,7	26,7
Нийт	2652	442		1628.8	256	2434,3	59	58,2	38,7

Хүснэгт 5.1.4. Суралцагчдын унших, бичих чадварын сорилын харьцуулсан гүйцэтгэлийн хувь (2013 ба 2017)

Сорил	Нийт гүйцэтгэл		Үүнээс			
			Унших		Бичих	
	2013	2017	2013	2017	2013	2017
Казах хэл	55,8	59	50,6	53,4	61	64,9
Тува хэл	42,6	58,2	42,8	53,7	42,5	62,7
Монгол хэл	43,3	38,7	49,9	50,7	36,7	26,7

Сурагчийн сорилын гүйцэтгэлийг 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд тува, казах хэл дээр сорил өгсөн сурагчдын гүйцэтгэл ерөнхийдөө ахисан үзүүлэлттэй байна. Ялангуяа эх хэл дээр бичих сорилын даалгаврын гүйцэтгэл нэлээд ахисан, харин монгол хэл дээр бичих үзүүлэлт буурсан байна. (Боловсролын хүрээлэн, 2019)

• **Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, 2017**

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин бараг 100%-д хүрсэн ч хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнхийн хүүхдийн сургуульд хамрагдалт бага, тэгш хамран сургах арга зүй, хандлага сул байна.

• **Сургуулийн өмнөх боловсролын салбарын дүн шинжилгээ, 2019, БСШУЯ, ДБ**

Баян-Өлгий аймгийн СӨБ-ын хамран сургалт (60,7%) улсын дунджаас (79.8%) доогуур үзүүлэлттэй байна. Үндэстний цөөнх болох казах өрхүүдийн хүүхдийн СӨБ-д хамрагдах нь бусад аймгаас харьцангуй бага буюу 19 пунктээр доогуур байна.

Халх болон бусад үндэстний өрхийн тэргүүнтэй айлын хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал 80 гаруй хувьтай байгаа бол казах өрхийн тэргүүнтэй айлын хүүхдийн 59% сургуульд бэлтгэгдсэн байна.

- **НҮБ-ын Хүүхдийн сан, 2010 он**

“Баян-Өлгий аймгийн хувьд боловсролын зарим үзүүлэлтүүд улсын дунджаас доогуур байна. Тухайлбал, тус аймагт сургууль завсардалтын хувь хамгийн өндөр (улсын дундаж 1.1 хувь, Баян-Өлгий аймаг 4.7 хувь), сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь хамгийн бага (улсын дундаж 76 хувь, Баян-Өлгий аймаг 65.4 хувь), бичиг үсэгт үл тайлагдалтын хувь улсын дунджаас өндөр (улсын дундаж 4.6 хувь, Баян-Өлгий аймаг 6.8 хувь) байна. Түүнчлэн казах хүүхдүүд сургуульд зохих насандаа элсэхгүй байгаа нь сургууль завсардах болон сурлагын амжилт доогуур байхад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

- **Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан, 2019, БСШУЯ, БХ, ЮНЕСКО-гийн Үндэсний комисс**

Бид энэхүү БСМТ-д инклюзив/тэгш хамрах боловсролыг “бие махбод, оюун ухаан, сэтгэл мэдрэхүйн онцлог байдал, нийгэм, хэл зүйн зэрэг бусдаас ямар нэг ялгаатай нөхцөл байдлаасаа үл хамааран хүүхэд бүр сургуульд хамрагдах боломжтой байх явдал (Саламанкагийн тунхаглал-1994, 2014)” гэсэн. Саламанкагийн тунхаглалыг иш үндэс болгон боловсролын гадна үлдэх эрсдэл бүхий дараах бүлгийг хамруулан авч үзлээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид
- Малчдын хүүхдүүд
- Лам хүүхдүүд
- Үндэстний цөөнх болон гадаадад суралцаж буй монгол иргэдийн хүүхдүүд зэрэг болно.

- **ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТАЙЛАН, БАЙР СУУРИАС⁸⁹**

СӨБ-ын хувьд өнөөдрийн байдлаар 3-5 насны нийт хүүхдийн 70 гаруй хувь нь СӨБ-ын албан ёсны үйлчилгээ буюу цэцэрлэгт, 9 хувь

⁸⁹ “ТХЗ 4-р зорилгын хэрэгжилт: Тэгш хамруулсан, эрх тэгш байдлыг баталгаажуулсан чанартай боловсрол, насан туршдаа суралцах боломжийг бүх хүнд баталгаажуулах” байр суурийн баримт бичиг. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2019 он

нь хувилбарт сургалтад хамрагдаж байна. СӨБ-ын хамран сургалтын хувьд газарзүйн байрлал, яс үндэс, өрхийн аж байдлын түвшин зэргээс хамааралтай ялгаа байгаа нь анхаарал татах асуудал.

Цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн дунд хийсэн бага насны хөгжлийн үр дүнгийн судалгаанаас харахад хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал нийгэм-эдийн засгийн байдлын түвшингээс хамааран хол зөрүүтэй байна. Эрэгтэй, үндэстний цөөнх, тусгай хэрэгцээтэй байх зэрэг нь хүүхдийн хөгжлийн үр дүнд шууд нөлөөлж, бага буюу доогуур оноо авах нөхцөл болж байна

Боловсролын Ерөнхий хуулийн төсөлд өгсөн саналаас

Боловсролын зарчим

4.1.3. боловсролыг тэгш, хүртээмжтэй ялгаварлан гадуурхахгүйгээр олгох;

5 дугаар зүйл. Боловсрол эзэмших сургалтын хэл

5.1. Бүх шатны боловсрол эзэмших сургалтын хэл нь монгол хэл байна.

5.2. Хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн суралцагч болон тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийн сургуулийн өмнөх болон бага боловсрол эзэмших хэлийг холбогдох хуулиар зохицуулна.

5.3. Боловсролын сургалтын төлөвлөгөөнд заасан гадаад хэлийг эзэмшүүлэхэд энэ хуулийн 5.1 дэх хэсэг хамаарахгүй.

9 дүгээр зүйл. Суралцагчийн эрх, үүрэг

9.1. Суралцагч дараах эрхтэй:

9.1.3. уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд эх хэлээрээ харилцах;

Багш нь дараах эрхтэй байна:

12.1.2. Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, онцлогт нийцсэн суралцахуйн арга барил, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хэлбэрээ сонгон хэрэглэх;

17 дугаар зүйл. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага

17.1. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь дараах чиглэлээр суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг тасралтгүй эрхэлнэ:

17.1.7. үндэстний цөөнх, гадаад улсад амьдарч байгаа монгол хүүхдэд Монгол Улсын сургалтын хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлэх;

32 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

32.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.6. үндэстний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий Боловсролын тухай хуулийн төсөлд

7 дугаар зүйл. Сургалтын хэл

7.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг монгол хэлээр явуулна.

7.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т зааснаар батлагдсан хос хэлний хөтөлбөрийн дагуу сургалт явуулах цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг тогтооно.

7.3.Энэ хуулийн 7.2-т зааснаар цэцэрлэг, сургуулийн сургалтын үйл ажиллагаа явуулах хэлийг тогтоох нь суралцагч эх хэлээрээ суралцах, харилцах эрхийг үл хөндөнө.

7.4.Сургуулийн өмнөх боловсрол болон бага, дунд боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулах хэлээс өөр эх хэлтэй суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч эх хэлээрээ суралцах хүсэлтээ харьяа сум, дүүргийн Засаг даргад гаргаж болно.

7.5.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчийн хүсэлтийг харгалзан энэ хуулийн 7.4-т заасан хүсэлтийг гаргаж болно.

7.6.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 7.4, 7.5-д зааснаар хүсэлт гаргасан нэг түвшний суралцагчийн тоо 10 ба түүнээс дээш болсон тохиолдолд тэдгээрийг нэгтгэн бүлэг болгож, эх хэлээр нь суралцах бололцоог олгоно.

7.7.Тухайн сум, дүүргийн хэд хэдэн сургуулийн суралцагчийг нэгтгэн бүлэг болгох тохиолдолд аль сургуульд бүлэг нээх асуудлыг эцэг, эх, асран хамгаалагчийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

7.8. Энэ хуулийн 7.7-д зааснаар байгуулагдсан бүлэгт зургаа ба түүнээс дээш тооны суралцагч суралцсан хэвээр байгаа тохиолдолд тухайн бүлгийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлнэ.

8 дугаар зүйл. Сургалтад дохионы хэл, брайл үсэг ашиглах

8.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12.1-д зааснаар эх хэл нь дохионы хэл болох сонсголгүй хүүхэд эсхүл мэргэжилтний дүгнэлтээр дохионы хэлээр сургалт авах шаардлагатай суралцагч дохионы хэлээр цэцэрлэг болон ерөнхий боловсрол эзэмших эрхтэй байна

8.2. Харааны бэрхшээлтэй болон бүрэн хараагүй хүүхдэд зориулсан сургалтыг брайл үсэг болон бусад шаардлагатай хэрэгслийн тусламжтайгаар явуулна.

8.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 8.1, 8.2-т зааснаар сургалт явуулах цэцэрлэг, сургуулийг тусгайлан тогтоож болно.

8.4. Энэ хуулийн 8.3 дахь хэсэг нь бусад цэцэрлэг, сургуулийг сонсгол болон хараагүй хүүхдэд сургалтын үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахгүй.

Тус хуулийн 4-р бүлгийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтад: “... Эх хэлээрээ суралцаагүй үндэстний цөөнхийн хүүхэд болон хилийн чанад дахь монгол хүүхдэд зориулсан эх хэл түүх соёлын жишиг сургалтын хөтөлбөрийг боловсруулна”

Мөн 4-р бүлгийн 11-р зүйлийн 11.8 дахь заалтад: “...Сурах бичгийг сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан зохионо.” /Хос хэлний хөтөлбөрийн шинэчлэлтэй холбож болох/

11.11 дахь заалтад: “...Сурах бичгийг хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хөрвүүлнэ” /үндэстний цөөнх, дохионы хэл гэх мэт... холбох/

Мөн хуулийн 5-р бүлгийн 15-р зүйлийн 15.3 дахь заалтад: “... Багш нь тусгай хэрэгцээт болон хэл соёлын ялгаатай хүүхэдтэй ажиллах тохиолдолд тэдний онцлогт тохирсон заах арга эзэмшсэн байна” /хос хэлний багш бэлтгэх, давтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд хэрэгтэй/

Д.ТУНГАЛАГ

АШГИЙН ТӨЛӨӨ БУС БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА⁹⁰

Үндэслэл

Боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус байгууллагууд салбарын хууль тогтоомжийн хүрээнд харилцан адилгүй зохицуулагдаж, бүртгэл, тайлагналын хувьд ойлгомжгүй байдал үүсгэж, ашгийн болон ашгийн төлөө бус⁹¹ үйл ажиллагааг ялгаж салгахад ч хүндрэл учруулж ирлээ.

Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчлөлтэй байж болох бөгөөд ашгийн төлөө болон ашгийн бус зорилготойгоор үйл ажиллагаа явуулж болохоор Иргэний хуульд нээлттэй зохицуулсан байдаг. Гэтэл хуулийн этгээдийг тодорхойлсон Иргэний хуульд “ашгийн төлөө”, “ашгийн төлөө бус” зорилго нь хэрхэн ялгагдах, үүнд үндэслэн холбогдох зохицуулалт ямар байхыг тодорхойгүй орхисон. Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулсан бусад хуульд ч энэхүү ялгаа нь тодорхойгүй, бүдэг зааглагдсан байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан “Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно” гэсэн эрх зүйн харилцааны суурь нөхцөлийг эдгээр үйл ажиллагааны зорилго, мөн чанар, үр дагавартай холбон нарийвчлан тодотгосон зохицуулалт хуульд тун ч бүдэг байна. Үүнийг тодотгож байж ашгийн төлөө, эсвэл ашгийн

⁹⁰ Энэ хэсгийг “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг боловсруулав.

⁹¹ Ашгийн бус зорилготойгоор үйл ажиллагаа явуулах үзэл санаа бол Төрөөс үзүүлэх үйлчилгээг бүрэн хамрагдаж чадахгүй байгаа хэсэгт Төрийн үйлчилгээг нөхөх зорилготойгоор анхлан гарч ирсэн. Ихэвчлэн боловсрол, эрүүл мэнд, соёлын чиглэл, ардчиллыг дэмжих, тухайн нийгэмд хэрэгцээтэй байгаа Төрөөс бүрэн хүрч чадахгүй байгаа үйлчилгээ ... зэрэг, тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр нийтэд (нийгэмд) ашигтай байдаг учраас. Төрөөс хамааралтай биш, мөн хувийн ашиг олох зарчимтай үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээс ялгаатай нь ашиг хуваарилах, ашиг олох зорилгогүйгээр ажилладаг тул гуравдагч буюу ашгийн бус зорилготой (Хуулийн этгээд) гэж нэрлэдэг. Non profit organization буюу ашгийн бус хуулийн этгээд нь удирдлага менежментийн хувьд ашгийн төлөө хуулийн этгээдтэй адил уян хатан, шуурхай, хүнд сурталгүй ажиллах, нөгөө талдаа өмчлөлийн хувд олон нийтийн (public) буюу хэн нэгэн ашиг хүртэгч эзэн, хувь хүн, хуулийн этгээдийн гэж байх ёсгүй юм.

төлөө бус хуулийн этгээдтэй харьцах зохицуулалт боловсронгуй болох нөхцөл бүрдэнэ.

Ялангуяа боловсролын салбарт улсын төсвөөс хувийн хэвшлийн боловсрол сургалтын байгууллагад дэмжлэг өгдөг нь энэхүү зохицуулалтыг нарийвчлах шаардлагыг үүсгэж байгаа билээ. Ерөнхийдөө ашгийн төлөө ажилладаг боловсролын бизнесийн байгууллагад улсын төсвөөс татаас өгөх нь шударга ёс, эрх тэгш байдал, хүний эрхийн зарчмын үүднээс авч үзэхэд маргаантай юм. Үндсэн хуульд зааснаар “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” байх ёстой.

Сүүлийн хориод жилд боловсролд нео-либерал зах зээлийн зарчим, хандлага илт нэвтэрснээр боловсрол олгодог хувийн хэвшлийн оролцогчдын тоо эрс нэмэгдсэн дэлхийн хөгжлийн чиг хандлагаас Монгол улс хоцроогүй юм. 1993 онд анхны хувийн сургуулиуд Улаанбаатар, Дархан хотод байгуулагдаж байсан бол өнөөдөр нийт сургуулиудын 19,9%-ийг хувийн хэвшлийн сургууль эзэлж, нийт суралцагчдын 7% төрийн бус өмчийн сургуульд суралцаж байна. Тэдний тодорхой хувь нь өөрсдийгөө ашгийн төлөөх байгууллага гэж тодорхойлсон байгааг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 2. Ашгийн бус хуулийн этгээд: ОӨУБЕГ-ын мэдээ

№	Хуулийн этгээдийн хэлбэр	Хуулийн этгээдийн тоо
1.	ТББ	17,599
2.	Сан	1,302
3.	Шашны байгууллага	549
4.	Үйлдвэрчний эвлэл	1,264
5.	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд	1
6.	Хэвлэл мэдээллийн байгууллага	1,072
7.	Боловсрол сургалтын байгууллага	819 (ашгийн - 26, ашгийн бус - 670)
8.	Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар (Төрийн өмчит их сургууль)	16

Үндсэн хэсэг

Монгол улсын Үндсэн хуулийн ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ хэмээх Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

гэж заасан байдаг.

Энэ заалт нь хувь хүний хувийн сургууль байгуулах эрхийн тухай заалт биш эцэг эхчүүдийн хүүхдэдээ төрийн байгуулснаас өөр сургууль, тухайлбал, өөрийн шашин шүтлэг, ёс суртахууны итгэл үнэмшилд нийцсэн сургуулийг сонгож өгөх эрх чөлөөнөөс үүдэлтэй юм.

Дараагийн чухал санаа нь *“төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль”*-ийн тухай санаа бөгөөд төрөөс боловсролын үйлчилгээ үзүүлэгч хувийн оролцогчдод минимум стандарт тавьж, хангуулах, хянах, зохицуулах тухай асуудлыг хүний эрхийн гэрээгээр зөвшөөрсөн гэсэн үг. Тиймээс Боловсролын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар бүх шатны сургуулийг байгуулахад тусгай шаардлагууд тавьж, хангасан тохиолдолд байгуулан ажиллуулах тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар олгож, шаардлага хангасан тохиолдолд сунгаж, эс бөгөөс цуцалдаг эрхийг төрийн захиргааны төв байгууллага болох Боловсролын яаманд өгсөн байдаг.

Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл чиг хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байхаар Үндсэн хуульд тусгасан ч “... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах” үүргээ төр өөртөө авч үлдсэн байдаг. Мөн түүнчлэн төр нь “нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах” ч “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах” үүргээ мөн өөртөө авч үлдсэн байдаг.

Боловсрол дахь ашгийн бус ба ашгийн төлөө этгээд

Иргэний хуулийн 25 дугаар зүйлд хуулийн этгээдийг “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.” гэж тодорхойлоод “хуулийн

этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно” гэж заасан байдаг.

Мөн “хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.” гэсэн байгааг анхаарах хэрэгтэй. Манай нийгэмд хувийн л бол ашгийн төлөө байдаг гэсэн ойлголт түгээмэл. Ялангуяа боловсролын салбарт бусад улс оронд хувийн боловч ашгийн бус боловсрол сургалтын байгууллага дийлэнх байна. Сүм хийд, тосгон, ТББ зэрэг этгээдүүдийн зүгээс сургууль байгуулж, төлбөргүй, ашгийн бус ажиллуулах нь түгээмэл.

Цаашилбал “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр” байгуулахаар харин “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр” байгуулахаар хуульчилсан. “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани” гэхээр тодорхойлсон тул хувийн ашгийн төлөө сургууль компани болж, компанийн хуулиар үйл ажиллагаа явуулах хэрэгтэй болно.

Тэгтэл энэ нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд заасан дараах 2 заалттай зөрчилдөнө:

- Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
- Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Хүүхдийн эрхийн, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцууд, Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн Олон улсын пакт зэрэг хүний эрхийн олон тооны гэрээгээр төр нь сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хэрэгжүүлэх, хангах үүргийг хүлээсэн байдаг. “Төрөөс боловсролыг өөрөө хариуцан олгох, сургуулийн тогтолцоог байгуулж хөгжүүлэх үүргийг хүлээсэн байдаг ба энэ үүргээ хувийн оролцогчдод үүрүүлэн үүрэг хариуцлагаасаа чөлөөлөгдөх ёсгүй” гэдгийг Европын Хүний эрхийн шүүх шийдсэн байдаг. Тухайн улсад хувийн сургуулиуд үйл ажиллагаа явуулж байвал тэдгээр этгээдүүдээр нь хүний эрхийн зарчмуудыг мөрдүүлэх нь төрийн үүрэг хэвээр байна. Боловсролд

хүнийг аливаа байдлаар ялгаварлан гадуурхахгүй, хүртээмжийн тэгш байдлыг хангах, нийгмийн шударга ёсонд халгүй байх, эрх тэгш байдлыг гүнзгийрүүлэхгүй байх үүргийг хувийн хэвшлийн оролцогчдод үүрүүлж байнга хянаж нягталж байх үүргээ төр биелүүлнэ.

Боловсрол бол нийтийн сайн сайхны зүйл (public good) гэж үздэг улс орнууд боловсрол нийтийн эрх ашигт үйлчлэх ёстой ба хувь хүний болон корпорейт ашиг сонирхолд үйлчлэх ёсгүй гэж хуульчилсан байдаг (Эквадорын Үндсэн хууль) бол боловсрол, мэдлэг нь төрөөс баталгаажуулдаг нийтийн сайн сайхны зүйл (Аргентины Боловсролын хууль), төрөөс боловсролыг хамтын сайн сайхны зүйл гэж хөхиүлэн дэмжинэ (Доминикан улс), боловсрол бол нийгмийн сайн сайхны зүйл (Бразил улсын Үндсэн хууль) хувийн хэвшлийн олгож байгаа боловсрол төрийн үйлчилгээ байх шаардлага тавьж, ашгийн төлөө байхыг хориглодог хуультай улс орнууд нэлээдгүй байна.

НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгч Кишор Сингх өөрийн тайландаа ашгийн төлөө сургууль байхыг шууд хориглосон хуультай улс орнууд ч (Финлянд, Катар, Бразил, ӨАБНУ, Хятад, Бахам зэрэг) байгааг дурдаад бусад улс орнуудыг ашгийн төлөө боловсролыг бодлогоор хориглож, хуульчлахыг уриалсан байна.

Ашгийн төлөөх хувийн боловсролын байгууллагууд (Commercially-orientated private educational institutions) гэдэгт үйл ажиллагааных нь үндсэн гол зорилгын нэг нь боловсролын үйлчилгээг худалдах/арилжаалах байх ба нийтийн ашиг сонирхолд үйлчлэхээс илүүтэй өөрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан байгууллагыг хэлэхээр тодорхойлсон байдаг. Тэд боловсролыг бараа гэж харах тул бусад байгууллагуудтай өрсөлдөж, өөрийн загвар, үйл ажиллагааг өргөжүүлэн тэлж, борлуулалтаа нэмэгдүүлж, улмаар ашиг орлогоо өсгөдөг. Ихэнх тохиолдолд тэдгээр байгууллагууд өөрсдийгөө төрийн (public) үйлчилгээний үүргийг гүйцэтгэдэг байгууллага, төрийн/нийтийн боловсролын тогтолцоонд нэгдэх, нэгдэхээр бэлтгэх ёстой гэдэг ойлголтыг хүлээн зөвшөөрдөггүй.

Ашгийн төлөөх боловсролын байгууллагын гол ялгарах онцлог нь компанийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд үйл

ажиллагаагаа тэлэх зорилгоор маркетингийн үйл ажиллагаа өргөнөөр явуулах багтана. Илүү олон боломжит үйлчлүүлэгчдэд хүрэхийн тулд сургуулийнхаа талаар зар сурталчилгаа хийж, маркетингийн ажилтан ажилд авч, маркетингийн хэлтэс байгуулж, сонин, зарын самбар, радио, телевизээр зар сурталчилгаа цацаж байна. Сургуультайгаа танилцуулах аялал, найзыгаа авчрах оройн сургууль зохион байгуулах зэргээр харагдах байдлаараа (визибилити) татах зорилготой тусгай арга хэмжээнүүд зохион байгуулдаг байна. Зээл авах, өндөр төлбөр тогтоох, төлбөрөө байнга нэмэгдүүлэх, олимпиадад дээгүүр байр эзэлсэн хүүхдийг төлбөргүйгээр элсүүлэх, төгсөгчдөө сурталчлах зэргээр боловсролын тохиролцоо хийх зэрэг нь ашгийн төлөөх шинж чанар гэж үзэж болохоор байна.

Боловсролын тухай хуульд ашгийн төлөө бус боловсрол сургалтын байгууллагыг “ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага” гэж сургалтын үйл ажиллагаа явуулах үндсэн зорилготой, үйл ажиллагаанаасаа олсон ашгийг (орлогыг) зөвхөн үндсэн зорилгын дагуу зарцуулдаг, үндсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагддаггүй хуулийн этгээд” гэж нь ашгийн төлөө бус хуулийн этгээдэд тавих үндсэн шалгуурыг тодруулсан.

Гэхдээ хүний эрхийн хуульчид ашгийн бус ба ашгийн төлөө хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудыг ялгах маш нарийн зааг байдаггүй тул төвөгтэй гэж үздэг. Ашгийн төлөөх этгээдүүд ихэнхдээ олон улсын болон үндэстний том сүлжээ сургууль ажиллуулагчид, эсвэл үндэсний эзэмшигчтэй нэг сургууль ч байж болдог. Харин төрийн бус байгууллага болон шашны сургуулиуд ихэнхдээ ашгийн бус байдаг. Ашгийн бус сургууль гэж бүртгүүлсэн ч үүсгэн байгуулагч эсвэл захиралдаа үлэмж хэмжээний цалин өгсөн байдаг. Өндөр төлбөртэй байх, хөтөлбөрийнхөө хамгийн зардалтай хэсгүүдийг хасаж танан зардлаа багасгасан байх, хамгийн их дэмжлэг хэрэгтэй суралцагчдыг сургуулиасаа хасах, сургуулийн барилга байшин муу нөхцөлд байх зэрэг нь боловсролоос ашиг олж байгааг харуулах магадлалтай.

Салбарын хууль эрх зүйн актаар Эрүүл мэнд, боловсролын байгууллага, Шашны байгууллагын хяналтыг сайжруулж тус тусын салбарын хуулиар зохицуулах нь тухайн салбарын бодлого нэг мөр

хэрэгжих, нэгдсэн зохион байгуулалт, хяналтын хүрээнд хөгжих боломжийг бүрдүүлэх давуу талтай гэж судлаачид үзэж байна.

Боловсрол ашгийн төлөө байхыг хаах, хянах механизм

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд 2 чухал заалт байдаг:

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.
2. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

Япон, Сингапур зэрэг орнууд Хувийн боловсролын талаарх хуультай бөгөөд маш нарийн зохицуулалттай байдаг нь хувийн хэвшлийн зүгээс хүний/хүүхдийн эрхийг зөрчихөөс хувь хүнийг хамгаалах үүргээ төр нь олон улсын гэрээний дагуу биелүүлж байгаа гэсэн үг юм. Төрийн зохицуулалт бол төрийн хүний эрхийг хамгаалах үүргийн хүрээнд багтах ба хэд хэдэн улсын шүүх хувийн боловсрол олгогчдыг төрийн болон олон нийтийн өмнө хариуцан тайлагнах үүрэгтэй гэдэг шийдвэрийг гаргасан байдаг. (Непалийн Дээд шүүх, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх, Энэтхэгийн Дээд шүүх, Колумбийн Үндсэн хуулийн шүүх)

Сургалтын төлбөрийг зохицуулах шаардлагын хүрээнд

Сургалтын төлбөрийг зохицуулахгүй бол хүн амын тодорхой хэсэгт боловсрол эдийн засгийн хувьд хүртээмжгүй болно. Сургалтын төлбөрийн байж болох дээд хэмжээг зааж өгөх, урьдчилан зөвшөөрөл авалгүй сургалтын төлбөр нэмэхийг хориглож болно. (Бутан, Камерун)

Ил тод байх

Эцэг эх, багш, ИНБ-дад өөрийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, менежментийн талаарх мэдээллээ нээлттэй хуваалцах ёстой. Нийгэм, багш, сурагч, орон нутгийн иргэдийн өмнө хувийн хэвшлийн оролцогчдын хүлээх үүрэг, хариуцлагыг маш тодорхой тусгасан зохицуулалт хийх шаардлагатай.

Ашгийн төлөө ажиллаагүй гэдгийг нотлохын тулд жил бүр

санхүүжилтийн эх үүсвэрээ тайлагнах үүрэг хүлээлгэж, хувийн сургуулиудын санхүүгийн эх үүсвэрийг хянах ёстой.

Хяналт мониторингийн механизм

Хуулийн хэрэгжилтийг хянах үүднээс төрийн зүгээс Хяналт мониторингийн механизм ажиллуулах ёстой.

Хувийн хэвшлийн боловсролын байгууллагууд боловсролоос ашиг олох байдлыг хаахын тулд хэд хэдэн чиглэлээр арга хэмжээ авч болохыг хүний эрхийн хуульчид зөвлөдөг: журамласан, хориглосон, шийтгэлийн хэлбэртэй.

а. Журамласан зохицуулалт:

Хувийн сургууль байгуулагдах, үйл ажиллагаа явуулах, хөтөлбөр, багшийн мэргэжил, дэд бүтцийн стандарт гэх мэт минимум стандарт тогтоох, өөрөөр хэлбэл тухайн байгууллагад тавигдах үндсэн шаардлагуудыг тодорхойлж өгнө. Тайлан өгөх үүрэг оноох, тухайлбал, гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн тайлан, мониторингийн ба хяналтын байгууллагаас авсан дүгнэлтийг шаардах ёстой.

б. Хориглосон зохицуулалт:

Ашгийн төлөө ажиллахыг хориглох, нийгэм-эдийн засгийн тэгш бус байдлыг үүсгэж, бэхжүүлж байдаг тул төлбөр дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг хориглох ёстой. Хувийн сургуулиудыг компани гэж бүртгүүлэхийг хориглох, төрийн өмчийн сургуулиас багш ажилд авахыг хориглох, мэргэжлийн бус багш ажилд авахыг хориглох, хичээлийн жилийн үеэр сургуулиа хаахыг, мэдээлэл муутай эцэг эх, сурагчдыг хуурамч зар сурталчилгаагаар урхидах, батлагдсан төлбөр дээр нэмж, эцэг эх, сурагчдаас, аливаа байдлаар төлбөр хураамж авахыг хориглох ёстой. Хүүхдийг чадвар, нийгмийн болон үндэс гарлаар, ямар нэг хэлбэрийн тестээр шалгаж сонгож авахыг хориглох ёстой.

с. Шийтгэх зохицуулалт:

Аливаа дүрэм журмыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хураах, луйврын залилангийн, авлигын шинжтэй үйлдлүүд гаргах, багш нарт өгсөн цалин хөлс, олсон ашгаа худал тайлагнах, татвараас зайлсхийх зэрэгт шийтгэл оноохоор зохицуулалтууд байх ёстой. Луйврын, залилангийн, авлигын шинжтэй үйлдлүүдийг мөрдөн шалгах, сурагчдын

төлбөрийг авч зугтах зэргээр хууль бус үйлдлүүд хийсэн сургуулийн эздийг эрүүгийн хуулиар шийтгэх нь чухал.

НҮБ-ын сурч боловсрох эрхийн тусгай илтгэгчид хувийн хэвшлийн оролцогчдыг төрөөс зохицуулахдаа “Абижаны зарчмууд” баримт бичгийг ашиглахыг зөвлөдөг.

Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагыг төрөөс зохицуулах нь

Боловсрол - хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр - нэр төртэй, эрх чөлөөтэй амьдралын баталгаа бөгөөд бидний хамтын амьдралын мөн чанарыг, бид хүмүүнлэг, ардчилсан, шударга нийгэмд амьдрах эсэхийг тодорхойлох хүчин зүйл, нийгмийн баялаг, бид бүгдийн нийтийн өмч билээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэж, мөн зүйлийн 7 дах хэсэгт “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно” гэж заасан.

Боловсролын хуулийг Үндсэн хуульд нийцүүлэх үүднээс ТӨРӨӨС ТАВИХ ШААРДЛАГА-ыг шинэчлэн сайжруулах эрэлт хэрэгцээ нийгэмд үүслээ. Үүнд:

Боловсролын хуулийн төсөлд өгч буй САНАЛ:

1. Ашгийн төлөө ба ашгийн төлөө бус боловсрол сургалтын байгууллагуудын талаарх зохицуулалтыг нарийвчлах
 - а. Бүх сургууль, боловсрол сургалтын байгууллага ашгийн бус байх заалт тусгах
2. Төлбөртэй төрийн бус өмчийн сургуульд улсын төсвөөс өгдөг дэмжлэгийг зогсоох.
3. Дараах сургалтын байгууллагыг цаашид төрөөс дэмжлэг үзүүлэхгүй байхаар хуульчлах:
 - эдийн засгийн боломж, чадварыг харж сонголт хийдэг,
 - ашгийн төлөө ажилладаг, эсвэл арилжааны чиглэлтэй,

- ялгаварлан гадуурхал гаргадаг,
- чанарын шаардлага хангаж чадахгүй байгаа зэргээр эрх зүйн хүрээнд хуулиар хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөх.

Боловсролын багц хуулийн заалтууд уг хуульд өөрөөр заагаагүй бол өмчийн бүх хэлбэрийн боловсрол сургалтын байгууллагад үйлчилнэ гэдгийг тодотгосон заалт оруулах. Хуульд төрийн бус өмчийн боловсрол сургалтын байгууллагын талаар дараах зохицуулалтыг оруулах:

- Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүүхэд элсүүлэх
- Сургалтын чанарыг тогтмол хангах, сайжруулах
- Сургалтын төлбөр тогтоох
- Сургууль, цэцэрлэг дэх авлигатай тэмцэх зохицуулалт, үр дүн бүхий дотоод хяналтын тогтолцоо бий болгох
- Боловсролын сургалтын байгууллагын зар сурталчилгаанд тавих хязгаарлалт
- Ялгаварлан гадуурхахгүй байх, хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт хийх
- Сургалтын хөтөлбөр, сурах бичиг болон сургалтын бусад материалууд, сургалтын үйл ажиллагаанд, үнэлгээний систем, сургалт явагдаж байгаа хэлэнд хяналт тавих
- Багш нарын мэргэжил, ур чадварын шаардлага, багш сурагчийн харьцаа, багшийн цалингийн шатлал, доод хэмжээг тогтоох, багшийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг зохицуулах
- Материаллаг дэд бүтэц: анги танхим, бусад өрөө танхим, орчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын гэх мэт шаардлага тавих
- Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн: сурах бичиг, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан гэх мэт
- Хүүхэд хамгаалал (бэлгийн дарамт, бие махбодын шийтгэлээс урьдчилан сэргийлэх хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тодорхой стандарт болон хяналт тавих аргачлал, дүрэм журам гэх мэт)

Олон улсын туршлага

Олон улсын түвшинд хувийн хэвшлийн сургалтын байгууллагуудын талаар дараах зохицуулалтуудыг хийдэг байна:

№	Зохицуулалт хийх гол асуудлууд
1	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийг үүсгэн байгуулах болон “тусгай зөвшөөрөл олгох” улсын бүртгэлд бүртгүүлэх дүрэм, журам бий болсон
2	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд тавигдах шалгуур үзүүлэлт, (тусгай зөвшөөрлийн шаардлага) магадлан итгэмжлэлийн шаардлагуудыг тодорхой болгосон
3	Санхүүжилтийн түвшин, механизм (төсвөөс санхүүжилтээ авах, зарцуулах, тайлагнах гэх мэт үйл явцыг шаардсан байдлаар журамласан байх)-ыг хуульчилсан
4	Татвар болон гаалийн хураамж тодорхой
5	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн засаглал, удирдлагатай холбоотой дүрэм журмуудыг гаргасан.
6	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд элсүүлэх, хамран сургах журмыг тодорхой болгож, элсэлтийн шалгалт авахгүй байхаар зохицуулсан.
7	Сургалтын хөтөлбөр
8	Өдөр тутмын үйл ажиллагаа
9	Мэдээллийг нийтэд, эсвэл эцэг эхэд ил тод болгох шаардлагууд
10	Багш, сурган хүмүүжүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт
11	Багшийн ажиллах нөхцөл, статус, багшийн мэргэжил эзэмшсэн байдал, мэргэшүүлэх сургалт, цалин болон мэргэжлийн ур чадварт тавигдах стандартууд
12	Сургалтын чанарыг баталгаажуулах дүрэм, журам, үйл явц
13	Сургалтын төлбөрийг тогтоох аргачлал (хэрхэн тогтоох, хэн хэн оролцох, төрөөс хэрхэн хянах гэх зэргийг зохицуулсан эсэх удирдамж)
14	Эрүүл ахуй, аюулгүй байдал
15	Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн авлигатай тэмцэх хууль зүйн зохицуулалт эсхүл өндөр үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоо
16	Эцэг эхийн оролцоог дэмжсэн зохицуулалт
17	Багш нарын холбоог дэмжих баталгаа (Үйлдвэрчний эвлэл, эвлэлдэн нэгдэх байгууллага байгуулах эрхийг баталгаажуулсан)
18	Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн олгож буй боловсролын чанарын талаарх мэргэжлийн хяналт шалгалт
19	Боловсролын зар сурталчилгаанд нийтийн сайн сайхны тусын тулд хяналт тавих эрх зүйн зохицуулалт
20	Ялгаварлан гадуурхахгүй байх болон хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт (Хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, гэх мэт хүүхдийг элсүүлэн сургах байдлыг баталгаажуулсан эсэх)

Тулгамдаж байгаа бодит асуудлууд

Бодит байдалд ялгаварлах, гадуурхах хандлага болон сөрөг асуудлууд хувийн сургуулиудын түвшинд нэмэгдсээр байгаа нь боловсрол эзэмших эрхийг зөрчихөд хүргэж, бүх нийтээр тэгш шударга, чанартай боловсрол

эзэмшихэд илэрхий саад тотгор учруулж байгааг нотолгоо харуулж байна.

Нотолгоо 1 Тэгш бус байдлыг нэмэгдүүлэх санхүүжилт⁹²

Засгийн газрын боловсролын санхүүжилтийн бодлого тэгш байдлыг хангахад биш, тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжиж байна. Учир нь нэгдүгээрт, улсын төсвөөс 30 гаруй лаборатори сургуулийг илүү хэмжээгээр санхүүжүүлдэг. Хоёрдугаарт, улсын төсвөөс хувийн сургуулиудын хувьсах зардлыг санхүүжүүлж байгаагаар тус тус илэрнэ.

Боловсролын тухай хуулийн 40.2-д заасны дагуу төсвөөс хувийн хэвшлийн бүх цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад нэг суралцагчид ногдох норматив зардлыг суралцагчдын тоогоор үржүүлэн олгодог бөгөөд үдийн цай хөтөлбөрийн нэг хүүхдэд ногдох санхүүжилтийг ч нэмж олгож байна. Эдгээр хувийн сургуулиудад амьжиргааны дунд болон дундаас дээш түвшний өрхийн хүүхдүүд суралцдаг бөгөөд доогуур орлоготой болон хөдөө орон нутагт амьдардаг, мөн нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүдтэй яг ижил норматив зардлын санхүүжилтийг нэмж авч боловсрол эзэмшиж байгаа нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна хэмээн үзэж байна.

Нотолгоо 2 Төлбөрийн асуудал - хяналтгүй, эцэг эхийн оролцоо, хяналтгүй байдал⁹³

Сургалтын төлбөрийг сургуулиуд дангаараа, жил бүр нэмэгдүүлэх байдлаар тогтоож ирсэн. Сургалтын төлбөрийн зэрэгцээ, зарим сургууль хүүхдийн дүрэмт хувцас, хоол, сурах бичиг, сонгон суралцах дугуйлан, унаа, хичээлийн дараах үйл ажиллагааны төлбөрийг үндсэн сургалтын төлбөр дээр нэмж авдаг. Эцэг эхийн чөлөөт сонголтоос илүүтэйгээр төлбөрийн нөхцөлд хэт анхаарч боловсролыг бизнесийн, арилжааны дэг жаягтай хутгаж байна. Жишээ нь, хүүхдээ суралцуулахаар нэгэнт өгсөн бол дараа жилийн суудлыг нь хадгалж, урьдчилгаа төлбөр төлүүлэх, хүүхдээ шилжүүлбэл нэг улирлын хичээлийн төлбөртэй тэнцэх хэмжээний

⁹² Боловсролын салбарын тойм судалгаа, БХАН, 2013

⁹³ “Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуульд төрөөс үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг, түүний үр нөлөө” судалгааны тайлан. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2015 он

зардлыг суутгах зэргээр гэрээ байгуулдаг сургуулиуд ч байна. Түүнчлэн, төлбөрийн асуудлаас болж сургуулийн орчинд сургалтын төлбөрөө төлсөн, төлөөгүй гэдгээр хичээлд суулгахгүй байх, мөн үе тэнгийнхний дунд хувийн, төлбөртэй сургуульд сурдаг, баян айлын хүүхэд гэх мэтээр ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, дээрэмдэх явдал гарч байдаг талаар эцэг эх, хүүхдийн төлөөлөл дурдан тэмдэглэсэн байдаг.

Нотолгоо 3 ⁹⁴

Боловсролын тухай хуульд зааснаар төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн зөвлөл, гадаад улстай хамтарсан хэлбэрээр байгуулсан төрийн бус өмчийн ЕБС-ийн удирдах зөвлөл нь сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тус тус тогтоох чиг үүрэгтэй байдаг. Гэвч, тус хуульд заасан “зохих журам” гэдэгт юу байх нь тодорхой бус тул төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн зөвлөл, удирдах зөвлөл нь сургалтын төлбөрийн хэмжээг одоогоор өөрийн мэдлээр тогтоож байна. Үүний улмаас Монгол Улсад сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшиж буй хүүхдүүдийн сургалтын төлбөр, орчин нөхцөл өөр хоорондоо хэт зөрүүтэй байх, жил бүр үндэслэлгүйгээр өсөн нэмэгдэх байдлыг бий болгож байна гэж үзэж байна.

Тиймээс Боловсролын тухай хуулийн 35.4.8, 36.12.4-т заасан “зохих журам”-ыг бий болгож мөрдүүлэх, үнийг тогтооход нөлөөлөх тодорхой бүрэлдэхүүнийг бий болгох, төрийн бус өмчийн цэцэрлэг, ЕБС-иудын сургалтын төлбөрийн үнийн таазыг бий болгох шаардлагатай гэж судлаачийн зүгээс дүгнэж байна. Энэ нь иргэд бүх нийтийн боловсролыг адил тэгш, ялгаварлан гадуурхалтгүйгээр эзэмших боломжийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Нотолгоо 4 Хүүхдийн эрх зөрчигдөх ⁹⁵

ХЭҮК-т хандаж Нийслэлийн Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, ... тоотод оршин суугч Э-гээс ирүүлсэн гомдолд “Миний охин Б нь 2015-2016

⁹⁴ “Монгол Улс дахь төрийн бус өмчийн цэцэрлэг, ЕБС-д хамаарах эрх зүйн орчинд дутагдаж буй зохицуулалтыг тодорхойлох нь” судалгаа, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2018 он

⁹⁵ ХЭҮК-ын гишүүнээс иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн сургуульд хүргүүлсэн шаардлага, 2019 он

оны хичээлийн жилд ... буюу хуучин нэрээр “...” бүрэн дунд сургуулийн 9 дүгээр ангид элсэн суралцсан юм. Тухайн жил хувийн бизнес маань дампуурч, манай гэр бүл өр төлбөрт орсны улмаас охиныхоо сургалтын төлбөр 2,5 сая төгрөгийг төлж чадахгүй болсон. Ингээд 2016 оны намар Нийслэлийн Ерөнхий боловсролын ... дугаар сургуульд охиноо шилжүүлэн суралцуулсан юм. Энэ үед “...” сургууль нь охины маань сурагчийн хувийн хэрэг, суурь боловсролын гэрчилгээг барьцаанд авч, сургалтын төлбөрөө бүрэн төлсний дараа аваарай гээд өгөөгүй. Одоо охин маань 12 дугаар ангид суралцаж байгаа боловч сурагчийн хувийн хэрэг, суурь боловсролын гэрчилгээгүй учир элсэлтийн ерөнхий шалгалтдаа бүртгүүлж чадахгүй, сурч боловсрох эрх нь зөрчигдөж байна” хэмээн дурджээ.

Комиссоос гомдлын мөрөөр гомдол гаргагч болон тус сургуулийн холбогдох албан тушаалтнаас тайлбар тодруулга авч, гомдолд хавсаргаж ирүүлсэн баримт материалтай танилцаж, дүн шинжилгээ хийхэд тус сургууль нь хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг ноцтой зөрчсөн байгаа болох нь тогтоогдож байна.

Нотолгоо 5 Хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх ⁹⁶

Хүний эрхийн үндэсний комисст сүүлийн 3 жилд сурч боловсрох эрх зөрчигдсөн асуудлаар хувийн хэвшлийн ЕБС-тай холбоотой 11 гомдол ирсний 1 нь суралцагчийг ялгаварлан гадуурхсан, бусад нь төлбөр төлөхтэй холбоотой байжээ.

Мөн ковид цар тахлын нөлөөгөөр төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн суралцагчдын эцэг эх, их, дээд сургууль, коллежийн оюутнуудаас ирсэн гомдлуудыг түүвэрлэн үзвэл⁹⁷:

- ТВ хичээл үзэх боломжгүй, хөтөлбөр зөрдөг
- Зарим жижиг сургуулиуд цахимаар сургалт хийхгүй, даалгавар өгч байна
- Багш нарын цалинг өгөхгүй байна

⁹⁶ Хүний эрхийн үндэсний комиссын албан бичиг, 2020

⁹⁷ “КОВИД 19- халдварын Боловсролд үзүүлэх нөлөө: Нийгмийн эгэх хариуцлага” сэдэвчилсэн багийн мониторингийн тайлан, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний тайлан, 2020 он

- Цахим сургалт гэж нэмэлт төлбөр нэхсэн
- Хожимдож эхэлсэн гэсэн гомдол

Нотолгоо 6 Ашгийн төлөө эсэх ⁹⁸

2018 онд төрийн бус өмчийн нийт цэцэрлэгт 35 тэрбум төгрөгийг төсвөөс өгсөн нь СӨБ-ын нийт санхүүжилтийн 11% болж байна. Төрийн бус өмчийн цэцэрлэгийг магадлан итгэмжлэх, хэрэв тухайн төрийн бус өмчийн цэцэрлэг магадлан итгэмжлэгдээгүй бол төсвөөс олгодог дэмжлэгийг зогсоох шаардлага тавьснаар хүчин чадал багатай, чанар нь баталгаажаагүй төрийн бус өмчийн цэцэрлэгийн тоо цөөрч, СӨБ-ын үйлчилгээний чанарт эергээр нөлөөлнө.

Төрийн бус өмчийн цэцэрлэгийг 100-аас олон хүүхэдтэй ажиллах шаардлага тавьснаар өөрийн байртай, шаардлагатай тооны багш, ажилтантай байхад хүргэн санхүүгийн хувьд төсвийн дэмжлэггүйгээр ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

УБ хотын ... цэцэрлэг 2018-2019 оны хичээлийн жилд 118 хүүхэдтэй, сарын төлбөр 250,000₮ гэж тооцоход 265.5 сая төгрөгийн орлоготой, тухайн оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нийт зардал 115 сая төгрөг. Мөн уг цэцэрлэг 95 сая төгрөгийг төсвөөс авсан. УБ хотын ... цэцэрлэг 54 хүүхэдтэй 38 сая төгрөгийн зардал гаргасан. Сарын төлбөр 100,000₮ байхад орлого 48.6 сая төгрөг болно. Архангай аймгийн ... цэцэрлэг 51 хүүхэдтэй 41 сая төгрөгийн зардалтай 50-иас дээш тооны хүүхэдтэй, сард 100,000₮-өөс дээш төлбөртэй төрийн бус өмчийн цэцэрлэг төсвөөс олгох дэмжлэггүйгээр бие даан ажиллах боломжтой.

Нотолгоо 7 Стандартын шаардлага хангадаг эсэх ⁹⁹

Нийслэлд 2019 онд төрийн бус өмчийн 20 сургууль, 2020 онд 24 төрийн бус өмчийн сургууль шалгалтад хамрагдсан байна.

Шалгалтад хамрагдсан төрийн бус өмчийн сургуулиудын 64.5% нь сургалтад зориулсан эзэмшил газаргүй учир биеийн тамирын хичээлийн

⁹⁸ СӨБ-ын салбарын дүн шинжилгээ. Боловсролын Хамтын ажиллагааны нийгэмлэг, 2019 он

⁹⁹ Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2018-2020 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээс, 2020 он

гадна талбай, биологийн хичээлийн туршилт явуулах нөхцөл бүрдээгүй, 50 хувь нь түрээсийн болон зориулалтын бус барилгад үйл ажиллагаа явуулдаг, тусгай зөвшөөрөлд заасан хүүхдийн тоонд хүрдэггүй, байгалийн ухааны зарим хичээл, технологийн хичээл явуулах нөхцөл бүрдээгүй.

44.5 хувь нь гүнзгийрүүлсэн сургалт удирдан явуулах өндөр ур чадвар, дадлага туршлагатай, мэргэжлийн зэрэгтэй багшгүй, мэргэжлийн нийгмийн ажилтангүй, номын санчгүй эсхүл өөр албан тушаалтай хавсран гүйцэтгэж байна. 22 хувь нь цагийн багштай. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд нийт багш нарын 90-с доогүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар заасан ч энэ тоонд хүрдэггүй.

2018 онд 58, 2019 онд 75, 2020 онд 109 төрийн бус өмчийн цэцэрлэгүүд шалгалтад хамрагдсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн нийт зөрчлийн 50 гаруй хувь нь боловсролын сургалтын байгууллагуудад сургалтын орчинтой холбоотой зөрчил эзэлж байгаа нь сургалтын байгууллагуудын сургалтын орчин хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангахгүй байгааг харуулж байна.

Нотолгоо 8 Төрийн зөвшөөрөл өгөх, хяналт тавих чадавх хүрдэггүй

Хяналтын хуудсаар үнэлгээ хийхэд төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд зориулалтын хөгжлийн болон биеийн тамирын заал танхим байхгүй, эзэмшил газар байхгүй зэрэг өрөө тасалгаа дутагдалтай байгаагаас их эрсдэлтэй буюу зөрчил ихтэй үнэлэгдэж байна. Учир нь тухайн цэцэрлэгүүдэд анх зөвшөөрөл олгохдоо сургуулийн өмнөх боловсролын байгууллагад тавигдах шаардлагад нийцүүлэн олгоогүйгээс цэцэрлэгийн удирдлагуудад цэцэрлэгийн барилга байгууламжийн өрөө тасалгааг нэмэгдүүлэх боломжгүй, богино хугацаанд зөрчлийг арилгаж чадахгүй нөхцөл байдлыг үүсгэж, тухайн байгууллага болон бидний үйл ажиллагаанд бэрхшээл гарч байна. Энэ нь тухайн байгууллагад суралцаж байгаа хүүхдийн эрх ашиг зөрчигдөх нөхцөл болж байна.

Г.ГАНЦЭЦЭГ

БОЛОВСРОЛЫН ЗАСАГЛАЛ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО¹⁰⁰

Монгол улс “Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгах” зарчим, бодлогыг төрөөс баримталж ирсэн уламжлалтай.

2015 онд батлагдсан Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгыг хэрэгжүүлэх амлалтыг манай төр засаг авсан. Бүх нийтэд хүртээмжтэй, чанартай, тэгш хамруулсан боловсрол олгох зорилтод хүрэх хариуцлагыг хэнтэй тооцох вэ гэдэг асуулт гарна.

Аливаа улсын төр нь сурч боловсрох эрхийг хангахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой хэдий ч боловсролын салбарын өргөн хүрээний зорилтыг биелүүлэхэд талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бүхий харилцаа хамгийн чухал билээ. Хэрэв төрөөс хязгаарлагдмал боломжийн хүрээнд хууль эрхзүйн үндэслэлтэй зорилт, биелэхүйц үйл ажиллагаа явуулж чадвал олон нийтийн итгэл, дэмжлэгийг олж авна. Ингэж чадахгүй, боловсролын тогтолцоо чанартай боловсрол олгохгүй бол ашгийн төлөөх хувийн хэвшлийнхэн энэ орон зайг нөхөж, улмаар зарим үйл ажиллагаа зохицуулалтгүй явагдаж, эмзэг бүлгийн иргэд улам хохирсоор байна.

Тиймээс боловсролын салбар бол бид бүгдийн хамтын үүрэг хариуцлага төдийгүй нийтийн хүчин чармайлтын үр дүнд хөгжиж чанаржина. Боловсрол нь үүрэг хариуцлагыг авсан дан ганц тоглогч бус олон талуудын хуваан авсан хариуцлагын үр дүнд үнэ цэнтэй, үр дүнтэй болно. Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилго болох тэгш, хүртээмжтэй чанартай боловсрол нь боловсролд оролцогч талуудын дор бүрнээ үүрэг хариуцлагаа ухамсарласан хамтын ажиллагааны үр дүн байна.

Боловсролын салбарт хамтын хариуцлага хүлээх оролцогч талуудыг төр Засгийн Газар, сургуулийн удирдлага, багш, эцэг эх, суралцагчид, ТББ-ууд, олон улсын байгууллагууд, хувийн хэвшил гэж тодорхойлж байна. Сургууль, боловсрол, сургалтын байгууллагууд нь албан ёсоор

¹⁰⁰ Энэ хэсгийг “Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбоо” ТББ-ын зохицуулагч Г.Ганцэцэг боловсруулав.

төрийн өмнө, албан бусаар эцэг эх, суралцагчдын өмнө хариуцлага хүлээдэг. Нийгмийн хариуцлагыг олон нийт хүлээснээр сургуулийн үүрэг хариуцлага, үр нөлөөг дээшлүүлж чадна. Шийдвэр гаргах эрх мэдэл болон хариуцлага нь орон нутгийн түвшинд шилжсэнээр иргэд, олон нийтийн төлөөлөл нь сургуульд суурилсан менежмент (ССМ)-нд оролцох боломжтой болдог.

Боловсролыг сайжруулж, төгөлдөржүүлэхэд хүн бүр чухал үүрэгтэй. Чанартай, тэгш хамруулсан боловсролыг хөгжүүлэхийн тулд иргэний нийгмийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудын дэмжлэгтэйгээр иргэд өөрсдөөсөө эхлүүлэх шаардлагатай гэж ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал үзэж байна.

Өнөөдөр боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, төрийн албаны удирдлага, зохицуулалтад тулгамдсан асуудал байгаа бөгөөд үүнийг шийдэх нэг арга нь иргэд, ИНБ-уудын бодит оролцоог хангах, хөндлөнгийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх явдал юм.

Оролцоог иргэд санал бодлоо илэрхийлж шийдвэр гаргахад нөлөөлөх үйл явц гэж тодорхойлдог.¹⁰¹ Иргэдээс төрийн байгууллага, ажилтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа үйл ажиллагаа, үйл явцыг оролцоо гэж нэрлэж болно.¹⁰²

¹⁰¹ J.L.Creighton, 2005

¹⁰² Улс төрийн боловсролын академи, 2013

Боловсролын салбар дах иргэдийн оролцооны өнөөгийн байдал
(Боловсролын салбарт мөрдөгдөж байгаа багц хуулиар)

Оролцооны хэлбэр	Идэвхтэй (хамтран шийдвэр гаргах, чиг үүргээ шилжүүлэх)	Зөвлөлдөх (санал авах, уулзалт, хэлэлцүүлэг хийх)	Мэдээлэх (терийн зүгээс мэдээллийг олон нийтэд өгөх, нээлттэй байлгах)	Хяналт тавих (Төрийн үйл ажиллагааны хяналтыг иргэд болон ИНБ-ууд хэрэгжүүлэх)	Оролцогчид (сонирхогч этгээд, хэлбэр, түвшин)
СӨБ	✓ (14.1.6*-СӨБТХ)	✓ (ЦЗ**-БТХ35)	✓ (14.1.3* СӨБТХ)	✓ (14.1.1, 2, 4, 5* СӨБТХ)	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх, • Цэцэрлэгийн түвшинд • хувь хүний хязгаарлагдмал мэдээллийг авах боломжтой
БДБ	✓ (20.2.11 БДБТХ)* (35.4.1; 4.8; 4.9 БТХ)**	✓ (20.2.4БДБТХ) (27.3 ба 34, 35 БТХ) (35.4.2; 4.4 БТХ)**	✓ (20.2.2 ба 22.1.2, 5, 6, 8 БДБТХ)* (35.4.11 ба 46.2.6 БТХ)**	✓ (35.4.3; 4.5; 4.10 БТХ)**	<ul style="list-style-type: none"> • багш, ажилтан, сурагч, эцэг, эх, олон нийтийн • сургуулийн түвшинд
МБС	✓ (МБС-ын ҮЗ-6 зүйл) (8.4.17 ба 8.4.18, 8.4.20)	✓ (12.11) ба (20.2.1-10)	✓ (судлах, сурталчлах-8.4.5)	✓ (6.3.5)	<ul style="list-style-type: none"> • НӨУ болон ТЗБ, АО, ажилтан, ҮЭ, мэргэжлийн холбоо, ААНБ, суралцагч, эцэг, эх зэрэг (20.1) • салбарын, орон нутгийн, сургалтын байгууллагын түвшний (20.1.1-3)
ДБ	✓ (16.1.5.* ДБТХ) (26.4 ба 36.12.1-4 БТХ)	✓ (УЗ 11.1.1, 2 ДБТХ) (36 БТХ)	✓ (5.9.ба 9.1; 12.2.3 ба 12.2.5* ДБССНБТХ)	✓ (36.12.5 БТХ)*	<ul style="list-style-type: none"> • олон нийт, суралцагч (БМИҮЗ) • Сургалтын байгууллагын түвшинд
Жич	<p>* оролцоо болон хяналтыг яаж, хэзээ, ямар хэлбэрээр хийх вэ гэдэг нь тодорхойгүй тул хэрэгжих боломжгүй. ** Энэ зөвлөлийг хамт олны хурлаас сонгож байгаа хуулийн зохицуулалт нь оночтой бус юм. Энэ зөвлөлийн эрх мэдлийг өргөжүүлэх, сургуулийн удирдлагыг томилох, төсвийг хуваарилалтыг хэлэлцэх эрхтэй болгох шаардлага байна. Санхүүжилт нь тодорхой байх ёстой</p>				

Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хяналт

“Ардчилал”-ын суурь зарчим болох төрийн эрх мэдлийн хуваарилалт, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт, төрийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хараат бус хяналтын төлөвшилт нь сайн дураар эвлэлдэн нэгдэж нийтлэг эрх ашиг, үнэт зүйлсийн төлөө төр, бизнесийн үйл ажиллагаанаас гадуур үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус олон нийтийн бусад байгууллага буюу Төрийн бус байгууллага, “Иргэний нийгмийн байгууллага”-ын оролцооноос шууд хамаардаг байна.

“Иргэд үзэл бодол, нийтлэг ашиг сонирхлоороо албан болон албан бус бүлэгт сайн дураараа нэгдэн, эсхүл дан ганцаараа улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор орон нутаг, салбар, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулахыг иргэний нийгэм гэж ойлгоно.”

Сүүлийн жилүүдэд боловсролын асуудалд санаа зовдог бүлгүүд нэмэгдэх, тэдний өөрсдөдөө тулгамдаад байгаа асуудлыг олж харах, хүний эрхийн байр сууринаас дүн шинжилгээ хийх, асуудлаа шийдвэрлүүлэхээр төрийн байгууллагад хандах, харьцах чадавх бэхжиж байна. Эцэг эхчүүдийн байгууллага, залуусын байгууллага зэрэг шинэ тоглогчид идэвхжиж, тэгш хамруулан сургах, насан туршийн суралцахуй, хүний эрхэд суурилсан хандлага арга зүй зэрэг боловсролын бодлогыг тодорхойлох хүрээ сайжирч, боловсролын чанарыг илүү өргөн хүрээнд тодорхойлох, сургууль, багшийн түвшинд шинэчлэл хийгдэх, өөрийн орны онцлог болон судалгаа шинжилгээнд суурилсан бодлого боловсруулах зэрэг ахиц дэвшил бидэнд ажиглагдаж байна.

Өргөн утгаараа ИНБ нь нийгэмд дараах түгээмэл үүргийг хэрэгжүүлж байна хэмээн судлаачид тодорхойлсон байна.

- Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох (agenda setting)- ИНБ нь нийгэм, иргэдтэй илүү ойр хамтран ажилладгийн хувьд нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг ил гарган тавьж, төрийн болон засгийн газрын бодлогод тусгуулах, нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Шийдэл боловсруулах (development of solution) - ИНБ-ууд нь олон улс, бүс нутгийн түвшинд хамтарч, асуудлыг шийдвэрлэх шийдэл

боловсруулж, уг шийдлээ бүс нутаг, улс оронд хэрэгжүүлэн ажилладаг.

- Бодлогод нөлөөлөх (lobby, effecting role) - төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчийн шийдвэрт нөлөөлөх, лоббины шахалт үзүүлэх нь ИНБ-ын чухал чиг үүргийн нэг юм.
- Шинэчлэлийн чиг үүрэг (reforming role) - ИНБ нь нийгэмд хийгээд иргэдийн оюун санаанд эерэг шинэчлэл, өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой байдаг. Ялангуяа иргэдэд нийгэм, улс төр, эдийн засгийн талаарх системтэй мэдлэг боловсрол олгоход гол үүрэг гүйцэтгэдэг.
- Хэрэгжүүлэгчийн чиг үүрэг (executing role) - ИНБ нь улс, үндэстэн, хүн амд хэрэгцээтэй байгаа боловсрол, эрүүл мэнд, санхүү, хөдөө аж ахуй болон хүний эрхийг хангах олон салбарт үйлчилгээ үзүүлдэг нь түүний чухал чиг үүрэг юм.
- Хамтран ажиллах чиг үүрэг (constructive engagement)– ИНБ нь өөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улс орны төр засаг, хувийн хэвшлийн болон хандивлагч, донор байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажилладаг.
- Нийгэмд харилцан яриа үүсгэх, зөвшилцөх, түншлэл үүсгэх чиг үүрэг (establishing public dialogue, building consensus and partnership through consultations and negotiations) - төрийн бус байгууллага нь асуудлыг шийдвэрлэж тодорхой ажлын үр дүн бий болгохын тулд олон талын хэлэлцээр, зөвшилцөл, хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг.
- Нөхөх чиг үүрэг (complementing role) – төр, засгийн газраас үзүүлж буй олон нийтэд зориулсан бодлого, үйл ажиллагаанд хамрагдаж чадаагүй нийгмийн гишүүдийн эрх ашгийг хамгаалж, тэдэнд үйлчлэх үүрэг гүйцэтгэнэ.
- Шаардлагатай үед төртэй сөргөлдөх (opposing role) - Бүхий л ИНБ нь иргэний ардчилсан, шударга, ялгаварлан гадуурхалтгүй нийгмийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгыг бодитой хангахын төлөө үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг тул төр, түүний байгууллага, албан тушаалтны аливаа хууль бус шийдвэр, үйл ажиллагаа,

хариуцлагагүй байдлыг үл тэвчин, төрд хандан шаардлага, мэдэгдэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд жагсаал, цуглаан зохион байгуулах хэлбэрээр энэ чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Үүнээс дүгнэж үзэхэд, нэг талаас нийгэмд ТББ-уудын чадавх, хяналт, оролцоо хүчтэй байхын хэрээр төрийн зүгээс нийгэм болон иргэний өмнө хүлээсэн чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, захиргааны хүнд суртлыг халж, нээлттэй, ил тод, хариуцлагатай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах зэрэг боломжийг бүрдүүлдэг давуу талтай.

Нөгөө талаас төрд дэмжлэг болж, нөхөж ажиллах, олон нийтийг соён гэгээрүүлэх зэргээр нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрахад ИНБ-ууд чухал үүрэгтэй тул чадавх бүхий үндэсний төрийн бус байгууллагыг хөгжүүлэх нь төрийн нэг чухал зорилт болно. Энэ утгаараа ИНБ-ууд нийгэмд гүйцэтгэх үүргээ бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж чадах эсэх нь тэдгээрийг дэмжих төрийн бодлого, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн таатай орчноос шууд хамаардаг байна.

Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгч буй санал:

- Иргэдийн оролцоог үр дүнтэй хангахын тулд иргэдийн оролцооны 4 хэлбэрийг хууль тогтоомжид цогцоор, иж бүрнээр оруулж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг нарийн тодорхой хуульчилж өгөх шаардлагатай байна.
- Аливаа бодлого шийдвэр гаргахын өмнө олон нийттэй зөвшилцдөг жишиг, ялангуяа орон нутаг ба үндэстний түвшинд тогтоох, олон талын төлөөлөлтэй зөвлөлүүдийг байгуулах, ажиллуулах заалтуудыг хуульчлах, (Боловсролын салбарт хуульд тусгалаа олоогүй ч холбогдох яамд, салбарын хандивлагчид, иргэний нийгмийн байгууллагын гишүүнчлэл бүхий Үндэсний/орон нутгийн боловсролын бүлэг (LEG), ХБХЭТХ-ийн дагуу байгуулагдсан олон талт төлөөлөл бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл" зэрэг оролцооны бүтцүүд шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгааг удам батжуулах)
- Сургалтын байгууллагын шийдвэр гаргах түвшинд суралцагчдын, эцэг эхийн, оюутны байгууллагуудын оролцоог хуульчлах

- Санал, гомдол зэрэг мэдээллийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйлдлийн талаарх эргэж мэдэгддэг тогтолцоог хуульчилж өгөх шаардлагатай байна. Иргэдийн, ялангуяа эцэг эхчүүдийн санал, хүсэлт гомдлыг хэрхэн яаж шийдвэрлэсэн үйл явц, хариу үйлдлийг тодорхой ил тод байлгах зэрэг үүнд ордог.
- Боловсролын салбарт ИНБ-уудаар төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг сайжруулах
- Багштай холбоотой аливаа бодлогын асуудлаар тэднийг төлөөлсөн ҮЭ-тэй зөвлөлдөх байдлыг хуульчлах

Боловсролын харилцаанд оролцох төрийн бус байгууллагын оролцоог дараах чиглэлээр хуульчлах:

- Салбарын хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, хэлэлцүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд оролцох, санал, зөвлөмж өгөх;
- Бие даасан болон хамтарсан судалгаа хийх, сургалт зохион байгуулах;
- Ажлын хэсэгт ажиллах, шинжээчийн дүгнэлт гаргах;
- Гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Боловсролын салбар, байгууллага, хүний нөөц, техник, технологийн хөгжил, чанар, хүртээмж зэрэг чиг чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах эрхтэй байх;
- Боловсролын тухай хууль тогтоомжид нийцүүлэн гаргах нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын талаар санал өгөх;

Сургуулийн ардчилсан хамтын удирдлага

Олон улс орны хувьд сургуулийн засаглалын талаарх эрх зүйн баримт бичигт нь тухайлсан тодорхойлолт байдаггүй ч сургуулийн удирдлага менежмент болон сургуулийг сайжруулах үйл хэрэгт оролцогч талууд, байгууллагууд идэвхтэй оролцох ба хамтран ажиллахыг хэлнэ гэсэн ойлголт тодорхойлолт зонхилдог. Эрх зүйн баримт бичигт Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг удирдах гол байгууллага гэж тусгадаг ба улмаар бүтэц бүрэлдэхүүн, үүрэг хариуцлага болон бусад үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах нөхцөлийг хуульчилсан байдаг. Мөн

сүүлийн үед нийгмийн эгэх хариуцлагыг боловсролын байгууллагад төлөвшүүлэх санаачилгууд хэрэгжиж эхлээд байна. Сургалтын байгууллагад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор сургуулийн удирдлага, багш, эцэг эх, иргэний нийгмийн байгууллагууд нүүр тулан бүтээлчээр хамтран ажиллах үйл ажиллагааг нийгмийн эгэх хариуцлага гэж тодорхойлоод байна. (БСШУСЯ, ДБ, 2019)

Монгол улс ч боловсролын салбартаа төвлөрлийг сааруулах, сургуулийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх бодлого баримталж, 1995 оны Боловсролын багц хуульд сургууль, цэцэрлэгийн зөвлөл, их, дээд сургуулийн удирдах зөвлөл хэмээх “өөрийн удирдлагын” олон талт төлөөлөл бүхий удирдлагын бүтцийг хуульчилсан. Анх энэ бүтэц “шийдвэр гаргах” эрх мэдэл бүхий байсан боловч, 2002 оны хуулиар “зөвлөх” үүрэг бүхий бүтэц болгож хувиргасан байна. Боловсролын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь захирал, эрхлэгчийг ажилд томилох, ажлаас чөлөөлөх шийдвэр гаргадаг байсныг өөрчлөн сургууль, цэцэрлэгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, багш суралцагчдын эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй болсон юм. Үүнийг боловсролын харьцуулсан судлаачид тодорхойлохдоо засаглал, санхүүжилтийн төвлөрлийг сааруулах шинэчлэлийг “монголчилсон” бөгөөд эргэн төвлөрүүлэх, төвлөрлийг эргэн сааруулах зэргээр хэдэнтээ эргэж буцсан гэж тодорхойлсон байдаг. (Гита Штайнер-Хамси, И.Штольпе, 2004)

Эдгээр эрх зүйн шинэчлэл нь боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах, өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хэдий ч бүх шатны боловсролын захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх хүний нөөц зохих төвшинд бэлтгэгдээгүй, тэдний менежментийн чадвар сул, сургууль, цэцэрлэгийн зөвлөл хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж чадахгүй байгаа нь өөрийн удирдлагын төлөвшил, үр нөлөөнд зарчмын өөрчлөлт гараагүй, эрх зүйн шинэчлэлийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. (Н.Бэгз, С.Санжаабадам 2020 он)

Сургуулийн засаглалын асуудал руу чиглэсэн санал:

- Сургууль дээр эцэг эхийн байгууллага ажиллахаар хуульчлах
- Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд дараах заалтуудыг нэмж тусгах. Үүнд:
- Сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, ажиллах журмыг батлах үүргийг салбарын яаманд хүлээлгэх
- Сургуулийн зөвлөлд сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн байгууллагаас төлөөлөл оруулах
- Тэгш хамруулах боловсролын бодлогын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, дэмжлэгийн багийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Зөвлөлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлэх,
- Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь зөвлөлийг үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангах,
- Зөвлөл нь эрхлэгч, захирлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, тэднийг томилох, чөлөөлөх саналыг эрх бүхий байгууллагад тавих,
- Зөвлөлийн бүрэлдэхүүн дэх суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл нь нийт гишүүдийн 51.0 хувиас доошгүй байхаар заах

Үндэслэл нотолгоо

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод (2014-2024) боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Боловсролын удирдлагын бүх түвшинд төрийн болон орон нутгийн, мэргэжлийн, олон нийтийн төлөөллийн байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоог тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах зорилт мөн тавигдсан.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд:

- Боловсролын үйл хэргийг төрийн зүгээс нэгдсэн бодлого зохицуулалт, санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, аж ахуйн

нэгж, олон нийт, иргэдийн оролцоог дэмжин, ил тод, нээлттэй, хяналттай байлгах;

- Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлэх зарчмыг баримтална гэж тусгажээ.

Сайн жишээ

Сургуулийн эцэг эх, багшийн холбоо

Монгол улсын 8 аймгийн 32 суманд сургуулийн эцэг эх, багшийн холбоо (СЭЭБХ) “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийн “...сургуульд эцэг, эх, асран хамгаалагчийн... байгууллага ажиллаж болно” гэсэн заалтын дагуу 2016 оноос эхлэн байгуулагдан үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. Энэ нь дэлхийн олон улсад байдаг “Эцэг эх, багшийн холбоо” (Parents Teacher Association)-ны загварыг өөрийн улсын нөхцөлд буулгасан эцэг эхийн оролцооны шинэлэг загвар бөгөөд эцэг эх, багш ганц нэгээрээ зөвхөн өөрийн хүүхдийн төлөө бус, хамтран нийтлэг хүүхдүүдийн эрх ашгийн төлөө сайн дураараа нэгдэн ажиллах боломж олгодог.

СЭЭБХ нь өөрсдийн боловсруулсан аргачлалын дагуу нөхцөл байдлаа үнэлж, үнэлгээний үр дүнд үндэслэн сургуулийн түвшинд сургалтын үр дүн, хүүхэд хөгжлийн үр дүнг сайжруулахад чиглэсэн төлөвлөлт хийх, сургуулийн удирдлагуудад сургууль, дотуур байрны засаглал, сэтгэл зүй, материаллаг орчныг сайжруулах зөвлөмж хүргүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө босгох, төсөл хөтөлбөрт оролцох, хэлэлцүүлэг зохион байгуулах чиглэлээр орон нутгийн төрийн захиргааны болон өөрийн удирдлагын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

СЭЭБХ-ны үйл ажиллагааны үр дүнд эцэг эхчүүдийн сургуулийн орчинд тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх шийдлийг эрэлхийлэхэд багш, сургуулийн удирдлага нартай хамтрах, оролцох оролцоонд мэдэгдэхүйц өөрчлөлт, ахиц дэвшил гарсан байна. Сургууль, орон нутгийн удирдлагууд СЭЭБХ-ны үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллаж, бусад аймаг, сумын сургуулийн удирдлагуудаас СЭЭБХ-той болох хүсэлтүүд ирж байна.

СЭЭБХ-ны гишүүд хүүхдийнхээ хувьд орон гэртэй байлгах, хоол тэжээл, өмсөх хувцсыг бэлтгэх зэрэг эцэг эхийнхээ үүргийг биелүүлж оролцох, хүүхдийнхээ сурлага, төлөвшлийн талаар мэдээлэл авах, өөрөө хүүхдийнхээ талаар мэдээлэл өгөх зэргээр мэдээлэл солилцох, өөрсдийн чаддаг, мэддэг зүйлээр хувь нэмрээ оруулж, сайн дурын ажил хийж байна. Мөн хүүхдээ гэртээ суралцахад номын сантай байх, харилцан ярилцах зэргээр орчныг бүрдүүлэх, гэрийн даалгавраа хийхэд туслах төдийгүй сургуулийн шийдвэр гаргахад оролцох, сургуулийг тухайн орон нутагтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх зэргээр идэвхтэй оролцох болжээ.

Ялангуяа цар тахлын үед сурлагаар хоцрогдсон сурагчдад хүрч ажиллахад багштай хамтрах, баг, сумын удирдлагуудтай хамтран малчдын хүүхдэд хүрч ажиллах, халдвар хамгааллын мэдээллийг эцэг эхэд хүргэх чиглэлээр санаачилга гарган ажиллаж байна.

Багшийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг дараах байдлаар хуульчлах

Боловсрол хувь хүний цаашлаад нийгмийн хөгжилд юугаар ч орлуулшгүй онцгой үүрэг гүйцэтгэдэг, харин багш нар боловсролын хөгжилд гол үүргийг гүйцэтгэнэ. Энэ утгаараа багш мэргэжлийн хөгжил нь өргөн хүрээний боловсролын хөгжлийн бодлого, эрх зүйн шинэчлэлийн салшгүй хэсэг байх ёстой.

Багш мэргэжлийн хөгжил нь сургуулийн анги танхим дахь багш хүний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тодорхойлоод зогсохгүй тухайн мэргэжлийн нийгэмд эзлэх байр суурь, үнэ цэн, улмаар үр нөлөөтэй бодлогын манлайллыг тодорхойлно. Багш нар мэргэжилтний хувьд хөгжих хийгээд үндэсний боловсролын бодлогод манлайллаа хэрэгжүүлэхэд багш нарын хамтын манлайллын илэрхийлэл болох мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага (цаашид “Багш нарын мэргэжлийн холбоо” гэх) зайлшгүй шаардлагатай. Энгийнээр, багш нар хүний амьдралыг эергээр хувьсган өөрчлөх хүчтэй байдаг бол Багш нарын мэргэжлийн холбоогоороо өөрсдийн мэргэжлийг хувьсган өөрчлөх, шинэ түвшинд хөгжүүлэх хүчтэй болох юм.

Багш нарын мэргэжлийн өөрөө удирдах ёс бий болох нөхцөлийг бүрдүүлж, дэмжих нь Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилго, тэр дундаа 4.с зорилт буюу чанартай боловсролыг түгээх эхний алхам болох чадварлаг багш мэргэжилтнүүдийг далайцтайгаар нэмэгдүүлэх зорилтод бүрэн нийцэх юм.

Мэргэжлийн өөрөө удирдах ёс бол төр нь тухайн мэргэжлийг удирдахад шаардлагатай мэдлэгтэй мэргэшсэн бүлэгт нь зохицуулах чиг үүргээ шилжүүлэн өгч буй явдал юм. Иймээс мэргэжлийн өөрөө удирдах ёсыг хүлээн зөвшөөрч, ханган баталгаажуулах нь тухайн мэргэжилтнүүд өөрсдийгөө засаглах чадвартайг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм. Нийтийн өмнө хариуцлага хүлээдэг онцгой статустай мэргэжлүүд (тухайлбал, эмч, хуульч г.м.) мэргэжлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх нь чухал бөгөөд эдгээр мэргэжлийн нэг нь багш юм.

Өндөр хөгжилтэй улс орнуудын багш нар мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг байгуулах замаар боловсролын чанар, багш нарын

ур чадварыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэж байна. Тухайлбал, Канад улсын Онтарио хотод “Багшийн коллеж” нэртэй мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага 1997 онд байгуулагдсан бөгөөд нийтийн сургуулийн багш нартаа багшлах эрхийг олгодог бөгөөд ийнхүү эрх авсан багш нар нь бүгд Коллежийн гишүүн байхаар зохицуулагдсан байна. Тус Коллеж нь сурагчид тодорхой мэргэжлийн стандартыг дагаж мөрддөг чадварлаг багш нараар багшлуулдаг байхыг баталгаажуулах, мэргэжлийн стандарт, ёс зүйн дүрэм журмуудыг батлан гаргах, мэргэжлийн эрхийг олгох, түдгэлзүүлэх, цуцлах, багшийн мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, гишүүдээ үргэлжилсэн сургалтын боломж нөхцөлөөр хангах гол зорилготой.

Багш нарын мэргэжлийн холбоо нь мэргэжлийн хараат бус байдлыг дээдэлж, мэргэжлийн хөгжил, мэргэжлийн ёс зүйг тодорхойлдог, нийт гишүүдийн эрх мэдлийг хэрэгжүүлэх хэвтээ удирдлагын тогтолцоотой, үндэсний хэмжээний боловсролын бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд манлайлан оролцох мэргэжилтнүүдийн нэгдмэл дуу хоолой байх явдал юм.

Б.БАТЖАРГАЛ

ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨХ САНХҮҮЖИЛТ¹⁰³

Монгол Улс боловсролыг тэргүүлэх салбар хэмээн үзэж ирснийг бодлогын хоёр баримт бичгээр жишээ авбал УИХ-аас 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024”-д “Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж заасан байдаг бол УИХ-аас 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогот “Боловсрол бол хүний хөгжлийн чухал хөдөлгүүр бөгөөд улс орны хөгжлийн суурь юм” гэж заажээ.

Боловсролыг тэргүүлэх салбар гэж үзэн хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулахад санхүүжилт чухал үүрэгтэй юм. ЮНЕСКО-гоос эрхлэн гаргадаг 2020 оны Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайланг дагалдан гарсан хэд хэдэн бодлогын баримт бичгийн нэгэнд хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулах тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхийн тулд санхүүжилт мөн л энэ чиглэлд байх, өөрөөр хэлбэл санхүүжилт зөвхөн хамран сургалт руу хандаад зогсохгүй тэгш хамруулсан бөгөөд эрх тэгш байдлыг баталгаажуулахад чиглэгдэх хэрэгтэйг сануулж байна. Хэдийгээр тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хувьд боловсролын санхүүжилттэй шууд холбоотой зорилт, хүрэх үр дүн, индикатор байхгүй ч гэсэн эрх тэгш байдлыг санхүүжилттэй нь уясан “хүн амын эмзэг хэсэгт боловсролын нөөцийг дахин хуваарилах санхүүжилтийн механизм байгаа эсэх” гэсэн индикатор байдаг. Боловсролын санхүүжилтийн талаарх дээр дурдсан баримт бичигт дэлхий нийтэд хэрэглэж байгаа боловсролын салбарын санхүүжилтийн дөрвөн ерөнхий механизм байгааг тодорхойлсон. Үүнд:

¹⁰³ Энэ хэсгийг Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Б.Батжаргал боловсруулав.

1. Төсвөөс үйл ажиллагааны зардлыг орон нутаг болон сургуульд олгох. Ингэхдээ сургуулийн насны хүүхдийн тоо болон нэгжийн зардалд үндэслэн төвөөс орон нутагт шилжүүлэх замаар олгодог. Зарим тохиолдолд эрх тэгш байдлыг хангахын тулд ядуурал, байршил зэрэг хүчин зүйлийг тусгадаг. Үүн дээр нэмээд орон нутгаас нэмэлт санхүүжилт олгох тохиолдол байдаг ч энэхүү санхүүжилтийн хэмжээ нь (орон нутгийн санхүүгийн нөөц дайчлах чадавх, боломжоос шалтгаалан) ихээхэн зөрүүтэй байдаг учраас тэгш бус байдалд нөлөө үзүүлдэг байна.
2. Сургууль дээрх хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг санхүүжүүлэх нэмэлт тэтгэлэг олгох. Зарим тохиолдолд дэмжлэг шаардлагатай орон нутаг эсвэл дэмжлэг шаардлагатай суралцагчид зориулан олгодог. Ихэнхдээ жижиг тэтгэлэг хэлбэрээр тоног төхөөрөмж худалдан авах, багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа зэрэг зориулалтаар олгогдоно.
3. Боловсролын салбарын дахь санхүүжилтийн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан тусгайлсан дэмжлэг үзүүлж болно. Жишээлбэл энэ нь суралцагчид болон тэдний гэр бүлийг мөнгөн хэлбэрээр (жишээ нь: тэтгэлэг) болон төлбөр (жишээ нь: сургалтын төлбөр)-өөс чөлөөлөх байдлаар тусгайлан чиглэсэн дэмжлэг үзүүлж болох юм. Энэ арга замыг дээд боловсролын салбарт илүү их ашиглаж байна. Дээд боловсролын зээлийн сан бол энэ чиглэлийн хөтөлбөрийн нэг тод жишээ болдог. Дөрвөн улс тутмын нэг нь дээд боловсролд хамрагдахад дэмжлэг үзүүлдэг үйл ажиллагааны хөтөлбөртэй байна.
4. Боловсролын бус тодорхой санхүүжилтийн бодлого, хөтөлбөрүүд нь боловсролд ихээхэн нөлөө үзүүлэх боломжтой. Жишээлбэл нөхцөлт мөнгөн тэтгэмжүүд гэж байдаг. Манай улсад үүний нэг хувилбар нь хүүхдийн мөнгөн тэтгэмж юм. Хүүхдийн мөнгөний бодлогыг нэлээн сайн хөгжүүлсэн улс орнуудад энэ хөтөлбөр үр дүнгээ өгч байгаагийн жишээ нь Латин Америкийн орнуудад урт удаан хугацааны туршид хэрэгжсэн нөхцөлт мөнгөн тэтгэмжүүд нь боловсролд хамрагдсан хугацааг 0.5-1.5 жилээр нэмэгдүүлсэн байна. Өөр нэг хэлбэр нь сургуулийн хоолны хөтөлбөр юм. Бага

болон дунд орлоготой улс орнуудад 310 сая орчим суралцагч сургуулийн хоолны хөтөлбөрт хамрагддаг. Энэ нь тэднийг амжилттай суралцах нөхцөл бололцоогоор хангаж өгч байна гэсэн судалгаа байдаг.

Тогтвортой хөгжлийн 4-р зорилтын үндсэн үзэл санааны нэг болох Эрх тэгш байдал гэж юу вэ?

“Тэгш хамралт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой” гэсэн нэрээр гарсан Боловсролын хяналт шинжилгээний 2020 оны дэлхийн тайланд тодорхойлсноор:

“... ТХЗ 4-ийн гол суурь нь “тэгш хамруулсан, эрх тэгш” боловсрол... Тэгш байдал гэдэг нь аливаа үйлийн нөхцөлт байдал юм (юу): орц буюу нөөц, гарц буюу анхдагч үр дүн эсвэл дам үр дүнд ажиглагдаж болох ямарваа нэгэн үр дүн. Эрх тэгш байдал бол үйл явц (хэрхэн): тэгш байдлыг баталгаажуулахад чиглэсэн үйлдэл юм.”

Өөр нэгэн эх сурвалжийн тайлбарласнаар боловсрол дахь эрх тэгш байдал гэдэг нь “хүүхэд бүрд амжилт гаргахад нь шаардлагатай байгаа нөөц, багш, үйл ажиллагаа, дэмжлэг” юм. Энэ нь хүн бүрд ижил зүйлийг тэгш байдлаар өгөх тухай асуудал биш, харин хувь хүний нөхцөл болон хэрэгцээг тооцож үзэж буй явдал юм.

Эрх тэгш байдлын төлөөх санхүүжилт гэж юу вэ?

Боловсролд эрх тэгш байдлыг баталгаажуулах нь боловсролын салбарын санхүүжилттэй нягт холбоотой. Хэрэв нөөцийг зөвхөн аль нэг бүлэгт чиглүүлбэл энэ нь бусад бүлэгт ноогдох нөөцөөс авч байна гэсэн үг. Тэгэхээр эрх тэгш байдал гэдэг нь хэсэг бүлэг хүний, хэсэг бүлэг хүүхдийн тухай асуудал биш энэ бол бүх хүүхдийн тухай асуудал юм.

2013 онд хийгдсэн Боловсролын салбарын тойм судалгаанд санхүүжилтээр дамжуулан ялгаварлан гадуурхахгүй байх мөн санхүүжилт нь тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхгүй байх ёстой юм гэдгийг сануулсан. Үүний тодорхой жишээ болох ЕБС-ийн түвшинд лаборатори сургууль, Кембрижийн хөтөлбөртэй, хос хэлний сургууль байгуулах болон бусад санхүүжилтийн сувгаар дамжуулаад тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх алхмыг хэрхэвч хийж болохгүй юм.

Санхүүжилтийг эрх тэгш байдлын төлөө болгож хувиргахын тулд дараах гурван асуудлыг анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Боловсролын салбар улс орны хөгжлийн тэргүүлэх салбар гэдгийг [санхүүжилтийн түвшинд] баталгаажуулах: Ослогийн тунхаглал (2008)-аар анх дэвшүүлж Инчоны тунхаглал (2015)-аар баталгаажуулан зөвлөсөн хэмжээ бол улсын төсвийн зардлын 15-20 %, эсвэл ДНБ-ний 4-6 %-ийг боловсролын салбарт зарцуулах зөвлөмж байдаг. Манай улсын хувьд тодорхой хугацаанд яг энэ чиглэлээр тэргүүн туршлага болон нэрлэгдэж байсан. Боловсролын тухай хуульд төсвийн 20%-иас доошгүйг боловсролын салбарт зарцуулна гэсэн заалт 2012 он хүртэл тусгагдсан байсан бөгөөд энэ заалтыг хуулиас хассанаар ухралт хийсэн байдаг.
2. Монгол Улсад боловсрол олгох үйл ажиллагаа зардал ихээр шаарддагийг тооцож үзэх. Үүнийг өмнө дурдсан Боловсролын салбарын тойм судалгаанд дараах гурван шалтгаанаар тайлбарласан байдаг. Үүнд:
 - a. газар нутаг уудам бөгөөд хүн ам нь тархай суурьшдаг
 - b. удаан үргэлжлэх өвлийн хүйтэн улирлаас хамааран дулаан, халаалтын зардал өндөр гардаг
 - c. боловсролын салбар нь хөдөлмөр багтаамж болон орц ихтэй салбар учраас бусад салбартай харьцуулахад цалингийн зардал өндөр гардаг нь хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээг хүргэх зардлыг ихээр нэмэгдүүлж байна.
3. Улс орны эдийн засгийн нөхцөл болон дэлхий нийтийг хамарсан цар тахлаас улбаатай эрсдэлд анхаарал хандуулах. Үүнд:
 - a. Ковидтой холбоотойгоор боловсролын зардал нэлээн хэмнэгдэж байгаа бөгөөд энэ зардлыг бусад салбарт шилжүүлж байгаа нь дараа дараагийн онуудад салбарын төсөв буурахад нөлөөлөх эрсдэл гарах магадлал байна.
 - b. Улсын хэмжээнд өнгөрсөн хугацаанд авсан олон өрийн эргэн төлөлт хийгдэх хугацаа ойртон зарим нь төлөгдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор тус салбарын төсөвт сөрөг нөлөө үзүүлэх вий гэсэн болгоомжлол байна.

Боловсролын тухай багц хуулийн төсөлд тусгах санал

1. Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, тогтвортой хадгалах

Инчоны тунхаглал буюу Боловсрол 2030-ын зөвлөмж, Монгол Улсын боловсролын салбарын зардлын онцлог байдалд тулгуурлан судлаачдын санал болгосноор боловсролын салбарын санхүүжилтийг улсын төсвийн 20%-иас доошгүй хувь байхаар хуульчлах, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих

2. Санхүүжилтэд орон нутаг, сургууль, цэцэрлэгийн болон суралцагчийн, гэр бүлийн онцлогийг тусгах боломжтойгоор санхүүжилтийг боловсронгуй болгох.

Монгол Улс нэг хүүхдэд ногдох хувьсах зардал тооцож санхүүжүүлэх хувилбарыг 1998 онд нэвтрүүлснээр хамгийн анх нэвтрүүлсэн улсуудын эгнээнд багтдагийн зэрэгцээ харьцангуй сайн хэрэгждэг гэж олон улсад туршлага болж байсан. Харин боловсролоос орхигдсон болон орхигдох магадлалтай байгаа бүлгүүдийн сурч боловсрох эрхийг дэмжихэд чиглэсэн байдлаар санхүүжилтээ шинэчилж чадах юм бол дахин шинэ туршлага болох боломжтой юм.

2013 онд анх боловсруулсан “ЕБС-ийн норматив зардалд суурилсан санхүүжилтийн аргачлалыг өөрчлөх санал”-д суурилан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын томъёог нарийвчлан тооцоолбол суралцагч бүрийн суралцах боломжийг нэмэгдүүлж, ингэснээрээ чанарт анхаарч эрх тэгш байдлыг баталгаажуулахад түлхэц болно. Үүний тулд одоогийн ашиглаж байгаа томъёонд дараах нарийвчилсан итгэлцүүр, хувьсагчийг нэмж оруулах нь зүйтэй. Үүнд:

- Сургуулийн онцлогоос хамааралтай хүчин зүйлсийг тооцсон итгэлцүүр
 - Алслагдсан байдал: Тухайн сургууль болон аймгийн төв, аймаг болон Улаанбаатарын хоорондох зай болон нөхцөл бөгөөд жишээлбэл үүнийг тооцохдоо хоорондын зайгаар бус туулах цагаар нь тооцох
 - Төвлөрсөн хангамжид холбогдсон байдал: Тухайн сургууль

халаалт, цахилгаан, ус болон бохирын шугамд холбогдсон эсэхээс хамаарна.

- o Дотуур байранд амьдарч байгаа суралцагчид - малчдын хүүхэд 24 цагаар 9 сар амьдарч байгааг тооцон, хүүхдийн суралцах, хөгжих, хамгаалуулах эрэлт хэрэгцээг хангах үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хуваарилах
- o Сургуулийн хэмжээ/суралцагчийн тооноос хамаарсан итгэлцүүр: Тухайн сургуульд суралцаж байгаа хүүхдийн тооноос нь хамаараад шаталсан итгэлцүүрээр тооцох. Өөрөөр хэлбэл цөөхөн суралцагчтай /500 ба доош/ сургуульд тодорхой итгэлцүүрээр зардлыг нь нэмж олгодог бол олон суралцагчтай /2000 ба дээш/ сургуульд итгэлцүүр нь багасах байдлаар явах гэх мэт
- o Боловсрол олгох түвшнээр ялгаатай итгэлцүүр: Бага, дунд, ахлах – ахлах ангид илүү их зардал гарах шаардлагатай болдог гэх мэт
- Суралцагчийн онцлогоос хамааралтай хүчин зүйлсийг тооцсон итгэлцүүр: хамгийн чухал бөгөөд эрх тэгш байдалтай холбоотой зүйл бол суралцагчдын онцлог хэрэгцээтэй холбоотой нэмэлт итгэлцүүр байх шаардлагатай ба хүүхэд бүрийг амжилт гаргах боломжийг тэнцвэржүүлэхэд түлхэц болно.
 - o Хөгжлийн бэрхшээл – Одоогийн санхүүжилтийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийг анхаарч үзэж байгаа хэдий ч бүх тохиолдолд биш байгаа. Хэдийгээр эрхзүйн хувьд нөхцөл нь бүрдсэн боловч тусгай сургуулийн суралцагчдад энэ боломж хүрч, ердийн сургуульд суралцаж байгаа хүүхдүүдэд хүртээмжтэй биш хэвээр байна.
 - o Тухайн сурагчийн эх хэлээс хамаарсан итгэлцүүр – Зөвхөн Баян-Өлгий аймаг суралцаж байгаа казак хүүхдүүдээс гадна хэлний цөөнх тува хүүхэд, дохионы хэлээр суралцаж байгаа суралцагчийн хувьд сурах эрхээ эдлэхэд шаардагдах зардлуудыг гаргах санхүүжилт хэрэгтэй
 - o Тухайн орон нутгийн нийгэм-эдийн засгийн статус – Тухайн

сургууль оршин байгаа орон нутгийн ядуурлын түвшнийг харгалзаж тооцсон итгэлцүүрийг тооцох

3. Санхүүжилтийг хамран сургалтаас чанарт чиглүүлэн хувирган өөрчлөх

Боловсролын салбарт хамран сургалтаас гадна чанарт анхаарах хэрэгцээ зайлшгүй гарч байна. Хамран сургалтыг алдахгүйгээр чанараа дээшлүүлэх дараагийн алхмыг хийх хэрэгтэй байна. Ялангуяа хүүхэд бүрийн чанартай сурч боловсрох эрхийг хангахын тулд санхүүжилтээ хувирган өөрчлөх шаардлагатай юм. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх санхүүжилтэд анхаарах. Жишээлбэл:
 - Хичээл практикийн зардал
 - Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил
 - Багшийн цалин хөлс, ажлын нөхцөл
 - Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын суралцахуйд тулгарах саадыг арилгах болон суралцахуйг дэмжих тогтолцоо, үйлчилгээг санхүүжүүлэх
 - Хөтөлбөр, сурах бичиг, сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн
 - Тохирох хэрэглэгдэхүүн
 - Дэмжлэгийн тогтолцоо, үйлчилгээ гэх мэт сургалтын үйл ажиллагаанд шууд нөлөөлж болохуйц санхүүжилтийг өөрчлөх шаардлага байна гэж үзэж байна.

4. Санхүүжилтэд тавих хяналт: Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгалаа олсон эцэг эхийн гүйцэтгэх үүргийг илүү хүчтэй болгох, бусад хамааралтай талын оролцоог утга учиртай болгох шаардлага байна. Санхүүжилтийн хяналтыг дараах гурван түвшинд хэрэгжих боломжтойгоор зохицуулалт хийж түвшин бүрд тохирсон хяналтын үйл явц, тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Орон нутгийн боловсролын бүлэгт (**үндэсний түвшинд**):
- Боловсролын салбарт хөгжлийн албан ёсны тусламжаар

хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хяналт тавих эрх

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын тайланг сонсдог, хэлэлцдэг байх.
- Орон нутгийн боловсролын зөвлөлд (**аймаг орон нутгийн түвшинд**):
 - Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн санал, хуваарилагдаж ирсэн төсвийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих эрх
 - Ашиглалтын зардлыг орон нутгийн түвшинд зөвлөлөөр шийдэх, хяналт тавих.
 - Хүүхэд бүрийн сурч боловсроход саад болж буй хүчин зүйлсийг арилгах нөхцөлийг бүрдүүлэх
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.1-д заасан сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж орон нутгийн төсөвт туссан зардлын гүйцэтгэлийг хянах
 - Хос хэлний боловсролын хэрэгжилт
 - Тохирох хэрэглэгдэхүүн, дэмжлэгийн тогтолцоо, үйлчилгээний санхүүжилтийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих
 - Эцэг эхийн зөвлөл, холбоо -(**сургуулийн түвшинд**):
 - o Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, санхүү, өөрийн үйл ажиллагаанаас орсон орлого, сургууль хөгжүүлэх сангийн зарцуулалтыг хянах эрх (багш, суралцагчийн нэгэн адил)

Сургууль дахь хичээл практик, урсгал засварын зардал, хөгжлийн бэрхшээлтэй ба үндэстний цөөнх хүүхдэд өгөх нэмэлт санхүүжилтийн төсөвлөлтөд эцэг эхийн байгууллагыг оролцуулах, зарцуулалтад хяналт тавих эрх олгох.

“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН¹⁰⁴ БАЙР СУУРЬ: БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ, ТУСГАХ ЗАРЧИМ

Боловсролыг үзэх хүмүүнлэг хандлага (Humanistic approach)

- Боловсролыг бүх нийтийн баялаг гэж үзэх, боломжийг тэгш хуваарилж нийгмийн тэгш бус байдлыг арилгах үүрэгтэй тул төр хүн бүрийн сурч боловсрох эрхийг хангах, нийгмийн шударга ёс, боловсрол дахь нийтийн ашиг сонирхлыг сахин хамгаалах үүргээ биелүүлэх ёстой;
- Хүний эрхэм чанар¹⁰⁵, авьяас чадвар, амьдралын сайн сайхан бүхнийг хадгалан бэхжүүлэх зорилготой гэж үзэх;
- Боловсролын гүйцэтгэх үүргийг хүн утга учир дүүрэн, нэр төртэй амьдрахад шаардлагатай ур чадвар бүрдүүлэх гэж үзэх (эдийн засгийн хөгжлийн хэрэгсэл гэж явцуу үзэхгүй байх);
- Хүний амьдрал ба нэр төрийг хүндлэх, тэгш эрх ба нийгмийн шударга ёс, соёлын болон нийгмийн олон янзтай байдал, хүн төрөлхтний эв санааны нэгдэл, нийтлэг ирээдүйн төлөөх хамтын хариуцлага зэрэг хүмүүнлэг үнэт чанарууд боловсролын зорилго, түүний үндэс суурь нь болох ёстой;
- Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх (Хүний эрхийн түгээмэл тунхаглал), өөрийн нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын хөгжлийн төлөө суралцах (ЮНЕСКО), хувь хүний хөгжил, идэвхтэй иргэн байх, нийгэмд тэгш хамрагдах, хөдөлмөр эрхлэх/дасан зохицох гэсэн өргөн хүрээний зорилготой (Европын комисс) гэж үзэх хандлага өнөө үед дэлхийд хүчтэй байна;

¹⁰⁴ “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (Боловсрол эвсэл) нь боловсролын чанар, санхүүжилтэд хяналт тавьж, уг салбарын хариуцлагын тогтолцоог иргэдийн оролцоотойгоор сайжруулах зорилгоор 2010 онд байгуулагдсан, иргэний нийгмийн 35 байгууллага, 8 аймагт 10 салбар зөвлөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг үндэсний хэмжээний төрийн бус байгууллага юм.

¹⁰⁵ Dignity- гэдэг үгийг хүний нэр төр, эрхэм чанар, эрхэмсэг оршихуй гэх мэтээр орчуулж хэрэглэж ирсэн хэдий ч иргэний нийгмийн байгууллагуудын хувьд “хүний эрхэм чанар” гэх үгийг сонгон хэрэглэдэг болно.

САНАЛ: Боловсролын хуулийг хүүхэд, залуус/суралцагч төвтэй буюу тэдний чадамжийг нээж, хөгжүүлэх гол үндсэн зорилгод анхаарч, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд шаардлагатай бүх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор боловсруулж батлах

Насан туршдаа суралцахуйн хандлага (Lifelong learning approach)

- Хүний амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн боловсролын тогтолцоог зохион байгуулах зарчим;
- Хүн төрөхөд эхэлж, амьдралын туршид болон гэр бүл, ажил, чөлөөт цаг гэх мэт амьдралын бүхий л хүрээнд үргэлжлэх үйл явц, суралцахуй ба амьдралыг нэгтгэн харах үзэл баримтлал;
- Боловсролд олон тооны уян хатан суралцах арга замууд байх, шинээр элсэн орох болон дахин элсэх нь аль ч насны хүнд ээлтэй, нээлттэй, албан ба албан бус бүтцийн хооронд уялдаа холбоотой байх зарчим. Тухайлбал албан бус ба амьдрах орчны боловсролоор олж авсан мэдлэг, ур чадвар, цогц чадамжийг албан ёсоор магадлан итгэмжлэхийг багтаасан ойлголт;
- Боловсролыг “Албан боловсрол + Албан бус боловсрол + Амьдралаас суралцах” гэсэн 3 хүрээнд өргөнөөр авч үзэх. Уг 3 хүрээнд суралцах өргөн боломжийг бий болгох, бүгдэд, ялангуяа нийгмийн эмзэг¹⁰⁶ бүлгийнхэнд хүртээмжтэй байлгах;
- Мэдээлэл харилцааны технологийг үр дүнтэй ашиглах, чанартай суралцах арга замуудыг боломжийн үнэтэй, хүртээмжтэй болгох;

САНАЛ: Бүх шатны боловсролд хамрагдаж чадаагүй хүүхэд/ залууст хоёр дахь боломж олгосон, малчдын хүүхдийн бага насны боловсрол хөгжилд анхаарч, чанартай хүртээмжтэй сургуулийн өмнөх боловсрол олгох, хүүхдэд ээлтэй дотуур байрыг хөгжүүлэх, насанд хүрэгчдийн боловсрол сургалтын эрэлт хэрэгцээг хангах, ажлын байран дээр суралцах өргөн боломжуудыг хуульчлах

¹⁰⁶ Эмзэг (маргинал бүлэг)- Бодлого шийдвэрийн гадна үлддэг бүлэг. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөдөлмөр эрхэлдэг, алслагдсан бүс нутагт амьдардаг, нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн, жендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн зэрэг

Боловсролд тэгш хамруулах (Inclusive approach)

- Хүмүүс ялгаатай хэдий ч нэг хүмүүн төрөлтөнд хамаардаг тул бие биедээ хандах, боломж олгохдоо зүй зохист хэмжээнд байх гэсэн ёс суртахууны “тэгш байдал” хэмээх үзэл баримтлалаас үүдэлтэй;
- Нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд амьдарч байгаагаасаа шалтгаалан, хүүхдүүд (өөрийн сонголт, эсвэл буруугаас биш) эрүүл мэнд, сайн сайхан байдал, ба амьдралын чанарын хувьд мэдэгдэхүйц ялгаатай байх нь энгийнээр хэлэхэд зүй зохист зүйл биш;
- Тэгш боломж дангаар хангалттай биш, эрхийг нь тэгш эдлүүлэхэд чиглэсэн бодлогын болон санхүүжилтийн нэмэлт арга хэмжээг зарим бүлгүүдийн хувьд авч хэрэгжүүлэх;
- Тэгш хамруулах боловсрол нь бүх суралцагчдад хүрч ажиллах боловсролын тогтолцооны чадавхыг бэхжүүлэн, тэдэнд учирч буй саад тотгорыг арилгах хариуцлага үүрч, нийгмийн соёл, дадал, заншилд өөрчлөлт, шинэчлэл хийнэ;
- Тэрээр бүх суралцагчдыг ялгаварлан гадуурхалгүйгээр тэдний сургалтын үйл явц дах бүрэн, үр дүнтэй оролцоо, хамралт, хүсэл эрмэлзэл болон амжилтад төвлөрнө;
- Энэ нь боловсролын хөтөлбөрийн агуулга, сургалтын арга зүй, хандлага, бүтэц болон стратегид хийж буй тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц юм;
- Төр, Засгийн Газрууд энэхүү үйл явцад шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн эх үүсвэрүүдийг хангалттай зориулах ёстой;

САНАЛ: Боловсролын салбарт, ялангуяа улсын сургууль, боловсролын байгууллагын хувьд чанар, орчны ялгаатай байдал, ялгаварлан гадуурхалт үүсгэж байгаа тусгай, кембриж, лаборатори, олон улсын хөтөлбөртэй гэх мэтээр ялгаж хуульчлахгүй байх, хүүхдийг гэртээ ойрхон сургууль, цэцэрлэгт хамрагдах нөхцөлийг бүрэн хангах

Боловсролыг төр, олон нийтийн хяналтад байлгах

- Боловсролын салбар, үйлчилгээ нь улс төрийн нам, эдийн засаг болон бусад явцуу ашиг сонирхлоос ангид, тогтвортой, тасралтгүй хөгждөг байх;

- Боловсролын агуулга, зорилго хэт нэг талыг барьж, үзэл суртлын зэвсэг болохгүй байхыг баталгаажуулах;
- Боловсролын зорилго, агуулга, хөтөлбөр нь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс болон үндэсний соёл, үнэт зүйл, өв уламжлалын зохист харьцааг хадгалах, Тогтвортой хөгжлийн зорилго 4: Чанартай боловсрол зэрэг олон улсын хөгжлийн чиг хандлагад тулгуурласан байх;
- Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын үзэл баримтлалтай уялдах;

САНАЛ: Боловсролын оновчтой засаглал, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх; боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх; боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр зохицуулалт нарийвчлан тусгах

Боловсролын хуулиар зохицуулах шаардлагатай тулгамдсан болон шинээр үүссэн асуудлууд

- Тэгш хамруулах боловсрол;
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол
 - Үндэстний цөөнхийн хос хэлний боловсрол
- Багш нарын мэргэжлийн байгууллага;
- Боловсролын салбар дахь засаглал, хариуцлагыг сайжруулах;
- Боловсролын төсөв, санхүүжилт;
- Эцэг эхийн оролцоо;
- ИНБ-уудын оролцоо, хяналт;
- Төрийн бус өмчийн боловсрол сургалтын байгууллагуудад төрөөс хийх зохицуулалт;
- Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхний дарамтаас урьдчилан сэргийлэх үүрэг;
- Дотуур байран дахь хүүхдийн эрэлт хэрэгцээ зэрэг нарийвчилсан зохицуулалт;

- Сургуулийн түвшний хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжийг сургуулиудад бий болгох: мэргэжлийн чиг баримжаа, сурлагын хоцрогдол арилгах, нийгэм-сэтгэл зүйн өөрчлөлт, зан төлөвийн өөрчлөлттэй, сахилга батын асуудалтай хүүхэдтэй ажиллах гэх мэт хичээлээс гадуур хөтөлбөрүүдтэй байх, хүүхдийн төлөвшил, хөгжилд ижил түвшинд анхаарах боломж олгох;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 сарын 13 өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдан хэрэгжиж байна. Уг баримт бичигт **боловсролын дараагийн 30 жилийн хөгжлийн бодлогыг чанартай, тэгш хамруулсан, эрх тэгш боломж бүхий насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоо бэхэжсэн байна** хэмээн тодорхойлсон. Тухайлбал:

- Улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэх;
- Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх;
- Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, санхүүжилтийг суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ.

“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛЭЭС БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ БОЛОН СӨБ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ

Хувийн өмчийн цэцэрлэг, сургуультай холбоотой тусгайлсан бүлгийн эхний төсөл

9 дүгээр зүйл. Сурч боловсрох эдийн засгийн боломжийг хангах

9.1. Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 7-д заасан эрхийн хүрээнд 18 хүртэлх насны Монгол Улсын иргэн, Монгол Улсад гурван сараас дээш хугацаагаар хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэний хүүхэд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуульд үнэ төлбөргүй хамрагдах эрхтэй.

9.2. Хуульд заасан шаардлагыг хангаж тусгай зөвшөөрөл авсан хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангах ба ашгийн төлөө бус байна.

9.3. Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн сургалтын төлбөрийн дээд хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

9.4. Энэ хуулийн 9.1-д зааснаар үнэ төлбөргүй сургалт явуулж байгаагаас бусад цэцэрлэг, сургуулийн сургалтын төлбөрийн хэмжээ болон байршлаас шалтгаалан хувьсах зардал олгохгүй байхаар тогтоож болно.

9.5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 26.6-д зааснаар зөрчил арилгах хугацаа тогтоосонтой холбоотойгоор тухайн хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд хувьсах зардал олгохыг түр түдгэлзүүлж болно.

26 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эрх хязгаарлах

26.1. Дараах нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээд хувийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байгуулах хүсэлтийг

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд¹⁰⁷ заасан тусгай зөвшөөрөл эрх олгох эрх бүхий этгээдэд гаргана:

26.1.1. үүсгэн байгуулагч, гишүүн, удирдах зөвлөлийн гишүүний боловсролын байгууллагад ажиллах эрх энэ хуульд зааснаар хязгаарлагдаагүй;

26.1.2. цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай сургалтын орчин, хэрэглэгдэхүүний шаардлагыг хангасан.

26.2. Цэцэрлэг, сургууль байгуулах тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

26.3. Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд олгосон хувьсах зардал болон суралцагчийн төлбөрийн зарцуулалт түүний хэвийн үйл ажиллагаа явуулах, хүүхдийг хөгжүүлэхэд зориулагдах ба энэ тухай энэ хуулийн 18.3-т заасан дүрэмд тусгасан байна.

26.4. Хувийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байгуулах тусгай зөвшөөрөл хүсэгчийн үйл ажиллагаа ашгийн төлөө бус байх бөгөөд дараах байдлаар үүсгэн байгуулагч, гишүүн болон бусад этгээдэд гэрээгээр тохирсон цалин хөлс, төлбөрөөс бусад байдлаар ашиг хуваарилахгүй, ногдол ашиг олгохгүй байна.

26.5. Дараах нөхцөл байдлыг энэ хуулийн 26.4-т заасныг зөрчсөн гэж тооцно:

26.4.1. цэцэрлэг, сургууль үйл ажиллагаа явуулж байх хугацаанд эсхүл үйл ажиллагаа зогсоосон, татан буулгасны дараа үүсгэн байгуулагч, гишүүн болон тэдгээрийн харилцан хамаарал бүхий этгээдэд ашиг, орлого, хөрөнгө хуваарилах, аливаа бусад байдлаар шилжүүлэх;

26.4.2. үүсгэн байгуулагч, гишүүн болон тэдгээрийн харилцан хамаарал бүхий этгээдийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг түрээслэх хэлбэрээр зардал гаргах;

¹⁰⁷ Дараах заалт сургуулийн хувьд таарахгүй байх жишээтэй: 13.1.Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг, татварын өрөө төлөхгүй хоёр ба түүнээс дээш удаа зайлсхийсэн, зугтсан тохиолдолд татварын албаны хүсэлтийг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

26.4.3. энэ хуулийн 26.3-т заасныг зөрчиж цэцэрлэг, сургуулийн хэвийн үйл ажиллагаа явуулах, хүүхдийг хөгжүүлэхтэй хамааралгүй эсхүл зах зээлийн ханшаас өндөр гэж үзэж болох бусад зардал гаргах.

26.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гурван жилийн хугацаанд цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг эхлүүлээгүй эсхүл энэ хуулийн 26.3-т заасныг зөрчиж ашиг хуваарилсан бол тусгай зөвшөөрөл хүчингүй болсонд тооцно.

26.6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн гэж үзвэл зөрчлийг арилгах талаар хугацаа тогтоож болно.

26.7. Дараах тохиолдолд цэцэрлэг, сургууль байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

26.7.1. энэ хуулийн 26.6-д заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй;

26.7.2. тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон;

26.7.3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4.-т заасан нөхцөлөөр¹⁰⁸

26.8. Цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаалтан, үүсгэн байгуулагч эсхүл зөвлөлийн гишүүний хувьд зөрчил гаргасан иргэнийг боловсролын байгууллагад ажиллах эрхийг хоёр хүртэл жилийн хугацаанд хязгаарлах шийдвэр гаргаж болно.

26.9. Энэ хуулийн 26.8-д зааснаар эрх хязгаарлуулсан иргэн цэцэрлэг, сургуульд удирдах албан тушаал эрхлэх, эсхүл үүсгэн байгуулагч, гишүүнээр бүртгүүлэхийг хориглоно.

27 дугаар зүйл. Хувийн өмчийн сургуулийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

27.1. Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа энэ хуульд нийцсэн байна.

¹⁰⁸ 6. Мөн зүйлийн 14.1.4-т заасан "удаа дараа" гэж 2 буюу түүнээс дээш зөрчсөнийг хэлэх ба "ноцтой зөрчсөн" гэдэгт тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг илтэд зөрчсөний улмаас нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хохирол учруулсан буюу учруулж болох байсан зэрэг нөхцөл байдлыг ойлговол зохино.

27.2. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

27.3. Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд элсэн суралцах суралцагчид энэ хуульд зааснаас нэмэлт шаардлага тогтоох, ялгаварлан гадуурхахыг хориглоно.

27.4. Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн эрх барих дээд байгууллага нь суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагчийн зөвлөл, багш, ажилтнуудын төлөөлөл бүхий удирдах зөвлөл байна.

27.5. Зөвлөлийн хурлаар хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон байгууллагын нууцад хамаарах асуудлыг хэлэлцэх бол суралцагчийн зөвлөлийн насанд хүрээгүй гишүүнийг хуралдаанд оролцуулахгүй.

27.6. Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөлд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

28 дугаар зүйл. Хувийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд төрөөс тавих шаардлагууд

28.1. Монгол улсын Үндсэн хуульд заасан¹⁰⁹ сурч боловсрох эрхийг хамгаалах хүрээнд төрөөс тогтоосон хувийн сургалтын байгууллагуудад хамааралтай хамгийн доод стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, мөрдүүлнэ.

28.2. Энэхүү стандарт нь дараах асуудлуудыг зохицуулсан байх ёстой:

1. улсын бүртгэлд бүртгэх болон тусгай зөвшөөрөл олгох үйл явц, тэдгээрийг цуцлах нөхцөл;
2. Санхүүгийн ба үйл ажиллагааны тайлан эсвэл чанарын мэдээлэл зэрэг төрд тайлагнах шаардлага;
3. Хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч, хүй олон, багшлах болон багш бус ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэл, бусад иргэний нийгмийн байгууллагуудын бүрэн, үр дүнтэй оролцоо;

¹⁰⁹ Арван зургадугаар зүйл.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:
7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.
Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

4. Боловсролын хэлбэр, мөн чанар нь хүлээн зөвшөөрөгдөхүйц, дасан зохицох чадвартай, Хүний эрхийн баримт бичигт заасан боловсролын зорилгод нийцсэн байх ёстой.
5. шаардлагатай тохиолдолд төлбөрийн хэмжээ болон бусад шууд ба шууд бус зардлын тааз тогтоох;
6. дотоодын болон шаардлагатай тохиолдолд олон улсын захиргаа, санхүүгийн бүтэц, суралцагчдад учирч болзошгүй бүх сургалтын төлбөр ба бусад төлбөр хураамж; боловсролын нөөцийн ашиглалт; хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, өдөр тутмын үйл ажиллагаа; элсэлтийн нөхцөл; байгууллагын эрх зүйн байдал, гарал үүсэл; болон байгууллагуудын бусад бодлого зэргийг багтаасан хувийн сургалтын боловсролын байгууллагуудын тухай мэдээллийн ил тод байдал, хүртээмжтэй байдал;
7. суралцагчдын гэрчилгээжүүлэх нөхцөл, ил тод байдал.
8. академик болон сурган хүмүүжүүлэх эрх чөлөөг хүндэтгэх;
9. суралцагчдын эвлэлдэн нэгдэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалах;
10. сурч боловсрох эрхийг эдлэхдээ ялгаварлан гадуурхагдах бүх хэлбэрээс суралцагчдыг хамгаалах, элсэлт, хамран сургалт, суралцах нөхцөлүүд шууд болон дам байдлаар ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулах замаар бүх суралцагчдын тэгш байдал, тэгш хамруулсан боловсролыг баталгаажуулах;
11. ажилтнуудын мэргэжлийн минимум ур чадвар; сургалт; хөдөлмөрлөх эрх, үүнд хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн гэрээний нөхцөл, цалин хөлс, эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх эрх чөлөө; боловсролын сургалтын байгууллагын удирдлага, багш, бусад ажилтны статус нь наад зах нь хүний эрхийн холбогдох хууль, стандартад нийцсэн байх ёстой;
12. суралцагчдыг сургуульд явахаас түр түдгэлзүүлэх, сургуулиас хөөх явдалд хатуу хязгаарлалт тогтоох, зохих журмын дагуу хийгдсэн эсэхийг баталгаажуулж, ийм түдгэлзүүлэх, хөөх нь үндэслэлтэй ба пропорциональ байх;
13. бие махбодын шийтгэлийг хориглох ба сахилга батын арга хэмжээ;

14. төлбөрийг төлөөгүй эсвэл саатсантай холбогдуулан суралцагчдын эрхийг хамгаалах;
15. сурах орон зайн хэмжээ, засвар үйлчилгээ, ариун цэврийн болон гал тогооны өрөөний тоноглол, тавилга, тоног төхөөрөмж, гамшиг эрсдэлийн удирдлага мөн түүнчлэн сурах бичиг, сургалтын болон сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг хүчин зүйлийг харгалзсан охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зэрэг бүх суралцагчдад тохирсон аюулгүй сургалтын орчин, дэд бүтцийн стандартууд;
16. хүртээмжтэй холбоотой наад захын шаардлага, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг суралцагчаас шууд болон шууд бусаар нэмэлт төлбөр авахгүй байхыг баталгаажуулах;
17. суралцагчдын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдал, түүний дотор нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх стандартыг хангах; эрүүл мэнд, эрүүл ахуй; суралцагчдыг хүчирхийлэл, бэлгийн дарамтаас хамгаалах;
18. суралцагчид болон тэдний гэр бүлийнхнийг заналхийлэх, ичээх, дээрэлхэхээс хамгаалах, ялангуяа тухайн байгууллагын хүлээгдэж буй академик/ эрдэм шинжилгээний стандартад нийцэхгүй байж болох болон тухайн байгууллагын талаар санал гомдол гаргах хүмүүсийг хамгаалах;
19. суралцагчдыг, ялангуяа хүүхдүүдийг элссэн байгууллагынхаа хэтийдсэн зар сурталчилгаанаас хамгаалах;
20. нууцлал ба мэдээллийн хамгаалалт, ялангуяа хувийн мэдээллийн талаар хууль, ёс зүйн хэм хэмжээг хүндэтгэх дээдлэх. Төр хувийн, түүний дотор биометрийн өгөгдлийг зөвшөөрөлгүйгээр цуглуулах, хадгалах, эсвэл шууд зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдтэй хуваалцах, боловсролоос бусад зорилгоор, үүнд арилжаа, цагаачлал, аюулгүй байдлын зорилгоор ашиглахгүй байхыг баталгаажуулах ёстой;
21. чанартай боловсролыг хангах үүднээс багш/суралцагчийн хүлээн зөвшөөрөгдөх хамгийн дээд харьцаа;
22. хүний эрхийг хамгаалахад шаардагдах бусад стандартууд

Ц.МАНДХАЙХАТАН, Н.ДОЛЖИН

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ¹¹⁰

Бодлогод залуусын хяналт ТББ болон түүний түнш байгууллага, залуучуудын бүлэг хамтран дараах санал зөвлөмжийг Засгийн газраас өргөн барьсан Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон 2022 оны 2-р сарын 22-нд УИХ-ын Дэд ажлын хэсгээс ажлын хэсэгт хүргүүлсэн төслүүдтэй танилцсаны үндсэн дээр дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна.

Бид боловсрол ялангуяа дээд боловсролын гол хэрэглэгчид болох залуучуудын өнцгөөс асуудалд хандаж буй бөгөөд Дээд боловсролын тухай хуулийн төсөл нь “**суралцагч буюу иргэн төвтэй**” болсон эсэхийг гол шалгуур болгон дараах саналыг хүргүүлж байна.

ЗАРЧМЫН ШИНЖТЭЙ БУЮУ ЕРӨНХИЙ САНАЛ

Нэг. Дээд боловсролын зорилго болон дээд боловсролын байгууллагын нийгэмд гүйцэтгэх үүргийг өргөжүүлж, ЮНЕСКО-оос тодорхойлсон болон Монгол Улсын Үндсэн хуулийн зорилгыг хэрэгжүүлэх “бүх нийтийн баялаг” болохынх нь хувьд зорилго, нийтийн эрх ашигт үйлчлэх чиг үүргийг хуульчлах нь зүйтэй байна.

Үндэслэл: ЮНЕСКО тодорхойлохдоо харилцан хамаарал нэмэгдэж буй дэлхий дээр тогтвортой хөгжлийг бий болгох хэрэгцээнээс үүдэн мэдлэг, боловсролыг “нийгмийн баялаг (public good)” бус, харин “**бүх нийтийн баялаг (common good)**” гэж авч үзэх шаардлагатай болсныг цохон тэмдэглэж байна. Учир нь “мэдлэг бол хүн төрөлхтний нийтийн өвийн салшгүй нэг хэсэг бөгөөд нийгмийн хамтын хүчин чармайлтын үр дүн гэсэн утгаараа мэдлэгийг бүтээх, түүнийг эзэмших, баталгаажуулах, хэрэглэх нь бүх нийтийн баялаг байх ёстой” гэсэн.

Түүнчлэн хүний эрх, нийгмийн эв нэгдэл, тэгш байдал, соёл хоорондын харилцаа, олон улсын ойлголцолд хамаарах бүх нийтийн баялаг нь дээд боловсрол дахь нийтлэг бүх нийтийн баялаг болно. Дээд боловсролын байгууллага нь бүх нийтийн баялгийг буюу өөрийн улс орны онцлогт

¹¹⁰ Энэ саналыг “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын зөвлөх Ц.Мандхайхатан, Н.Должин нар боловсруулав.

тохирсон мэдлэгийг хөгжүүлж, энэ мэдлэгээ үнэ төлбөргүй хуваалцах замаар нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж болохыг бусад судалгаануудад тусгасан байна. Мөн дээд боловсролын байгууллага нь нийгэмд үйлчлэхдээ сургалт болон судалгаа хийх, үнэт зүйлийг төлөвшүүлэх, нийгмийг шүүмжлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн хөдөлгөөн өрнүүлж болно гэж салбарын судлаачид, олон улсын байгууллага ДЭЭД БОЛОВСРОЛ-ын ач холбогдол, үр нөлөөг өргөн хүрээнд авч үзэж байна.

Гэтэл өнөөгийн Дээд боловсролын тухай хуулийн төсөлд: *“Дээд боловсролын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсад өрсөлдөх мэдлэгтэй, ур чадвартай, хөрвөх чадвартай, бүтээлч, хариуцлагатай, төлөвшсөн, эх оронч иргэнийг бэлтгэх, мэдлэг бүтээх, мэдлэгээр үйлчлэх замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршино”* гэсэн нь зөвхөн ажиллах хүч, эдийн засгийн явцуу байдлаар зорилгыг тодорхойлж, дээд боловсролын “мэдлэг бүтээх”-тэй холбоотой асуудлыг авч үзсэн байна.

Санал: Дээд боловсролын зорилго, зарчим, нийгэмд гүйцэтгэх үүргийг томъёолохдоо “бүх нийтийн эрх ашигт үйлчлэх, улс орны онцлогт тохирсон академик мэдлэгийг бүтээж, нээлттэй хуваалцах” үүргийг тусгахыг зөвлөж байна.

Ингэснээр Монгол улсын дээд боловсролын байгууллагууд өөрийн улс орны онцлогт тохирсон, өнгөрсөн 80 гаруй жилийн хугацаанд дээд боловсролд бий болсон академик мэдлэгийг нээлттэй хуваалцах, хөгжүүлэх, инновацилах боломжтой болох юм. Тодруулбал, монголын мал аж ахуй, экологи, ноолуур, газар тариалан гэх мэт өөр ямар ч улсаас олж авч чадахгүй мэдлэгийг өнгөрсөн хугацаанд дээд боловсролын байгууллагууд бий болгож чадсан билээ.

Хоёр. Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2002 оны Дээд боловсролын тухай хуулийн зохицуулалтаас ялгарах үзэл баримтлал, дараагийн 20-30 жилийн алсын хараа бүрхэг байгааг тодруулах, “хэрэглэгч” талын эрх ашиг, оролцоо, хариуцлага, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарсан зохицуулалтууд үгүйлэгдэж байна.

Үндэслэл: Залуучуудын хувьд дээд боловсрол эзэмших нь мэдлэг, чадвараа ахиулан хөгжих, улмаар амьдралын чанараа сайжруулах гол арга зам бөгөөд зөвхөн ажиллах хүч болох зорилготой биш юм. Гэтэл одоогийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд дээд боловсролын зорилгыг эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлд хувь нэмэр болох хэрэгсэл мэтээр явцуу хүрээнд томъёолжээ.

Гэтэл Америкийн боловсролыг шинэтгэгч Фрэнк Ньюмэний (2000) тодорхойлсноор “Дээд боловсролын байгууллага нь хичээл болон хичээлээс гадуурх ажлаар дамжуулан нэгд, хамтран ажиллах чадвартай болгож (ардчилсан үнэт зүйлийг эрхэмлэдэг, ялгаатай байдлыг хүндэлдэг) нийгмийн амьдралд бэлтгэх, хоёрт, танхимаас гадуур тэр бүр судлах боломжгүй гүн ухаан, түүх, утга зохиол зэрэг хичээлүүдээр дамжуулан оюун санааны амьдралд бэлтгэх, гуравт, оюутнуудыг мэргэжлийн амьдралд дасгахад тусалдаг” гэж өргөн хүрээнд авч үзжээ. Мөн манай улсын урт хугацааны хөгжлийн бодлогод боловсролын зорилгыг “*Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ*” гэж тусгасан алсын хараанд нийцүүлсэн зохицуулалт алга байна.

Хэлэлцэхээр бэлдэж буй хуулийн төсөлд дээд боловсролын “хэрэглэгч” болох оюутан залуусын эрх ашгийг хамгаалах, дэмжих тогтолцоог үндсэндээ тусгаагүй орхигдуулж, дээд боловсролын байгууллагын захиргааны асуудлыг зохицуулахад голлон анхаарснаараа дутагдалтай байна. Жишээлбэл, зөвхөн 12-13 дугаар зүйлд суралцагчийн эрх, үүрэг, нийгмийн баталгаа гэсэн агуулга хангалтгүй 2002 оны хуулийн нөхцөл байдлаас дээрдүүлсэн зохицуулалт байхгүй байна.

Мөн нийгэм, эдийн засгийн статус доогуур өрхийн, үндэсний цөөнхийн, хөгжлийн бэрхшээлтэй болон бага насны хүүхэдтэй залуу эмэгтэйчүүд зэрэг зайлшгүй дэмжлэг шаардлагатай суралцагчдыг хэрхэн дэмжих зохицуулалтууд огт тусгаагүй байгааг цохон тэмдэглэж байна. Түүнчлэн өөрийн удирдлагын байгууллагыг дээд боловсролын байгууллагад суралцагчийн түвшинд хэрхэн бий болгох, засаглал, шийдвэр гаргах түвшинд оролцох эрхийг үзэл баримтлал, зарчим, тодорхой зохицуулалтуудад тусгаагүй орхигдуулжээ.

ЮНЕСКО-гоос боловсролын салбар дахь төрийн үүргийг тодорхойлохдоо “Боловсрол бол тэнцүү боломж олгох гинжин холбоосны эхний гогцоо учраас боловсролын үйлчилгээг бүхэлд нь зах зээлийн харилцаанд шилжүүлэх ёсгүй. Энэ байр сууринаас үзвэл, төр дараах хоёр үүрэгтэй:

1. Нийгмийн өмнө илүү хариуцлагатай болгох тодорхой журмыг ашиглаж боловсролын салбарын авилгатай тэмцэх, төрийн өмчийн боловсролын системийг мэргэжлийн хувьд бэхжүүлж, өөрчлөлт хийх.
2. Боловсролын салбарт хувийн хэвшлийг татан оролцуулах ажлыг хянах зохицуулах. Ийм хяналт бол захиргааны ба хүнд суртлын саад байж болохгүйн дээр цагдаагийн үүргийг биелүүлж бүр ч болохгүй. Төрийн зүгээс тавих хяналт нь төрийн болон хувийн өмчийн боловсролын байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн боловсруулж баталсан стандартын хэрэгжилт, түүнчлэн олон улсын норматив баримт бичгүүдийн заалтуудыг биелүүлэх явцыг хангахад оршино” гэсэн.

Санал: Дээд боловсролын байгууллагад суралцаж буй оюутны эрх ашиг хохирохоос төр хамгаалах, засаглалын болон шийдвэр гаргах түвшний оролцоог нь баталгаажуулах, сургуулийн удирдлагад зөвшилцөх, хамтран ажиллах үүргийг оногдуулах зэргээр олон улсын туршлагад тулгуурласан нэмэлт заалтуудыг тусгахыг санал болгож байна.

Гурав. Энэхүү шинэчилсэн найруулгад 2002 оны Дээд боловсролын тухай хуулийн хамгийн бүрхэг асуудал болох “ашгийн болон ашгийн бус” дээд боловсролын байгууллагын ялгаа зааг, төрийн оролцоо ямар байх, чанарын хяналт, засаглалын онцлог, суралцагч эрх ашгаа хэрхэн хамгаалах, иргэний нийгмийн буюу хөндлөнгийн хяналт, оролцоо зэрэг асуудлаар тодорхой шийдлийг тусгах шаардлагатай байна.

Үндэслэл: Эрх тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээг үзүүлж буй эсэхийг хянах, хүний эрхийн зарчмуудыг дээд боловсролын байгууллагаар мөрдүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар төрд хүлээлгэсэн үүрэг билээ. Боловсрол нь “бүх нийтийн баялаг” болохынх нь хувьд дээд боловсролын байгууллагууд, ялангуяа хувийн хэвшлийн

байгууллагуудын нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар өргөн хүрээний нийгмийн диалоги өрнүүлэх замаар “ашгийн бус” боловсролын байгууллагууд хөгжих эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй байна. Тодруулбал, “Олон жилийн түүхэндээ төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежууд хувийн ашиг хонжоо олохоос илүү нийгмийн хэрэгцээ шаардлагад анхаарлаа хандуулж байсан тул онцгой байр суурь эзэлсээр ирсэн. Энэ байр суурийг дагаад тодорхой үүрэг хариуцлагууд бий” гэдгийг судлаачид цохон тэмдэглэсэн байдаг.

Одоогийн хуулийн төслийн нэр томъёоны тодорхойлолтоос үзвэл “ашгийн бус” гэдэг нь зөвхөн “төрийн өмчийн сургуулиудад хамаатай байх бөгөөд нийтийн эрх зүйн хуулийн этгээд” байхыг заажээ. Мөн “ашгийн төлөө” гэдэг нь хувийн өмчийн боловсролын байгууллагуудад хамаатай байж, хувийн эрх зүйн хуулийн этгээд болохыг заасан боловч энэхүү ялгаа зааг хуулийн бусад заалтуудтай хэрхэн уялдах нь тодорхойгүй байна.

Боловсролын байгууллагын зорилгыг өмчийн хэлбэрээр нь ангилан, хатуу ялган зохицуулах нь “бүх нийтийн эрх ашиг”-т хохиролтой бөгөөд боловсролын байгууллагуудын хөгжил, төлөвшлийг хаан боогдуулах, ялангуяа ашгийн бус зорилготой, хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм. Учир нь дэлхийд үнэлэгддэг АНУ-ын Харвард (Harvard), Йел (Yale) зэрэг их сургуулиуд хувийн хэвшлийнх боловч “ашгийн бус” зорилготой байдаг билээ. Ийнхүү ашгийн бус байх нь боловсролын үйлчилгээнээсээ олж буй орлогыг байгууллагын эрхэм зорилго, урт хугацааны хөгжилд зориулахаас гадна төрөөс үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, бусад олон нийтийн сангаас хөрөнгө оруулалт татах зэрэг давуу тал үүсгэдэг.

Гэтэл манай улсын хувьд дээд боловсролын салбарт энэхүү “ашгийн болон ашгийн бус” байх асуудлыг хэлэлцээгүй, төрийн бодлогын ялгаа зааг, дэмжлэгийн төрлийг тодорхойлоогүй өдгөөг хүрсэн билээ.

Санал: “Боловсрол бүх нийтийн баялаг” болохынх нь хувьд Дээд боловсролын байгууллагын зорилгыг “ашгийн бус” байх зарчмыг хуульчлах нь зүйтэй байна.

Хэрэв “ашгийн төлөө” байгууллага байх ёстой гэж үзэх тохиолдолд хувийн өмчийн байгууллагууд зорилгоо өөрсдөө томъёолох, сонголт

хийх боломжийг олгох нь зүйтэй юм. Мөн төрийн зүгээс үзүүлэх аливаа дэмжлэг, жишээлбэл боловсролыг дэмжих сан, татварын хөнгөлөлт чөлөөлөлт зэрэг арга механизмууд зөвхөн ашгийн бус байгууллагад зориулах болохыг тусгайлан оруулах, чанарын шаардлага, хяналтыг хуульчлах шаардлагатай байна.

Дөрөв. Дээд боловсролын чанар, үйлчилгээний стандартыг дээшлүүлэх, хүртээмжтэй орчныг бий болгохоос эхлэн суралцагчдын ялгаатай байдлыг авч үзэх, дэмжлэг үзүүлэх бодлогын шийдлүүд хуулийн төсөлд тусаагүй байна.

Үндэслэл: Дэлхийн 15 улсын дунд чадварлаг боловсон хүчин, санхүүгийн чадвар болон боловсролын тогтолцоо нь өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж чаддаг эсэх талаар явуулсан судалгаанд Монгол улс сүүлийн байр эзэлжээ. Дээд боловсролын байгууллагын чанарыг сайжруулахад сургалтын хөтөлбөр, албан бус хөтөлбөр, оюутныг дэмжих хөтөлбөрүүд зэргийг цогцоор тусгах нь зүйтэй байна. Учир нь шинжлэх ухаан хоорондын зааг бүдгэрч буй энэ цаг үед ганцхан нарийн мэргэжлээр бэлтгэх нь суралцагчдын мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд хангалтгүй тул салбар дундын болон хос, хавсарсан мэргэжил эзэмших боломжийг бий болгох шаардлагатай нь хүн ам цөөтэй Монгол Улсын хувьд хүний нөөцөө бүрэн дайчлах боломжийг бүрдүүлэх юм.

Мөн хуулийн төслийн 14-р зүйлийн суралцагчийн нийгмийн баталгаанд “тэтгэлэг, зээл авах боломжтой” гэсэн заалт байгаа боловч бусад заалтуудаар энэхүү зээлийн санг хэрхэн санхүүжүүлэх, ямар шалгуур тавих зэрэг зохицуулалт тусгагдаагүй нь эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүдэд дэмжлэг болж чадахгүй юм. Иймд хуульд эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан боловсролын зээл, тэтгэлгийн сангийн төсвийг тэвчиж болох зардалд оруулан танахгүй байх, мэдээллийн ил тод байдал болон хөндлөнгийн хяналт болох иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хуульчлах, дээд боловсрол эзэмших шалгуурыг хангасан иргэдэд нээлттэй, уян хатан байх, мэргэжлээр ангилан ялгаварлахгүй байх зохицуулалтыг нарийвчлан тусгах шаардлагатай байна. Түүнчлэн мэргэжил болон салбар хоорондын уялдаа холбоог хангах, аль нэг хүйс давамгайлж буй салбаруудад бусад хүйсийн оролцоог хэрхэн бий болгох зэрэг дараагийн 20-30 жилийн

алсыг харсан зохицуулалтууд хангалтгүй байна. Жишээлбэл, мэргэжил сонголттой холбоотой жендерийн хэвшмэл ойлголтыг арилгах, тэгш хамруулах үүднээс ирээдүйн хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийг тооцож инженерчлэл, геологи, техник, технологийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт эмэгтэй элсэгчдийн хувийн жинг 30 хувь байлгах квотыг тогтоох, тэтгэлэг авах боломжийг бүрдүүлэх зэрэг жендерийн тэгш эрхийг хангахад ахиц дэвшил авчрах зохицуулалтыг тусгаж болох юм.

Хуулийн төслөөс үзвэл оюутан суралцах хугацаандаа аюулгүй, хүртээмжтэй орон байраар хангагдах, дээд боловсролын байгууллага энэ асуудалд “үүрэг хүлээгч” болохыг тусгалгүй орхигдуулжээ. Оюутны эрүүл мэнд, сайн сайхан байдал, амжилттай суралцах үндсэн нөхцөл болох “дотуур байр”-ны асуудал өдгөөг хүртэл боловсролын салбарт орхигдсон асуудал юм. 2019 онд хийсэн “Дээд боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүрэлцээ, хангамж, орчин нөхцөлийн судалгаа”-гаар зах зээлийн нийгэмд шилжсэн 30 гаруй жилийн хугацаанд оюутны дотуур байр нэмэгдээгүй, 90-ээд оноос өмнөх хэв шинжээр ажиллаж байгаа, орчин нөхцөл хангалтгүй байгааг харуулсан байдаг. Мөн жил бүр суралцаж буй оюутны 10 орчим хувь л дотуур байраар хангагдаж буй бөгөөд үлдсэн оюутнууд дээд боловсрол эзэмшихийн тулд илүү их зардал гаргах, хүчирхийлэл дарамтад өртөх, сургууль завсардах зэрэг сөрөг үр дагаврууд гарсаар байгаа тул хууль тогтоомжид “оюутны дотуур байр”-ны асуудлыг бодлогын түвшний асуудал болгон авч үзэх нь дээд боловсролын салбарын цаашдын хөгжил, чанарыг дээшлүүлэх гол хүчин зүйл билээ.

Санал: Дээд боловсролын чанарыг сайжруулахад суралцагч төвтэй хичээлийн болон хичээлийн бус хөтөлбөр, агуулгыг хөгжүүлэх, суралцагчдын ялгаатай хэрэгцээг авч үзэх, суралцахыг дэмжих бодлогын шийдлүүдийг (зөвхөн боловсролын зээлийн сангаар хязгаарлалгүй) төрөлжүүлэхийг зөвлөж байна. Мөн эн хуульд хөндлөнгийн буюу олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хяналтыг тусгаснаар үр ашигтай байдал, чанарын хяналт бий болж чадах юм.

Тав. Дээд боловсролын салбарыг хөгжүүлэх, байгууллагыг удирдах шийдвэр гаргах бүхий л түвшинд талуудын ялангуяа хэрэглэгчийн төлөөллийг оролцуулах зохицуулалт үгүйлэгдэж байна.

Үндэслэл: Боловсролын салбарт хамтын хариуцлага хүлээх оролцогч талуудыг төр буюу Засгийн Газар, сургуулийн удирдлага, багш, эцэг эх, суралцагчид, ТББ-ууд, олон улсын байгууллагууд, хувийн хэвшил гэж тодорхойлж байна. Учир нь ЮНЕСКО-оос “хүн төрөлхтний язгуур үндэс болсон эв нэгдлийн тухай үзэл санаанд тулгуурлаж мэдлэг, боловсролыг дэлхий нийтийн баялаг гэж үзэх зарчим нь боловсролд оролцогч төрөл бүрийн сонирхогч талуудын үүрэг, хариуцлагад нөлөөлөх болно” гэсэн нь дээд боловсролын салбарт ч хамаатай юм. Өөрөөр хэлбэл, дээд боловсролын засаглалын асуудал зөвхөн тухай боловсролын байгууллагад хамаатай ойлголт биш юм. Иймд бидний зүгээс “хамтын засаглал” буюу хэлэлцэх, зөвлөлдөх, хамтрах, багаар ажиллах зарчмаар ажиллаж шийдвэр гаргадаг удирдлагын хуваарилалтын хэлбэр-ийг хуульчлахыг санал болгож байна. Ингэснээр тус салбарт харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, дээд боловсролд инновацийг нэвтрүүлэх, сургуулийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, судалгааны сургууль болох зорилгыг хэрэгжүүлэх, багш, ажилтнуудын [хоорондын] өрсөлдөөний сэтгэлгээнээс илүүтэйгээр хамтын сэтгэлгээ, дэмжлэг, хоорондын итгэлцлийг чухалчлах зэрэг ач холбогдолтой болохыг салбарын судлаачид цохон тэмдэглэжээ.

Мөн ЮНЕСКО-гийн тайланд “Боловсролын талаарх өргөн хүрээний зорилтыг биелүүлэхэд талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бүхий харилцаа хамгийн чухал билээ. Хэрэв хязгаарлагдмал боломжийн хүрээнд хууль эрх зүйн үндэслэлтэй зорилт, биелэхүйц үйл ажиллагаа явуулж чадвал олон нийтийн итгэл, дэмжлэгийг олж авна. Эцсийн дүнд, олон нийтийн итгэл алдарснаас иргэний оролцоо үгүй болж эцэг эхчүүд боловсролд хандуулах анхаарал нь сулардаг. Боловсролын тогтолцоонд итгэл алдарснаар боловсролын шинэчлэл удаан, өнгөц шинжтэй болдог. Итгэл төрүүлэхийн тулд бүх сонирхогч талыг боловсролын талаарх нэгдсэн зорилго боловсруулахад татан оролцуулах, харилцан хамааралтай хариуцлагад суурилсан хамтын ажиллагаатай болохын чухлыг ойлгуулах хэрэгтэй.”

Хуулийн төслийн 5 дугаар бүлэгт “Дээд боловсролын удирдлага” гэсэн хэсгээс үзэхэд “хэрэглэгч тал буюу суралцагч”-ийн төлөөллийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах заалт хангалтгүй буюу хязгаарлагдмал

байна. Жишээлбэл, “Үндэсний зөвлөл” гэсэн 21 гишүүнтэй, орон тооны бүрэлдэхүүнтэй ажиллах зөвлөлд зөвхөн төр, бизнес, профессоруудын төлөөлөл байна гэсэн байна. Мөн төрийн өмчийн сургуулийн Удирдах зөвлөлийн 20 хувьд багш болон оюутан, 10 хувьд төгсөгчийн төлөөлөл байхаар тусгасан бол хувийн өмчийн сургуулийн хувьд оюутан, багш, төгсөгчийн төлөөлөл байх зохицуулалтыг орхигдуулжээ.

Санал: Дээд боловсролын байгууллагын засаглалын онцлог болох “хамтын удирдлага”-ын зарчмыг хуульчлах, суралцагчдын буюу хэрэглэгчдийн эрх ашиг, оролцоог хамгаалах, төлөөллийн байгууллагаа ажиллуулах, бүхий л шатанд хамтын шийдвэр гаргахад оролцох оролцооны механизмуудыг бий болгох зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Зургаа. Энэхүү хуулийн төсөл нь Судалгааны их сургуулийн хуулийн малгай буюу суурь зохицуулалтыг агуулах ёстой боловч тус хуульд энэ талаарх зохицуулалт, зарчмын шинжтэй заалтууд огт тусгагдаагүй байна.

Үндэслэл: “Судалгааны их сургууль”-ийн хуулийн суурь зарчмуудыг энэ хуульд тусгаснаар хууль хоорондын уялдаа холбоо хангагдаж, эрх зүйн эх сурвалжийн эрэмбийн шаардлагыг хангаж чадах юм.

Санал: “Судалгааны их сургууль”-ийн хуулийн суурь зарчим болон зохицуулах асуудлыг тусгах шаардлагатай. Энэхүү хуулийн төсөлтэй холбоотой санал зөвлөмжийг бид бэлдэн хүргүүлэх болно.

ТУСГАЙЛСАН САНАЛ

1. Хуулийн төсөлд “Дээд боловсролын байгууллагын чиг үүрэг” гэсэн зарчмын шинжтэй, өргөн хүрээний зохицуулалтыг 29-р зүйлд буюу хуулийн төгсгөлд байршуулсан нь хууль зүйн техникийн хувьд анхаарах шаардлагатай байна. Иймд 2-р бүлгийн 5 дугаар зүйлийн өмнө буюу дээд боловсролын байгууллагын ангиллын зохицуулалтаас өмнө хэсэгт оруулахыг санал болгож байна.
2. Төслийн 9-р зүйлийн 10-р заалтад “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын хамтарсан шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт, эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл, дадлагын түшиц газар болгож болно” гэжээ.

Дээрх заалтын хувьд сургалт, эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл, дадлагын түшиц газрыг сонгох, өөрчлөхөд төрийн захиргааны төв байгууллага оролцох нь эрх мэдлийн төвлөрөл үүсгэх, сургуулиуд өөрийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн дадлагын түшиц газрыг сонгох, өөрчлөхөд хүндрэл учруулах эрсдэлтэй. Түшиц газрын нийтлэг шалгуурыг төрийн захиргааны төв байгууллагаас гаргаж, дээд боловсролын байгууллага мэргэжлийн багш, тэнхимийн саналд тулгуурлан сонгох, өөрчлөх эрхтэй байх илүү тохиромжтой. Түшиц газрын нийтлэг шалгуурт нь шинжлэх ухааны салбаруудын онцлогийг харгалзан гарахын зэрэгцээ талуудын эрх, үүргийг тусгавал илүү үр дүнтэйг анхааралдаа авахыг зөвлөж байна.

3. Хуулийн төслийн 9-р зүйлийн 12-т “Дээд боловсролын байгууллага дотуур байртай байна” гэсэн заалт нь хэт ерөнхий байгаа тул хуулийн төсөлд “дотуур байр”-тай холбоотой дараах зохицуулалтыг нарийвчлан тусгахыг санал болгож байна. Үүнд:

- Их, дээд сургууль, тэдгээрийн оюутны байрны орчинд тавигдах стандартыг хуульчилж, уг стандартыг хэрэгжүүлэх үүргийг их дээд сургуулийн удирдлагад оногдуулж, магадлан итгэмжлэх шалгуурт тусгах;
- Дээд боловсролын сургалтын байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах шалгуурт хүссэн оюутан дотуур байранд амьдрах боломжоор хангах шаардлагыг тусгах;
- Сургуулийн удирдах зөвлөлийн үүрэгт оюутны аюулгүй байдлыг хангах үүргийг тусгаж, өөрийн сургуулийнхаа оюутны дотуур байранд жил бүр хяналт шалгалт явуулах, оюутныг амьдрах таатай нөхцөл бүрдүүлэх үүргийг хуульчлах;
- Орчин үеийн хэв загварын оюутны дотуур байр шинээр байгуулах буюу Улаанбаатар хотод их, дээд сургууль, коллежийн оюутанд зориулсан оюутны цогцолбор (кампус) байр болгон хөгжүүлэхэд чиглэсэн агуулгыг тусгаж, холбогдох төрийн байгууллагад журам батлах буюу төлөвлөлт хийх үүргийг оногдуулах;
- Дотуур байранд амьдрахаар ирсэн оюутан залууст зориулсан үйлчилгээ бий болгож, холбогдох журам, заавар батлахыг хуульчлах. Үүнд:

- o Оюутны байранд амьдрахаар ирсэн оюутнуудад дасан зохицох тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - o Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ, үзүүлэх;
 - o Оюутны дотуур байрны номын сангийн үйлчилгээтэй байх;
 - o Дотуур байрны оюутнуудын дунд урлаг, спортын клуб хичээллүүлэх гэх мэт.
- Амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчдад дотуур байрны төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, сургуулиас төлбөрийг нь даах, оюутны зээлд дотуур байрны төлбөрийг багтаах зэрэг арга замыг тодорхой заах;
4. Мөн төслийн 13-р зүйлд заасан нийгмийн баталгаанд “дотуур байраар хангуулах” гэсэн томъёоллыг нэмэх нь зүйтэй байна.
5. Төслийн 26-р зүйлд заасан “Удирдах зөвлөлийн чиг үүрэг,” 27-р зүйлд заасан “Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг” гэсэн зүйлүүдэд оюутан бүрийн ялгаатай хэрэгцээг харгалзсан, оюутанд үзүүлэх үйлчилгээний төрөл, хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх үүргийг удирдах түвшинд үүрэг болгосон зохицуулалтуудыг тусгахыг зөвлөж байна. Учир нь ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд орж ирснээр дээд сургуульд элсэгч нэмэгдэх учраас тэгш хамруулан сургах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дээд боловсролын байгууллага бэлтгэлтэй байх ёстой юм.

Иймд дараах асуудлуудыг хуулийн төслийн холбогдох хэсэгт нэмж тусгах хэрэгтэй байна. Үүнд:

- Их, дээд сургуулийн аль нэг мэргэжлийн ангид суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутанд “нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх” журмыг батлах, боловсон хүчнийг бэлдэх (жишээлбэл, хөдөлмөр засалч, туслах багш, сэтгэл зүйч, дохионы хэлмэрч гэх мэт), тусгай хэрэглэгдэхүүнээр хангах, хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх гэх мэт.
- Хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн цөөнх, үндэсний цөөнх зэрэг оюутнуудыг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах буюу сургууль, оюутны байрыг эрүүл, аюулгүй орчин болгох, хэрэв энэ төрлийн гарсан зөрчил гарсан тохиолдолд гомдлыг хэн, хэрхэн шийдвэрлэх,

хариуцлагын механизмыг тодорхой хуульчлах;

- Их дээд сургуулийн орчин, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй, бэлгийн цөөнх, үндэсний цөөнхийн онцлогт нийцсэн байх бөгөөд үүнийг сургуулийн удирдах зөвлөл бодлогын хувьд чиглүүлж, сургуулийн захиргаа хариуцан гүйцэтгэхийг үүрэг болгох;
- Их дээд, сургууль, коллежийн номын сан болон хичээлийн байруудад тусгай лаборатори, компьютер технологийн өрөө хүртээмжтэй байх;
- Үндэсний цөөнхийн оюутанд зориулсан хэлний бэлтгэл ажиллуулах хөтөлбөртэй байх гэх мэт хүний эрхэд суурилсан дээд боловсролын салбарыг хөгжүүлэхэд анхаарсан зохицуулалт хуулийн төсөлд үгүйлэгдэж буйг дахин ЦОХОН тэмдэглэж байна.

Ц.МАНДХАЙХАТАН, Н.ДОЛЖИН

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ¹¹¹

Бодлогод залуусын хяналт ТББ болон түүний түнш байгууллага, залуучуудын бүлэг хамтран дараах санал зөвлөмжийг Засгийн газраас өргөн барьсан Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөлд дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна. Бид боловсрол ялангуяа дээд боловсролын гол “хэрэглэгчид” болох залуучуудын өнцгөөс асуудалд хандаж буй бөгөөд Боловсролын ерөнхий хууль болон Дээд боловсролын тухай хуулийн төсөлтэй уялдаж буй эсэх, судалгааны их сургуулийн талаарх олон улсын туршлагад тулгуурласан эсэх, “**суралцагч буюу хүн төвтэй**” болсон эсэхийг гол шалгуур болгон дараах саналыг хүргүүлж байна.

Биднээс хүргүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төслийн талаарх санал, зөвлөмжтэй энэхүү баримт бичиг уялдаж буйг цохон тэмдэглэе.

ЗАРЧМЫН ШИНЖТЭЙ ЕРӨНХИЙ САНАЛ

Нэг. Хуулийн төсөл нь Дээд боловсролын тухай хуулийн зохицуулалттай уялдаагүй, “гараа”-ны нөхцөлийг тодорхойлоогүй буюу одоо байгаа их сургуулийн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс хэрхэн сэргийлэх нь тодорхойгүй байна.

Үндэслэл: Дээд боловсролын тогтолцоо нь тусгаар тогтнолын баталгаа, улс үндэстний ижилсэл-ондоошлын салшгүй хэсэг. Одоогийн хуулийн төслөөс судалгааны их сургууль байгуулах “гараа”-г хэрхэн эхлүүлэх талаарх тодорхой зохицуулалт байхгүй байна. Гэтэл төрийн өмчийн 6 сургууль аль хэдийнээ ахисан түвшний сургалтын хөтөлбөрүүдээ болон дүнгийн тогтолцоогоо нэгтгэх бэлтгэл ажлаа эхлүүлж, бакалаврын түвшиндээ ижил мэргэжлийг шинээр бий болгож, өрсөлдөхгүй гэсэн санамж бичиг байгуулах зэргээр хамтран ажиллаад эхэлжээ. Төрийн өмчийн их сургуулиудын эдгээр санаачилгаас үзвэл “судалгааны их сургууль” (СИС) болох бэлтгэл хийгдэж байна гэж үзэж

¹¹¹ Энэ саналыг “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын зөвлөх Ц.Мандхайхатан, Н.Должин нар боловсруулав.

болохоор байгаа боловч өргөн баригдсан хоёр хуулийн төсөлд СИС-ийн “гараа”-г хэрхэн эхлүүлэх, шилжилтийг хэрхэн зохицуулах, тулгарч болох эрсдэлийг хаасан зохицуулалт агуулсан зүйл, заалтууд алга байна.

Монгол Улсын хувьд ууган их сургууль 1942 онд байгуулагдан 80 гаруй жилийн турш дээд боловсролтой боловсон хүчнийг бэлдсэн түүхэн уламжлал, мэдлэгийн сантайн хувьд “судалгааны их сургууль”-тай болохыг зорих нь дэлхийн өрсөлдөөнт зах зээлийн үйл явцад байр сууриа олоход хэрэгтэй боловч, хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн боловсролын дэд салбараа унагах бодлогын эрсдэлийг дагуулж байна. Учир нь Дээд боловсролын тухай хуулийн төсөлд судалгааны их сургуулийн талаарх өгүүлбэр, зохицуулалтыг тусгаагүй байтал судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөл тун ерөнхий байгаа нь хууль батлаад хэрэгжихгүй байх, хэрэгжсэн ч “хийдэл”-тэйн улмаас суралцагчид хохирохоос эхлээд сургалтын чанарын хувьд тэргүүлж байгаа төрийн өмчийн боловсролын салбараа унагааж болзошгүй юм.

Мөн СИС-ийн олон улсын туршлага дараах хэд хэдэн эрсдэлийг агуулж байдаг байна.

1-рт, зөвхөн их сургууль нь “судалгаа” буюу мэдлэг бүтээх үйл явцад төвлөрч, үндсэн үүрэг болох “мэдлэг”-ийг дамжуулах үүргээ умартаж болзошгүйд хүрдэг. Энэ нь ахисан түвшний буюу магистр, докторын сургалтад голлон анхаардгаас оюутны тоо нь бакалаврын түвшний оюутнаас их байдаг, зарим нь бүр бакалаврын түвшний оюутангүй байх тохиолдол ч байдаг байна. Гэтэл манай улсын дээд боловсролын байгууллагуудын дүр зураг эсрэгээрээ бөгөөд бакалаврын оюутнуудын сургалтын төлбөр дээр тогтдог. Иймд бакалаврын түвшний сургалт дээр тогтдог тогтолцоог СИС болгох нь шат дараалсан бодлогын зохицуулалт хэрэгтэй юм.

2-рт, СИС-иуд хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах үйлдвэрлэлийн, бизнесийн ашиг өндөртэй судалгааг илүүтэй анхаарах эрсдэлтэй болдог байна. Хамгийн ашиг өндөртэй судалгаа нь голцуу техник, технологи, байгалийн ухааны судалгаа байдаг тул богино хугацаанд өгөөжөө өгөх судалгаанд тэргүүлэх ач холбогдол өгөн суурь судалгаа, нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгааг хойш тавьж болзошгүй болдог байна.

3-рт, Судалгаанд хэт анхаарснаар сургалтын үйл явцыг орхигдуулах буюу оюутныг төлөвшүүлэх, багшийн заах ур чадварыг дээшлүүлэх зэрэг их сургуулийн үндсэн үүргийг хоёрдугаарт тавих эрсдэлтэй байдаг байна.

4-рт, Мөн СИС-д зөвхөн нийгэм эдийн засгийн статус дээгүүр өрхийн хүүхдүүд суралцах боломжтой байдаг сөрөг үр дагавар гарч болзошгүй байна.

Санал: Өнөөгийн их сургуулиуд нь бүхий л салбарт нэн шаардлагатай эмч, багш, зоотехникч, малын эмч, инженер гэх зэрэг тодорхой мэргэжилтэн бэлтгэх нийгмийн өмнө хүлээсэн үүрэгтэй. Хэрэв төрийн өмчийн сургуулийг судалгааны сургууль болгон өөрчлөх тохиолдолд одоо байгаа бүтцийг бэхжүүлэх, аль болох төрийн өмчийн их сургуулийн тоог цөөрүүлэхгүй байх замаар “судалгааны сургууль болгон хөгжүүлэх” арга замыг хуульд тодорхой заах хэрэгтэй байна.

Мөн дээр дурдсан СИС байгуулагдан ажиллахад тулгарч болох эрсдэлүүдээс сэргийлсэн *тунхаглалын шинжтэй бус* (төслийн 3-р зүйлд СИС-ийн зорилгыг тодорхойлсон нь тун ерөнхий байна, энэ зорилгод бүх нийтийн баялаг болох, нийгэмд үйлчлэх, улс үндэстний эрх ашгийн талаарх зорилго тусаагүй) **зохицуулалт агуулсан заалтыг** оруулах буюу удирдах зөвлөл, олон нийтэд мэдээллийг ил тод болгох, чанарын үнэлгээний механизмыг тодорхойлох болон бодлогоор дэмжих салбаруудыг тодорхой заах нь зүйтэй юм.

Хоёр. Судалгааны их сургуулийн шалгуур, тавигдах шаардлага, шилжилтийн үеийн болон салбар дундын зохицуулалт, хариуцлагын тогтолцоог хуулийн төсөлд тодорхойлоогүй байна.

Одоогийн хуулийн төслийн 7.4-т “Сургуульд тавигдах шаардлага, холбогдох журмыг Дээд боловсролын үндэсний зөвлөл батална” гэсэн байна. Гэтэл Дээд боловсролын тухай хуулийн 23.2-т зааснаар уг зөвлөл нь нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон буюу төрийн төлөөлөл, бизнесийн төлөөлөл, профессорын төлөөллөөс бүрдсэн 21 гишүүнтэй байх ба гишүүний бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байхаар заасан байна. Мөн зөвлөлийн эрх хэмжээнд СИС-тай холбоотой чиг үүрэг, хариуцлага тусгагдаагүй юм.

Ийнхүү СИС-д тавигдах гол шалгуур, байгуулж ажиллуулах журам, хариуцлагын тогтолцоог СИС-ийн тухай хуульд нарийвчлан зааж өгөхгүйгээр, УИХ-аас улс орны хэмжээний бодлого, салбарын шинэчлэлийн асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлээ “хараахан бий болж, бэхжиж амжаагүй бүтэц”-эд шилжүүлэх нь маш их эрсдэлтэй үйлдэл гэж үзэж байна. Мөн энэ нь СИС-ийн тухай хуулийг Дээд боловсролын тухай хуулиас тусдаа батлах ач холбогдлыг бууруулж байна.

Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт дурдсанаар “Хэфэйн тунхаглал”-д орчин үеийн судалгаанд суурилсан их сургуулийн талаар дараах үндсэн шинжийг нэрлэсэн байна. Үүнд:

- “нээлттэй засаглалын тогтолцоотой байх, олон улсын хэмжээнд чадварлаг мэргэжилтнийг татах чадвартай шилдэг хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
- өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй эрхэм зорилгоо тодорхойлж, стратегийн төлөвлөгөө хэрэгжүүлдэг, судалгаа, сургалтын тэргүүлэх чиглэлээ бие даан тодорхойлох эрхтэй байх;
- судалгааны ёс зүй, түүнтэй холбоотой хэм хэмжээний стандартыг мөрддөг, эрдмийн эрх чөлөөг хариуцлагатайгаар хэрэгжүүлдэг байх;
- судлаачдыг тасралтгүй бэлтгэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлдэг байх;
- тэргүүлэх салбарт бакалаврын, ахисан түвшний сургалтаар үндэсний болон олон улсын түвшинд инновацыг бий болгох, нэвтрүүлэх чадамжийг бүрдүүлсэн байх” гэжээ.

Хуулийн төслийн 5-р зүйлд дээрх Хэфэйн тунхаглалд дурдсан шинжүүдийг “СИС-ийн баримтлах зарчим” гэж агуулгын тусгасан боловч аливаа хуулийн зарчим дараагийн нарийвчилсан зохицуулалт болон хариуцлагын тогтолцоогоор дамжин амь ордог боловч одоогийн хуулийн төсөлд энэхүү шаардлагыг тусгалгүй орхигдуулжээ.

Санал: СИС-д тавигдах шалгуурыг 5 жил дутамд солигдох Зөвлөлд даатгалгүй энэ хуулийн төсөлд нарийвчлан тусгахыг зөвлөж байна. Мөн СИС-ийг хэрхэн байгуулах бодлогын шийдлийг сонгож, шилжилтийн

үеийн болон салбар дундын зохицуулалт, хариуцлагын тогтолцоог хуульчлах нь зүйтэй байна.

Ялангуяа, төрийн болон хувийн өмчийн сургуулиуд нэгдэх, татан буугдах замаар СИС-ийг бий болгох тохиолдолд суралцаж буй оюутны эрх ашгийг хамгаалсан заалтыг тусгайлан оруулах шаардлагатай байна. Аливаа шилжилтийн зохицуулалтыг нарийвчлан зохицуулах, шилжилтийн журам, төлөвлөгөөг олон талын оролцоотой батлаагүйгээс “хэрэглэгч” болсон оюутны эрх ашгийг хохироосон жишээ цөөнгүй байдаг.

Гурав. СИС-ийн хөгжүүлэх тэргүүлэх салбарыг хэрхэн тодорхойлох, бодлогын хувьд чиглүүлэх үүргийг хэн хүлээх, ялангуяа төрийн өмчийн судалгааны сургуулиудын хувьд хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байна.

Үндэслэл: Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайланд дурдсанаар “Дээд боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED) ба Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, бэлчээрийн мал ахуй зэрэг үндэсний онцлог хоорондын тохирцыг үнэлж, мэргэжлийн үндэсний хүрээ (national qualification framework)-г боловсруулан батлахгүйгээр сургалтын хөтөлбөрийн хөгжил бүрэн хангагдах боломжгүй байна” гэж дүгнэсэн байдаг. Тус судалгаанд Монгол улсын дээд боловсролын салбарын мэдлэг буюу хөгжил бусад улс орнуудаас хэрхэн ялгарах онцлогийг тодорхойлох, ялангуяа үндэстний онцлог болсон мал аж ахуйд тулгуурласан мэдлэгийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байгааг хэд хэдэн удаа цохон тэмдэглэжээ.

Мөн ШУТИС-ийн СИС-ийн асуудлаар хийсэн бодлогын цувралд дурдсан жишээ, баримтуудаас үзэхэд СИС-ийг байгуулах, хөгжүүлэх, дэмжих нь маш их санхүүжилт, бодлогын шат дараалсан дэмжлэгийг төлөвлөх шаардлагатай байдаг байна. Мөн аль салбарыг хөгжүүлэх вэ гэдэг нь улс орны бодлогын цөм болох буюу бодлого тодорхойлогчдын алсын хараанаас шууд хамаарахаас аргагүй байдаг байна.

Одоогийн хуулийн төслийн зохицуулалтад инновацыг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах талаас ерөнхий заасан бөгөөд аль салбарын инновацыг хөгжүүлэхэд анхаараагүй байна. Мөн энэ талаарх бодлогын чиглэлийг 5 жил тутамд солигдох Дээд боловсролын зөвлөл ерөнхийд нь хариуцахаар ойлгогдож байна. Энэ зөвлөл нь Засгийн газарт

ажлаа тайлагнах бөгөөд хэрэв зөвлөлийн бодлого буруу байвал хэрхэн хариуцлага тооцох нь бүрхэг байгааг цохон тэмдэглэе.

Санал: СИС-ийн хөгжүүлэх тэргүүлэх салбарыг тодорхойлох зарчим, өөрчлөх хугацааг хуульд заах, ялангуяа үндэсний онцлог болсон мал аж ахуй, нэн шаардлагатай боловсрол, анагаах ухаан зэрэг салбаруудын судалгаа, мэдлэг дамжуулах үйл явцыг сайжруулах талаар тусгах нь зүйтэй байна. Бодлогын хувьд чиглүүлэх үүргийг Дээд боловсролын зөвлөл хариуцах бол хариуцлагын тогтолцоог хуульд заах шаардлагатай.

Дөрөв. Хуулийн төсөлд СИС-ийг байгуулах тохиолдолд хэрхэн санхүүжүүлэх, төрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, судалгааг захиалах, дэмжихэд оролцох оролцоо болон чанарын хяналт тавих, хариуцлагын тогтолцооны асуудал бүрхэг байна.

Үндэслэл: “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчид бэлтгэх,” “олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болох,” “шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх...”, “эрдэм шинжилгээний ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог шинэчилж, чадварлаг эрдэмтдийг бэлтгэх үндэсний тогтолцоог бий болгож, олон улсын томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх” зэрэг өндөр амбицтай зорилтуудыг дэвшүүлсэн билээ. Гэтэл бодит амьдралд дэвшилтэт судалгааны бааз, чадавхыг бий болгоход өндөр зардал шаардагддаг тул бодлогын таатай орчин, олон нийтийн шууд санаачилга, дэмжлэггүйгээр дэлхийн жишигт нийцсэн их сургуулийг маш хурдан бий болгох боломжгүй юм.

ЮНЕСКО-оос 2017 онд гаргасан “Боловсролд хариуцлагатай хандах нь” тайланд боловсролын санхүүжилтийн гол бүрдүүлэгчид нь төр, хандивлагчид, айл өрхүүд байгааг дурджээ. БШУЯ-аас 2019 онд гаргасан тайланд дурдсанаар “дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн гол эх үүсвэрийг боловсролын зээлийн сангаас олгодог тэтгэлэг, зээл, сургалтын төлбөр, бусад эх үүсвэрээс бүрдүүлдэг. Төрийн өмчийн их,

дээд сургуулиудын орлогын 70-85 хувийг сургалтын төлбөр, 30-15 хүртэл хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байсан ба төрөөс авах тогтмол зардлын санхүүжилт 5-6% эзэлж байна. Төрийн бус өмчийн ДБСБ-уудын орлогын 96%-ийг үндсэн үйл ажиллагаанаас, үлдсэн хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байгаа” гэжээ.

Гэтэл 2016 оны статистикаар төрийн өмчийн их, дээд сургуулийн санхүүжилтийн 88.1-94.3 хувь сургалтын төлбөрөөс бүрдэж байжээ. 2017 оны байдлаар нийт суралцагчдын 84 хувь нь хувийн зардлаар суралцдаг бөгөөд 250 тэрбум төгрөгийн айл өрхүүд дээд боловсролын санхүүжилтэд зарцуулж байжээ. 2021-2022 оны хичээлийн жил 148,954 суралцагч дээд боловсрол эзэмшиж байгаагаас 145,326 нь хувийн зардлаар сурч байгаа нь нийт суралцагчдын 97.6 хувь байна. Эдгээр үзүүлэлтээс харахад дээд боловсролын салбар дахь төрийн санхүүжилт туйлын хангалтгүй байна.

Ийнхүү өмчийн хэлбэр харгалзахгүйгээр орлогын гол эх үүсвэрээ сургалтын төлбөр буюу “иргэд”-ийн халааснаас гарган сургалт явуулж буй дээд боловсролын тогтолцоог СИС-ийн маш өндөр зардалтай тогтолцоонд шилжүүлэхэд төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай болох нь тодорхой юм. Хэрэв төрийн өмчийн 6 их сургуулийг нэгтгэх замаар СИС-ийг байгуулах зардал нь шинээр сургууль байгууллахаас бага боловч санхүүжилт өнөөгийн түвшинд хэвээр байвал олон улсын шаардлагад нийцсэн судалгааны их сургууль болох боломжгүй юм.

Одоогийн хуулийн төслийн 2.1-дэх СИС-ийн зорилгод “Монгол Улсын **төрийн ивээлд** эрдмийн эрх чөлөөг баталгаажуулж, эдийн засаг, нийгмийн хөгжил, шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлнэ” гэсэн боловч 21.1-д “Төрөөс судалгааны их сургуульд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална” гэж эх үүсвэр, үүрэг хариуцлагыг тодорхойгүй байдалд хүргэхээр томьёолжээ.

Санал: Төрийн өмчийн сургуулиудыг судалгааны их сургууль болохыг зорьж буй бол гол хөрөнгө оруулалтыг төр даахыг хуульчлах шаардлагатай байна. Ингэхдээ уул уурхайн баялгаас олж буй орлогын тодорхой хувийг боловсролд ялангуяа дээд боловсролд зарцуулна гэж хуульчлах боломжтой юм. Түүнчлэн төрөөс ажиллуулах болон бусад

хэвшлээс төвлөрөх сангууд хэрхэн ажиллахыг нэг бүрчлэн тодорхой заах шаардлагатай байна.

Мөн СИС-д хөрөнгө оруулж буй талуудын харилцаа, эрх үүргийг ялгаатай заах шаардлагатай. Тухайлбал, төрөөс олгох санхүүжилт, эрдэм шинжилгээний сан, хувийн сектор, тусгай зориулалтын сангуудын эрх үүргийг тодорхой заалт хуулийн төсөлд тусгахыг зөвлөж байна.

Тав. СИС-ийн үндсэн мөн чанар болох засаглал, шийдвэр гаргах үйл явц, хяналтын асуудлыг энэхүү хуулийн төсөлд хангалтгүй тусгажээ.

Үндэслэл: 2009 онд судлаач Салмигийн хэвлүүлсэн “Дэлхийн түвшний их сургуулиудыг хөгжүүлэх нь” бүтээлдээ судалгааны их сургуулийн үндсэн суурь нь нэгдүгээрт; удирдлагын бие даасан байдал, сайн засаглал, манлайлал, оновчтой менежмент, хоёрдугаарт; гоц авьяастнуудын төвлөрөл буюу шилдэг судлаач, профессор багш, оюутныг татсан байдал, гуравдугаарт; санхүүгийн олон эх үүсвэр, санхүүгийн чадавх, сургалт, судалгааны таатай орчин юм гэж тодорхойлсон байдаг.

Дээрх шинжүүдтэй хуулийн төслийг харьцуулан авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Засаглалын тодорхойгүй байдал: Хуулийн төслийн 9-12-р зүйлд Удирдах зөвлөл (УЗ)-ийн талаар зохицуулсан бөгөөд 5 жилийн хугацаанд, 18 гишүүнтэй томилогдох тус зөвлөлийн даргыг БСШУ-ы сайд томилохоор тусгажээ. Энэхүү УЗ-ийн талаарх зохицуулалтаас үзвэл төрийн өмчийн сургалттай НЭГ л судалгааны их сургуульд зориулсан зохицуулалт гэж ойлгогдохоор байна. Гэтэл 6.2 дахь заалтад Иргэний хуулийг эшэлж хувийн, нийтийн, төрийн өмчийн СИС байж болохыг заасан байна. Мөн УЗ-ийн эрх хэмжээ нь голдуу захиргааны хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан, УЗ-ийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, бизнес эрхлэгчдийн төлөөлөл голлохоор заасан нь СИС-ийн үндсэн шинж болох “эрдмийн эрх чөлөө”-г хэрхэн хангах нь тодорхойгүй байна. Учир нь СИС-ийн УЗ-д эрдэмтэн, судлаачид гол цөмийг бүрдүүлэх ёстой байдаг боловч энэхүү төлөөллийг УЗ-ийн дэргэдэх Эрдмийн зөвлөл гэсэн бүтцээр хязгаарласан байна. Мөн УЗ ажлаа үүсгэн байгуулагчид тайлагнах тухай ганцхан

ерөнхий заалт байгаа нь СИС-ийг засаглалын хувьд хангалттай байна гэж үзэх боломжгүй болгож байна.

2. Хөрөнгө оруулалт: Мөн хуулийн төсөлд СИС-ийн хөрөнгө оруулагчдын эрх, үүрэг, хариуцлага, хэмжээ хязгаарыг тогтоосон заалт хангалтгүй байна. Сургалтын төлбөрөөр санхүүждэг өнөөгийн дээд боловсролын эмзэг тогтолцоонд өндөр дүнтэй санхүүжилт өгөх замаар хараат бус байдлыг алдагдуулах, хувийн эрх ашигтаа үйлчлүүлэх шаардлага тавих эрсдэлээс хэрхэн сэргийлэх вэ гэдэг нь энэ хуулиар шийдэх ёстой асуудал юм. Хэрэв хөрөнгө оруулагчдаас маргаан үүсгэж шүүх, арбитра хандсан тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг үндэслэж маргалдах боломжгүй байдаг билээ.
3. Санхүүжилтийн хяналт: Энэ хуулийн төсөл СИС-ийг хэрхэн санхүүжүүлэх нь тодорхойгүйн адил орж ирж буй хөрөнгийг хэрхэн зарцуулах, хяналт тавих арга зам мөн бүрхэг байна. Төсөлд дурдсанаар аудитор гэсэн хоёр хүнийг Сангийн яам болон Боловсролын яамнаас хоёр жилийн хугацаагаар томилохоор заасан нь 5 жил эрх барих УЗ-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт болж чадах эсэхэд эргэлзэхэд хүргэж байна. Мөн санхүүжилтийг хэрхэн, юунд зарах хязгаарыг, олон нийтэд хэрхэн танилцуулах арга замуудыг тунхгийн түвшинд бус нарийвчилсан заалтуудаар тусгах шаардлагатай байна.
4. Боловсон хүчин: Хуулийн төсөлд багш, боловсон хүчин болон хамгийн шилдэг оюутнуудыг хэрхэн татах, тогтоон үлдээх, судалгааны шинжилгээний ажлыг нь үргэлжлүүлэх талаарх зохицуулалтууд үгүйлэгдэж байна. Одоогийн хуулийн төсөл нь энэ талаар тунхгийн шинжтэй зохицуулалт байгаагаас нийгэм, эдийн засгийн баталгаа, эрдэм мэдлэгийнхээ үр шимийг хэрхэн хүртэх, академик эрх чөлөө, мерит зарчим, шударга өрсөлдөөний талаарх тодорхой шинэлэг зохицуулалт байхгүй байна. Ялангуяа СИС болох тохиолдолд дэлхийд өрсөлдөхийн тулд гадаадын эрдэмтэд, судлаачид, чадалтай оюутнуудыг татах, тогтоон үлдээх нь чухал байдаг.

5. Олон нийтийн хяналт: Энэ хуулийн төсөлд олон нийтийн хяналтыг “тунхаг” байдлаар тусгажээ. Хуулийн төслийн 22.1-т “Сургуулийн хөрөнгийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна” гэснээр өөр нийгэм, олон нийт, ТББ болон суралцагчдад мэдээлэл хэрхэн нээлттэй байх талаарх ямар ч зохицуулалт алга байна. Гэтэл СИС байгуулах, ажиллуулах үйл явцад Монгол Улсын өөрийн эрх ашгаас эхлэн нийгэм, олон нийт, суралцагчид, эрдэмтэн судлаачид, зах зээл зэрэг маш олон талын эрх ашиг хамаатай байдаг. Энэ тогтолцооны чанар, санхүүжилт, үр ашигтай байдалд олон нийт хяналт тавих боломжгүй байх нь дараа дараагийн “Хөгжлийн банк,” “Жижиг дунд бизнесийг дэмжих сан” гэх мэт асуудлууд гарах эрсдэлтэй болох юм.

Санал: Санхүүжилт, олон нийтийн хяналтын тогтолцоо, үйл явцыг хуульд дэлгэрэнгүй оруулахыг зөвлөж байна. Мөн СИС-ийн үндсэн тулгуур болох чадварлаг боловсон хүчин болон суралцагчдыг татах, тогтоохын тулд сургуулийн засаглал дахь оролцоог баталгаажуулж, УЗ болон шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй. Үүний зэрэгцээ нийгэм, эдийн засгийн баталгаа, эрдэм мэдлэгийнхээ үр шимийг хэрхэн хүртэх, академик эрх чөлөө, мерит зарчим, шударга өрсөлдөөний талаарх тодорхой зохицуулалтууд үгүйлэгдэж байна.

“Хүн бүрд гутал өгвөл тэгш байдал.

Хүн бүрд таарсан гутлыг нь өгвөл эрх тэгш байдал.”

Хүний эрхийн төлөө тэмцэгч Др. Нахийд Досани

“Цаг үеийн сорилтуудыг амжилттай даван туулахын тулд улам илүү тэгш хамруулсан боловсрол руу тэмүүлсэн шилжилтийг өөр зүг рүү чиглүүлшгүй бөгөөд үүнийг хийхгүй байх сонголт гэж үгүй”

ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Одри Азулэй

Боловсролд тэгш хамруулан сургах нь *“Бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаан дахь тэгш оролцоог хангах,*

боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц”

Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилго болох **“Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийг насан туршийн боловсролоор хангах”**, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад дэд зорилтуудын хэрэгжилтийг үнэлэхдээ тухайн улс орны хамгийн маргинал бүлэг боловсролын үйлчилгээг авч чадаж буй эсэх шалгуур үзүүлэлтийг авч үздэг. Угтаа боловсролын үйлчилгээний гадна үлдэх хамгийн өндөр эрсдэл бүхий бүлгүүдэд боловсролын үйлчилгээ хүрч чадаж байвал тухайн улсын боловсролын үйлчилгээ иргэддээ хүртээмжтэй байна гэж дүгнэдэг. Боловсрол бүх нийтэд хүртээмжтэй байх нь Тогтвортой хөгжлийн бусад **зорилтуудыг хангах суурь, хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл юм.**

ХАВСРАЛТ

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Боловсролын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу энэхүү үзэл баримтлалыг боловсруулав.

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Өнөөдөр Монгол Улс оюуны чадавхаараа дэлхийд эхний 10 орны тоонд орж байгаа хэдий ч хүний хөгжлийн индексээр 189 орноос 92-т, Боловсролын индексээрээ 189 орноос 103-т, Өрсөлдөх чадварын индексээрээ 141 орноос 102-т, Оюуны чадавхаа хэрэглэх ур чадвараар 49-д, мэдлэг чадвараа хөгжүүлэх үзүүлэлтээр 59-д орж байна. 2018 онд хийгдсэн “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны үр дүнгээс харахад 7-14 насны хүүхдийн сурч чадах үндсэн суурь чадвар болсон унших чадвар 61.6 хувь, энгийн аргын тоо бодох чадвар 51.5 хувь байгаа зэрэг нь боловсролын чанар, үр дүнд чиглэсэн эрх зүйн шинэчлэл хийх практик хэрэгцээг илтгэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогын үргэлжлэл болох Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршийн суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” зорилтыг тус тус дэвшүүлсэн. Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангахад тулгуур болох боловсролын салбарын эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлж буй хууль тогтоомж хангалтгүй байгаа тул энэхүү шинэчилсэн найруулгыг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Үүнд:

Хүн бүрийн насан туршдаа, чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмших эрхийг хангах асуудал дэлхийн улс орнуудын тулгамдсан асуудлын нэг юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар дэлхий нийтийн ирэх 15 жилийн хөгжлийн зорилтыг тодорхойлсон “Эх дэлхийгээ эрс шинэчилье-Тогтвортой хөгжлийн зорилго 2030” хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрөөр 2030 он гэхэд боловсролын бүх түвшинд тэгш хамруулсан чанартай боловсрол олгох, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих зорилгыг боловсролын салбарт дэвшүүлсэн.

Боловсролын салбарт 2006-2019 онд авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнд хийсэн “Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ”, “Боловсролын тухай хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа” зэрэг нь хуулийн төслийг боловсруулах судалгаа, шинжилгээний үндэслэл болсон юм. Судалгааны дүгнэлтээс үзэхэд бүх шатны боловсролын зорилгыг дэлхийн болон улс, орны хөгжлийн шинэ хэрэгцээ шаардлага, чиг хандлагад нийцүүлэх, албан, албан бус боловсролын тогтолцоонд шинэчлэл хийх, боловсролын байгууллагын бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой болгох, үр ашгийг сайжруулах, боловсролын салбар дахь тэгш бус байдлыг арилгах, сургалтын чанар, үр ашгийг сайжруулах бодит хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Түүнчлэн боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага, өөрийн улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан боловсролын зорилгыг шинэчлэх, хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд шинээр бий болж буй өргөн боломж, түүний дотор технологийн дэвшлийг ашиглан боловсрол эзэмших арга хэлбэрийг уян хатан, эрчимтэй болгохын хамт сургалтын хөтөлбөрийг залгамж холбоотой, тогтвортой байх нөхцөлийг хангах, үнэлгээний тогтолцоог сайжруулах, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг чанаржуулах, сургуулийн хэв шинж, бүтэц, байршлыг оновчтой болгох эрх зүйн орчныг оновчтой болгох шаардлага байна.

Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах агуулгыг хуульчилсан салбарын бус 17 хуулийн 20 заалт байна. Энэ нь хичээл, судлагдахууны тоо болон багш, суралцагчийн ачааллыг нэмэгдүүлэх болон сургалтын хөтөлбөрийн тохирц, нийцлийг хангахгүйгээр богино

хугацаанд хийж ирсэн гэж ЮНЕСКО-оос 2019 онд хийсэн Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээний тайланд дурдсан байна. Уг байдал нь сургалтын хөтөлбөрийн тогтворгүй байдлыг үүсгэж байна.

Боловсрол эзэмших хэлбэр /танхимын, зайн, онлайн болон цахим сургалт, хосолсон сургалт/-ийг тодорхой, нарийвчлан зохицуулж, иргэн бүрт насан туршдаа суралцах боломжийг дэмжих эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ шаардлагатай байна.

Боловсрол эзэмшихэд тэгш хамруулах, суралцагч бүрийн авьяас билгийг эртнээс нээн хөгжүүлэх, ажил мэргэжил сонгох, мэргэжил шинэчлэх, насан туршдаа тасралтгүй суралцахад нь чиг зорилготой туслан дэмжихэд Улсын Их Хурал, Засгийн газар, боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, байгууллага аж ахуйн нэгжийн үүрэг оролцоог зохистой, уялдаа холбоотой болгох: Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын ахиц, амжилтын талаарх өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний дүн өөр хоорондоо зөрүүтэй, хот, хөдөөд сургалтын чанар харилцан адилгүй байгаа нь сурлагын ахиц, амжилтыг тодорхой давтамжтайгаар хөндлөнгөөс үнэлэх үнэлгээний тогтолцоог бүх шатны сургуульд нэвтрүүлэх шаардлагатайг харуулж байна.

Багшийн мэргэшил, ажиллах нөхцөл, хөдөлмөрийн үнэ үнэлэмжийг эрс сайжруулах цогц механизм бүрдүүлэх замаар мэргэжлийн нэр хүнд, нийгмийн үнэлгээг дээшлүүлэх: Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлгээ, цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмж, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулснаар нийгэм дэх нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх, багш бэлтгэх үндэсний тогтолцоог бий болгох, чадавхжуулах, сургалтын чанар, үнэлгээ, үр дүнг сайжруулах, чанартай багш бэлтгэх хэрэгцээ шаардлага байна.

Мөн байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед сургалтын үйл ажиллагааг танхимын бус хэлбэрээр хэрхэн зохион байгуулах, сургалтыг зөвхөн танхимаар зохион байгуулж ирсэн уламжлалт хандлагад өөрчлөлт оруулж, сургалтыг олон хувилбараар зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Боловсролын байгууллага бие даан, бүтээлчээр ажиллах эрх

мэдлийг өргөжүүлэхийн хамт үйл ажиллагааныхаа үр дүнг хариуцах хариуцлагыг дээшлүүлж, мэргэжлийн болон хэрэглэгчийн хяналт, сонирхлын бүлгүүдийн хамтын ажиллагааг үр нөлөөтэй болгох: Боловсролын үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн болон ашгийн бус боловсролын байгууллагын эрх зүйн орчныг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах шаардлага үүсээд байна.

Боловсролын санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо нь хүртээмжийг Нэмэгдүүлэхэд анхаарсан, боловсролын чанар, гүйцэтгэл, үр дүнтэй уялдаа холбоогүй, нэг хүүхдийг сургаж буй бодит өртөг, зардал ялгаа ихтэй, сургалтын хөтөлбөр болон боловсролын стандартыг хангах, сургалтын байгууллага төсөв, санхүүжилтээ үр ашигтай захиран зарцуулах идэвх, санаачилгыг урамшуулдаггүй зэрэг сул талтай байна.

Боловсролын сургалтын байгууллагын хэв шинж, нэр томъёог шинэчлэх, суралцагчдын элсэлт, төгсөлт, гадаад улсад боловсрол эзэмшсэн иргэний боловсролын баримт бичиг болон олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг ерөнхий боловсролын хөтөлбөрийн шалгалтын үнэлгээ (SAT, ATAS level IGCSE, IB, TOFEL, IELTS гэх мэт)-г Монгол Улсын их, дээд сургуулийн элсэлтийн шалгалттай дүйцүүлэх шаардлагатай байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын статус, хэв шинж, бүтэц, засаглалын тогтолцоо, хөтөлбөрт тавигдах шаардлага, санхүүжилтийн хэлбэрийг үр ашигтай, оновчтой болгох хэрэгцээ байна.

Шинжлэх ухаан, дээд боловсролын уялдааг өргөжүүлэх судалгаа, их сургуулийн шинжлэх ухааныг бэхжүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу хийгдэж буй хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тухайн орон нутгийн өмчит, салбарын харьяа байгууллагын тухайн байгууллагын үл хөдлөх болон үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар, үйлчилгээтэй холбоотой зардлыг хариуцдаг байх зохицуулалтыг хийх шаардлага бий болоод байна.

Иймд Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилтыг биелүүлэх, боловсролын салбарыг орчин үеийн чиг хандлагад тулгуурлан хөгжүүлэх, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг шинээр тодорхойлох, сургалтын чанар, агуулгыг хүний хөгжил, улс орны хөгжлийн ирээдүй, өрсөлдөх чадвар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, цаашдын төлөв байдалд нийцүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн төслийг боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, хөгжлийн зорилт, зарчим, удирдлага, зохион байгуулалт, иргэн насан туршдаа тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшихтэй холбоотой харилцааг өөрийн орны болон дэлхий нийтийн хөгжлийн шаардлагад нийцүүлэх зорилгыг удирдлага болгон боловсруулна.

Хуулийн төсөл нь 8 бүлэгтэй бөгөөд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэлийн хүрээнд:

Боловсролын зорилго, зорилт, зарчим, тогтолцоо, иргэн боловсрол эзэмших арга, хэлбэр, эрх, үүргийг тусгана.

Боловсролын тогтолцоог албан, албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцах тогтолцооноос бүрдэхээр зохицуулах бөгөөд албан болон албан бус боловсролын суралцахуйн үр дүнг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн хүлээн зөвшөөрч, баталгаажуулах институцийг бүрдүүлнэ.

Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг хуульд иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийг ангилан төрөлжүүлэх, түвшнээр нь эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдэл байхаар тусгана.

Боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгоно.

Багш бэлтгэх, хөгжүүлэх үндэсний тогтолцоог бий болгож, чадвартай

багшийг чанартай хөтөлбөрөөр бэлдэж, боловсролын сургалтын байгууллагын удирдлага, багшлах хүний нөөцийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, багшийн мэргэжлийн түвшин, ур чадварыг үнэлэх ажлыг зохион байгуулдаг байх зохицуулалтыг тусгана.

Иргэдийн боловсрол эзэмших арга, хэлбэрийг нээлттэй, уян хатан, технологийн дэвшилд тулгуурласан байх зохицуулалтыг хийнэ.

Хоёрдугаар бүлэг. Боловсролын агуулга, сургалтын хөтөлбөр, стандартын хүрээнд:

Бүх шатны боловсролын агуулга, сургалтын хөтөлбөрийг зөвхөн боловсролын хуулиар зохицуулж, Монгол Улсын боловсролын бодлогын нэгдмэл байдлыг хангана.

Боловсролын агуулга мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн байна.

Боловсролын агуулга, сургалтын хөтөлбөр, орчны стандартыг судалгаа болон үнэлгээний үндсэн дээр тогтвортой мөрдөх зарчим баримтлан хэрэгжилтийг хангах зохицуулалтыг тусгана.

Монголын түүх, монгол хэл, бичиг, үндэсний уламжлал, соёл, эх оронч сэтгэлгээг боловсролын агуулга, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах замаар интеграцчилж, заавал хэрэгжүүлэхээр тусгах, боловсролын бүх түвшинд эзэмшүүлэхээр хуульчилна.

Суралцагчдыг иргэний ёс зүй, эрх зүйн болон эрүүл мэндийн боловсролыг дэмжих, аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор, суралцагчдын нас, сэтгэхүй, хөгжлийн байдалд тохирсон боловсролын хөтөлбөр, агуулгын уялдаа холбоог цэгцтэй, боловсронгуй болгож, боловсролын бүх түвшний хөтөлбөрт тусгана.

Гуравдугаар бүлэг. Боловсролын байгууллага, тэдгээрийн бүтэц, чиг үүргийн хүрээнд:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал, хэв шинжийг олон улсын жишигт нийцүүлэн оновчтой тогтооно.

Бүх шатны боловсролын чанарын баталгаажуулалт нь байгууллагын сургалт, судалгааны үйл ажиллагааны гүйцэтгэлийн болон чанарын

удирдлагыг сайжруулахад чиглэж, нээлттэй, бүх оролцогч талыг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа бүхий тогтолцоо бүрдүүлнэ. Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төрөөс хараат бус, мэргэжлийн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц болгох зохицуулалт оруулна.

Судалгааны их сургууль, их сургууль, дээд сургууль, коллежийн болон их сургуулийн эмнэлэг, консерваторын статус, чиг үүргийг оновчтой тодорхойлно.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох зохицуулалтыг цахим хэлбэрт шилжүүлж, нээлттэй, ил тод, шударга, хүнд сурталгүй эрх зүйн орчныг бий болгоно.

Боловсролын эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт оруулна.

Дөрөвдүгээр бүлэг буюу Боловсролын удирдлагын тогтолцоо, тэдгээрийн эрх хэмжээ, гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд:

Боловсролын сургалтын байгууллагын засаглалыг бие даалгах, удирдах албан тушаалд томилогдох шалгуурт мэргэшсэн, мерит зарчмыг баримтлан, эрх, үүргийг нарийвчлан тусгана.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтсийн ажлын Чиг үүрэг, зохион байгуулалтын хэлбэрийг оновчтой болгож өөрчилнө.

Орон нутгийн засаг захиргаа нь өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа сургалтын байгууллагын үйлчилгээний чанарыг Засгийн газрын өмнө бүрэн хариуцах, иргэд олон нийтийн өмнө үүрэг, хариуцлага хүлээдэг байхаар хуульчилна.

Тавдугаар бүлэг. Боловсролын эдийн засаг, санхүүжилтийн хүрээнд:

Боловсролын санхүүжилт нь боловсролын зорилго, стандартын хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж боловсролын үйлчилгээний гүйцэтгэл, чанар, үр дүнд чиглэсэн байх бөгөөд хүн бүрд тэгш боломж бүрдүүлэх, насан туршийн суралцахуйг дэмжих, сургалтын

байгууллага нь төсөв, санхүүгийн хувьд бие даан шийдвэр гаргах эрх мэдлийг зохистой түвшинд бий болгох, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилтуудыг хангадаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

Тухайлбал, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд суурь болон хувьсах зардал, үр дүнд чиглэсэн нэмэлт санхүүжилтийн зарчимд шилжүүлж, ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчид нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дэмжлэгийг төрөөс үзүүлдэг байхаар зохицуулна.

Төрөөс боловсролын хүртээмж, суралцах Тэгш нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг улсын болон орон нутгийн төсөвт ирэх ачааллыг бууруулж, үе шаттай шийдвэрлэх зорилгоор (i) төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийн тоног, төхөөрөмжийн хангамж хүрэлцээгүй сургалтын байгууллагад богино, дунд хугацаанд сургалтын орчны стандартыг хангах зорилгоор хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн зориулалтаар тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авах бол, (ii) суралцах эрх нь зөрчигдөх эрсдэлтэй, хүн амын нягтаршил ихтэй, хамран сургах тойргийн ачаалал өндөр, 2 ба түүнээс дээш ээлжээр хичээллэх нөхцөлд хүрсэн байршилд хувийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулийн зориулалтаар барилга, байгууламж барьж, хамран сургах тойргийн суралцагчид үнэ төлбөргүй сургалтын үйл ажиллагаа тасралтгүй явуулах бол анхны хөрөнгө оруулалттай дүйцэх хэмжээний хөрөнгийг ашиглалтын хугацаанд нөхөх нөхцөлтэйгөөр жил бүр төсөв, санхүүгийн шударга, зохистой дэмжлэг үзүүлж болох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

Боловсролын зээлийн санг Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт элсэгчид, их сургууль, дээд сургууль, коллежийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр ахисан шатны суралцагчдын сурлагын амжилт, судалгааны ажлын чанартай уялдуулан шаардлага хангасан тохиолдолд сургалтын тэтгэлэг, тусламж, зээл олгох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, оюутны болон багшийн хөгжлийг дэмжих хэлбэрээр өөрчлөн зохион байгуулна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тухайн орон нутгийн өмчит боловсролын салбарын байгууллагын

байр ашиглалт, тоног төхөөрөмж, их засварын зардлыг хариуцаж байхаар хуульд тусгана.

Цаашид нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн болон өрхийн орлогын дундаж түвшний өсөлт, амьжиргааны баталгаажих түвшин зэрэг нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлтийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн Нэг суралцагчид ногдох хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн, хүүхдийн хоолтой холбоотой зарим шууд зардлын зохистой хэсгийг үе шаттайгаар эцэг эх, асран хамгаалагч нь хамтран хариуцах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

Багшийн нийгмийн баталгааг тэтгэвэрт гарсны дараа хангах зорилготой одоо олгож буй зарим мөнгөн тэтгэмжийг багшаар ажиллаж байх хугацаандаа жил бүр үе шаттайгаар хуримтлуулж, багшаар ажиллаж байх хугацаандаа орон сууц, Нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд санхүүгийн нэмэлт баталгаа, ирээдүйд тэтгэвэрт гарахад нэмэлт орлогын эх үүсвэр болгон өөрчлөх, үүнтэй холбоотой шаардлагатай эрх зүйн харилцааг судалж, төсөлд тусгана.

Зургаадугаар бүлэг. Боловсролын харилцаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг, хариуцлагын хүрээнд:

Боловсролын харилцаанд оролцогч бүрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

Боловсролын харилцаанд багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчдаас гадна төрийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод болон иргэн оролцох тэгш боломжийг бүрдүүлж, тэдгээрийн оролцоог хангах зохицуулалтыг тусгана.

Ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчийн сурч боловсрох эрхийг тэгш хангах, хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамаарч боловсролын үйлчилгээ авах, адил, тэгш нөхцөл боломж бүрдүүлэх тогтолцоог бий болгоно.

Долоодугаар бүлэг. Боловсролын цахим шилжилтийн хүрээнд

Монгол Улсын дунд урт хугацааны бодлогын барим бичиг болон “Е-Монгол”, “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Мэдээлэл харилцаа холбооны технологийг боловсролд ашиглах алсын харааг

тодорхойлж, боловсролын салбарын бодлого, үндэсний мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогын зорилтуудтай нийцүүлэх шаардлагатай байна.

Тэгш боломжтой, насан туршдаа тасралтгүй суралцахуйн хүрээнд сургалтад харилцаа холбоо, мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад Платформыг ашиглах орчин, суралцахуйн удирдлагын системийг бий болгох орчныг бүрдүүлнэ.

Боловсрол эзэмших танхимын, танхимын бус, хосолсон сургалтыг үнэлэх, дүйцүүлэх, баталгаажуулах асуудлыг тусгана.

Бүх шатны боловсролын байгууллагыг тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, сүлжээний гадаад, дотоод дэд бүтцийг шийдвэрлэх тэгш хамран сургах боломж нөхцөлийг бүрдүүлэх, багш бүрийг компьютержуулах, мэдээлэл харилцаа холбоо, технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах багшийн үндсэн сургалтын цахим хэлбэрт шилжүүлж, багш бэлтгэх сургуулийн хөтөлбөрт цахим боловсролын агуулга түлхүү оруулах, мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлээр өндөр ур чадвартай боловсон хүчний нөөцийг бий болгох шаардлагатай байна.

Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, салбарын бодит мэдээлэлд тулгуурлан хичээл сургалтын үйл ажиллагаатай холбоотой төлөвлөлт хийх, шийдвэр гаргах, сургууль, цэцэрлэгт улсын төсвөөс олгогддог хувьсах зардал, хоолны мөнгө зэрэг зардлын гүйцэтгэлийг хянах боломжийг бүрдүүлнэ.

Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан, төрийн болон иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтыг тусгана.

Наймдугаар бүлэг.Бусад асуудлын хүрээнд:

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хуулийн төсөлтэй холбогдон зарим харилцаанд үүсэх асуудлыг зохицуулах шилжилтийн үеийн болон бусад асуудлуудыг тусгана.

Хуулийн төслийн нэрийг Боловсролын ерөнхий хууль гэж өөрчилнө.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна:

Боловсролын зорилго, зорилт, зарчим, тогтолцоо, иргэн боловсрол эзэмших арга хэлбэр, эрх, үүрэг тодорхой болж, дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцсэн байна.

Боловсролын салбарын эрх зүйн шинэчлэл хийгдсэнээр ядуурлын бүх төрлийг эцэс болгох, орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтах, суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшнийг 100 хувьд хүргэж, насан туршийн суралцахуйн тогтолцоог шинэчлэх, хүний хөгжлийн үзүүлэлтээр улс орнуудын жагсаалтад эхний 70 орны нэг болох, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвших үндсийг бүрдүүлэх суурь бий болно.

Хүний хөгжлийн үндсэн хэмжүүр нь хүний хөгжил байх гол зарчмыг үндэс болгон хуулийн төслийг боловсруулах ба иргэн бүр эрүүл байж, боловсрол эзэмшиж, амьжиргаандаа хүрэлцэхүйц орлоготой боломжийг бүрдүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулж, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, мэдлэгт суурилсан нийгэм, ур чадвартай, зөв хандлагатай Монгол хүнийг төлөвшүүлэх зорилгод хүрнэ.

Төрөөс боловсролын талаар үзүүлж буй зарим үйлчилгээг хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд орон нутгийн засаг, захиргаа түүний удирдлагад шилжүүлсэн байна.

Насан туршийн суралцахуйн эрх зүйн орчныг бүрдүүлж, салбар дундын мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг боловсролын түвшин бүрт хэрэглэж, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагаа хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Боловсролын харилцаа тогтвортой хөгжих нөхцөл бүрдэн, боловсролын сургалтын байгууллагын ангилал, хэв шинж, үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гарна.

Боловсролын салбарын удирдах ажилтны томилгоо нь шатлан дэвшсэн /мерит/, мэргэшсэн тогтолцоотой болсон байна.

Хүүхэд өөрт тулгамдсан асуудлаа бие даан шийдвэрлэж, хүндрэлийг

даван туулахад мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ авч, аливаа ёс суртахууны доголдол, зөрчил, гэмт хэргээс өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв хандлага төлөвшил бий болно.

Сургалтын байгууллага, удирдах зөвлөл, цэцэрлэг, сургуулийн болон эцэг эх, асран хамгаалагчийн зөвлөл, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа сайжирна.

Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах нас дэлхий нийтийн чиг хандлага, малчдын ахуй амьдралтай уялдуулан уян хатан зохицуулалттай болно.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 5 настай хүүхдийг заавал хамруулна.

Бага, дунд боловсролын сургалтын бодлого, агуулга, үндэсний хөтөлбөр, сурах бичгийн тогтвортой байдал, ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчийн сурч боловсрох эрхийг тэгш хангах, хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамаарч боловсролын үйлчилгээ авах адил, тэгш нөхцөл боломж бүрдэнэ.

Суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгох, сургалтын цахим платформыг хөгжүүлж, цахим онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим контент, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршийн суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлж, судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагаа үнэлүүлэх, баталгаажуулах үйлчилгээг цахимжуулна.

Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг хөндлөнгөөс үнэлэхдээ үнэлгээний шалгалтад хамрагдах бүлгийг тодорхойлон зааж, санхүүгийн нөөц, хөндлөнгийн шалгалтын хугацаа, давтамж, үр дүн тодорхой болно.

Дээд боловсролын сургалтын байгууллагын статус, хэв шинж, бүтэц сайжирч, удирдах зөвлөлд ажил олгогч, мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллагын төлөөлөл, бизнес хөрөнгө оруулагчдын төлөөллийг оруулснаар сургалт-судалгаа үйлдвэрлэл, академик эрх чөлөө, боловсролын чанарын баталгааны тогтолцоо сайжрах болно.

Их, дээд сургуулийн засаглал, удирдлагын хараат бус, бие даасан

байдал хангагдаж, ахисан түвшний сургалт, судалгаа олон улсын жишигт хүрэх нөхцөл бүрдэнэ.

Боловсрол эзэмших хэлбэр /танхимын, зайн болон цахим сургалт, нээлттэй боловсрол, насан туршийн суралцахуй/ тодорхой болж, иргэдийн насан туршдаа суралцах боломж, тэдний өмнө нь олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах зохицуулалт оновчтой, тодорхой болно.

Боловсролын чанарын хөндлөнгийн үнэлгээний үр дүн, үнэлгээний санал дүгнэлт, зөвлөмж нь боловсролын бодлогод тусах арга механизм тодорхой болж боловсролын бодлогын эргэх холбоо зүй зохистой, үр дүнтэй хэрэгжинэ.

Боловсролын санхүүжилт нь боловсролын зорилго, стандартын хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж боловсролын үйлчилгээний гүйцэтгэл, чанар, үр дүнд чиглэсэн байх бөгөөд хүн бүрд тэгш боломж бүрдүүлж, төсөв, санхүүжилт үр ашиг, үр дүн хангагдсан байна.

Иргэдийн сурах эрх баталгаажиж, сургалтын чанарт дэвшилт гарч, энэ салбар дахь төрийн бус байгууллага, ажил олгогчдын оролцоо сайжирч, дээд боловсролын сургалтын бодлого нь хөдөлмөрийн зах зээлийн хандлага, чиглэлтэй уялдсан байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцнэ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуулийг нэгтгэн Сургуулийн өмнөх болон суурь, ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг нэгтгэн Дээд боловсролын тухай хууль болгон шинэчлэн хуулийн төслүүдийг боловсруулна.

Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулна.

Монгол Улсад судалгааны их сургуулийг үүсгэн байгуулснаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадамжийг сайжруулж, мэдлэгт суурилсан нийгмийг манлайлах өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг төвлөрүүлэн, эдийн засаг, нийгмийн хөгжил, шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, дээд боловсролын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд ахиц гарч, шинэ бүтээл, үр ашигтай шинэ технологийг нэвтрүүлэх, ашиглах хөгжүүлэх ажлыг төрийн ивээлд зохион байгуулна.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн, судлаачдын хүний нөөцийг бэлтгэж, судалгааны их сургуулийг хөгжүүлэхэд өндөр хөгжилтэй орнуудын их сургуулиудтай хамтран ажиллаж, шинжлэх ухааны хамтын судалгаа, инновацийн соёлыг нэвтрүүлнэ.

Судалгааны их сургуулийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, санхүүжүүлэх, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах эрх зүйн орчныг баталгаажуулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад төрийн болон төрийн бус өмчийн 1454 цэцэрлэг, 839 ерөнхий боловсролын сургууль, 88 их, дээд сургуульд нийт 1,075,170 суралцагч суралцаж, 50,043 багш ажиллаж байна.

Энэ нь улсын нийт хүн амын 32 хувийг эзэлж байна. Боловсрол эзэмших нь хүний амьдралын туршид явагддаг тасралтгүй үйл явц гэж үзвэл боловсролын асуудал манай орны нийт хүн амд шууд хамааралтай юм.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” батлагдаж, “ХҮН” төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангахад боловсролын салбарын эрхзүй, хууль тогтоомжийн зохицуулалт хангалтгүй байгаа тул энэ шинэчилсэн найруулгыг боловсруулах үндсийг бүрдүүлсэн.

Монгол Улс оюуны чадавхаараа дэлхийд эхний 12, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтаар 11-рт байгаа хэдий ч Хүний хөгжлийн индексээр 189 орноос 92-т, Боловсролын индексээрээ 189 орноос 103-т, Өрсөлдөх чадварын индексээрээ 141 орноос 102-т, Оюуны чадавхаа хэрэглэх ур чадвараар 49-д, мэдлэг чадвараа хөгжүүлэх үзүүлэлтээр 59-д орж байна.

2018 онд хийгдсэн “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны үр дүнгээс харахад 7-14 насны хүүхдийн сурч чадах үндсэн суурь чадвар болсон унших чадвар 61.6 хувь, энгийн аргын тоо бодох чадвар 51.5 хувь байгаа зэрэг нь боловсролын чанар, үр дүнд чиглэсэн эрх зүйн шинэчлэл хийх практик хэрэгцээ байгааг харуулж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан “Эх дэлхийгээ эрс шинэчилье. Тогтвортой хөгжлийн зорилго 2030” хөтөлбөрт боловсролын бүх түвшинд тэгш хамруулсан чанартай боловсрол олгох, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих зорилгыг боловсролын салбарт дэвшүүлсэн. Монгол

Улс ч 2030 он гэхэд хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн хийнэ.

Иймд боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршийн суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх зорилтыг хангахад энэ хуулийн төсөл чиглэж байна.

Хуулийн төслийг боловсруулахад ЮНЕСКО-той хамтран хэрэгжүүлсэн “Боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлан”, Монгол Улсын боловсролын багц хуулиудыг тоймлон шинжилж, бусад улс, орнуудын хууль тогтоомжтай харьцуулан, задлан шинжилсэн “Боловсролын эрх зүйн харьцуулсан шинжилгээ ба зөвлөмж”, Монгол Улсын Боловсролын суурь мэдээллийн болон салбарын бусад судалгаанууд хуулийн төслийг боловсруулах судалгааны гол эх сурвалж болсон байна.

Түүнчлэн хуулийн төсөлд Монголын багш нарын VII их хурлаас гаргасан болон “Тогтвортой хөгжил-боловсрол” улсын зөвлөгөөнүүдээс гарсан санал, зөвлөмжүүдийг тусган, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтран баталсан “Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-д нийцүүлэн боловсрууллаа.

Эрх зүйн бодлогын баримт бичиг, салбарын суурь судалгаануудад үндэслэн боловсролын салбарт үүссэн дараахь хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон байна:

- хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх боловсролын зорилго, зорилт, агуулгыг шинэчлэх;
- сургахаас суралцахуй руу чиглэсэн дэлхий нийтийн чиг хандлагын өөрчлөлтөд нийцүүлэн иргэний хүмүүжил, төлөвшил, ёс зүй, хандлага, чадамжид чиглэсэн сургалтын агуулга, боловсролын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх;
- боловсролын удирдлагын тогтолцоог оновчтой болгож, улс төрөөс хараат бус, чадахуйн зарчимд суурилсан хөгжил дэвшлийг хангах;
- боловсролын цахим шилжилтийг хангаж, цахим боловсрол, зайн сургалттай холбоотой харилцааг зохицуулах;
- чанар, үр дүн, гүйцэтгэлд чиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бий болгох;

- боловсролын чанарын баталгаажуулалтыг боловсронгуй болгох.

Хуулийн төслийг боловсруулах явцад Боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, холбогдох судалгаанууд, Боловсролын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандалт судалгаа, Боловсролын ерөнхий хуулийн төслийн үр нөлөөллийн судалгаа болон зардлын тооцоог тус тус хийж гүйцэтгэсэн.

Боловсролын сургалтын болон мэргэжлийн байгууллага, багш, ажилтан, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг ажиллаж, хуулийн төсөлд цахимаар санал авч, хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулсан.

Боловсрол, шинжлэх ухааны яамны веб сайтад байршуулсан үзэл баримтлал болон хуулийн төсөлтэй 56845 иргэн хандалт хийн танилцаж, цахимаар 24299 хүн саналаа ирүүлсэн байна.

Нийт боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, мэргэжлийн байгууллага, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг анх удаа цахимаар зохион байгуулж, саналыг хуулийн төсөлд тусгасан байна.

Цахим хэлэлцүүлэгт 21 аймаг, 9 дүүргийн боловсролын байгууллагын хамт олны төлөөлөл болох 5632 багш, ажилтан, бусад их дээд сургууль, шинжлэх ухааны болон харьяа байгууллагын 505 төлөөлөл, нийт 6137 хүн оролцжээ.

Хуулийн төслийг сайжруулах зорилгоор боловсролын салбарын системийн шинжилгээ, тогтолцооны хөгжлийн загвар, багш бэлтгэх болон үнэлгээний тогтолцоо, сургуулийн өмнөх, бага, дунд болон дээд боловсролын бодлогын шинэчлэл, насан туршийн боловсрол, боловсролын санхүүжилт зэрэг чиглэлээр нэмэлт судалгаануудыг хийсэн байна.

Мөн өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Боловсролын тухай хуулийг 2002 онд, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2008 онд, түүнчлэн 1995 онд батлагдсан Бага, дунд боловсролын тухай хуулийг 2002 онд шинэчлэн найруулж, Дээд боловсролын тухай хуулийг 2002 онд тус тус баталжээ.

Энэ хугацаанд Боловсролын тухай хуульд 26 удаа, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд 6 удаа, Бага, дунд боловсролын тухай хуульд

13 удаа, Дээд боловсролын тухай хуульд 10 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн Боловсролын тухай хуулийн нэрийг Боловсролын ерөнхий хуулийн төсөл гэж өөрчиллөө.

Боловсролын ерөнхий хуулийн төслийг дагалдуулан Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон Бага, дунд боловсролын тухай хуулийг нэгтгэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болон Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийг нэгтгэн Дээд боловсролын тухай хууль, Судалгааны их сургуулийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, санхүүжүүлэх, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн

тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон эдгээр хуулийн төслийг дагалдуудан холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

Хуулийн бүтэц.

Боловсролын ерөнхий хуулийн төсөл нь 8 бүлэг, 51 зүйлтэй, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 9 бүлэг, 30 зүйлтэй, Дээд боловсролын тухай хууль 7 бүлэг, 33 зүйлтэй, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль 5 бүлэг 24 зүйлтэйгээр тус тус боловсруулагдсан.

Хуулийн үзэл баримтлалын дагуу хуулийн төсөлд дараахь онцлог зохицуулалтыг тусгасан байна:

-Боловсролын зорилгыг “төрт ёс, түүх, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай иргэнийг хөгжүүлэхэд оршино” гэж томъёолсноор цаашид хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа нийгэмд амьдрах иргэний хүмүүжил төлөвшил, мэдлэг, чадвар, хөгжлийг онцлон үзсэн.

Өнөөдөр зөвхөн анги танхимд багш сургаж, суралцагч мэдлэг

эзэмшдэг боловсролын концепц шинэчлэгдэж байгаатай холбогдуулан анх удаа иргэн албан ба албан бус боловсролоос гадна амьдралын орчноос сурч, хөгжих;

- Танхимын, танхимын бус болон хосолсон сургалтын хэлбэрээр суралцахуй буюу сурган-сурах үйл явцын үр дүнд иргэн насан туршдаа тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмших;
- Боловсролын харилцаанд оролцогчдын эрх үүрэг, хариуцлага, нийгмийн баталгааг тодорхой болгохдоо багш, түүнийг бэлтгэх, хөгжүүлэх асуудлыг бие даасан үндэсний тогтолцоогоор дамжуулан чанартай, чадварлаг, тасралтгүй хөгждөг багшийг бэлтгэх, хөгжүүлэх нөхцөл бүрдэх;
- Албан боловсролын агуулгыг суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлага, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлэх;
- Албан бус боловсролын агуулга нь иргэний хэрэгцээнд нийцсэн, нээлттэй байх бөгөөд сургалтын зохион байгуулалт нь уян хатан байж, ерөнхий боловсролын агуулгыг нөхөн эзэмшүүлэхэд албан боловсролын хөтөлбөрийг баримтлах;
- Бүх шатны боловсролын хөтөлбөр, арга зүйд хүний эрхийг хүндэтгэн дээдлэх, монголын түүх, хэл зохиол, монгол бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, аюулгүй амьдрах арга ухаан зэргийг оруулснаар бусад салбарын 17 хуулийн 22 заалтаар зохицуулж байсан бүх шатны сургалтын хөтөлбөрийн агуулгатай холбоотой заалтуудыг зөвхөн энэ хуулиар тогтвортой хэрэгжүүлэхээр;
- Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, боловсрол дахь цахим шилжилт, иргэнд боловсрол эзэмших тэгш, хүртээмжтэй боломжийг олгох цахим, зайны сургалтыг болон бүх шатны сургалтын агуулга, хөтөлбөрийг цахим хэлбэрт шилжүүлж хөгжүүлэхээр;
- боловсролын сургалтын байгууллагын ангилал, хэв шинжийг

- шинэчлэн тогтоосон. Тухайлбал, Боловсролын ерөнхий хуулийн төсөлд боловсролын байгууллага нь сургалтын болон сургалт-эрдэм шинжилгээний байгууллагаас бүрдэж, сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль, сургалт-эрдэм шинжилгээний байгууллага нь их сургууль байхаар;
- Боловсролын ерөнхий хуулийг дагалдан гарах Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөлд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь цэцэрлэг байхаар, ерөнхий боловсролын сургууль нь бага сургууль, цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор, 1-9 дүгээр ангитай дунд сургууль, 1-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль, 6-12 ангитай эсхүл 10-12 ангитай ахлах сургууль байхаар;
 - Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын чиг үүргийг нарийвчилж, суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг тасралтгүй эрхэлдэг байхаар;
 - Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн тогтолцоог дэлхийн жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, түүний үр дүнг боловсролыг хөгжүүлэх хөшүүрэг болгон ашиглах;
 - Боловсролын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор боловсролын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий боловсролын төрийн захиргааны байгууллагыг байгуулахаар;
 - Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг Засгийн газар болон иргэд, олон нийтийн өмнө хариуцахаар;
 - Боловсролын удирдах албан тушаалтанд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлж, мерит /чадахуйн/ зарчмыг баримтлан томилохоор;
 - Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсад өрсөлдөх хөрвөх мэдлэг, ур чадвартай, оюунлаг бүтээлч, хариуцлагатай иргэнийг бэлтгэх зорилготой их, дээд сургуульд тавигдах шаардлагыг шинэчлэн, үндэсний зөвлөл,

- удирдах зөвлөлийн бүтэц, чиг үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхээр;
- Монгол Улсад судалгааны их сургууль байгуулж, олон улсад өрсөлдөх хэмжээнд хөгжүүлэх зорилгоор улс орны эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд манлайлах, шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, шилдэг хүний нөөцийг бэлтгэх, шинэ мэдлэг, технологи бүтээх, эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсад өрсөлдөх судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийг хөгжүүлэх харилцааг зохицуулахаар;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсөв, туслах үйл ажиллагааны орлого болон хуульд заасан эцэг, эх, асран хамгаалагчаас хариуцах зардал байхаар;
 - Ингэхдээ цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлын тодорхой хэсгийг эцэг эх хариуцахаар хуульчилснаар төр, иргэний хариуцлага хуваалцах зарчимд шилжих нөхцөл бүрдүүлэхээр;
 - Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг суурь, хувьсах болон үр дүнгийн үнэлгээнд суурилсан нэмэлт зардлаар санхүүжүүлэхээр;
 - Суралцагчийн эрхийг нэмэгдүүлэх, тэднийг хүндэтгэх, нийгмийн баталгааг нь тодорхойлох, аюулгүй эрүүл орчинд сургах, хөгжүүлэх, хүмүүжүүлэхээр;
 - Мэргэшсэн, ёс зүйтэй, чадварлаг багшийн эрх, үүргийг илүү тодорхой болгож, нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг нь өргөж, ажиллах орчныг хангах, цалин хөлс, нийгмийн баталгааг хангахаар;
 - Боловсролыг хүртээмжтэй, тэгш боломж олгохуйц болгох зорилгоор хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан суралцагчийн сурч боловсрох эрхийг хангах, хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамаарч боловсрол эзэмших тэгш нөхцөл боломж бүрдүүлэхээр;

Иргэний насан туршдаа тасралтгүй суралцах асуудлыг сургалтын хөтөлбөр, агуулгад нээлттэй, уян хатан, дэмжсэн байхаар болон аймаг,

нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн чиг үүрэгт иргэнийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, албан бус сургалтад хамрагдах нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байхаар.

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон дагалдан гарах хуулийн төсөлд бүхэлд нь судалгаа хийж, олон улсын жишиг, дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн нэр томъёо, ойлголт, ангиллыг тодорхой болгон, орхигдсон зарим харилцааг дараахь байдлаар тусгалаа:

- Амьдрах орчноос суралцах асуудлыг боловсролын тогтолцооны салшгүй хэсэг гэж хүлээн зөвшөөрөх;
- Монгол Улсын Үндсэн хуульд “Бүх нийтийн ерөнхий боловсрол...” гэж заасны дагуу заавал эзэмших боловсролыг 1-12 анги байхаар өөрчлөх;
- Иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийг ангилан төрөлжүүлэх, түвшнээр эрэмбэлэх мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг бий болгох;
- Англи хэлний боловсрол олгохтой холбоотойгоор “Үндсэн гадаад хэл нь англи хэл байна” гэсэн эрх зүйн зохицуулалтыг тусгах;
- Бүх шатны боловсролын чанарын баталгаажуулалтын асуудлыг тодорхой болгох;
- Боловсролын сургалтын байгууллагын хэв шинж, статус, чиг үүрэг, тэдэнд тавигдах шаардлагыг оновчтой болгох;
- Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудыг суурь болон хувьсах зардал, үр дүнд чиглэсэн нэмэлт санхүүжилтийн зарчимд шилжүүлж, боловсролын санхүүжилтийг боловсролын үйлчилгээний гүйцэтгэл, чанар, үр дүнд чиглэдэг болгох;
- Сурлагын амжилт, ахиц, дэвшлийн үнэлгээний тогтолцоог бий болгож, сургалтын чанарт суурилсан багшийн ажлын үнэлэмж, цалин, урамшуулал, нийгмийн баталгааг боловсронгуй болгох.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь боловсролын зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Боловсролын хууль тогтоомж

2.1.Боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“ерөнхий боловсрол” гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг;

3.1.2.“боловсролын агуулга” гэж боловсролын тухайн түвшинд суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, төлөвшлийг;

3.1.3.“боловсролын түвшин” гэж сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон дээд гэсэн ангиллыг;

3.1.4.“багц цаг” гэж боловсролын агуулгын багтаамжийн хэмжих нэгжийг;

3.1.5.“зайн сургалт” гэж боловсролын агуулгыг суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран, танхимын бус хэлбэрээр явуулах сургалтын үйл ажиллагааг;

3.1.6.“мэргэжлийн чиглэл” гэж мэргэжил олгох хөтөлбөрийн ангиллыг;

3.1.7.“насан туршийн суралцахуй” гэж бүх насны иргэн албан боловсролоос гадна хэрэгцээ, сонирхолдоо нийцүүлэн орон зай, цаг

хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг;

3.1.8.“албан боловсрол” гэж боловсролын байгууллагаар дамжуулж, эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөрийн дагуу суралцагчийн боловсрол эзэмших хэрэгцээг ханган, тухайн түвшний боловсролын баримт бичгээр баталгаажуулдаг зохион байгуулалттай үйл ажиллагааг;

3.1.9.“албан бус боловсрол” гэж албан боловсролоос гадуур тодорхой зорилго, төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд иргэнд мэдлэг, чадвар олгох зохион байгуулалттай үйл ажиллагааг;

3.1.10.“амьдралын орчинд суралцах” гэж албан болон албан бус боловсролоос гадуур гэр бүл, ажлын байр, хүрээлэн буй орчноос бие даан суралцах үйл ажиллагааг;

3.1.11.“суралцагч” гэж боловсролын байгууллагад албан ёсоор элсэн суралцаж байгаа иргэнийг;

3.1.12.“сургалтын орчин” гэж суралцах хэрэгцээг хангахад шаардагдах, холбогдох стандартад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг;

3.1.13.“сургалтын хөтөлбөр” гэж суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, төлөвшил, түүний үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан багц баримт бичгийг;

3.1.14.“суурь зардал” гэж боловсролын байгууллагын гэрэл, цахилгаан, цэвэр, бохир ус, түлш, дулаан, байрны түрээс, урсгал засварын зардлыг;

3.1.15.“төлөвшил” гэж хүмүүжил, хандлагыг;

3.1.16.“мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц” гэж иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийг ангилан төрөлжүүлэх, түвшнээр нь эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдлийг;

3.1.17.“хувьсах зардлын дундаж норматив” гэж сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооноос шууд хамааралтай өөрчлөгдөх зардлын нэг суралцагчид ногдох хэмжээг;

3.1.18.“цахим сургалт” гэж мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан явуулах сургалтын үйл ажиллагааг;

3.1.19.“цэрэг, цагдаа, аюулгүй байдлын дээд боловсролын байгууллага” гэж зэвсэгт хүчин, аюулгүй байдал, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдал, шүүхийн шинжилгээ болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг;

4 дүгээр зүйл.Боловсролын зорилго

4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь төрт ёс, түүх, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай иргэнийг хөгжүүлэхэд оршино.

5 дугаар зүйл.Боловсролын зарчим

5.1.Боловсролын бодлого, үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;

5.1.2.үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухаан, олон улсын дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан байх;

5.1.3.тогтвортой, уялдаатай байх;

5.1.4.тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх;

5.1.5.төр, олон нийтийн оролцоо, хамтын хариуцлагатай байх;

5.1.6.насан туршийн суралцахуйг дэмжсэн байх;

5.1.7.мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд үндэслэсэн байх;

5.1.8.боловсролын байгууллагын удирдах албан тушаалтныг чадахуйн /мерит/ зарчимд үндэслэн сонгон шалгаруулах;

5.1.9.нийгэм, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий гадаад улсын санхүүжилт, зохион байгуулалттайгаар шашны чиглэлээр сургалт, зан үйл, бусад үйл ажиллагаа явуулахгүй байх;

5.1.10.улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

6 дугаар зүйл.Боловсрол эзэмших сургалтын хэл

6.1.Бүх шатны боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь монгол хэл байна.

6.2.Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд гадаад хэл дээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж болно:

6.2.1.Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулагдсан боловсролын байгууллага;

6.2.2.олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль;

6.2.3.гадаад улсын их, дээд сургуультай хамтран болон дангаараа сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх дээд боловсролын байгууллага;

6.3.Сургалтын төлөвлөгөөнд заасан гадаад хэлний сургалт энэ хуулийн 6.1-д хамаарахгүй.

6.4.Энэ хуулийн 6.2-т заасан боловсролын байгууллага нь суралцагчид Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн агуулгыг заавал монгол хэл дээр эзэмшүүлнэ.

7 дугаар зүйл.Боловсролын тогтолцоо

7.1.Боловсролын тогтолцоо нь албан, албан бус болон амьдралын орчноос суралцах боловсролоос бүрдэнэ.

7.2.Албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол болон дээд боловсрол гэсэн шаттай байна.

7.3.Иргэний амьдралын орчноос суралцахуйг хүлээн зөвшөөрч, үр дүнг баталгаажуулж болно.

7.4.Албан ба албан бус боловсролын агуулга, стандартыг энэ хуульд заасны дагуу тогтооно.

8 дугаар зүйл.Боловсрол эзэмших сургалтын хэлбэр

8.1.Сургалт нь танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрийн зохион байгуулалттай байна.

8.2.Бага ангийн сургалтыг заавал танхимаар зохион байгуулна.

8.3. Танхимын бус сургалтад зайн, дэмжигч болон явуулын багшийн, цахим сургалт хамаарна.

8.4. Тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчид ганцаарчилсан сургалт явуулж болно.

8.5. Гамшгийн улмаас боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг хязгаарласан тохиолдолд энэ хуулийн 8.2 дахь хэсэг хамаарахгүй ба хичээл, сургалтыг танхимын бус болон хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

8.6. Боловсрол эзэмших танхимын, танхимын бус, хосолсон сургалтыг үнэлэх, дүйцүүлэх, баталгаажуулах журам, сургалтад тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9 дүгээр зүйл. Боловсролын болон сургалтын баримт бичиг

9.1. Боловсролын баримт бичиг нь суралцагчийн эзэмшсэн боловсролын түвшин, мэргэжлийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн.

9.2. Дунд, бүрэн дунд, ахлах сургууль төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгсөгчид үнэмлэх, коллеж, дээд сургууль, их сургууль төгсөгчид диплом тус тус олгоно.

9.3. Боловсролын баримт бичгийн загвар, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.4. Сургалтын баримт бичиг нь сурагчийн хувийн хэрэг, багшийн журнал байна. Сургалтын баримт бичиг нь цахим хэлбэртэй байж болно.

9.5. Сургалтын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.6. Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан хүлээн зөвшөөрөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.7. Гадаад улсын болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс Монгол Улсын боловсролын байгууллагад шилжин суралцах тохиолдолд сургалтын баримт бичгийг дүйцүүлэх, багц цаг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

9.8.Суралцагч нь тухайн шатлалын боловсролын агуулгыг бүрэн эзэмшээгүй тохиолдолд аливаа боловсролын баримт бичиг олгохыг хориглоно.

10 дугаар зүйл.Суралцагчийн эрх, үүрэг

10.1.Суралцагч дараах эрхтэй:

10.1.1.өөрийн хэрэгцээ, онцлогт нийцсэн, эрүүл, аюулгүй орчинд суралцах нөхцөлөөр хангуулах;

10.1.2.уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд эх хэлээрээ харилцах;

10.1.3.судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагаа үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, дүйцүүлэх, баталгаажуулах;

10.1.4.стандарт, сургалтын хөтөлбөрийн шаардлага хангасан тоног төхөөрөмж, сурах бичиг, ном, гарын авлага хэрэглэх;

10.1.5.сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;

10.1.6.суралцагчийн төлөөллийн байгууллагаар дамжуулан боловсролын байгууллагын үйл ажиллагаанд оролцох;

10.1.7.сургалтын чанар, сургалтын хөтөлбөр, агуулгын талаар санал, хүсэлт илэрхийлэх, судалгаа, шинжилгээний ажилд оролцох;

10.1.8.нийгмийн сайн сайхны төлөө хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;

10.1.9.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;

10.1.10.суралцахын зэрэгцээ ажил хөдөлмөр эрхлэх;

10.1.11.хуульд заасан бусад.

10.2.Суралцагч дараах үүрэгтэй:

10.2.1.сургалтын хөтөлбөр, агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;

10.2.2.бие даан суралцах арга барилыг эзэмших;

10.2.3.суралцагчийн хөгжил, төлөвшилтэй холбоотой боловсролын байгууллага, багшаас тавьсан хууль ёсны шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

10.2.4.багш, суралцагч, анги, хамт олны харилцааг эрхэмлэх, бусдыг хүндэтгэх;

10.2.5.сургуулийн дотоод журам, боловсролын байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

10.2.6.хуульд заасан бусад.

11 дүгээр зүйл.Суралцагчийн нийгмийн баталгаа

11.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативт зардлыг төр хариуцна.

11.2.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид сургуулийн автобусаар үйлчилж болно.

11.3.Авьяаслаг болон онцгой амжилт гаргасан суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгоно.

11.4.Мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон хэмжээний дагуу сар тутам тэтгэлэг олгоно.

11.5.Тэргүүлэх, нэн шаардлагатай мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл олгоно.

11.6.Хууль тогтоомжид заасан бусад баталгаагаар хангагдана.

12 дугаар зүйл. Багш, багшийг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоо

12.1.Багш нь сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх, суралцагчийн сурч боловсрох, хөгжих, төлөвших, суралцахуйг удирдах цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

12.2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нь бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

12.3.Коллеж, дээд сургууль, их сургуулийн багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

12.4.Бүрэн дунд сургууль болон ахлах сургуульд багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.5.Багш бэлтгэх их, дээд сургууль болон багш бэлтгэх хөтөлбөрт

тавих тусгай шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.6.Багш бэлтгэх их, дээд сургуулийн үйл ажиллагаа, сургалтын чанар, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн чадвар үнэлэмжид хөндлөнгийн үнэлгээ хийхдээ суралцагч, төгсөгч, эцэг эх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангана.

12.7.Багш бэлтгэх хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

12.8.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт багшид тусгай, ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчтай ажиллах тусгайлсан арга зүй, ур чадварыг эзэмшүүлэх агуулгыг заавал тусгана.

12.9.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчийн сургалтын төлбөрийг Засгийн газраас баталсан журмын дагуу хөнгөлөх буюу бусад хэлбэрээр төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.10.Суралцагчаас авах багшлах эрхийн улсын нэгдсэн шалгалтыг энэ хуулийн 30.1.22-т заасан журмын дагуу багш бэлтгэх их, дээд сургууль зохион байгуулна.

12.11.Багш мэргэжлээр амжилттай суралцаж, өөрийн хүсэлтээр орон нутагт 5 буюу түүнээс дээш жил ажиллах гэрээ байгуулсан төгсөгчид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

13 дугаар зүйл.Багшийн эрх, үүрэг, багш, ажилтны нийгмийн баталгаа

13.1.Багш нь дараах эрхтэй:

13.1.1.эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажлын үр дүн, гүйцэтгэлд тохирсон цалин хөлс авах;

13.1.2.суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, онцлогт нийцсэн суралцах арга барил, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хэлбэрээ сонгон хэрэглэх;

13.1.3.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.1.4.судалгаа шинжилгээний ажил хийх;

13.1.5.жил тутам холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

13.1.6.боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх болон шийдвэр гаргахад санал өгөх;

13.1.7.мэргэжлийн холбоонд нэгдэх;

13.1.8.нийгмийн сайн сайхны төлөө хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;

13.1.9.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;

13.1.10.хуульд заасан бусад.

13.2.Багш дараах үүрэгтэй:

13.2.1.суралцагчид тогтоосон хугацаанд сургалтын хөтөлбөр, агуулгыг чанартай, бүрэн эзэмшүүлэх;

13.2.2.сургалтыг хувь хүний чадамжид суурилсан уян хатан, суралцагчид тэгш боломж олгож удирдан явуулах;

13.2.3.суралцагчийг идэвхжүүлсэн сургалтын арга зүйг сургалтад ашиглах, суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг бодитой үнэлэх, тэдний авьяас, хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг судлан суралцахуйг дэмжих;

13.2.4.суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэн дэмжих;

13.2.5.суралцагчаа хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;

13.2.6.хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих;

13.2.7.багшийн мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэн, ажил амьдрал үйл ажиллагаагаараа үлгэрлэх;

13.2.8.суралцахуйг дэмжсэн онол, арга зүйн мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэх;

13.2.9.сургалтад харилцаа холбоо, мэдээллийн технологийг

үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад платформыг ашиглах;

13.2.10.багшийн мэргэжлээ дээшлүүлэх, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;

13.2.11.ажил хаялт болон цэцэрлэг, сургуулийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, удирдах ажилтан хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах үйлдэл гаргахгүй байх;

13.2.12.байгууллагын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, бусад багш, ажилтан, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагч, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

13.2.13.эцэг эх, асран хамгаалагчид хүндэтгэлтэй хандаж, соёлтой харьцах;

13.2.14.улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

13.2.15.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

13.2.16.хуульд заасан бусад.

13.3.Багш, ажилтан нь дараах нийгмийн баталгаагаар хангагдана.

13.3.1.багш нь ажлын гүйцэтгэл, ур чадвар, мэргэжлийн тасралтгүй хөгжил, сургалтын үр дүнд үндэслэсэн цалин хөлсөөр хангагдах;

13.3.2.багш, ажилтан хуульд заасны дагуу хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, тусламж, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;

13.3.3.хөдөлмөрийн онцлогийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15, багш, туслах багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно;

13.3.4.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багшид нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг үзүүлэх;

13.3.5.сум, тосгон, баг дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, туслах багш, сэтгэл зүйчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;

13.3.6.төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох.

13.4.Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

13.5.Бүх шатны боловсролын байгууллага нь багшийг сургалтын үйл ажиллагаанд шаардагдах техник тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалаар хангана.

13.6.Багш, ажилтны ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

13.7.Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан нэмэгдэл амралт энэ хуулийн 13.3.3-т заасан албан тушаалтанд хамаарахгүй.

13.8.Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, буцалтгүй тусламж авсан багш, ажилтныг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд үргэлжлүүлэн ажиллуулах тохиолдолд энэ хуулийн 13.3.5 дахь заалт хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГА, СТАНДАРТ

14 дүгээр зүйл.Албан боловсролын хөтөлбөр, агуулга

14.1.Албан боловсролын агуулга нь суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, үндэсний соёл, өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

14.2.Албан боловсролын агуулгыг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дипломын, бакалавр, магистр, докторын гэж ангилах бөгөөд агуулгыг сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

14.3.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол болон дээд боловсролын хөтөлбөр, агуулгатай холбоотой нарийвчилсан харилцааг холбогдох хуулиар тус тус зохицуулна.

14.4.Бүх шатны боловсролын хөтөлбөр, арга зүйд дараах агуулгыг заавал тусгаж, өмчийн хэлбэр харгалзахгүй боловсролын байгууллага хэрэгжүүлнэ:

14.4.1.монголын түүх, хэл зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил;

14.4.2.хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл;

14.4.3.жендэрийн эрх тэгш байдал;

14.4.4.иргэний ёс зүйн боловсрол;

14.4.5.эрүүл мэндийн боловсрол;

14.4.6.байгаль хамгаалал, экологи, ногоон хөгжил;

14.4.7.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан;

14.4.8.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох;

14.4.9.мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцийн донгоос сэргийлэх;

14.5.Шинжлэх ухаан, соёл урлаг, спортын байгууллагатай хамтран бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулгын дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж болно.

14.6.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд эзэмшүүлэх монгол хэл, соёлын боловсролын хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хянан батална.

14.7.Боловсролын хөтөлбөр, агуулгыг судалгаа, шинжилгээнд суурилан боловсруулж, тогтвортой хэрэгжүүлнэ. Ерөнхий боловсролын

сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байна.

14.8.Боловсролын хөтөлбөр, агуулгыг цахим хэлбэрт шилжүүлж хөгжүүлнэ.

14.9.Бүх шатны албан боловсролын хөтөлбөрт тусгах агуулгыг зөвхөн энэ хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл. Албан бус боловсролын хөтөлбөр, агуулга

15.1.Албан бус боловсролын агуулга нь иргэний хэрэгцээнд нийцсэн, нээлттэй байх ба сургалтын зохион байгуулалт нь уян хатан байна.

15.2.Ерөнхий боловсролын агуулгыг нөхөн эзэмшүүлэхэд албан боловсролын хөтөлбөрийг баримтална.

16 дугаар зүйл. Боловсролын стандарт

16.1.Боловсролын стандартаар сургалтын орчин, багшийн мэргэжлийн чадамж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих үндсэн шаардлагыг тодорхойлно.

16.2.Боловсролын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА, ТЭДГЭЭРИЙН АНГИЛАЛ

17 дугаар зүйл.Боловсролын байгууллага

17.1.Боловсролын байгууллага нь сургалтын, сургалт-эрдэм шинжилгээний байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

18 дугаар зүйл.Боловсролын сургалтын байгууллага

18.1.Боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль байна.

18.2.Боловсролын сургалт-эрдэм шинжилгээний байгууллага нь их сургууль байна.

18.3.Боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус эсвэл ашгийн төлөө байж болно.

18.4.Боловсролын байгууллага нь өмчийн хувьд төрийн, орон нутгийн өмчийн, төрийн бус өмчийн болон холимог хэлбэртэй байна.

18.5.Боловсролын байгууллага нь өөрийн үндсэн зорилгодоо нийцсэн сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрлэл явуулах орчин нөхцөлийг бүрдүүлсэн бүтэцтэй байна.

18.6.Боловсролын байгууллага нь шашны сургалт, шашны зан үйл, холбогдох бусад үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

18.7.Энэ хуулийн 18.6 дахь хэсэг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд заасан шашны сургуульд хамаарахгүй.

19 дүгээр зүйл.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага

19.1.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь дараах чиглэлээр суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг тасралтгүй эрхэлнэ:

19.1.1.боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлт;

19.1.2.боловсролын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт;

19.1.3.боловсролын байгууллагын бүтэц, байршил, төлөвлөлт, зохион байгуулалт;

19.1.4.хүний хөгжил, төлөвшил;

19.1.5.бүх шатны боловсролын агуулга, арга зүй, технологи, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн;

19.1.6.боловсролын тэгш байдал, тэгш хүртээмж;

19.1.7.насан туршийн суралцахуй;

19.1.8.үндэстний цөөнхийн хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр;

19.1.9.гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд эзэмшүүлэх монгол хэл, соёлын боловсролын хөтөлбөр;

19.1.10.боловсролын инновац.

19.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь бүх шатны боловсролын байгууллагыг сургалт, арга зүйгээр хангана.

19.3.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын нууцад хамааруулснаас бусад судалгаа, шинжилгээний тайлан, мэдээлэл нь ил тод байна.

19.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

19.5.Боловсрол судлалын ёс зүйн хороог боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын дэргэд ажиллуулна.

19.6.Энэ хуулийн 19.5-д заасан ёс зүйн хороо нь орон тооны бус байх бөгөөд бүрэлдэхүүн болон ажиллах журмыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20 дугаар зүйл.Насан туршийн суралцахуй

20.1.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд нь боловсролын чиглэлээр тусгай зөвшөөрөл шаардахаас бусад сургалтын үйл ажиллагаа эрхэлж, иргэн насан туршдаа суралцаж, мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг явуулж болно.

20.2.Насан туршийн суралцахуйн бодлого, үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах салбар дундын зөвлөл байна.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

21 дүгээр зүйл.Боловсролын байгууллагыг байгуулах, тусгай зөвшөөрөл олгох

21.1.Боловсролын байгууллагыг стандарт, аюулгүй байдлын шаардлага хангасан зориулалтын хичээлийн байр, номын сан, зориулалтын хоол үйлдвэрлэлийн байр, биеийн тамирын заал, талбай, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, багшлах хүний нөөц, шаардлагатай тохиолдолд лаборатори, тоног төхөөрөмжөөр хангагдсан нөхцөлд иргэн, аж ахуйн нэгж байгуулна.

21.2.Боловсролын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан эрх бүхий этгээд олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон насан туршийн боловсролын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

22.1.Тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ:

22.1.1.боловсролын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч болон хувь нийлүүлэгчдийн гэрээ;

22.1.2.боловсролын байгууллага байгуулах үндэслэл, танилцуулга;

22.1.3.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө;

22.1.4.багшлах хүний нөөц, тэдгээрийн боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар;

22.1.5.стандартын шаардлага хангасан, зориулалтын хичээлийн байр, номын сан, лаборатори, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг;

22.1.6.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа;

22.1.7.боловсролын байгууллагын үйл ажиллагаанд зориулан гаргасан хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа;

22.1.8.боловсролын байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.9.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа.

22.2.Боловсролын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 22.1.3-22.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх сургалтын үндэслэл, танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.3.Иргэн, аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа хүсэлт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад ирүүлэх үүрэгтэй.

22.4.Энэ хуулийн 22.1.1-22.1.9-д заасан баримт бичигт тавих шаардлага, загварыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.5.Энэ хуулийн 22.1, 22.2-т заасан хугацаанд баримт бичгийг эрх бүхий байгууллагад ирүүлээгүй нь тусгай зөвшөөрөл олгоход татгалзах үндэслэл болно.

23 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх

23.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь энэ хуулийн 22.1, 22.2-т заасан хүсэлт, баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

23.2.Эрх бүхий этгээд нь баримт бичиг, барилга, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнд магадлан шинжилгээ хийх төрийн захиргааны төв байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн баг томилно.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан магадлан шинжилгээ хийхтэй холбогдсон зардлыг хүсэлт гаргагч хариуцна.

23.4.Энэ хуулийн 23.2-т заасан шинжээчийн баг нь томилогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан баримт бичигт магадлан шинжилгээ хийж дүгнэлт гаргана.

23.5.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь шинжээчийн багийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

24.1.Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 12 жил байна.

24.2.Тусгай зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлно.

24.3.Боловсролын байгууллага нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас гурваас доошгүй сарын өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдэд цахимаар гаргана.

24.4.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах шийдвэр гаргахаас өмнө тусгай зөвшөөрлийн шаардлага хангаж байгаа эсэхэд магадлан шинжилгээ хийнэ.

24.5.Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

25 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

25.1.Тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

26 дугаар зүйл.Боловсролын байгууллагыг татан буулгах

26.1.Боловсролын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

26.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

26.1.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

26.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

26.1.4.нийт суралцагчийг суралцаж буй түвшинтэй нь хамааруулж боловсролын байгууллагад шилжүүлсэн;

26.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

26.2.Боловсролын байгууллагыг татан буулгах талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарснаар татан буугдсанд тооцно.

26.3.Татан буугдсан боловсролын байгууллага нь суралцагчид хохиролгүйгээр асуудлыг бүрэн шийдвэрлэж, холбогдох баримт бичгийг орон нутгийн болон үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.

26.4.Боловсролын байгууллага нь татан буугдсан тохиолдолд суралцагчид учирсан хохирлыг үүсгэн байгуулагч бүрэн хариуцна.

26.5.Боловсролын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг Иргэний хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

26.6.Боловсролын байгууллагыг татан буулгахад суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр тухайн хичээлийн жилтэй уялдуулж тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

27 дугаар зүйл.Боловсролын удирдлагын тогтолцоо

27.1.Боловсролын удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, боловсролын байгууллагын удирдлагаас тус тус бүрдэнэ.

27.2.Боловсролын байгууллагын удирдлага нь тухайн байгууллагын гүйцэтгэх удирдлага болон өөрийн удирдлага байна.

27.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийг нэгдсэн удирдлагаар хангана.

28 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

28.1.Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/ боловсролыг хөгжүүлэх, дэмжих талаар Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.төрөөс боловсролын талаар баталсан бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг удирдлагаар хангах;

28.1.2.боловсролын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

28.1.3.боловсролын салбар дахь хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах;

28.1.4.энэ хуулийн 11.3-11.5-д заасан тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх журмыг батлах;

28.1.5.энэ хуулийн 13.3.4-13.3.6-д заасан нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг, мөнгөн тэтгэмж олгох журмыг батлах;

28.1.6.боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

28.1.7.төрийн өмчийн олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон дээд боловсролын байгууллага, түүний харьяаллын сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хамтарсан сургууль байгуулах, өөрчлөх, татан буулгах шийдвэр гаргах;

28.1.8.энэ хуулийн 42.6-д заасан буцалтгүй тусламж, зээл олгох журмыг батлах;

28.1.9.сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, олон улсын хөтөлбөр, тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлэх цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд боловсрол эзэмшүүлэхэд хүүхдийн тоо, хэрэглээний үнийн түвшингээс хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр, суурь, хувьсах зардлын дундаж норматив болон үр дүнгийн үнэлгээнд үндэслэн төсөв тооцох аргачлал, санхүүжүүлэх журмыг батлах;

28.1.10.төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг тогтоох;

28.1.11.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрын хүүхдийн хоолны зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг тогтоох;

28.1.12.дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчид төрөөс үзүүлэх буцалтгүй тусламж, зээл, тэтгэлгийн хэмжээг тогтоох;

28.1.13.боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

28.1.14.дээд боловсролын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах;

- 28.1.15.мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг батлах;
- 28.1.16.энэ хуулийн 43.8-д заасан дэмжлэг үзүүлэх журам батлах;
- 28.1.17.энэ хуулийн 29.1.8-д заасан жагсаалтыг батлах;
- 28.1.18.хуульд заасан бусад бүрэн эрх.

29 дүгээр зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

29.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлагаар хангах;

29.1.2.боловсролын стандартыг боловсруулах;

29.1.3.боловсролын хөтөлбөр, норм, нормативын хэрэгжилт, боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах;

29.1.4.боловсролын байгууллагын удирдах ажилтан, багшийг нэгдсэн бодлого, тодорхой чиглэлээр бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангах;

29.1.5.боловсролын асуудлаар гадаад улс орны болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, үр өгөөжийг дээшлүүлэх;

29.1.6.төрийн бус өмчийн боловсролын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

29.1.7.гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

29.1.8.тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн боловсруулж батлуулах;

29.1.9.иргэнд боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохион байгуулж байгаа ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах;

29.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

29.2 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.14-т заасан зөвхөн боловсрол, танин мэдэхүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сувагтай байж болно.

30 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

30.1.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.боловсролын болон багш, ажилтны ажлын норм нормативыг эрүүл мэнд, хөдөлмөр, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батлах;

30.1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам, тавих шалгуурыг батлах;

30.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын багш, удирдах ажилтны ажлыг үнэлэх, дүгнэх болон багшлах эрх олгох, хасах журам батлах;

30.1.4.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, албан бус боловсролын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам батлах;

30.1.5.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын багш, удирдах ажилтны ажлыг төлөвлөх аргачлал батлах;

30.1.6.иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцан эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

30.1.7.төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах;

30.1.8.сурах бичгийн эхийг зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлагыг батлах;

30.1.9.төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг батлах;

30.1.10.мэргэжлийн болон дээд боловсролын мэргэжлийн чиглэл, индексийг батлах;

30.1.11.мэргэжлийн боловсролын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

30.1.12.хуульд өөрөөр заагаагүй бол дээд боловсролын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага батлах;

30.1.13.боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын бүтэц, орон тоо, дүрмийг батлах;

30.1.14.боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасны дагуу чөлөөлөх;

30.1.15.зайн болон цахим сургалт зохион байгуулах журам батлах;

30.1.16.боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сан бий болгох, ашиглах, түүний тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалыг хангах журам батлах;

30.1.17.энэ хуулийн 29.2-т заасан сувгаар дамжуулах хөтөлбөр, агуулга болон нэвтрүүлэг, хөтөлбөр, контенттой холбоотой харилцааг зохицуулах журмыг батлах;

30.1.18.гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед боловсролын салбарын бэлэн байдлыг хангах, зохицуулалт хийх шийдвэр гаргах;

30.1.19.боловсролын байгууллагын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн биелэлт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

30.1.20.аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн үйл ажиллагааны журмыг батлах;

30.1.21.аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн

цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралд нэр дэвшигчээс боловсролын удирдах ажилтны шалгалт авах журмыг батлах;

30.1.22.багш бэлтгэх их, дээд сургуулийн суралцагчаас улсын нэгдсэн болон багшлах эрхийн шалгалт авах журмыг батлах;

30.1.23.боловсролын байгууллагын үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.1.24.хуульд заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

31.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

31.1.1.боловсролын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

31.1.2.сурах бичиг зохиох, хэвлэх, ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах, төлөвлөгөө хэрэгжүүлэх;

31.1.3.багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх;

31.1.4.аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;

31.1.5.бүх шатны боловсролын сургалтын чанарт үнэлгээ, судалгаа хийх, их, дээд сургууль, коллежид элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалт, багш бэлтгэх их, дээд сургууль төгсөгчийн улсын нэгдсэн шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

31.1.6.боловсролын салбарын мэдээллийн технологийн хөгжүүлэлт, мэдээллийн систем, сан, нэгдсэн сүлжээ болон тэдгээрийн дэд бүтцийн хяналт, аюулгүй байдлын хэрэгжилтийг хангах;

31.1.7.боловсролын болон сургалтын баримт бичгийг хэвлүүлэх, түгээх, олгох ажлыг зохион байгуулах;

31.1.8.улсын олимпиад зохион байгуулах журам, ерөнхий

боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам баталж мөрдүүлэх;

31.1.9.насан туршдаа суралцахуйн бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах;

31.1.10.боловсролын салбарын чиглэлээр гадаад улс, олон улсын төрөлжсөн бусад байгууллагатай байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах;

31.1.11.боловсролын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуульд заасны дагуу мэдээлэх;

31.1.12.мэргэжлийн болон дээд боловсролын байгууллага, түүний сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

31.1.13.магадлан итгэмжлэх шалгуур батлах;

31.1.14.гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээ авах нэгдсэн зохицуулалт хийх;

31.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

32 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх

32.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомж, шийдвэр, дүрэм, журам, заавар, стандарт, норм, нормативын биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх;

32.1.2.аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн бүтэц, орон тоог батлах;

32.1.3.стандарт, норм нормативыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

32.1.4.өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

32.1.5.боловсролын салбарын асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авч хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэх;

32.1.6.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

32.1.7.төрийн өмчийн олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургуулийн захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасны дагуу чөлөөлөх;

32.1.8.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгслийн жагсаалт батлах;

32.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

33 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс

33.1.Аймаг, нийслэлийн боловсролын газар харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

33.1.2.хичээл, судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээ, технологи болон зайн, цахим сургалтыг хөгжүүлэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

33.1.3.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргах;

33.1.4.багш, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

33.1.5.боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

33.1.6.боловсролын салбарын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;

33.1.7.төрийн бус өмчийн боловсролын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

33.1.8.өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах;

33.1.9.өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагыг хөгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах;

33.1.10.иргэнд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, насан туршдаа суралцахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

33.1.11.өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагад хоол хүнсний хангамж, орчны аюулгүй байдлыг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

33.1.12.боловсролын байгууллагын орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, боловсролын байгууллагыг арга зүй, зохицуулалтаар хангах;

33.1.13.орон нутгийн боловсролын байгууллагын гамшгийн эрсдлийг үнэлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах, нөхцөл байдлыг тогтворжуулахад хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

33.1.14.гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоох тохиолдолд боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;

33.1.15.орон нутгийн боловсролын байгууллагын багш, ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

33.1.16.орон нутгийн насан туршийн боловсролын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

33.1.17.боловсролын байгууллагын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн биелэлт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

33.1.18.хуульд заасан бусад.

33.2. Нийслэлийн боловсролын газар нь дүүргийн боловсролын хэлтсийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэгээр хангаж ажиллана.

33.3.Дүүргийн боловсролын хэлтэс нь харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.3.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

33.3.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагатай хамтран ажиллах, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах;

33.3.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах;

33.3.4.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

33.3.5.зайн болон цахим сургалтыг хөгжүүлэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

33.3.6.иргэнийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах, насан туршийн суралцахуйг дэмжих ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх;

33.3.7.боловсролын салбарын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;

33.3.8.насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг зохион байгуулах;

33.3.9.энэ хуулийн 14.4-т заасан агуулгаар ерөнхий боловсролын сургуульд сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран зохион явуулах;

33.3.10.хуульд заасан бусад.

33.4.Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс нь хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй байх бөгөөд

төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, мэдээ, тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

33.5.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

33.5.1.боловсролын байгууллагад 15-аас доошгүй жил, үүнээс боловсролын байгууллагын багш, удирдах ажилтнаар 10-аас доошгүй жил, боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

33.5.2.боловсрол судлал, багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн, төрийн болон боловсролын удирдлага, төлөвлөлт, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн байх;

33.5.3.энэ хуулийн 30.1.21-д заасан шалгалт өгч, тэнцсэн байх.

33.6.Дүүргийн боловсролын хэлтсийн дарга нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

33.6.1.боловсролын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын байгууллагын багш, удирдах ажилтнаар 5-аас доошгүй жил, боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх;

33.6.2.боловсрол судлал, багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн, төрийн болон боловсролын удирдлага, төлөвлөлт, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн байх;

33.6.3.энэ хуулийн 30.1.21-д заасан шалгалт өгч, тэнцсэн байх.

34 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

34.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1.боловсролын асуудлаар тухайн шатны Засаг даргын тайланг хэлэлцэж, чиглэл өгөх;

34.1.2.орон нутгийн өмчийн боловсролын байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;

34.1.3.орон нутгийн боловсролыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

34.1.4.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин, сургалтын чанарыг сайжруулахад шаардагдах төсвийг жил бүр тусгайлан батлах;

34.1.5.орон нутгийн иргэний хэрэгцээнд нийцүүлэн насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилтийг батлах;

34.1.6.орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцах;

34.1.7.боловсролын салбарын барилга байгууламжийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавих шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд байлгаж, газар зохион байгуулалтын холбогдох төлөвлөгөөнд тусгах;

34.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

35 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

35.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

35.1.2.иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй хүний нөөц бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

35.1.3.орон нутгийн өмчийн боловсролын байгууллага байгуулах,

өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх;

35.1.4. боловсролын байгууллагын хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах;

35.1.5. орон нутгийн өмчийн боловсролын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

35.1.6. орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

35.1.7. нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний цөөнхийн монгол хэл болон эх хэлээрээ боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

35.1.8. орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг Засгийн газар болон иргэн, олон нийтийн өмнө хариуцах;

35.1.9. боловсролын байгууллагын нийт албан хаагчийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээг авах;

35.1.10. боловсролын байгууллагын багш, ажилтанд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах;

35.1.11. орон нутгийн өмчийн боловсролын байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газрыг зориулалтын барилга байгууламжаар хангах;

35.1.12. сургуулиасаа хол амьдардаг суралцагчид сургуулийн автобусаар үйлчлэх журам батлан, үйл ажиллагааг зохион байгуулах;

35.1.13. орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тогтоох;

35.1.14. аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг сонгон

шалгаруулалтын болон боловсролын удирдах ажилтны шалгалтын дүнг үндэслэн томилж, хууль тогтоомжид заасны дагуу чөлөөлөх;

35.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

36 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

36.1.Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

36.1.2.нутаг дэвсгэрийн боловсролын байгууллага эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;

36.1.3.хүүхдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх, иргэнд ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг дэмжих, хамтран ажиллах;

36.1.4.өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх;

36.1.5.иргэнд насан туршийн суралцахуйн талаарх мэдээллээр хангах, хамтран ажиллах, арга хэмжээ авах;

36.1.6.өмчийн хэлбэр үл харгалзан боловсролын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

36.1.7.сум, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг эцэг, эх, олон нийтийн оролцоонд тулгуурлан хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

36.1.8.өмчийн бүх хэлбэрийн боловсролын байгууллагын барилга байгууламж, орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

36.1.9.дүүргийн боловсролын хэлтсийн даргыг нийслэл дэх

Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн нийслэлийн боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;

36.1.10.аймаг, нийслэлийн боловсролын газраас зохион байгуулсан сонгон шалгаруулалтын болон боловсролын удирдах ажилтны шалгалтын дүнг үндэслэн орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

36.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

37 дугаар зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

37.1.Баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.1.1.сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах ажлыг хариуцан зохион байгуулах;

37.1.2.нутаг, дэвсгэрийн хэмжээнд иргэдийн сургууль завсардалт гаргахгүй байх, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;

37.1.3.иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

37.1.4.ерөнхий боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажлыг боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулах;

37.1.5.баг, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг эцэг, эх, олон нийтийн оролцоонд тулгуурлан хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.

37.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

38 дугаар зүйл. Боловсролын байгууллагын удирдлага, түүний чиг үүрэг

38.1.Өмчийн бүх хэлбэрийн боловсролын байгууллагыг үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээдийн томилсон гүйцэтгэх удирдлага удирдана. Гүйцэтгэх удирдлага нь цэцэрлэгт эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургуульд захирал, их сургуульд ректор байна.

38.2.Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын захирал, эрхлэгч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

38.2.1.багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр энэ хуулийн 31.1.3-т заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх;

38.2.2.боловсролын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын байгууллагад багшаар 6-аас доошгүй жил, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, арга зүйчээр 4-өөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх;

38.2.3.энэ хуулийн 30.1.21-д заасан шалгалт өгч, тэнцсэн байх.

38.3.Боловсролын байгууллагын захирал, эрхлэгч дараах чиг үүрэгтэй:

38.3.1.тухайн боловсролын байгууллагын үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах;

38.3.2.тухайн боловсролын байгууллагын багш, ажилтныг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх;

38.3.3.тухайн боловсролын байгууллагын багш, ажилтан, суралцагчийг удирдан чиглүүлэх, хяналт тавих;

38.3.4.суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагын амжилт чанарыг сайжруулахын тулд багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлэх;

38.3.5.суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

38.3.6.сургалтын цахим платформ хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах.

38.3.7.хуульд заасан бусад.

39 дүгээр зүйл. Боловсролын байгууллагын өөрийн удирдлага

39.1.Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль, их сургууль, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн

дагуу байгуулсан боловсролын байгууллагын өөрийн удирдлага нь удирдах зөвлөл байна.

39.2.Энэ хуулийн 39.1-д зааснаас бусад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн өөрийн удирдлага нь сургуулийн болон цэцэрлэгийн зөвлөл байна.

39.3.Цэрэг, цагдаа, аюулгүй байдлын мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагад энэ хуулийн 39.1 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд чиг үүргийн онцлогт нийцсэн захиргааны зөвлөлтэй байна.

39.4.Энэ хуулийн 39.3-т заасан захиргааны зөвлөлийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус байгуулна.

39.5.Энэ хуулийн 39.2-т заасан зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

39.6.Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан боловсролын байгууллагын өөрийн удирдах байгууллагын чиг үүрэг, төлөөлөл, бүрэн эрхийн хугацааг холбогдох хуулиар тус тус зохицуулна.

40 дүгээр зүйл.Боловсролын хяналт шалгалт, чанарын үнэлгээ

40.1.Боловсролын хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

40.2.Мэргэжлийн хяналтын байгууллага нь боловсролын хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, норм, норматив, боловсролын баримт бичиг, сургалтын орчин, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавина.

40.3.Боловсролын бүх түвшинд чанарын үнэлгээг холбогдох дүрэм, журмын дагуу тогтмол хийнэ.

40.4. Боловсролын чанарын үнэлгээний үйл ажиллагаанд суралцагч, эцэг эх, иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮЖИЛТ, СУРГАЛТЫН ОРЧИН

41 дүгээр зүйл.Боловсролын төлөвлөлт, тайлагналт

41.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан бодлого, төлөвлөлтөд үндэслэн аймаг, нийслэлийн нь боловсролыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

41.3.Боловсролын байгууллага нь энэ хуулийн 30.1.1.-д заасан норм, нормативд нийцсэн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

42 дугаар зүйл.Боловсролын санхүүжилт

42.1.Иргэнд ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг хуульд заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

42.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо нь дараах зарчмыг хангасан байна.

42.2.1.үр дүнд чиглэсэн байх;

42.2.2.тэгш хамруулахад чиглэсэн;

42.2.3.тэгш боломж бүрдүүлэхэд чиглэсэн байх;

42.2.4.боловсролын чанарыг сайжруулахад чиглэсэн байх;

42.2.5.үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, үр ашигтай байх;

42.2.6.байгууллагын бие даасан байдлыг хангахад чиглэсэн байх.

42.3.Боловсролын байгууллагад улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох харилцааг энэ хууль болон бусад хуулиар зохицуулна.

42.4.Боловсролын байгууллага нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаад улс орны аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс санхүүжнэ.

42.5.Боловсролын байгууллага нь үйл ажиллагааны онцлогоос хамаарч дараах нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байна:

42.5.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хуульд заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагчаас хариуцах зардлыг санхүүжүүлэх төлбөр, хандив, тусламж;

42.5.2.төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад улсын төсөв, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлын санхүүжилт;

42.5.3.цэрэг, цагдаа, аюулгүй байдлын дээд боловсролын байгууллагад төсвөөс санхүүжүүлсэн зардал, эрдэм шинжилгээний төсөлт ажлын санхүүжилт;

42.5.4.төрийн бус өмчийн боловсролын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүсгэн байгуулагчийн хөрөнгө, нэг суралцагчид ногдох сургалтын шууд зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хэсэг, сургалтын төлбөр, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжнэ.

42.5.5.төрийн бус өмчийн боловсролын байгууллагын нэг суралцагчид олгох сургалтын шууд зардлын санхүүжилтийн хэмжээг суурьшлын ялгаанаас үүсэж буй боловсролын ялгааг багасгах Засгийн газрын бодлого, эцэг эх асран хамгаалагчийн амьдралын түвшинтэй уялдуулан Засгийн газар тогтоох бөгөөд, санхүүжилт авах суралцагчийн хүсэлтийн дагуу эрэлтэд суурилсан хэлбэрээр олгоно.

42.6.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь улсын төсөв, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжнэ.

42.7.Боловсролын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын байгууллагын захирал, эрхлэгч хэрэгжүүлнэ.

42.8.Боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглоно.

43 дугаар зүйл.Боловсролын байгууллагын санхүүжилт

43.1.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны дор дурдсан зардлын бүрэлдэхүүнийг харгалзан-тооцож, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

43.1.1. сургуулийн хүчин чадлаас хамаарсан үйл ажиллагаа, үл хөдлөх болон үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын буюу суурь зардал, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал;

43.1.2. хүүхдийн тоо, бүлэг дүүргэлт, хүчин чадлын ашиглалт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, боловсролын стандарт, багш ажилтны дундаж цалин хөлснөөс хамаарсан сургалтын үйл ажиллагааны шууд зардлын дундаж нормативт үндэслэн тооцох хувьсах зардал;

43.1.3. боловсролын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллын санхүүжилт;

43.1.4. холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж буй үдийн цай, хоол болон бусад нэмэлт зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал;

43.1.5. багш нарын мэргэжил дээшлүүлэх зардал.

43.2. Энэ хуулийн 43.1.1-43.1.3-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

43.3. Энэ хуулийн 43.1.3-т заасан нэмэлт урамшууллын санхүүжилтийг олгоход боловсролын байгууллагын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээ нь сургалтын чанар, суралцагч бүрийн суралцахуйн үр дүнд гаргасан ахиц, тухайн байгууллагын засаглал, ил тод байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаар хийсэн хөндлөнгийн үнэлгээнд үндэслэнэ.

43.4. Улсын төсвөөс дор дурдсан зардлыг санхүүжүүлнэ:

43.4.1. өмчийн хэлбэр харгалзахгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив;

43.4.2. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын багш, ажилтны ажлын үр дүнгийн үнэлгээнд суурилсан нэмэлт зардал;

43.4.3. мэргэжлийн боловсролын байгууллагын дотуур байрын нийт зардал, төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын хувьсах зардлын дундаж норматив, хоолны зардал, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын суурь зардал;

43.4.4. тусгай цэцэрлэгийн хүүхдийн хоол, сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал;

43.4.5. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хэсэг;

43.4.6. төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлын тодорхой хэсэг;

43.4.7. төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд нэг жилд ногдох тоног төхөөрөмжийн зардлын дундаж нормативт санхүүжилтийн тодорхой хувь;

43.4.8. өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын байгууллагын суралцагчид хуульд заасан нөхцөлөөр төрөөс олгох тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, зээл.

43.5. Энэ хуулийн 43.4.5 - 43.4.7-д заасан зардлын улсын төсвөөс санхүүжих хувь, хэмжээг Засгийн газар тогтоож, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгана.

43.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ.

43.7. Төрөлжсөн хичээлийн улсын олимпиад зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны олимпиадад оролцох болон төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх дугуйлангийн зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

43.8. Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, бүс, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээнд үндэслэн мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяас, чадварыг дэмжих, зорилтод бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дээд боловсролын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгоно

43.9. Суралцагчаас элсэлтийн бүртгэл, олимпиад, уралдаан, тэмцээнд оролцох, засвар үйлчилгээ хийх зэрэг хуульд заагаагүй төлбөр, хураамж, зардал авах болон суралцагчид ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн борлуулахыг хориглоно.

43.10.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловсролын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.

44 дүгээр зүйл.Боловсролын байгууллагын орчин

44.1.Боловсролын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсрол, эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

44.3.Боловсролын байгууллагыг зориулалтын барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сурах бичиг, дотуур байраар хангах асуудлыг үүсгэн байгуулагч хариуцна.

44.4.Боловсролын байгууллага өөрийн харьяанд сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.

44.5.Боловсролын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байна.

44.6.Боловсролын байгууллагын барилга байгууламж, эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглана.

44.7.Энэ хуулийн 34.1.7-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн нөөцийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.

44.8.Боловсролын байгууллага нь болзошгүй эрсдэл, гамшгаас

хамгаалах аюулгүй байдлыг хангасан, суралцагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн орчин бүрдүүлсэн байна.

44.9.Боловсролын байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль болон бусад хуульд заасны дагуу тэгш боломж олгосон, хүртээмжтэй, хувь хүний хөгжил, сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг хангасан таатай орчин бүрдүүлсэн байна.

44.10.Төрөөс боловсролын хүртээмж, суралцах тэгш нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг улсын болон орон нутгийн төсөв дэх ачааллыг бууруулж, үе шаттай шийдвэрлэх зорилгоор дараах нөхцөлөөр хөрөнгө оруулалтын элэгдлийн зардлыг нэг хүүхдэд ногдох норматив тогтоон жил бүр санхүүжүүлж болно.

44.10.1.төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн тоног, төхөөрөмжийн хангамж хүрэлцээгүй боловсролын байгууллагад богино, дунд хугацаанд сургалтын орчны стандартыг хангах зорилгоор төрийн бус байгууллагаас арилжааны хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн зориулалтаар тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл авах зориулалтаар.

44.11.Энэ хуулийн 44.10-т заасан харилцааг зохицуулах журмыг Засгийн газар батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИЙН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

45 дугаар зүйл.Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

45.1.Эцэг, эх, асран хамгаалагч дараах эрхтэй:

45.1.1.хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, хөгжлийн талаар багш болон боловсролын байгууллагаас зөвлөгөө авах, хамтран ажиллах;

45.1.2.хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах;

45.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн болон зөвлөлийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай, бүтээлчээр оролцох;

45.1.4.боловсролын байгууллага, багшийн үйл ажиллагааны талаар санал, хүсэлт гаргах;

45.1.5.сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилт, сургалтын орчин, баримт бичигтэй танилцах;

45.1.6.хуульд заасан бусад.

45.2.Эцэг, эх, асран хамгаалагч дараах үүрэгтэй:

45.2.1.хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь илрүүлэн, дэмжин хөгжүүлэх, эерэгээр хүмүүжүүлэх, гэр бүлийн орчинд сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах;

45.2.2.хүүхдийг 5 настайд нь сургуулийн өмнөх боловсролд, цаашид ерөнхий боловсролд заавал хамруулах;

45.2.3.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг хариуцах;

45.2.4.гэр бүлийн орчинд хүүхдийг бие даан суралцах арга барил эзэмшихэд туслалцаа үзүүлэх, урамшуулан дэмжих;

45.2.5.хүүхдийн нас, хөгжлийн онцлог, зан төлвийг таньж мэдэх, хүүхдээ ойлгон хүндлэх, туслах, хараа хяналтгүй орхихгүй байх;

45.2.6.сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан сургууль, багшаас тавьсан холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн шаардлагыг биелүүлэх;

45.2.7.багшийг өөрийг нь болон багшийн нэр хүндийг гутаан доромжлохгүй байх, хүндэтгэлтэй хандаж, соёлтой харьцах;

45.2.8.хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, эрүүл мэнд, аюулгүй байдалд байнгын анхаарал тавих, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах;

45.2.9.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиас зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, багш, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

45.2.10.энэ хуулийн 43.5.5, 43.5.6-д заасан зардлын тодорхой хэсгийг хариуцах;

45.2.11.хуульд заасан бусад.

45.3.Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ сургалт, төлөвшил, авьяас, чадварыг хөгжүүлэх асуудлаар боловсролын байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлнэ.

46 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг

46.1.Хуулийн этгээд дараах эрхтэй:

46.1.1.мэргэжилтэн бэлтгүүлэх, ажилтны мэргэжлийг дээшлүүлэх захиалгыг холбогдох боловсролын байгууллагад өгөх, гэрээ байгуулан сургах;

46.1.2.гэрээгээр болон захиалгаар суралцагчийн сургалтын явц, чанарын талаар санал гаргах, шаардлага тавих;

46.1.3.байгууллагын ажилтан, албан хаагчдын боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;

46.1.4.боловсролын байгууллагын сургалтын орчин бүрдүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хуульд нийцсэн хандив өгөх;

46.1.5.иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр боловсролын байгууллагатай хамтарч ажиллах;

46.1.6.хуульд заасан бусад.

46.2.Хуулийн этгээд дараах үүрэгтэй:

46.2.1.гэрээний дагуу суралцагчийг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, бололцоогоор хангах, төгссөний дараа ажлын байраар хангах;

46.2.2.энэ хуулийн 46.1.1-д заасан гэрээгээр болон захиалгаар суралцагчийн сургалтын зардлыг хариуцах;

46.2.3.байгууллагын ажилтан, албан хаагчийг бие дааж сурч боловсрох, хүүхдээ сургахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, насан туршийн суралцахуйг дэмжих;

46.2.4.ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусган батлах;

46.2.5.хуульд заасан бусад.

47 дугаар зүйл.Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны эрх, үүрэг

47.1.Боловсролын харилцаанд оролцогч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо нь дараах эрхтэй:

47.1.1.салбарын хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, хэлэлцүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд оролцох, санал, зөвлөмж өгөх;

47.1.2.хамтарсан судалгаа хийх, сургалт зохион байгуулах;

47.1.3.боловсролын салбар, хүний нөөц, техник, технологийн хөгжил дэвшил, чанар, хүртээмж зэрэг чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах;

47.1.4.хуульд нийцүүлэн зарим чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлэх;

47.1.5.боловсролын чанарын үнэлгээ, баталгаажуулалт болон багшийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцох;

47.1.6.хуульд заасан бусад.

47.2.Боловсролын харилцаанд оролцогч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо нь дараах үүрэгтэй:

47.2.1.мэргэжлийн түвшинд боловсролын үйл ажиллагаанд оролцох;

47.2.2.судалгаанд суурилсан мэдээлэл, баримт бичгийг үйл ажиллагаанд ашиглах;

47.2.3.байгууллагын болон хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

47.2.4.энэ хуулийн 47.1.4-т заасан гэрээт ажлыг мэргэжлийн хэмжээнд, хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах;

47.2.5.насан туршийн суралцахуйг дэмжсэн үйл ажиллагаа явуулах;

47.2.6.оюуны өмчийн эрхийг хүндэтгэх;

47.2.7.боловсролын үйл ажиллагаанд оролцохдоо улс төрийн болон хувийн ашиг сонирхол илэрхийлэхгүй байх;

47.2.8.хуульд заасан бусад.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

48 дугаар зүйл.Боловсролын цахим, удирдлага болон мэдээллийн нэгдсэн сан

48.1.Монгол Улс боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд тус сан нь төрийн өмч байна.

48.2.Монгол Улс иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих суралцахуйн удирдлагын системтэй байна.

48.3.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан нь нууцад хамааруулснаас бусад бүх шатны боловсролын байгууллага, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн мэдээллээс бүрдэнэ.

48.4.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн ангилал, кодыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран батална.

48.5.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ, дэд бүтэц өөрчлөгдөх, үрэгдэх, устах, халдлагаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд улсын онцгой объектын зэрэглэлтэй байна.

48.6.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага хариуцна.

48.7.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хуулбар сан нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад хадгалагдана.

48.8.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

48.9.Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

48.10.Боловсролын байгууллагын удирдлага, багшлах хүний нөөцийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн нээлттэй, улсын нэгдсэн платформ байна.

49 дүгээр зүйл.Цахим мэдээллийн аюулгүй байдал

49.1.Эцэг эх, асран хамгаалагчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу хувь хүний нууцын зэрэглэлтэй суралцагчийн хувийн мэдээллийг халамжийн болон хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий байгууллагад өгч болно.

49.2.Ажилтан, албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойших хугацаанд боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сангийн байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, бусдад задруулахыг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

50 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

50.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

51.1.Энэ хуулийн 33.5, 33.6, 38.2 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

51.2.Энэ хуулийг 2021 оны ... дүгээр сарын .-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын тогтолцоо, дээд боловсролын харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, сургалтын агуулга, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Дээд боловсролын зорилго

2.1. Дээд боловсролын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсад өрсөлдөх мэдлэг, ур чадвартай, хөрвөх чадвартай, бүтээлч, хариуцлагатай, төлөвшсөн, эх оронч иргэнийг бэлтгэх замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршино.

3 дугаар зүйл. Дээд боловсролын хууль тогтоомж

3.1. Дээд боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. дээд боловсролын суралцагч” цаашид “суралцагч” гэх гэж дипломын болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагч оюутан, магистрын хөтөлбөрөөр суралцагч магистрант, докторын хөтөлбөрөөр суралцагч докторантыг;

4.1.2. ахисан түвшний сургалт” гэж магистр, докторын хөтөлбөрийн сургалтыг;

4.1.3. ”суралцагчийн тэтгэлэг” гэж сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан суралцагчид олгох мөнгөн тусламжийг;

4.1.4. "сургалтын зээл" гэж сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгогдох мөнгөн хөрөнгийг;

4.1.5. эндаументийн сан" гэж аж ахуйн нэгж байгууллагаас ашиг, эдийн засгийн сонирхолгүй, судалгаа шинжилгээнд зориулан шилжүүлсэн хөрөнгийг;

4.1.6. "их сургуулийн эмнэлэг" гэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5 дугаар зүйл.. Дээд боловсролын сургалтын байгууллага

5.1. Дээд боловсролын байгууллага нь коллеж, дээд сургууль, их сургууль гэсэн ангилалтай байна.

5.2. Дээд боловсролын байгууллага болон судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын хөгжил, нөөцийн хуваарилалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор газар зүйн байршлаар бүсийн сургалт судалгаа, эрдэм шинжилгээний цогцолбор байгуулж болно.

5.3. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний цогцолбор байгуулахад тавих шаардлага, чиглэл, зохион байгуулалтын журмыг Засгийн газар батална.

5.4. "Монгол Улсын" болон "Үндэсний" гэсэн үг, түүний англи хэл дээрх орчуулга, барааны тэмдгийг зөвхөн төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад хэрэглэнэ.

5.5. Дээд боловсролын байгууллагын ангилалд тавих энэ хуульд зааснаас бусад нэмэлт шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

5.6. Аюулгүй байдлыг хангах мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн цэрэг, цагдаа, аюулгүй байдлын сургалттай төрийн өмчийн их, дээд сургуульд олгоно.

6 дугаар зүйл. Их сургууль

6.1. Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны лаборатори, төв, хүрээлэн бүхий сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн нэгдэл хэлбэртэй сургалт-эрдэм шинжилгээний байгууллага байна.

6.2. Их сургууль нь ахисан түвшний сургалт дагнан эрхэлж болно.

6.3. Их сургууль нь судалгааны их сургуулийн хэв шинжтэй байж болох ба Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлыг холбогдох хуулиар зохицуулна.

6.4. Их сургууль нь дараах шаардлагыг хангасан байна:

6.4.1. таваас доошгүй хөтөлбөрөөр докторын, 15-аас доошгүй хөтөлбөрөөр магистрын сургалт эрхэлдэг байх;

6.4.2. үндсэн багшийн 50-иас доошгүй хувь нь докторын зэрэгтэй байх;

6.4.3. нийт багшийн 50-иас доошгүй хувь, ахисан түвшний суралцагчийн 40-өөс доошгүй хувь нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэдэг байх;

6.4.4. сургуулийн жилийн төсвийн 10-аас доошгүй хувийг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулдаг байх;

6.4.5. шинжлэх ухаан, технологийн чиглэлийн сургуулийн хэмжээнд гүйцэтгэдэг судалгаа, боловсруулалтын ажлын 10-аас доошгүй хувь нь өндөр технологи, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан эдийн засаг, нийгмийн тэргүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажил байх;

6.4.6. нийт эрдэм шинжилгээний бүтээлд олон улсын түвшинд хянагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн болон оюуны өмчийн гэрчилгээ, патент авсан бүтээлийн эзлэх хувь нь 3-аас доошгүй хувь байх;

6.4.7. ахисан түвшний сургалт хариуцсан нэгжтэй байх.

6.5. Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ахлах сургуультай байж болно.

6.6. Их сургууль нь эрүүл мэнд, мэдээлэл, харилцаа холбооны технологи, инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл, үйлдвэрлэл

боловсруулалт, архитектур ба барилга угсралт, салбар хоорондын инженерчлэл, цэрэг цагдаа, аюулгүй байдлын чиглэлээр дипломын сургалт эрхэлж болно.

7 дугаар зүйл. Дээд сургууль

7.1. Дээд сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулж, бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалтын байгууллага байна.

7.2. Хөгжим, урлагийн дээд сургуулийг консерватор гэнэ.

7.3. Дээд сургууль нь дараах шаардлагыг хангасан байна:

7.3.1. үндсэн багшийн 10-аас доошгүй хувь нь докторын зэрэгтэй байх;

7.3.2. бакалаврын хөтөлбөрийг магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш хөтлөн явуулдаг байх;

7.3.3. үндсэн багшийн 30-аас доошгүй хувь нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байх;

7.3.4. сургуулийн жилийн төсвийн 5-аас доошгүй хувийг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулдаг байх;

7.3.5. нийт эрдэм шинжилгээний бүтээлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн болон оюуны өмчийн гэрчилгээ, патент авсан бүтээлтэй байх.

7.4. Дээд сургууль нь харьяалалдаа коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай байж болно.

7.5. Консерватор нь дипломын сургалт эрхэлж болно.

8 дугаар зүйл. Коллеж

8.1. Коллеж нь дипломын сургалт эрхэлдэг сургалт, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

8.2. Коллеж нь дараах шаардлагыг хангасан байна:

8.2.1. үндсэн багш магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

8.2.2. үндсэн багшийн 25-аас доошгүй хувь нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байх;

8.2.3. үндсэн багшийн 30-аас доошгүй хувь нь зохион бүтээх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагаанд оролцдог байх.

8.3. Коллеж нь харьяалалдаа мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн байгууллага, ахлах сургуультай байж болно.

9 дүгээр зүйл.. Дээд боловсролын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах

9.1. Дээд боловсролын байгууллагыг Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу байгуулж, тусгай зөвшөөрөл олгоно.

9.2. Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

9.3. Төрийн бус өмчийн дээд боловсролын байгууллагын харьяа сургууль байгуулах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр, үүсгэн байгуулагч шийдвэрлэнэ.

9.4. Дээд боловсролын байгууллага татан буугдсан нөхцөлд суралцагчийг ижил мэргэжлийн сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг тухайн байгууллагын эцсийн эзэмшигч буюу үүсгэн байгуулагч болон удирдах зөвлөл нь дээд боловсролын бусад байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

9.5. Энэ хуулийн 9.4-д заасантай холбогдон гарах зардлыг татан буугдсан дээд боловсролын байгууллагын үүсгэн байгуулагч, эцсийн эзэмшигч нь хариуцна.

9.6. Татан буугдсан дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандаа баталсан шийдвэр, суралцагчийн хувийн хэрэг, мэдээлэл, төгсөгчийн дипломын хуулбар, сургалтын төлөвлөгөө зэрэг дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.

9.7. Татан буугдсан дээд боловсролын байгууллага төгсөлт хийгээгүй суралцагчийг өөр сургуульд шилжүүлэхдээ түүнийг сургуульд анх элсүүлсэн шийдвэр, судалсан багц цаг, сурлагын дүн, шалгалттай холбоотой материалыг шилжүүлсэн шийдвэрийн хамт шилжин суралцах сургуулийн захиргаанд хүлээлгэн өгнө.

10 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

10.1. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна.

10.2. Их, дээд сургуульд Эрдмийн зөвлөл, коллежид Сургалт, арга зүйн зөвлөл ажиллана.

10.3. Эрдмийн болон сургалт, арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн сургуулийн гүйцэтгэх удирдлага батална.

10.4. Их сургууль нь профессорын багтай байж болох ба профессорын багийн үйл ажиллагааг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

10.5. Төрийн өмчийн анагаах ухааны чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь их сургуулийн эмнэлэгтэй байна.

10.6. Төрийн бус өмчийн анагаах ухааны сургалттай их сургууль нь их сургуулийн эмнэлэгтэй байж болно.

10.7. Цэрэг, цагдаа, аюулгүй байдлын сургалттай их сургууль нь ахлах сургууль, консерватор нь бүрэн дунд сургуультай байж болно.

10.8. Дээд боловсролын байгууллагын харьяаллын сургууль нь хуулийн этгээд байх бөгөөд бие дааж магадлан итгэмжлэлд орно.

10.9. Цэрэг, цагдаа, аюулгүй байдлын сургалттай дээд боловсролын байгууллагад энэ хуулийн 10.8 дахь хэсэг хамаарахгүй.

10.10. Дээд боловсролын байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр орон нутагт салбар сургууль байгуулж болно.

10.11. Салбар сургууль нь тухайн сургуулийн үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлнэ.

10.12. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын хамтарсан шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт, эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл, дадлагын түшиц газар болгож болно.

10.13. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тухайн сургалтын байгууллагын дүрмээр тогтооно.

10.14. Дээд боловсролын байгууллага нь дотуур байртай байна.

10.15. Дээд боловсролын байгууллагад эмч, сэтгэл зүйч ажиллана.

11 дүгээр зүйл. Дээд боловсролын байгууллагын элсэлт

11.1. Их, дээд сургууль, коллежид бүрэн дунд буюу ахлах сургууль эзэмшсэн иргэнийг түүний мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээг харгалзан элсүүлнэ.

11.2. Дээд боловсролын байгууллага нь хөтөлбөр, мэргэжлийн онцлогоос хамаарч нэмэлт шалгалт зохион байгуулж болно.

11.3. Дээд боловсролын байгууллагад суралцагч элсүүлэх элсэлтийн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.4. Их, дээд сургууль, коллежийн дипломын болон бакалаврын түвшний элсэлтийн шалгалт нь энэ хуулийн 11.3-т заасан журмаар зохицуулагдах ба элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг харгалзана.

11.5. Ахисан түвшний хөтөлбөрт элсэн суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

11.6. Дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр үл харгалзан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

11.7. Мэргэжлийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн сургалтын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцож, элсэлтийн шаардлага хангасан төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулж болно.

12 дугаар зүйл. Чанарын баталгаажуулалт

12.1. Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагааны гүйцэтгэлийн болон чанарын удирдлагыг сайжруулах зорилготой, нээлттэй, бүх оролцогч талыг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа байна.

12.2. Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь дараах хэлбэртэй байна:

12.2.1. дотоод чанарын баталгаажуулалт;

12.2.2. хөндлөнгийн үнэлгээ;

12.2.3. магадлан итгэмжлэл.

12.3. Дээд боловсролын байгууллага нь өөрийн үнэлгээ, дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх замаар дотоод чанарын баталгаажуулалтыг хийнэ.

12.4. Хөндлөнгийн үнэлгээг Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, төр, эцэг эх, оюутан, хамтран ажиллагч түнш зэрэг дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд оролцогч талын хүсэлтээр үндэсний эсхүл олон улсын хэмжээний мэргэжлийн байгууллага, мэргэжлийн холбоо, төлөөллийн бусад байгууллага болон шинжээчид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу хийнэ.

12.5. Дээд боловсролын байгууллага нь өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний тайланд үндэслэж чанарын сайжруулалтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлнэ.

12.6. Чанарын сайжруулалтын төлөвлөгөө нь гүйцэтгэх удирдлагын үр дүнгийн гэрээний нэг хэсэг байх бөгөөд түүний ажлын үр дүнг хэмжих нэг үзүүлэлт нь чанарын ахиц дэвшил байна.

12.7. Магадлан итгэмжлэл нь дээд боловсролын байгууллага болон хөтөлбөрийн чанарт эрх бүхий байгууллага мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийх үйл явц юм.

12.8. Дээд боловсролын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг 5 жил тутам хийлгэнэ.

12.9. Дээд боловсролын Үндэсний зөвлөлөөс нэн шаардлагатай гэж тодорхойлсон мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөрийг заавал магадлан итгэмжлүүлнэ.

12.10. Хуульд өөрөөр заагаагүй бол дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрийн чанар, нийцлийг сайжруулах зорилгоор энэ хуулийн 12.8, 12.9-д зааснаас бусад тохиолдолд сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлж болно.

12.11. Шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө тухайн хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ.

12.12. Магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ,
НИЙГМИЙН БАТАЛГАА

13 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн эрх, үүрэг

13.1. Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй.

13.1.1. эрдэм шинжилгээ, судалгаа хийх;

13.1.2. бүтээлээ хэвлүүлэх;

13.1.3. докторантаар суралцах хугацаандаа бакалаврын хөтөлбөрт суралцагчдад хичээл заах;

13.1.4. хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэх;

13.1.5. дадлага хийх;

13.1.6. инновац, шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах, хөгжүүлэх;

13.1.7. гарааны компани байгуулах;

13.1.8. хичээлийн хөтөлбөр болон багшийг сонгох;

13.1.9. хуульд заасан бусад.

13.2. Суралцагч нь дараах үүрэгтэй:

13.2.1. хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмших, бие даан суралцах;

13.2.2. сургуулийн дотоод дүрэм, журмыг мөрдөх;

13.2.3. сургалтын төлбөрийг гэрээний дагуу төлөх;

13.2.4. хуульд заасан бусад.

14 дүгээр зүйл. Суралцагчийн нийгмийн баталгаа

14.1. Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд заасан нийгмийн баталгаанаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

14.1.1. стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хичээлийн байр, лаборатори, номын сан, нийтийн хоол, биеийн тамирын заал, талбайгаар үйлчлүүлэх;

14.1.2. сургалтын зээл авах;

14.1.3. суралцагчийн тэтгэлэгт хамрагдах;

14.1.4. хуульд заасан бусад.

15 дугаар зүйл. Суралцагчийн сургалтын үнэлгээ

15.1. Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.

15.2. Суралцагчийн сургалтын агуулгыг багц цагаар тооцно.

15.3. Сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, суралцаж буй мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг энэ хуулийн 15.2-т заасан багц цагт тооцож болно.

15.4. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.5. Магистрын хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар, докторын хамгаалуулах зөвлөлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмаар зохицуулна.

16 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш

16.1. Ахисан түвшний сургалтын хичээлийг докторын зэрэгтэй багш заана.

16.2. Дээд боловсролын сургалтын байгууллагад семинар, дадлага, лабораторийн хичээлийг тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх, дадлага, туршлагатай мэргэжилтэн удирдаж болно.

16.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь багшийн мэргэжил эзэмшээгүй бол заах арга зүйн сургалтад хамрагдана.

16.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлтэй байна.

17 дугаар зүйл. Багшийн эрх, үүрэг

17.1. Багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

17.1.1. эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл авах;

17.1.2. бүтээлийн чөлөө авах;

17.1.3. зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

17.1.4. эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, технологи, инновацийн бүтээгдэхүүн, оюуны өмчөө хамгаалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах;

17.2. Багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй:

17.2.1. мэргэжлээрээ нийгэмд үйлчлэх, соён гэгээрүүлэх, сурталчлах ажилд оролцох;

17.2.2. байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр чанарын баталгаажуулалт, сургалтын хөтөлбөрийн сайжруулалтад оролцох.

18 дугаар зүйл. Багшийн нийгмийн баталгаа

18.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь дараах нийгмийн баталгаагаар хангагдана.

18.1.1. өөрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд байгуулагдсан гарааны компанийн инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогоос хувь, ногдол ашиг хүртэх;

18.1.2. мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг авах;

18.1.3. судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх боломж, орчин, нөхцөлөөр хангагдах;

18.1.4. багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх харилцааг сургууль нь дотоод журмаар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГА

19 дүгээр зүйл. Сургалтын хөтөлбөр

19.1. Сургалтын хөтөлбөр нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна суралцах үр дүнд чиглэсэн байна.

19.2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, энэ хуулийн 19.2-т заасан нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

19.4. Сургалтын хөтөлбөрийг тухайн сургалтын байгууллага боловсруулж энэ хуулийн 10.2-д заасан зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэх удирдлага батална.

20 дугаар зүйл. Сургалтын хөтөлбөрийн агуулга

20.1. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь харилцан уялдаа холбоотой ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсэгтэй байна.

20.2. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дор дурдсан агуулгыг тусгана:

20.2.1. ерөнхий суурь хэсэгт дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил;

20.2.2. мэргэжлийн суурь хэсэгт суралцах чиглэлийн шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар олгох, бүтээлчээр сэтгэх, мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголт;

20.2.3. мэргэших хэсэгт тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, тухайн салбар, чиглэлийн шинжлэх ухаан, арга, технологи.

20.3. Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна.

20.4. Багц цагийн хэмжээ нь дипломын шатлалд 90 багц цагаас доошгүй, бакалаврын шатлалд 120 багц цагаас доошгүй, магистрын шатлалд 30 багц цагаас доошгүй, докторын шатлалд 60 багц цагаас доошгүй байна.

21 дүгээр зүйл. Сургалтын зохион байгуулалт

21.1. Дээд боловсролын байгууллага нь танхимын, танхимын бус, тэдгээрийн хосолсон хэлбэрээр сургалт зохион байгуулна.

21.2. Магистр, докторын сургалтын судалгаа, туршилтын ажлын зарим хэсгийг эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрийн лаборатори, дадлагажих газрыг түшиглэн явуулж болно.

21.3. Хичээлийн жилийн үргэлжлэх, дуусах болон шалгалтын хугацааг

сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулах бөгөөд хичээлийн жил нь улиралд хуваагдана.

21.4. Гамшгийн нөхцөл байдлыг харгалзан хичээлийн жилийн эхлэх, дуусах хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр тухайн дээд боловсролын сургалтын байгууллага тухай бүр өөрчилж болно.

22 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа

22.1. Дээд боловсролын байгууллага нь эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

22.2. Дээд боловсролын байгууллага нь эдийн засаг, нийгмийн тэргүүлэх чиглэлээр болон ахисан түвшний хөтөлбөрийн холбогдох чиглэлээр бие дааж болон хамтарсан төсөл хэрэгжүүлнэ.

22.3. Дээд боловсролын байгууллага нь оюуны өмчийг бүртгүүлэх, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах технологи дамжуулах бүтцийг бий болгож, их сургууль аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсэн тогтолцоог бүрдүүлсэн байна.

22.4. Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их сургууль нь өөрийн үндсэн бүтцэд эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт судалгааны, бизнес инкубацийн болон технологи дамжуулах төв, гарааны компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацийн кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжийг бие даан эсхүл хамтран байгуулж болно.

22.5. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн хүрээнд багш, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үнэлж, багшийн нэмэлт орлого олох, суралцагчийн сургалтын төлбөрийг хөнгөлөх эх үүсвэр болгон ашиглаж болно.

22.6. Суралцагчийг эрдэм шинжилгээний ур чадвараа хөгжүүлэх, гүнзгийрүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх профессорын багт ажиллуулж, хамтран ажиллах боломжоор хангана.

22.7. Хуулийн 22.4-т заасан нэгж нь удирдлага, санхүүгийн бие

даасан үйл ажиллагаа явуулах ба холбогдох журмыг Дээд боловсролын Үндэсний зөвлөлөөс баталсан нийтлэг журам, бусад хууль тогтоомжид нийцүүлэн тухайн сургуулийн удирдах зөвлөл батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

23 дугаар зүйл. Дээд боловсролын удирдлага

23.1. Дээд боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1. төрийн захиргааны бусад байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах;

23.1.2. төрийн захиргааны бусад байгууллага болон дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй санхүүгийн дэмжлэг олгох, суралцагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах;

23.1.3. төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийн гишүүдийг томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

23.1.4. судлаачид эрдмийн зэрэг олгох нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох.

24. Дээд боловсролын Үндэсний зөвлөл

24.1. Дээд боловсролын Үндэсний зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь улсын хөгжлийн бодлого болон дээд боловсролын хөгжлийн харилцан уялдааг хангах, дээд боловсролын бодлого, стратегийг хэрэгжүүлэх, дээд боловсролын салбарын эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжих, дээд боловсролын хөгжилд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангахад чиглэсэн асуудлаар зөвлөмж, шийдвэр гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

24.2. Зөвлөл нь төрийн төлөөлөл, дээд боловсролын байгууллагын удирдах зөвлөл, бизнесийн төлөөллөөс бүрдсэн 21 гишүүнтэй байх ба гишүүний бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байна.

24.3. Яам, агентлагийн болон орон нутгийн төрийн байгууллагын

төлөөлөл, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөллийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санал болгоно.

24.4. Дээд боловсролын байгууллагын Удирдах зөвлөлийн болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөллийг боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулна.

24.5. Бизнесийн төлөөллийг Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар сонгоно.

24.6. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

24.7. Зөвлөлийн дарга нь Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн байна.

24.8. Зөвлөл нь ажлаа Засгийн газарт тайлагнана.

24.9. Зөвлөл нь орон тооны ажлын алба, тухайн чиглэлийн дэд зөвлөлтэй байна. Ажлын алба, дэд зөвлөлийн үйл ажиллагааг журмаар зохицуулна.

24.10. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.10.1. улсын хөгжлийн дунд, урт хугацааны бодлого, дээд боловсрол, шинжлэх ухаан, нийгэм, эдийн засгийн салбарын харилцан уялдааг хангах;

24.10.2. улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулж элсэлтийн бодлогын асуудлаар санал, зөвлөмж гаргах;

24.10.3. дээд боловсролын салбарын дунд болон урт хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

24.10.4. дээд боловсролын байгууллагын зохистой бүтцийг судлан тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэх;

24.10.5. өөрийн гаргасан шийдвэр, санал, зөвлөмжийнхөө хэрэгжилтэд хяналт тавих, тайланг хэлэлцэн, дүгнэлт гаргах;

24.10.6. дээд боловсролын байгууллагын эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжиж, хамтарсан судалгаа,

төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр бий болгох, оновчтой хуваарилах, хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх;

24.10.7. дээд боловсролын байгууллагын Удирдах зөвлөлийн нийтлэг дүрмийг батлах;

24.10.8. дээд боловсролын байгууллагын чанарын тогтолцоонд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэх;

24.10.9. дээд боловсролын хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтын сан, эндаумент сан байгуулах, удирдах, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих нийтлэг журам батлах;

24.10.10. дээд боловсролтой холбогдох олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орох асуудлыг судалж шийдвэр гаргах;

24.10.11. дээд боловсролын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээлэл, илтгэл хэлэлцэх, тогтоол, зөвлөмж гаргах, чиглэл өгөх;

24.10.12. төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн бүтэц, хэмжээ, төлөвлөлтөд санал өгөх;

24.10.13. нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр судалгаа хийлгэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүнд үндэслэн холбогдох байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэх, шийдвэр гаргах;

24.10.14. шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлогыг дээд боловсролын хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах асуудлаар зөвлөмж, шийдвэр гаргах;

25 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагын Удирдах зөвлөл

25.1. Дээд боловсролын байгууллагын өөрийн удирдлага нь Удирдах зөвлөл байна.

25.2. Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, бизнесийн төлөөлөл, орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгчийн төлөөлөл ба хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

25.3. Удирдах зөвлөл нь 7-15 гишүүнээс бүрдэх бөгөөд үүний 51 ба түүнээс дээш хувь нь үүсгэн байгуулагчийн төлөөлөл байна.

25.4. Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн буюу төрийн төлөөллийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 жилийн хугацаатай томилно.

25.5. Энэ хуулийн 25.4-д заасан төрийн төлөөлөлд тухайн дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулна.

25.6. Багш, суралцагч, төгсөгч, бизнесийн болон орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл болон хараат бус гишүүдийг Удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу сонгон шалгаруулалтаар сонгоно.

25.7. Удирдах зөвлөлийн даргыг удирдах зөвлөлийн хурлаас олонхын саналаар сонгоно.

25.8. Удирдах зөвлөл нь энэ хуулийн 24.10.7-д заасан нийтлэг дүрэмд нийцүүлэн өөрийн дүрмийг батална.

25.9. Удирдах зөвлөлийн даргыг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон эсхүл өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

26 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн чиг үүрэг

26.1. Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.1.1. холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн дээд боловсролын байгууллагыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, хөтөлбөрийг батлах, өөрчлөх;

26.1.2. дээд боловсролын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, тухайн жилийн төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;

26.1.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив, тусламж авах журам тогтоох, зарцуулалтад хяналт тавих;

26.1.4. сургалтын төлбөр, оюутны үйлчилгээний зардал, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох;

26.1.5. дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

26.1.6. удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан,

сургуулийн үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлтийг үүсгэн байгуулагчид танилцуулах;

26.1.7. нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн дээд боловсролын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг 5 жилийн хугацаагаар томилж, гэрээ байгуулах, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.1.8. гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх, гэрээ дүгнэх журмыг батлах, өөрчлөх;

26.1.9. гүйцэтгэх удирдлагын гэрээг жил бүр дүгнэж, үр дүнд үндэслэн сунгах эсэхийг шийдвэрлэх;

26.1.10. гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг батлах, өөрчлөх;

26.1.11. дээд боловсролын үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;

26.2. Удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

26.3. Удирдах зөвлөл нь дэргэдээ дотоод хяналтын нэгж эсвэл мэргэжилтэнтэй байх ба холбогдох харилцааг Удирдах зөвлөлийн журмаар зохицуулна.

26.4. Элсэгчдийн тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох бусад стандартад нийцүүлэн сургуулийн Удирдах зөвлөл тогтооно.

27 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагын гүйцэтгэх удирдлага

27.1. Дээд боловсролын байгууллагын гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг дээд сургууль, коллежийн хувьд захирал /цаашид захирал гэх/, их сургуулийн хувьд ректор /цаашид ректор гэх/ хэрэгжүүлнэ.

27.2. Захирал, ректор нь сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, сургуулийн Удирдах зөвлөлд ажлаа тайлагнана.

27.3. Захирал, ректорыг гэрээний биелэлт, үр дүнд үндэслэн нэг удаа улираан томилж болно.

27.4. Цэрэг, цагдаа, аюулгүй байдлын дээд боловсролын

байгууллагын гүйцэтгэх удирдлагыг хууль зүй, дотоод хэргийн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлнө.

27.5. Энэ хуулийн 27.4-д зааснаас бусад гүйцэтгэх удирдлагыг үүрэгт ажлаас чөлөөлөх, гэрээг цуцлахтай холбогдох харилцааг Хөдөлмөрийн тухай болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

28 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг

28.1. Гүйцэтгэх удирдлага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

28.1.1. дээд боловсролын байгууллагыг улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, чиглэл, хөтөлбөрийг санаачлан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг хангах;

28.1.2. гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;

28.1.3. байгууллагын стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийн чанар, үр дүнг бүрэн хариуцах;

28.1.4. санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж, санхүү, төсвийг үр дүнтэй төлөвлөж зарцуулах;

28.1.5. сургуулийн хөгжлийг дэмжихэд үр нөлөөтэй, хөгжихүйн болон чадахуйн /мерит/ зарчмыг хангасан засаглал, менежментийг тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх;

28.1.6. хүний нөөцийг чадавхжуулах, өндөр мэдлэг ур чадвартай мэргэжилтнийг татан ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, ажиллагчдын нийгмийн баталгааг хангах;

28.1.7. дээд боловсролын байгууллагын чанарын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

28.1.8. багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад ажилтны орон тоо, цалингийн сүлжээг баталж, сонгон шалгаруулалтыг чадахуйн /мерит/ болон хөгжихүйн зарчимд үндэслэн явуулж, томилох;

28.1.9. гүйцэтгэх удирдлагын чиг үүрэгтэй холбоотой бусад харилцааг дүрмээр зохицуулна.

29 дүгээр зүйл. Дээд боловсролын байгууллагын чиг үүрэг

29.1. Дээд боловсролын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.1.1. дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр төрөөс болон удирдах зөвлөлөөс баталсан бодлого, стратеги төлөвлөгөө, дүрэм, журмыг чанартай хэрэгжүүлэх, тайлагнах;

29.1.2. сургуулийн дотоод үйл ажиллагаатай холбоотой журам, дүрэм батлан хэрэгжүүлэх;

29.1.3. сургалтын хөтөлбөр, агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэлийг тодорхойлж, чанартай хэрэгжүүлэх;

29.1.4. зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, оролцох;

29.1.5. элсэлт, төгсгөлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;

29.1.6. тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

29.1.7. багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, технологийн судалгаа хийх;

29.1.8. сургуулийн үйл ажиллагаа, сургалтад цахим технологи нэвтрүүлэх;

29.1.9. гадаад, дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах;

29.1.10. багш, ажилтан, суралцагчийг соён гэгээрүүлэх, олон нийтийн болон хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлэх;

29.1.11. багш, ажилтан, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;

29.1.12. амжилттай суралцаж, олон нийтийн болон хүмүүнлэгийн бүтээлч ажил гүйцэтгэсэн суралцагчид тухайн сургалтын байгууллага

тэтгэлэг олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг сургуулийн дүрэмд тусган хэрэгжүүлэх;

29.1.13. аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөр, амьжиргааны зардлын болон эрдэм шинжилгээ судалгааны ажлын дэмжлэг үзүүлэх;

29.1.14. статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ

30 дугаар зүйл. Дээд боловсролын санхүүжилт

30.1. Дээд боловсролын байгууллагын санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

30.1.1. үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;

30.1.2. олон улсын хөрөнгө оруулалтын сангуудаас татах хөгжлийн албан ёсны зээл тусламж, хандивын хөрөнгө;

30.1.3. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

30.1.4. их, дээд сургуулийн дэргэд байгуулсан гарааны компаниас орох орлого;

30.1.5. их сургуулийн эндаументийн сангийн хөрөнгө;

30.1.6. гадаад, дотоодын аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хандив, тусламжийн хөрөнгө;

30.1.7. технологи дамжуулалт, патент, ашигтай загвар, роялти, зөвлөх үйлчилгээнээс олсон орлого;

30.1.8. сургалтын төлбөр;

30.1.9. сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орох орлого;

30.1.10. хуульд заасан бусад эх үүсвэр.

30.2. Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад улсын төсвөөс дэмжлэг үзүүлж болно.

30.3. Энэ хуулийн 30.2-т заасан улсын төсвийн дэмжлэгийг дараах зориулалтаар зарцуулна:

30.3.1. дээд боловсролын салбарын талаар баримтлах чиглэл, стратегийн ач холбогдолтой хөтөлбөр хэрэгжүүлэх;

30.3.2. дээд боловсролын байгууллагын тусгай зориулалтын сангийн үйл ажиллагааг дэмжих;

30.3.3. төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа төрийн өмчийн суурь зардлыг санхүүжүүлэх;

30.4. Энэ хуулийн 30.1.1-30.1.3 болон 30.1.8-д зааснаас бусад эх үүсвэрээс бүрдсэн орлогыг сургуулийн хөгжил, багш, судлаачид, тухайн орлогыг бий болгоход оролцсон оролцогчдыг дэмжихэд зарцуулах бөгөөд сургуулийн удирдах зөвлөлөөс баталсан журмаар зохицуулна.

30.5. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд тухайн судалгаа, ажил үйлчилгээний онцлогоос хамааруулан нийт төсвийн 10 хүртэлх хувьтай тэнцэх байгууллагын зардлыг захиалагч талд нэмж тооцуулж болно.

31 дүгээр зүйл. Бие даасан санхүүгийн үйл ажиллагаа

31.1. Дээд боловсролын байгууллага нь санхүү, төсвийн хувьд бие даасан байдлаа хадгалах талаар дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

31.1.1. оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт, судалгааны бизнес инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн иж бүрдэл тогтолцоогоор байгуулан ажиллуулах;

31.1.2. судалгаа шинжилгээний үр дүн, инновац, оюуны өмчийг зах зээлийн эргэлтэд оруулах зорилгоор дэргэдээ гарааны компани, технологи дамжуулах төв байгуулж ажиллуулах;

31.1.3. хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах зорилгоор зээл авах;

31.1.4. сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орлого олох;

31.2. Дээд боловсролын байгууллага нь эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, нийгмийн баталгаатай холбогдох мэдээллийн цахим сантай байна.

31.3. Дээд боловсролын байгууллагын нууцад хамааруулснаас бусад мэдээлэл нь нээлттэй, ил тод байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

32 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

32.1. Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

33.1. Энэ хуулийн 6.4, 7.1, 7.3, 8.1, 8.2 дахь хэсгийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

33.2. Энэ хуулийг 2021 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Судалгааны их сургуулийг үүсгэн байгуулах, сургуулийн удирдлага, чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

2 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн зорилго

2.1. Монгол Улсын төрийн ивээлд эрдмийн эрх чөлөөг баталгаажуулж, эдийн засаг, нийгмийн хөгжил, шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлнэ.

2.2. Эрдэм шинжилгээ, судалгааны чадамжийг сайжруулж, мэдлэгт суурилсан нийгмийг манлайлах хүний нөөцийг бэлтгэнэ.

2.3. Эрдэмтэн судлаачдын оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, инновацийн соёлыг бүрдүүлнэ.

3 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

3.1. Судалгааны их сургуулийн (цаашид сургууль гэх) эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "эрдмийн эрх чөлөө" гэж багш, судлаач, оюутан нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хараат бус бие даан эрдэм шинжилгээ,

судалгааны ажил гүйцэтгэх, үр дүнгээ хэвлэн нийтлэхийг,

4.1.2. “мэдлэгт суурилсан эдийн засаг” гэж мэдлэгийг бий болгох, түгээх, ашиглах үйл ажиллагааг эдийн засгийн бүх салбарын өсөлт, хөгжилтийг хангах, баялгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болгон хэрэглэдэг эдийн засгийг;

4.1.3. “эрдэм шинжилгээний ажлын үр дүн” гэж шинжлэх ухааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ болон нэмэлт мэдлэг, техник технологийн шийдлийг.

5 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн зарчим

5.1. Судалгааны их сургуулийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. төрийн дэмжлэг нь ил тод, шударга, нээлттэй байх;

5.1.2. хамтын удирдлагатай бие даасан хараат бус байх;

5.1.3. эрдмийн эрх чөлөөг дээдлэх;

5.1.4. санхүүжилтийн тогтвортой эх үүсвэртэй байх;

5.1.5. шинжлэх ухааны нэгдмэл үнэт зүйлтэй байх;

5.1.6. судалгааны ёс зүйтэй байх;

5.1.7. инновацийн үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тэгш эрхтэй, чөлөөтэй оролцуулах;

5.1.8. үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх инновацийн үйл ажиллагаа явуулахгүй байх;

5.1.9. төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад эрдэм шинжилгээний ажил, түүний шалгаруулалт нь чөлөөт өрсөлдөөнд үндэслэсэн ил тод, шударга, нээлттэй байх;

5.1.10. сургалт, судалгааны үр дүн нь үйлдвэрлэгчийг дэмжсэн, эдийн засаг, нийгмийн өндөр үр ашигтай байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

6 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн хэлбэр

6.1. Сургууль нь эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэл, инновацийн байгууллага байна.

6.2. Сургууль нь Иргэний хуулийн 25.3-т заасан өмчийн хэлбэртэй байна.

7 дугаар зүйл. Судалгааны их сургуулийг бүртгэх

7.1. Судалгааны их сургууль оноосон нэртэй байна.

7.2. Сургуулийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин буй газар гэнэ.

7.3. Сургуулийг оршин байгаа газрын харьяаллын дагуу бүртгүүлнэ.

7.4. Сургуульд тавигдах шаардлага, холбогдох журмыг Дээд боловсролын үндэсний зөвлөл батална.

7.5. Судалгааны сургуулийг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгахтай холбоотой харилцааг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн чиг үүрэг

8.1. Сургууль нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. олон улс, бүс нутагт өрсөлдөхүйц шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд манлайлан оролцож, бодитой хувь нэмэр оруулна;

8.1.2. төрөөс баримталж буй хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлнэ;

8.1.3. шинэ мэдлэг бүтээх технологи үйлдвэрлэх, инноваци гаргах, хэрэглээнд нэвтрүүлэх, инновацийн эко-системийг бий болгож, шинэ мэдлэг бүтээж, үр өгөөжтэй технологи боловсруулна;

8.1.4. шилдэг профессор авьяаслаг оюутныг төвлөрүүлэх, олон улсад өрсөлдөх чадвартай хүний нөөцийг тасралтгүй бэлтгэнэ;

8.1.5. үйлдвэрлэлийн болон бусад оролцогчдын оролцоог дэмжсэн судалгааны бааз бүрдүүлэн инновацийн соёлыг хөгжүүлнэ;

8.1.6. судалгаанд суурилсан ахисан түвшний сургалт, судалгаа, үйлдвэрлэлийг интеграцид оруулах, дээд боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлнэ;

8.1.7. салбар дундын судалгааг хөгжүүлэх, нээлттэй дундын судалгааны дэд бүтцийг бий болгоно;

8.1.8. дэлхийн тэргүүлэх их сургуультай хамтран ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, ЧИГ ҮҮРЭГ

9 дүгээр зүйл. Судалгааны их сургуулийн удирдах зөвлөл

9.1. Сургуулийн өөрийн удирдлага нь Удирдах зөвлөл байна.

9.2. Удирдах зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

9.3. Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

9.4. Удирдах зөвлөлийн даргыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

10 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн хурал

10.1. Дарга нь удирдах зөвлөлийн хурлыг зарлана.

10.2. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Хурал нь гишүүдийн 75-аас доошгүй хувийн ирцтэй хуралдаж, олонхын саналаар шийдвэр гаргана.

10.3. Удирдах зөвлөлийн бусад харилцааг дүрмээр зохицуулна.

10.4. Төрийн бус өмчийн сургуулийн удирдах зөвлөлийн харилцааг дотоод журмаар зохицуулна.

11 дүгээр зүйл. Удирдах зөвлөлийн гишүүн

11.1. Удирдах зөвлөл нь дарга, 18 гишүүдээс бүрдэнэ.

11.2. Удирдах зөвлөл нь дараах төлөөлөлтэй байна:

11.2.1. их сургуулийн ректороос санал болгосон 1 гишүүн;

11.2.2. Монгол Улсын нийгэм эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон 4 гишүүн;

11.2.3. сургуулийн оршин буй орон нутгийн захиргааны байгууллагаас санал болгосон 1 гишүүн;

11.2.4. эрдмийн зөвлөлөөс санал болгосон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судлаач, профессорын төлөөлөл 5 гишүүн;

11.2.5. Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимаас

санал болгосон бизнесийн байгууллагын төлөөлөл 4 гишүүн;

11.2.6. их сургуулийн Үйлдвэрчний Эвлэлээс санал болгосон 1 гишүүн;

11.2.7. оюутны төлөөлөл 1 гишүүн;

11.2.8. төгсөгчийн төлөөлөл 1 гишүүн;

11.3. Энэ хуулийн 11.2.2-т заасан төрийн төлөөллийг Дээд боловсролын Үндэсний зөвлөлтэй зөвшилцөж боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

11.4. Энэ хуулийн 11.3-т зааснаас бусад гишүүнийг Удирдах зөвлөлийн баталсан сонгон шалгаруулалтын журмаар сонгоно.

12 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн чиг үүрэг

12.1. Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1. удирдах зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах;

12.1.2. холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сургуулийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлах;

12.1.3. бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх дүрэм, журмыг батлах;

12.1.4. санхүүжилтийн тогтвортой, олон эх үүсвэрийг бүрдүүлэх дүрэм, журмыг батлах;

12.1.5. судалгаанд суурилсан ахисан түвшний сургалт, эрдэм судлал, үйлдвэрлэлийг бүсчлэх, дээд боловсрол, шинжлэх ухаан, бизнесийн түншлэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12.1.6. ректорыг томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

12.1.7. ректорын ажлын үр дүнг үнэлэх, гэрээ дүгнэх журмыг батлах;

12.1.8. сургуулийн бүтэц батлах;

12.1.9. тухайн жилийн төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;

12.1.10. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж, хөрөнгө оруулалтын зарцуулалтад хяналт тавих;

12.1.11. сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох;

12.1.12. сургуулийн үйл ажиллагааны тайланг жилд 2-оос доошгүй удаа хэлэлцэж дүгнэлт өгөх;

12.1.13. удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар үүсгэн байгуулагчид тайлагнах.

12.2. Удирдах зөвлөлийн бусад чиг үүргийг дүрмээр зохицуулна.

13 дугаар зүйл. Аудитор

13.1. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс нэг аудитор, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс нэг аудиторыг санал болгосныг удирдах зөвлөлөөс томилно.

13.2. Аудиторын бүрэн эрхийн хугацаа 2 жил байх ба энэ хугацааг өөрчлөхгүй.

13.3. Аудитор нь хяналт, шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил, хууль бус ажиллагааны талаар Удирдах зөвлөл, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлж, удирдах зөвлөлийг хуралдах санал гаргана.

13.4. Аудитор нь удирдах зөвлөлийн дэргэд ажиллах ба холбогдох харилцааг журмаар зохицуулна.

14 дүгээр зүйл. Эрдмийн зөвлөл

14.1. Сургуулийн мэргэжлийн ажлын удирдлага нь Эрдмийн зөвлөл байна.

14.2. Эрдмийн зөвлөл нь 21-ээс доошгүй гишүүнээс бүрдэнэ.

15 дугаар зүйл. Эрдмийн зөвлөлийн чиг үүрэг

15.1. Эрдмийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1. улс орны, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, судалгааны чиглэлийг тогтоох;

15.1.2. судалгааны багийг бүрдүүлэх;

15.1.3. сургуулийн дэд профессор, профессорын цол олгох;

- 15.1.4. судалгааны бодлого боловсруулах;
- 15.1.5. ахисан түвшний сургалт судалгааны үйл явцыг хянах;
- 15.1.6. судалгааны төслийн нэгдсэн санг бүрдүүлэх;
- 15.1.7. дундын судалгааны лабораторийн баазын хамтын үйл ажиллагааг дэмжих;
- 15.1.8. судалгааны ажлын чанар, үр дүнг тодорхойлох;
- 15.1.9. судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжих;
- 15.1.10. дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратегийг боловсруулах;
- 15.1.11. сургалт, судалгааны чанарыг сайжруулахтай холбоотой асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргах;
- 15.1.12. судалгааны санхүүжилтийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

15.2. Эрдмийн зөвлөлийн бусад чиг үүргийг дүрмээр зохицуулна.

16 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн гүйцэтгэх удирдлага

16.1. Сургуулийн гүйцэтгэх удирдлагыг ректор хэрэгжүүлнэ.

16.2. Ректорыг 5 жилийн хугацаагаар томилно.

17 дугаар зүйл. Ректорыг сонгох

17.1. Ректорыг сонгон шалгаруулах хорооноос санал болгосон 3-аас доошгүй нэр дэвшигчийн дотроос Удирдах зөвлөл томилно.

17.2. Ректорыг сонгон шалгаруулах хороо нь удирдах болон эрдмийн зөвлөлийн 7-оос доошгүй гишүүнээс бүрдэнэ.

17.3. Хороог үүсгэн байгуулах, сонгон шалгаруулахтай холбоотой бусад харилцааг дүрмээр зохицуулна.

17.4. Ректор нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:

- 17.4.1. хүний эрх, эрх чөлөө, эрхэм оршихуйг хүндэтгэдэг байх;
- 17.4.2. үнэнч, шударга, зарчимч, ёс журмыг сахин биелүүлдэг байх;
- 17.4.3. удирдахуйн арга ухааныг эзэмшсэн манлайлагч байх;
- 17.4.4. шинжлэх ухаан, дээд боловсролын салбарын удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй байх;

17.4.5. олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл туурвисан байх;

17.4.6. дэлхийн шилдэг их сургуульд ажиллаж, туршлага судалсан байх;

17.4.7. сургалт судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах менежерийн ур чадвартай байх.

18 дугаар зүйл. Проректор

18.1. Ректорт дэмжин туслах үүрэг бүхий проректортой байна.

18.2. Проректорыг удирдах зөвлөлтэй зөвшилцөж томилно.

18.3. Проректорын орон тоо, томилох журам, тавигдах шаардлага, чиг үүргийг дүрмээр зохицуулна.

19 дүгээр зүйл. Ректорын чиг үүрэг

19.1. Ректор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1. төрийн бодлогод нийцүүлж сургууль хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, чиглэл, хөтөлбөрийг санаачлан удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг хангах;

19.1.2. сургуулийн гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах;

19.1.3. сургуулийн стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийн чанар үр дүнг хариуцах;

19.1.4. санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж, төсвийг төлөвлөх;

19.1.5. өндөр мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

19.1.6. багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан бусад ажилтны орон тоог тогтоох, цалингийн сүлжээг батлах;

19.1.7. батлагдсан орон тоонд сонгон шалгаруулалтыг чадахуйн болон хөгжихүйн зарчимд үндэслэж томилох.

19.2. Ректорын бусад чиг үүргийг дүрмээр зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ

20 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн санхүүжилтийн эх үүсвэр

20.1. Сургууль нь Дээд боловсролын тухай хуульд зааснаас гадна дараах эх үүсвэрээс санхүүжнэ:

20.1.1. гадаад, дотоодын зээл тусламж, хандив;

20.1.2. инновацийн грант;

20.1.3. эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнгээс олсон орлого;

20.1.4. олон улсын төслийн орлого;

20.1.5. хуульд заасан бусад эх үүсвэр.

20.2. Сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт тогтвортой, үр дүнд чиглэсэн байна.

20.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх судалгаа, эрдэм шинжилгээний ажил, төсөл хөтөлбөрийг Засгийн газрын захиалгаар тогтмол хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл. Судалгааны их сургуулийн санхүүгийн дэмжлэг

21.1. Төрөөс судалгааны их сургуульд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

22 дугаар зүйл. Хөрөнгийн удирдлага

22.1. Сургуулийн хөрөнгийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

22.2. Төр, орон нутгийн захиргаанаас шилжүүлсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

22.3. Энэ зүйлийн 22.2 дахь хэсэгт зааснаас бусад хөрөнгийг сургуулийн дүрмээр зохицуулна.

22.4. Сургуульд хэрэгжүүлэх судалгааны төсөлд үндсэн зардлаас гадна байгууллагын нэмэгдэх зардлыг гэрээгээр зохицуулна.

22.6. Судалгаа, эрдэм шинжилгээний ажил, төслөөс олсон орлогын тодорхой хэсгийг багш, оюутны судалгаанд зарцуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1. Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

24.1. Энэ хуулийг 2021 оны...дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тогтолцоо, түншлэл, санхүүжилт, уг харилцаанд оролцогчдын эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж

2.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “чадамжид суурилсан сургалт” гэж ажил, мэргэжлийн стандартад тодорхойлсон чадамж эзэмшихэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг;

3.1.2. “чадамж” гэж мэдлэг, ур чадвар, хандлагын цогцыг;

3.1.3. “чадамжийн нэгж” гэж тодорхой ажил, мэргэжлийн чадамж эзэмшихэд чиглэсэн харилцан уялдаа бүхий сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүнийг;

3.1.4. “мэргэшил” гэж хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ахисан түвшний чадамжийг;

3.1.5. "мэргэшлийн түвшин" гэж ажил мэргэжлийн стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг;

3.1.6. "мэргэжлийн сургалт" гэж хувь хүний хэрэгцээнд нийцсэн эсхүл хөдөлмөр эрхлэхэд шаардагдах чадамжийг богино хугацаанд эзэмших сургалтыг;

3.1.7. "мэргэжлийн боловсрол" гэж мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж эзэмших боловсролын түвшинг;

3.1.8. "техникийн боловсрол" гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж эзэмших боловсролын түвшинг;

3.1.9. "мэргэшүүлэх сургалт" гэж иргэнийг мэргэжлийн чиглэлээр давтан сургах, мэргэшлийн түвшин ахиулах богино хугацааны сургалтыг;

3.1.10. "хосмог сургалт" гэж сургалтын байгууллага болон үйлдвэрлэлийн орчин, ажлын байранд сургалтыг хослуулан зохион байгуулахыг;

3.1.11. "өмнө эзэмшсэн мэдлэг" гэж иргэн албан бус боловсрол эсвэл амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, ур чадварыг.

4 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго

4.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь иргэн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, чадамж, мэргэжил эзэмших, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино.

5 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын бодлого, үйл ажиллагаанд Боловсролын тухай хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн байх

5.1.2. шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан байх;

5.1.3. сургалт нь уян хатан байх;

5.1.4. нийгмийн түншлэлд суурилсан байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН АГУУЛГА, ХӨТӨЛБӨР, СТАНДАРТ

6 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын агуулга, хөтөлбөр

6.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын агуулга нь энэ хуулийн 4.1-д заасан зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

6.2. Мэргэжлийн боловсролын агуулгыг суралцагчид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах чадамж, бие даан ажил хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлж, мэргэжил олгох чиглэлээр тогтооно.

6.3. Техникийн боловсролын агуулгыг суралцагчид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, техник, технологийн үйл ажиллагааг удирдах, гүйцэтгэх чадамж, бие даан ажил хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлж, мэргэжил олгох чиглэлээр тогтооно.

6.4. Мэргэжлийн сургалтын агуулгыг суралцагчид мэргэшлийн түвшний ур чадвар, чадамжийг эзэмшүүлэх, мэргэшлийн түвшин ахиулах чиглэлээр тогтооно.

6.5. Мэргэжлийн болон техникийн боловсролын агуулгыг багц цагаар хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ.

6.6. Багц цаг тооцох, дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.7. Энэ хуулийн 6.2, 6.3, 6.4-д заасан агуулгыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

6.8. Сургалтын хөтөлбөрийг ажил олгогчийн оролцоог хангаж ажил, мэргэжлийн стандартад нийцүүлэн энэ хуулийн 9.1-д заасан сургалтын байгууллага боловсруулна.

6.9. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр нь ерөнхий болон мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсэгтэй байна.

6.10. Сургалтын байгууллага нь суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинд харгалзан энэ хуулийн 6.7-д заасан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж болно.

6.11. Энэ хуулийн 6.7-д заасан сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.12. Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.13. Мэргэжлийн болон техникийн боловсролд ижил түвшний олон улсын болон хамтарсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

6.14. Энэ хуулийн 6.13-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тусгай зөвшөөрөл олгоно.

7 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын стандарт

7.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын стандарт нь Боловсролын тухай хуулийн 11.2-д зааснаас гадна мэргэжлийн болон техникийн боловсролын үнэлгээнд тавигдах шаардлагыг тодорхойлно.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага батална.

8 дугаар зүйл. Үнэлгээ

8.1. Суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.2. Хүний мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 17.4-т заасны дагуу хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага

9.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын болон мэргэжлийн сургалтын гэсэн түвшинтэй байна.

9.2. Техникийн боловсролын сургалтын байгууллага нь политехник коллеж байна.

9.3. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн боловсролын сургууль байна.

9.4. Мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын төв байна.

9.5. Политехник коллеж нь мэргэжлийн боловсролын, мэргэжлийн сургалтын болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

9.6. Мэргэжлийн боловсролын сургууль нь мэргэжлийн сургалтын болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

9.7. Мэргэжлийн сургалтын төв нь мэргэжлийн анхан шатны ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалтыг эрхэлнэ.

9.8. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тухайн сургалтын байгууллагын дүрмээр тогтооно.

9.9. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хүн амын төвлөрөл, бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн төрөлжүүлж болно.

9.10. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь сургалт, үйлдвэрлэлийн цогцолбор, хотхоны зохион байгуулалттай байж болно.

9.11. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын нэгж нь тэнхим, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7.1-д заасан төв байна.

9.12. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь харьяандаа чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, бизнес инкубатор төв, аж ахуйтай байж болно.

9.13. Техникийн боловсролын сургалтын байгууллага нь харьяандаа гарааны компанитай байж болно.

9.14. Энэ хуулийн 9.12-т заасан дадлагын баазад тавих нийтлэг шаардлагыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.15. Энэ хуулийн 9.12-т заасан төв, бааз, аж ахуй нь өөрийн үйл ажиллагаанаас орлого олж болно.

9.16. Энэ хуулийн 9.1-д заасан сургалтын байгууллага нь суралцагчид сургалтад ашиглах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглуулна.

10 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чиг үүрэг

10.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1. мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;

10.1.2. элсэлт, төгсөлтийг чанартай зохион байгуулах;

10.1.3. байгууллагаар дамжуулан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, судалгаа хийх;

10.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

10.1.5. албан бус боловсрол болон амьдралын орчноос хүний бие даан эзэмшсэн мэдлэг, ур чадвар чадамжийг үнэлэх;

10.1.6. өөрийн үйл ажиллагаанаас гадна Төсвийн тухай хуулийн 44.1-д заасан туслах үйл ажиллагаанаас орлого олох;

10.1.7. туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох өөрийн орлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулах;

10.1.8. гадаад, дотоодын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу гэрээ хэлэлцээр байгуулах;

10.1.9. иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшил болон ур чадвараа дээшлүүлэхэд туслах /дэмжлэх үзүүлэх/;

10.1.10. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн сургалтын орчин бүрдүүлэх;

10.1.11. хуульд заасан бусад.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ, ЭЛСЭЛТ, ТӨГСӨЛТ

11 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт

11.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь онолын, сургууль дээрх дадлага, үйлдвэрлэлийн дадлага гэсэн бүрэлдэхүүнтэй, сургалтын байгууллага болон ажлын байран дахь, хосмог, зайны болон цахим сургалтын хэлбэртэй байна.

11.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавих шаардлага, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3. Хосмог сургалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1, 63.2, 63.3 дахь заалтад үндэслэн зохион байгуулна.

11.4. Мэргэжлийн болон техникийн боловсролын хичээлийн жилийн эхлэх, дуусах үргэлжлэх хугацаа, зохион байгуулалтыг сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулна. Тухайн салбар, мэргэжлийн онцлогоос хамаарч уян хатан зохицуулалт хийж болно.

11.5. Мэргэжлийн сургалтын байгууллагад тавих шаардлагыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.6. Мэргэжлийн сургалтын байгууллагын үйл ажиллагаанд Боловсролын тухай хуулийн 17.2-д заасан орон нутаг дахь насан туршийн байгууллага хяналт тавьж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

11.7. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 11.6-д заасан байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

12 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын элсэлт, төгсөлт

12.1. Техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт бүрэн дунд болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн хүнийг элсүүлнэ.

12.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрт суурь боловсрол

эзэмшсэн эсхүл насанд хүрсэн хүнийг элсүүлнэ.

12.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12.7-д заасныг баримтална.

12.5. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх тэргүүлэх мэргэжлийн чиглэлийг энэ хуулийн 22.1-д заасан Үндэсний зөвлөл батална.

12.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн төгсөлтийн нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.7. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бие даан ажил хөдөлмөр эрхлэх, бизнесээ хөгжүүлэхийг дэмжиж төрөөс хөнгөлөлттэй зээл олгож болно.

12.8. Энэ хуулийн 12.7-д заасан зээл олгох журмыг Засгийн газар батална.

13 дугаар зүйл. Боловсролын баримт бичиг

13.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг эзэмшсэн иргэнд дараах боловсролын баримт бичгийг олгоно:

13.1.1. мэргэжлийн сургалтад хамрагдаж чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээ;

13.1.2. мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчид мэргэжлийн үнэмлэх;

13.1.3. техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчид диплом.

13.2. Иргэний албан бус боловсрол, амьдралын орчинд суралцаж эзэмшсэн чадамжийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 13.1.1, 13.1.2-т заасан боловсролын баримт бичгийг олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН
ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД

14 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, түүнд тавих шаардлага

14.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуульд зааснаас гадна сургалтын байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд оролцох, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

14.2. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нь тухайн мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, мэргэшлийн өндөр ур чадвартай, багшлах эрхтэй байна.

14.3. Техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь тухайн мэргэжлийн чиглэлээр магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, мэргэшлийн дээд түвшний чадамжтай, багшлах эрхтэй байна.

15 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн эрх, үүрэг

15.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш Боловсролын тухай хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

15.1.1. өөрийн судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээл, бүтээгдэхүүний орлогоос хувь, ногдол ашиг хүртэх;

15.1.2. түншлэгч байгууллага, иргэн, ажил олгогчид зөвлөгөө өгөх;

15.1.3. үйлдвэрлэлийн орчинд дадлага хийх;

15.1.4. хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинд ажиллах, сургалт зохион байгуулах;

15.1.5. бусдад шилдэг туршлагаа түгээн дэлгэрүүлэх;

15.1.6. ажлын гүйцэтгэл, үр дүнгээ үнэлүүлэх;

15.1.7. ажил мэргэжлийн стандарт боловсруулахад оролцох.

15.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараах үүрэгтэй:

15.2.1. инноваци, шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтад нэвтрүүлэх, сургалтын идэвхтэй, шинэлэг арга зүйг үр өгөөжтэй ашиглах;

15.2.2. суралцагчийн мэдлэг, ур чадварыг оношилж, чадамжийн түвшинд үндэслэн сургалтыг уян хатан зохион байгуулах;

15.2.3. сургалтын хөтөлбөрийг боловсруулах, нэгж хичээлийн төлөвлөлт хийх, дадлага сургалтын удирдамж боловсруулах, шинэчлэх, сургалтад ашиглах;

15.2.4. суралцагчийг сургалтын явц, анги дэвших болон сургууль төгсөхөд нь тус тус үнэлэх;

15.2.5. үйлдвэрлэлийн дадлагыг удирдах багш нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.2.5-д заасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;

15.2.6. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3.4, 6.3.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх.

16 дугаар зүйл. Багш, ажилтны нийгмийн баталгаа

16.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д зааснаас гадна доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

16.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.9-д заасан хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангагдах;

16.1.2. мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.

17 дугаар зүйл. Суралцагчийн эрх, үүрэг

17.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын

байгууллагын суралцагч Боловсролын тухай хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

17.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл хангагдсан орчинд суралцах

17.1.2. сургалтын техник, тоног төхөөрөмж, багаж, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, түүхий эд материалаар хангагдах;

17.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.9-д заасан хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангагдах;

17.1.4. үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад үйлдвэрлэлийн дадлага хийхэд Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу цалин хөлсөөр хангагдах;

17.1.5. хосмог болон ажлын байран дээрх сургалтад суралцагч Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын цагаас хэтрүүлэн ажиллахгүй байх.

17.1.6. Боловсролын тухай хуулийн 11.4-т заасан тэтгэлэг авах;

17.1.7. мэргэжлийн ур чадварын уралдаан, тэмцээнд оролцох;

17.1.8. сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдох;

17.1.9. хуульд заасан бусад.

17.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 10.2-т зааснаас гадна доор дурдсан үүрэгтэй:

17.2.1. сургалтын байгууллагын орчинд хийх дадлагын үед байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг баримтлах;

17.2.2. мэргэжлийн онцлогоос шалтгаалан эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдах;

17.2.3. үйлдвэрлэлийн дадлагын үед аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг баримтлах;

17.2.4. сургалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглалтын зааврын дагуу ашиглах;

17.2.5. үйлдвэрлэлийн дадлагын явцад суралцагч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.2.5-д заасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх

18 дугаар зүйл. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг

18.1. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Боловсролын тухай хуулийн 45 дугаар зүйлд зааснаас гадна үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулахад санал өгөх эрхтэй.

18.2. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Боловсролын тухай хуулийн 45.2-т зааснаас гадна доор дурдсан үүрэгтэй:

18.2.1. хүүхдийнхээ суралцах, мэргэжил эзэмших үйл ажиллагааг дэмжих;

18.2.2. ур чадварын уралдаан, тэмцээнд дэмжлэг үзүүлэх;

18.2.3. хүүхдээ гэмт хэрэг зөрчил, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр багш, ажилтантай хамтран ажиллах;

18.2.4. хүүхдийнхээ авьяас, мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх

18.2.5. хууль тогтоомжид заасан бусад.

19 дугаар зүйл. Түншлэгч аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

19.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг сонирхогч талууд нийгмийн түншлэлийг бүрдүүлж зөвлөлийн хэлбэрээр дор дурдсан түвшинд ажиллана:

19.1.1. салбарын түвшний нийгмийн түншлэлийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогч, эцэг, эхийн төлөөлөл бүрдүүлэх;

19.1.2. орон нутгийн нийгмийн түншлэлийг нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод бүрдүүлэх;

19.1.3. сургалтын байгууллагын нийгмийн түншлэлийг аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, суралцагч бүрдүүлэх.

19.2. Түншлэгч аж ахуйн нэгж, байгууллага дараах эрхтэй:

19.2.1. сургалт, үнэлгээний стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахад оролцох, сайжруулах талаар санал өгөх;

19.2.2. үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн үнэлгээг зохион байгуулахад хамтран ажиллах;

19.2.3. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд төлөөлөл оролцуулах;

19.2.4. иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилтны мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, ур чадвар, чадамж эзэмшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах;

19.2.5. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийн талаар санал дүгнэлт гаргах;

19.2.6. иргэний хүсэл сонирхол, чадавх, боломжид нийцүүлэн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх.

19.3. Түншлэгч аж ахуйн нэгж, байгууллага дараах чиг үүрэгтэй:

19.3.1. түншлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэлд суурилсан, чанартай, хүртээмжтэй гүйцэтгэх;

19.3.2. түншлэлийн хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

19.3.3. өөрийн болон түншлэлд оролцогч байгууллагын чадавхыг бэхжүүлэх;

19.3.4. мэргэжилтэй ажилтны тоо, мэргэжлийн чиглэл, ур чадвар, чадамжийн шаардлага, мэргэшлийн түвшин ахиулах сургалт, өмнө эзэмшсэн мэдлэг ур чадварын үнэлгээний хүсэлтийг төлөөллийн байгууллагаар дамжуулан боловсролын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх;

19.3.5. үйлдвэрлэлийн дадлагыг Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1, 63.2, 63.3 дугаар зүйлд заасан гурван талт гэрээ, дадлагын удирдамжийн дагуу зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, үр дүнг хамтран дүгнэх;

19.3.6. үйлдвэрлэлийн дадлага сургалтыг хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд удирдамж, хөтөлбөрт тусгасан чадамжийг эзэмшүүлэх, дадлагын явцад суралцагчийн оролцоог хангах, хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулах;

19.3.7. дадлага сургалтыг үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшаар удирдуулах;

19.3.8. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад шаардлагатай орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материалын нөөцөөр хангахад дэмжлэг үзүүлэх;

19.3.9. үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг зохион байгуулах, мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэх дадлагажуулагч инженер-техникийн ажилтан ажиллуулах;

19.3.10. техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хийх, инновацийг сургалтын байгууллагатай хамтран хөгжүүлэх;

19.3.11. багш, инженер-техникийн ажилтны мэдлэг, чадварыг хөгжүүлэх, шинэ техник технологи дээр дадлагажуулахад дэмжлэг үзүүлэх;

19.3.12. сургалтын байгууллагыг бэхжүүлэх, сургалтын орчин бүрдүүлэх, шинэчлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

19.3.13. дагалдан суралцагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш цалин хөлсийг олгох.

20 дугаар зүйл. Мэдээллийн сан

20.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн сан бий болгох, ашиглах, аюулгүй байдлыг хангах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

20.2.1. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны мэдээлэл;

20.2.2. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлага, үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

20.2.3. түншлэгч аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН
УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

21 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын удирдлага

22 дугаар зүйл. Үндэсний зөвлөл, түүний чиг үүрэг

22.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг дэмжих, сургалтад төр хувийн хэвшлийн оролцоог хангах асуудлаар тогтоол, дүгнэлт гаргах, зөвлөмж, чиглэл өгөх үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөл байна.

22.2. Үндэсний зөвлөл нь төрийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, ажил олгогчийн хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

22.3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг доор дурдсан байгууллагын санал болгосноор Засгийн газар батална:

22.3.1. төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, төрийн өмчийн болон хувийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөллийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн.

22.3.2. ажил олгогч, мэргэжлийн холбоодын төлөөллийг тэдний эрх ашгийг албан ёсоор төлөөлөх байгууллага

22.4. Үндэсний зөвлөлийн дарга нь Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна

22.5. Үндэсний зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална

22.6. Зөвлөл нь ажлаа Засгийн газарт тайлагнана.

22.7. Энэ хуулийн 30.3-д заасан дэмжих сангийн улирлын болон жилийн жилийн тайланг хянан хэлэлцэх.

22.8. Энэ хуулийн 22.1-д заасан Үндэсний зөвлөл ажлын албатай байх бөгөөд ажлын албаны чиг үүргийг Дээд боловсролын тухай хуулийн ...-д заасан Үндэсний зөвлөлийн ажлын алба гүйцэтгэнэ.

22.9. Энэ хуулийн 22.1-д Үндэсний зөвлөл доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.9.1. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

22.9.2. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах;

22.9.3. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

22.9.4. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг дэмжих санд аж ахуйн нэгж, байгууллагаас үзүүлж болох санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг салбарын онцлогт нийцүүлэн тогтоох;

22.9.5. хуульд заасан бусад эрх.

23 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

23.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь боловсролын ерөнхий хуулийн 29.1-д зааснаас дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох;

23.1.2. мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг Санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах;

23.1.3. хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах журмыг боловсруулах, батлах;

23.1.4. хосмог сургалт, ажлын байран дахь сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох;

23.1.5. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтан, багшийг нэгдсэн бодлогоор хангах;

23.1.6. мэргэжлийн боловсрол, сургалтын тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг боловсруулж батлуулах;

24 дүгээр зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

24.1. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцүүлэх, сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

24.1.2. мэргэжлийн зөвлөл, холбоод, салбар зөвлөлтэй хамтран ажиллах, түншлэлийг бэхжүүлэх;

24.1.3. гадаад улсын болон олон улсын ижил төрлийн сургалтын хөтөлбөрөөр төгсөгч, суралцагч Монгол Улсын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцах тохиолдолд боловсролын баримт бичгийг дүйцүүлэх ажлыг зохион байгуулах;

24.1.4. мэргэжлийн сургалтын байгууллагыг арга зүй, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх.

24.1.5. мэргэжлийн сургалтын төгсөгч, өмнө эзэмшсэн мэдлэг ур чадварын үнэлгээгээр чадамж нь баталгаажсан хүнд чадамжийн гэрчилгээ олгоно.

24.1.6. хуульд заасан бусад чиг үүрэг.

25 дугаар зүйл. Судалгаа, арга зүйн төв

25.1. Судалгаа арга зүйн төв нь Боловсролын тухай хуулийн 16.1-д заасан Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын харьяанд үйл ажиллагаа эрхлэх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1. тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сургалт, судалгаа шинжилгээ хийх, зөвлөгөө, мэдээллээр хангах;

25.1.2. сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах судалгаа хийх;

25.1.3. сургалтын агуулгын хүндрэлийн түвшинг тогтоох

25.1.4. хосмог, ажлын байран дахь, зайн болон цахим сургалтыг хөгжүүлэх;

25.1.5. иргэн, аж ахуйн нэгж, сургалтын байгууллагыг арга зүй удирдлагаар хангах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

25.1.6. энэ хуулийн 7.1-д заасан стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

25.1.7. эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, инноваци хөгжүүлэх, онол практикийн хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах;

25.1.8. судалгаа, эрдэм шинжилгээний ажлын сан бүрдүүлэх, шинэ бүтээлийг патентжуулахад дэмжлэг үзүүлэх;

25.1.9. мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, сунгах сургалт, үнэлгээг салбарын төлөөлөл мэргэжлийн зөвлөл, холбоодтой хамтран зохион байгуулах;

25.1.10. хууль тогтоомжид заасан бусад.

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан байгууллагын дүрэм, бүтэц орон тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага

26.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрмийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан нийтлэг дүрмийг үндэслэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.

26.3. Цогцолбор, хотхон бүхий мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нэгдсэн удирдах зөвлөлтэй байж болно.

26.4. Удирдах зөвлөл нь есөн гишүүнээс бүрдэх бөгөөд үүсгэн байгуулагчийг төлөөлөх нэг, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх хоёр, түншлэгчийг төлөөлөх тав, төгсөгчийг төлөөлөх нэг гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5. Удирдах зөвлөл нь дараах эрхтэй байна:

26.5.1. сургалтын, судалгаа шинжилгээний, үйлдвэрлэлийн болон үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг тогтоох;

26.5.2. сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, сургалтын үр дүн, чанар гүйцэтгэлийг хэлэлцэх, дүгнэх.

26.6. Удирдах зөвлөл нь дараах үүрэгтэй байна:

26.6.1. сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, сургуулийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, дүгнэх;

26.6.2. энэ хууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалттай холбоотой стандарт, заавар, дүрэм, журам, эрх зүйн актыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагыг хөгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

26.6.3. аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог дэмжих, түншлэлийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

26.6.4. хандив, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, зарцуулалтад хяналт тавих.

27 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага

27.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг захирал хэрэгжүүлнэ.

27.2. Захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

27.2.1. бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

27.2.2. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага эсхүл үйлдвэрлэлийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс тухайн салбарт сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгчээр 4-өөс доошгүй жил ажилласан туршлагатай байх.

27.3. Энэ хуулийн 27.2.2-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд томилгоо хийхийг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцно.

27.4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг таван жилийн хугацаагаар томилох бөгөөд ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн, удирдах ажилтны манлайлал, хариуцлага, ёс зүйтэй байдлыг харгалзан дахин нэг удаа улируулан томилж болно.

27.5. Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын захирал дараах чиг үүрэгтэй:

27.5.1. сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

27.5.2. иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

27.5.3. нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог дэмжих;

27.5.4. гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;

27.5.5. батлагдсан төсөв, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогыг үр ашигтай зарцуулах;

27.5.6. хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, статистикийн мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

27.5.7. сургалтын төлөвлөгөө батлах;

27.5.8. төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах;

27.5.9. сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах орчин нөхцөл, материаллаг нөөцөөр хангах ажлыг удирдан зохион байгуулах;

27.5.10. удирдах ажилтны манлайлал, ёс зүйг хангаж ажиллах;

27.5.11. холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан бусад үүрэг.

ДОЛДУГААР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

28 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын санхүүжилт

28.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын зардлыг сургалтын үр дүн, чанар, гүйцэтгэлд үндэслэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

28.2. Нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан

дундаж норматив зардлыг төсөв, санхүүгийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

28.3. Салбар, үйлдвэрлэлийн онцлогоос хамааран аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих санд цалингийн сангаасаа Үндэсний зөвлөлөөс тогтоосон тодорхой хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

28.4. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийн хуваарийг Үндэсний зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.5. Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааны орлого бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг боловсролын боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

28.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэнэ

29 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан

29.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын дэмжих сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн 29.2-т заасан журмын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

29.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

29.3. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого нь Засгийн газрын тусгай сангийн хуульд зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

29.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

29.3.2. бусад эх үүсвэр.

29.4. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг доор дурдсан зориулалтаар зарцуулна:

29.4.1. төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилт;

29.4.2. төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын тогтмол зардал, суралцагчийн хоолны зардал;

29.4.3. өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг, бусад дэмжлэг;

29.4.4. нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардал;

29.4.5. багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, мэргэшүүлэх сургалтын зардал;

29.4.6. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зардал;

29.4.7. энэ хуулийн 26.1-д заасан байгууллагын үйл ажиллагааны зардал

29.4.8. мэргэжлийн ур чадварын олон улсын хэмжээний тэмцээнд бэлтгэх, оролцох, урамшуулах зардал болон үндэсний хэмжээний мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулах зардал;

29.4.9. бусад зардал.

30 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын төсвийг батлах, тайлан тэнцэл гаргах

30.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.

30.2. Үндэсний зөвлөл мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн төсвийн төслийг жил бүрийн 07 дугаар сарын 15-ны дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

30.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын тайлан тэнцлийг доор дурдсан хугацаанд улирал, жилээр нэгтгэн гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зөвлөлд тайлагнаж байна:

30.3.1. боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын нэг дэх сарын 15-ны дотор, жилийн нэгдсэн тайланг дараа оны 02 дугаар сарын 25-ны дотор тус тус нэгтгэн санал, дүгнэлтийн хамт мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;

30.3.2. боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улирлын тайланг дараа улирлын сүүлийн сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Үндэсний зөвлөлөөр хянан хэлэлцүүлэх.

30.4. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

НАЙМДУГААР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БУСАД АСУУДАЛ

31 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

31.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

32 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

32.1. Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

33.1. Энэхүү хуулийг 202 ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

33.2. Энэ хуулийн 14.3 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь суралцагч сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хууль тогтоомж

2.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилго

3.1. Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино.

3.2. Ерөнхий боловсролын зорилго нь суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс зүйтэй, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэн төлөвшүүлэхэд оршино.

3.3. Сургалтын байгууллага нь энэ хуулийн 3.1, 3.2-т заасан боловсролын зорилгыг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

ЭЗЭМШИХ ХУГАЦАА, НАС

4 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмших хугацаа, элсэх нас

4.1. Сургуулийн өмнөх боловсролыг 3, ерөнхий боловсролыг 12 жилд тус тус эзэмшинэ.

4.2. Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхэд хамрагдана.

4.3. Цэцэрлэгийн хүчин чадал, бүлэг дүүргэлтийг харгалзан 2 настай хүүхдийг цэцэрлэгт хамруулж болно.

4.4. Сургуулийн өмнөх боловсролыг 5 настай хүүхдэд заавал эзэмшүүлэх бөгөөд 200-аас доошгүй цагийн сургалтад хамруулсан байна.

4.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд 6 настай хамрагдаж болно.

4.6. Ерөнхий боловсролын сургуульд тухайн онд 6 нас хүрэх хүүхдийг элсүүлнэ.

4.7. Хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгаантай хүүхдийг 7 настайд нь сургуульд элсүүлж болно.

4.8. Энэ хуулийн 4.7-д заасан тохиолдол үүсэхэд эцэг эх, асран хамгаалагч нь ерөнхий боловсролын сургуулийн захиргаанаас өгсөн чиглэлийн дагуу хүүхдийн хөгжлийг дэмжинэ.

4.9. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэх хүүхдээс аливаа хэлбэрээр шалгалт авахыг хориглоно.

5 дугаар зүйл. Сургалтын цаг, хичээллэх хугацаа

5.1. Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаа нь 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

5.2. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ.

5.3. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч хичээлийн жилийн хугацаанд 170-185 хоног хичээллэнэ.

5.4. Ерөнхий боловсролын сургуулийн долоо хоногт хичээллэх цагийн

тоо, ээлжит хичээлийн үргэлжлэх болон суралцагчийн амралтын хугацааг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

5.5. Орон нутгийн байгаль, цаг уур, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогтой холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн үед нь өөрчилж болно.

5.6. Энэ хуулийн 5.5-д заасны дагуу хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг өөрчилсөн тохиолдолд сургалт, үйл ажиллагааны агуулгыг нөхөн эзэмшүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулна.

5.7. Холбогдох хуулийн дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу сургалтыг танхимын бус хэлбэрээр үргэлжлүүлэн зохион байгуулна.

5.8. Энэ хуулийн 5.5, 5.7-д зааснаас бусад тохиолдолд хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн амралтын хугацааг өөрчлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоохыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТЭГШ ХАМРАН СУРГАЛТ

6 дугаар зүйл. Тэгш хамран сургалт

6.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

6.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин бүрдүүлнэ.

6.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчийн саналыг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

6.4. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.5. Сургуулийн захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцөн тухайн суралцагчийн танхимд хичээллэх хугацааг уян хатан тогтоож болно. Энэхүү тогтоосон хугацаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байна.

6.6. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай дэмжлэг үзүүлэх журмыг боловсролын болон нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.7. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч энэ хуулийн 14.1, 14.3-т зааснаас гадна тусгай хэрэгцээт боловсролын багш, туслах багш, эмч, сувилагчтай байна.

6.8. Суралцагчийн тооноос шалтгаалан энэ хуулийн 6.7-д заасан багш, бусад ажилтныг сургалтын байгууллагын дунд ажиллуулж болно.

6.9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж буй багш, туслах багш, ажилтанд нэмэгдэл хөлс олгоно.

7 дугаар зүйл. Сургалтын хэл

7.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг монгол хэлээр зохион байгуулна.

7.2. Суралцагчийн дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн суралцагч байх тохиолдолд цэцэрлэг болон бага ангийн сургалт, үйл ажиллагааг эх хэлээр нь зохион байгуулж болно.

7.3. Энэ хуулийн 7.2-т заасан суралцагчийн дунд, ахлах ангийн сургалтыг монгол хэлээр зохион байгуулна.

7.4. Энэ хуулийн 7.2-т заасан суралцагчид зориулсан эх хэлнээс монгол хэлэнд шилжих шилжилт бүхий хос хэлний сургалтын жишиг хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СУРГАЛТЫН АГУУЛГА, ХӨТӨЛБӨР

8 дугаар зүйл.. Сургуулийн өмнөх боловсролын агуулга

8.1. Сургуулийн өмнөх боловсролын агуулга нь энэ хуулийн 3.1-д заасан боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

8.2. Сургуулийн өмнөх боловсролын агуулгыг хөдөлгөөн, бие бялдар, эрүүл мэнд, хэл яриа, математикийн энгийн төсөөлөл, хүрээлэн буй орчин, урлагийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх, харилцааны зөв дадал, хэвшил төлөвшүүлэх чиглэлээр тогтооно.

8.3. Цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлж болно.

9 дүгээр зүйл.. Ерөнхий боловсролын сургалтын агуулга

9.1. Ерөнхий боловсролын сургалтын агуулга нь энэ хуулийн 3.2-т заасан боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

9.2. Ерөнхий боловсролын сургалтын агуулгыг монгол хэл, үндэсний бичиг, түүх, уран зохиол, байгаль, нийгмийн ухаан, математик, гадаад хэл, биеийн тамир, урлаг, технологи, амьдрах ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх, ёс суртахуунтай иргэн төлөвшүүлэх чиглэлээр тогтооно.

9.3. Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна.

9.4. Боловсролын ерөнхий хуульд заасан агуулгыг энэ хуулийн 9.2-т заасан сургалтын агуулгад заавал тусгана.

10 дугаар зүйл.. Сургалтын хөтөлбөр

10.1. Энэ хуулийн 8.2, 9.5-д заасан агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөрийг боловсруулна.

10.2. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг тусгайлан боловсруулна.

10.3. Гадаад дахь монгол хүүхдэд зориулсан эх хэл, түүх, соёлын жишиг сургалтын хөтөлбөрийг боловсруулна.

10.4. Энэ хуулийн 10.1-10.3-т заасан болон ахлах ангийн сонгон судлах сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага

тус тус боловсруулж, боловсролын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.5. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсрол, нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

10.6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийн талаар мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий багш, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангасан орон тооны бус боловсролын мэргэжлийн зөвлөлтэй байна.

10.7. Энэ хуулийн 10.6-д заасан боловсролын мэргэжлийн Зөвлөлийн үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.8. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой тохируулга хийж болно.

10.9. Энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх хугацаа нь суралцагчийн ерөнхий боловсрол эзэмших хугацаанаас багагүй байх бөгөөд хэрэгжилтийн явцад сайжруулж болно.

10.10. Ахлах ангийн сургалтын хөтөлбөр нь заавал болон сонгон судлах хэлбэртэй байна.

11 дүгээр зүйл.. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

11.1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрсөн сурах бичгийг хэрэглэнэ.

11.2. Сурах бичгийн эх зохиох, турших, сургалтад ашиглахтай холбогдох харилцааг Боловсролын ерөнхий хуульд заасан журмаар зохицуулна.

11.3. Сурах бичиг зохиох үйл явц нь багш, эрдэмтэн судлаач, мэргэжлийн олон нийт, иргэний нийгмийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийн оролцоог хангасан, нээлттэй байна.

11.4. Холбогдох хуульд заасны дагуу ерөнхий боловсролын сурах бичгийн бүтээл ашиглах онцгой эрхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эзэмшинэ.

11.5. Ерөнхий боловсролын сурах бичиг нь хэвлэмэл, цахим хэлбэртэй байна.

11.6. Сурах бичиг нь сургалтын хөтөлбөрт нийцсэн, стандартын шаардлага хангасан байх ба хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд тогтвортой хэрэглэгдэнэ.

11.7. Сурах бичгийг бага ангийн суралцагчид үнэ төлбөргүй, дунд, ахлах ангийн суралцагчид сургуулийн номын сангаар дамжуулан төлбөртэй ашиглуулна.

11.8. Энэ хуулийн 11.7-д заасан төлбөрийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.9. Сурах бичгийг хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн брайл, бусад хэлбэрээр болон энэ хуулийн 7.2-т заасан суралцагчдад зориулан хөрвүүлж хэрэглэнэ.

11.10. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаанд шаардагдах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай нь сургалтын хөтөлбөрт нийцсэн байх ба тэдгээрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.11. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардлагатай сургалтын нэмэлт хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.12. Суралцагчийн нас, танин мэдэхүйн онцлог, сургалтын хөтөлбөрт нийцсэн нээлттэй эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд ашиглаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ СУРАЛЦАГЧ, БАГШ, АЖИЛТАН

12 дугаар зүйл. Суралцагчийн эрх

12.1. Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

12.1.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дээрэлхэлт, дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид, ээлтэй, аюулгүй, хамгаалагдсан орчинд суралцах;

12.1.2. суралцагч ерөнхий боловсролын сургуульд мөрдөх дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох;

12.1.3. хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчтай хамт боловсрол эзэмших;

12.1.4. өөрийн авьяас чадвараа хөгжүүлэх, сурлагын амжилтаа ахиулах зорилгоор дэмжлэг авах;

12.1.5. ерөнхий боловсролын сургуульд ирэх, очихдоо тогтоосон журмын дагуу тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх;

12.1.6. эрүүл мэнд болон хоол, хүнсний аюулгүй байдлыг хангасан, суралцагч өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжтой, тайван амьдрах дотуур байраар хангагдах.

13 дугаар зүйл. Суралцагчийн үүрэг

13.1. Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

13.1.1. хүндэтгэх шалтгаантайгаас бусад нөхцөлд ерөнхий боловсролыг заавал эзэмших;

13.1.2. сургуулиас баталсан дэг журмыг сахин биелүүлэх;

13.1.3. бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх үйлдэл гаргахгүй байх.

14 дүгээр зүйл. Цэцэрлэг, сургуулийн ажилтан

14.1. Цэцэрлэгт эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш, эмч, тогооч болон үйлчилгээний бусад ажилтан ажиллана.

14.2. Цэцэрлэгийн нэг бүлэгт багш, туслах багш ажиллах бөгөөд бүлгийн хүүхдийн тооноос хамаарч ээлжийн багш ажиллуулна.

14.3. Ерөнхий боловсролын сургуульд захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, эмч болон бусад ажилтан ажиллана.

14.4. Дотуур байранд багш, бага ангийн хүүхэдтэй ажиллах туслах багш ажиллана.

14.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын ерөнхий хуульд заасан шаардлагыг хангасан эрхлэгч, захирал удирдана.

15 дугаар зүйл. Багшийн ажил, үүрэг

15.1. Цэцэрлэг, сургуулийн багш нь дараах ажил, үүргийг гүйцэтгэнэ:

15.1.1. сургалт, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлж, сургалтын агуулгыг суралцагчид тогтоосон хугацаанд бүрэн эзэмшүүлэх;

15.1.2. цэцэрлэг, сургуулийн орчинд суралцагч бүрийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хариу арга хэмжээ авах;

15.1.3. суралцагчийн төлөвшил, авьяас чадварыг хөгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэх;

15.1.4. ажлын байрандаа өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн бүлгийн үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах, шилдэг туршлагаа түгээн дэлгэрүүлэх;

15.1.5. сургалт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх танхим, лаборатори байгуулах, ажиллуулах; үндсэн ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор эцэг эх, асран хамгаалагч, иргэний нийгмийн байгууллага зэрэг сонирхлын бүлэгт мэргэжлийн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах.

15.1.6. үндсэн ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор эцэг эх, асран хамгаалагч, иргэний нийгмийн байгууллага зэрэг сонирхлын бүлэгт мэргэжлийн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах.

15.2. Багш нь суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, нийгмийн болон хэл, соёлын ялгаатай суралцагчтай ажиллах арга зүй эзэмшсэн байна.

15.3. Багш нь зайн, цахим болон холимог бүлгийн сургалт зохион байгуулах мэдлэг, чадвартай байна.

15.4. Багш нь багшийн мэргэжлийн ёс зүйг баримталж, суралцагч болон хамт олондоо үлгэрлэнэ.

15.5. Багш нь суралцагчийн ялгаатай байдал, сурлагын амжилтын үнэлгээ, хувийн нууцыг хадгална.

16 дугаар зүйл. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил

16.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг багш бэлтгэдэг их, дээд сургуульд бэлтгэнэ.

16.2. Багш нь Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу багшлах эрхтэй байна.

16.3. Багшид ур чадвар, сургалтын чанар, үр дүн, ажилласан жилийг харгалзан мэргэшлийн зэрэг олгоно.

16.4. Багш нь ажлын байранд мэргэжлийн бүлгээр хамтран ажиллах болон бие даан суралцах замаар мэргэжлээ тасралтгүй дээшлүүлнэ.

16.5. Багшлах арга зүй, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг танхимын, танхимын бус болон эдгээрийн хосолсон хэлбэрээр үндэсний, орон нутгийн түвшинд болон ажлын байранд зохион байгуулна.

16.6. Багшлах арга зүй, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг танхимын, танхимын бус болон эдгээрийн хосолсон хэлбэрээр үндэсний, орон нутгийн түвшинд болон ажлын байранд зохион байгуулна.

16.7. Багшийн мэргэжлийн түвшин, ур чадварыг үнэлэх ажлыг 3-5 жил тутам зохион байгуулж, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

16.8. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 16.7-д заасан үнэлэх ажлыг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж болно.

17 дугаар зүйл. Удирдах болон бусад ажилтан

17.1. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, түүний хэрэгжилтийг мэргэжлийн түвшинд зохион байгуулахад багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлийг хангаж ажиллах;

17.1.2. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтныг тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, урамшуулах;

17.1.3. суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэх;

17.1.4. сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж бодис, хэрэглэгдэхүүн, сурах бичиг, ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, энэ асуудлаар олон нийтийн оролцоо, түншлэлийг хөгжүүлэх;

17.1.5. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд суралцагчийн хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

17.1.6. суралцагчийн эрүүл мэндийг дэмжсэн, шим тэжээллэг, амин дэмээр баялаг хоол, хүнсний үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

17.1.7. байгууллагын соёл төлөвшүүлэх, суралцагчдад ээлтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэхэд хамт олныг манлайлан удирдах;

17.1.8. боловсролын чанар, үр дүнг томилсон этгээд болон эцэг эх, асран хамгаалагчийн өмнө хүлээх;

17.1.9. хуульд заасан бусад.

17.2. Сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйч нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, багш нарын хамтын ажиллагааг дэмжих замаар сургалтын чанарыг сайжруулах үндсэн үүрэгтэй.

17.3. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан нь сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, эрсдэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчид үзүүлнэ.

17.4. Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч нь суралцагчийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх, ганцаарчилсан болон бүлгээр сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ. Шаардлагатай тохиолдолд багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ.

17.5. Сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад энэ хуулийн 6.7, 14.1, 14.3-т заасан ажилтан үүрэг хариуцлага хүлээнэ.

17.6. Багшаас бусад ажилтны орон тооны жишиг нормативыг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хүүхдийн тоог харгалзаж, үр дүнд чиглэсэн санхүүжилтийн зарчимд нийцүүлэн боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

18 дугаар зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага

18.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байна.

18.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт суралцах суралцагчийн тоог боловсролын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

18.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа баримтлах дүрэмтэй байна.

18.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн суралцах, хөгжих үйлийг дэмжих ганцаарчилсан сургалт болон багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах зориулалтын танхимтай байна.

18.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамааран боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байж болно.

18.6. Энэ хуулийн 18.5-д заасан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь эцэг, эх, асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

18.7. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа, суралцагчийн хөгжил, сурлагын амжилтын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулна.

18.8. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд эцэг эх, асран хамгаалагчийн болон суралцагчийн зөвлөл ажиллах бөгөөд үйл ажиллагааныхаа дүрмийг хурлаараа хэлэлцэн баталж мөрдөнө.

18.9. Энэ хуулийн 18.8-д заасан суралцагчийн зөвлөл цэцэрлэгт хамаарахгүй.

18.10. Суралцагчийн хөгжил хамгаалал, төлөвшил, аюулгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэгийн эрхлэгч нь эцэг эх, асран хамгаалагчтай, ерөнхий боловсролын сургуулийн захирал нь эцэг эх, асран хамгаалагч болон суралцагчтай тус тус гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

19 дүгээр зүйл. Хүүхдийн цэцэрлэг

19.1. Хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/ нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

19.2. Цэцэрлэг нь сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон холимог бүлгээр зохион байгуулна.

19.3. Цэцэрлэг нь салбар бүлэгтэй байж болно.

19.4. Цэцэрлэг нь сургалт, үйл ажиллагааны цагийг уртасгах буюу богиносгох байдлаар зохицуулалт хийж болно.

20 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургууль

20.1. Ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсролын зорилго болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжсэн үйл ажиллагаа эрхэлнэ.

20.2. Ерөнхий боловсролын сургууль нь дараах бүтэцтэй байна:

20.2.1. 1-5 дугаар ангитай бага сургууль, цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор;

20.2.2. 1-9 дүгээр ангитай дунд сургууль;

20.2.3. 1-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль;

20.2.4. 6-12 дугаар ангитай эсхүл 10-12 дугаар ангитай ахлах сургууль

20.3. Энэ хуулийн 20.2.3, 20.2.4-т заасан сургууль нь бүсийн болон аймаг, сум, дүүрэг дундын байж болно.

20.4. Энэ хуулийн 20.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг тогтооход хөгжлийн бодлого, төлөвлөлт, газар зүйн байршил болон Засгийн газраас тогтоосон нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх жишиг нормативыг тус тус баримтална.

20.5. Ерөнхий боловсролын сургууль нь дунд ангиас математик, байгалийн ухаан, техник-технологи, хэл, урлаг, спортын зэрэг чиглэлээр суралцагчийн авьяас, чадварыг хөгжүүлэх төрөлжсөн сургалт зохион байгуулж болно.

20.6. Ахлах сургууль нь сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамааран төрөлжиж болно.

20.7. Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.8. Энэ хуулийн 20.5, 20.6-д заасан төрөлжсөн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг 20.7-д заасан журамд нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн захирал сургуулийн зөвлөлөөр хэлэлцүүлж батална.

20.9. Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олон улсын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж болно.

20.10. Төрөлжсөн болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль нь энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан агуулгыг суралцагчид заавал эзэмшүүлнэ.

20.11. Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаатай болоход шаардлагатай нэмэлт үйлчилгээ үзүүлэх нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.

20.12. Ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн авьяасыг дэмжих нэмэлт сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж болно.

20.13. Ерөнхий боловсролын сургууль нь дотуур байранд амьдарч буй суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах үүрэгтэй.

20.14. Ерөнхий боловсролын сургууль нь сургууль завсардсан хүүхэд,

насанд хүрэгчдэд ерөнхий боловсролыг энэ хуулийн 18.7-д заасан хэлбэрээр нөхөн эзэмшүүлэх, сургуулийн насны хүүхдийг сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлнэ.

20.15. Ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэхэд энэ хуулийн 10.4-д заасан сургалтын хөтөлбөрийг мөрдөнө.

20.16. Ерөнхий боловсролын сургууль нь хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, соёл, урлаг, спорт, хүүхдийн хүмүүжил төлөвшлийг дэмжих арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.

21 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт

21.1. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа нь Боловсролын ерөнхий хуулийн 8.1-т зааснаас гадна зохион байгуулалтын дараах хэлбэртэй байна:

21.1.1. цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үндсэн сургалт;

21.1.2. цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх “дэмжигч /явуулын/ багшийн” болон “нүүдлийн бүлгийн” сургалт.

21.2. Энэ хуулийн 21.1.1-д заасан сургалтыг бүлгээр зохион байгуулна.

21.3. Энэ хуулийн 21.1.1, 21.1.2-т заасан сургалт зохион байгуулах журмыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын зохион байгуулалт

22.1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг анги, бүлгээр зохион байгуулна.

22.2. Гадаад хэл, технологийн сургалтыг дэд бүлэг, хэсгээр зохион байгуулж болно.

22.3. Сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт

суралцах хүүхдийн тооноос хамаарч холимог бүлгээр хичээллэж болно

22.4. Ахлах ангид сонгон судлах хичээлийг холимог бүлгээр зохион байгуулж болно.

22.5. Суралцагчийг сургуулийн амьдралд дасан зохицох, сургалтын агуулгын зөрүүг арилгах зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа болон нэмэлт үйлчилгээг дараах суралцагчид зориулан зохион байгуулна:

22.5.1. ерөнхий боловсролын сургуульд шинээр элссэн, боловсролын түвшин хооронд болон сургууль хооронд шилжин суралцаж буй;

22.5.2. сургуулиас түр хугацаанд завсардсан;

22.5.3. суралцахад нь хэлний бэрхшээл үүссэн;

22.5.4. онцгой авьяастай.

22.6. Ахлах ангид суралцагчийг дараагийн түвшний сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд бэлтгэнэ.

23 дугаар зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлага

23.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлагыг Зөвлөл хэрэгжүүлнэ.

23.2. Зөвлөл нь цэцэрлэг, сургуулийн сургалт, үйл ажиллагаа, суралцагчийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой ба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.2.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөгжил, бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

23.2.2. суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагаар хоцрогдохоос урьдчилан сэргийлэх, сурлагын амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлэх;

23.2.3. суралцагчийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, сургалт, үйл ажиллагааны орчин бүрдүүлэх;

23.2.4. суралцагчийн санаачилсан нийгэм хүмүүнлэгийн сайн дурын үйл ажиллагааг дэмжих, хамтран зохион байгуулах;

23.2.5. суралцагч, багш, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамт олонтой хамтран ажиллах, бүх талын оролцоог хангах;

23.2.6. хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломжийг бүрдүүлэх, аливаа ялгаварлал, хүчирхийлэл гаргахаас сэргийлэх;

23.2.7. энэ хуулийн 18.11-д заасан гэрээнд тусгах агуулга, гэрээний загварыг зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, хэрэгжилтэд хяналт тавих.

23.3. Зөвлөлийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дундын хэлбэрээр байгуулж болно.

23.4. Зөвлөлийн дарга, гишүүд шударга, хариуцлагатай, ёс зүйтэй ажиллана.

23.5. Зөвлөл нь хичээлийн жилд хоёроос доошгүй удаа үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

24 дүгээр зүйл. Зөвлөлийн төлөөлөл, бүрэн эрхийн хугацаа

24.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөл нь үүсгэн байгуулагч, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч болон төгсөгч зэрэг бусад сонирхлын бүлгийн төлөөллөөс бүрдсэн 7-11 хүний бүрэлдэхүүнтэй байна.

24.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн дэх үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь нийт гишүүдийн 51 хувиас доошгүй байна.

24.3. Зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөлөл тус бүрийг хамт олны хурлаас, нээлттэйгээр нэр дэвшүүлж, 3-5 жилийн хугацаагаар тус тус сонгоно.

24.4. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нь зөвлөлийг үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

24.5. Зөвлөл нь сургалтын байгууллагын болон санхүүгийн, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагын үйл ажиллагааны тайланг тус тус хэлэлцэж, дүгнэлтийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

24.6. Зөвлөлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлыг байгууллагын болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

24.7. Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг баталж мөрдөнө.

24.8. Зөвлөлийн бүрэлдэхүүнд цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал орохыг хориглоно.

25 дугаар зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжил, арга зүйн удирдлага

25.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжил, арга зүйн удирдлагыг багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлэг хэрэгжүүлнэ.

25.2. Багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлэг нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

25.2.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох;

25.2.2. багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих;

25.2.3. суралцагчдад амжилттай суралцах, хөгжих, төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх.

25.3. Багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн ажиллах журмыг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал баталж мөрдүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН БОЛОН СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

26 дугаар зүйл. Боловсролын үнэлгээ, хяналт-шинжилгээ

26.1. Боловсролын үнэлгээ, хяналт-шинжилгээ (цаашид боловсролын үнэлгээ гэх) нь сургалтын чанарыг баталгаажуулж, багш, суралцагчийн хөгжлийг дэмжих, боловсролын бодлого, төлөвлөлтийг сайжруулахад чиглэнэ.

26.2. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр хүүхдийн сургуульд суралцахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагын түвшнийг тогтооно.

26.3. Боловсролын үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн мэргэжлийн байгууллага зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

26.4. Боловсролын үнэлгээ хийхэд тухайн боловсролын байгууллага, орон нутгийн мэргэжлийн байгууллага болон сонирхлын талуудын оролцоог хангана.

26.5. Боловсролын үнэлгээний үр дүнг үнэлгээнд оролцогч талуудад мэдээлж, дэмжих үйл ажиллагааг хамтран зохион байгуулах арга хэмжээ авна.

26.6. Энэ хуулийн 18.8-д заасан өөрийн үнэлгээ хийх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.7. Боловсролын үнэлгээний мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

27 дугаар зүйл. Суралцагчийн үнэлгээ

27.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний хөгжлийг дэмжих, сурлагын амжилтаа ахиулахад суралцагчдад туслахад чиглэнэ.

27.2. Суралцагчийг сургалтын явц, анги дэвших, сургууль төгсөхөд тус тус үнэлнэ.

27.3. Ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн суралцагчид тоон болон үсгэн үнэлгээ хэрэглэхгүй.

27.4. Анги дэвших үнэлгээг ерөнхий боловсролын сургууль, сургууль төгсөх үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус зохион байгуулна.

27.5. Ерөнхий боловсролын сургууль төгсөх үнэлгээнд үндэслэн төгсөгчид боловсролын баримт бичиг олгоно.

27.6. Сурлагын амжилтаас шалтгаалан давтан сурах боломжийг суралцагчид олгох ба энэ талаарх шийдвэрийг суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой гаргана.

27.7. Боловсролын болон суралцагчийн үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

28 дугаар зүйл. Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага

28.1. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь боловсролыг хөгжүүлэх орон нутгийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

28.2. Нутгийн олон нийтийн (иргэдийн) өмнө сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанар, үр дүнг хариуцан ажиллана.

28.3. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь тухайн

нутаг дэвсгэртээ оршин суудаг 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд, сургуулийн насны хүүхдийг ерөнхий боловсролд заавал хамруулах үүрэг хүлээнэ.

28.4. Энэ хуулийн 4.7-д заасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутгийн ерөнхий боловсролын сургуультай хамтран зохион байгуулна.

28.5. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд шаардлагатай тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

28.6. Суралцагч зайн, цахим хэлбэрээр боловсрол эзэмшихэд зориулсан харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтцийг бүрдүүлнэ.

28.7. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан төлөвлөгөөнд тэгш хамран сургах чиглэлээр дараах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлнэ:

28.7.1. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчдад боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

28.7.2. шаардлагатай суралцагчид аюулгүй тээвэр, дотуур байрны үйлчилгээ үзүүлэх;

28.7.3. энэ хуулийн 6.2-д заасан орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.7.4. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих;

28.7.5. сургууль завсардсан сургуулийн насны хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлж, ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх

28.8. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага дотуур байранд амьдарч буй суралцагчийн эрүүл мэнд болон хоол хүнсний аюулгүй байдлыг хангаж хэвийн амьдрах, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлнэ.

28.9. Боловсролын байгууллагын барилга байгууламж түүний засвар

үйлчилгээг хариуцаж сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг хангана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1. Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29 .2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

30.1. Энэ хуулийг 2021 оны ... дүгээр сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

